



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ГОМБОЖАВЫН
ЗАНДАНШАТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

додл. 09.29 № 31-1/129
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон эдгээр хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД



Д.ОЮУН-ЭРДЭНЭ

000234004025



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

дод. о.р. л.р. № ХТ/до 94
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон эдгээр хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт ... хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр
Утас/факс. (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт www.mof.gov.mn


2023.09.29 № **01/7204**

-ны № -т

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА**

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон эдгээр хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль, тогтоомжийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрөв.

Хүндэтгэсэн.



В.ЖАВХЛАН

9761001997



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2023.09.28 № 1/5021
танай 2023.09.26-ны № 1/7134 -т

**САНГИЙН САЙД Б.ЖАВХЛАН
ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон эдгээр хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.


Х.НЯМБААТАР
151504362

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэлд:

“VI.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон эдгээр хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон эдгээр хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



САНГИЙН САЙД Б.ЖАВХЛАН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД**

Засгийн газрын XI байр, Самбуугийн гудамж 11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 33 33,
Цахим шуудан: info@med.gov.mn

2023.09.29 № 01/1788

танай _____-ны № _____-т

Зөвшөөрөл олгох тухай

Танаас 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр ирүүлсэн 01/7133 дугаар албан бичигтэй танилцлаа.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.3 дахь заалтын дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон эдгээр хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслүүдэд зөвшөөрөл олгож байна.



Ч.ХҮРЭЛБААТАР

230°53

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН
2024 ОНЫ ТӨСВИЙН
БАРИМТ БИЧИГ**

УЛААНБААТАР ХОТ

2023 он

МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙГ ӨРГӨН МЭДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ТОВЬЁОГ

1.МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2025-2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

1.1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал

1.2. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

1.3. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга

2.МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

2.1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал

2.2. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл

2.3. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулга

2.4. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн хавсралт

2.4.1. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн, хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын шалгуур үзүүлэлт

2.4.2. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт

2.4.3. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх “барих-шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн эргэн төлөлтийн жагсаалт

2.5. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүд

3.НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

3.1. Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал

3.2. Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл

3.3. Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуулийн төслийн танилцуулга

4.ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

4.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал

4.2. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл

4.3. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулга

5. ТООЦООЛЛЫН ХАВСРАЛТУУД



1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН
ТӨСВИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН
ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2025-2026
ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ,
ТАНИЛЦУУЛГА



1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН
ТӨСВИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН
ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2025-2026
ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ,
ТАНИЛЦУУЛГА



МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2025-2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтад "төсөв" гэж төрийн болон орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогц байхаар, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь заалтад "дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл" гэж тухайн төсвийн жилийн хүлээгдэж байгаа макро эдийн засгийн болон төсвийн гүйцэтгэлийн төлөв байдал, дунд хугацааны макро эдийн засгийн ба төсвийн үндсэн үзүүлэлтийн төсөөлөлд суурилсан төсвийн бодлогын баримт бичиг байхаар, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэхээр тус тус заасан нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

Монгол Улсын Засгийн газар Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулах, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, үнийн өсөлтийг хязгаарлаж иргэдийн бодит орлогыг хамгаалах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бодлого, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Энэхүү хуулийн төсөлд нүүрсний экспортыг 2024 онд 50 сая тонн байхаар тусгасан хэдий ч Засгийн газраас хэрэгжүүлж буй "Боомтын сэргэлт" ийн хүрээнд хилийн нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, экспортыг эрчимжүүлэх арга хэмжээний үр дүнд 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нүүрсний экспорт 52 сая тоннд хүрэхээр байна.

Иймд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд тооцсон нүүрсний экспортын биет хэмжээг 10 сая тонноор нэмэгдүүлэн, 60 сая тоннд хүргэх бололцоотой байна. Түүнчлэн, Оюутолгойн гүний уурхайн олборлолт явагдаж, зэсийн баяжмалын агууламж өссөнөөр уул уурхай, түүнийг дагасан тээвэр логистик, худалдааны салбарын өсөлт нэмэгдэж 2024 онд 6.5 хувь гэж тооцоолж байсан эдийн засгийн өсөлт 7 хувьд хүрэх төлөвтэй байна.

Ингэснээр, экспортын орлого өсөж төлбөрийн тэнцэл сайжрах, гадаад валютын албан нөөц нэмэгдэж валютын ханш тогтворжих зэргээр макро эдийн засгийн үзүүлэлтүүдэд эергээр нөлөөлөхөөс гадна төсвийн орлого нэмэгдэхээр тооцлоо.

Ирэх 2024 онд Монгол Улсын Засгийн газар Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд иргэдийн бодит орлогыг хамгаалах, хот хөдөөгийн сэргэлтийг дэмжих, хөгжил дагасан бүтээн байгуулалтуудыг хийх замаар эдийн засгийн суурийг тэлэх төсвийн бодлогыг хэрэгжүүлэхэд төсвийн орлогыг зарцуулна.

Дээр дурдсан нөхцөл байдлаас шалтгаалан Монгол Улсын 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд өөрчлөгдөхөөр байгаа нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн хэмжээг өөрчлөх зайлшгүй шаардлагыг бий болгоод байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөлд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг хүснэгтээр батлахтай холбогдсон зохицуулалтыг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар макро эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийг зөв тооцож, улсын төсвийг үр нөлөөтэй оновчтой төлөвлөх, хуваарилах асуудал бодитой болох юм.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төсөл байхгүй болно.

--- оОо ---


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН
2024 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2025-2026 ОНЫ ТӨСВИЙН
ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

УЛААНБААТАР ХОТ

2023 ОН



МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2025-2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг баталсан.

Энэхүү хуулийн төсөлд нүүрсний экспортыг 2024 онд 50 сая тонн байхаар тусгасан хэдий ч Засгийн газраас хэрэгжүүлж буй “Боомтын сэргэлт” ийн хүрээнд хилийн нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, экспортыг эрчимжүүлэх арга хэмжээний үр дүнд 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нүүрсний экспорт 52 сая тоннд хүрэхээр байна.

Иймд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд тооцсон нүүрсний экспортын биет хэмжээг 10 сая тонноор нэмэгдүүлэн, 60 сая тоннд хүргэх бололцоотой байна. Түүнчлэн, Оюутолгойн гүний уурхайн олборлолт хийгдэж, зэсийн баяжмалын агууламж өссөнөөр уул уурхай, түүнийг дагасан тээвэр логистик, худалдааны салбарын өсөлт нэмэгдэж 2024 онд 6.5 хувь гэж тооцоолж байсан эдийн засгийн өсөлт 7 хувьд хүрэх төлөвтэй байна.

Ингэснээр, экспортын орлого өсөж төлбөрийн тэнцэл сайжрах, гадаад валютын албан нөөц нэмэгдэж валютын ханш тогтворжих зэргээр макро эдийн засгийн үзүүлэлтүүдэд эергээр нөлөөлөхөөс гадна төсвийн орлого нэмэгдэхээр тооцлоо.

Ирэх 2024 онд Монгол Улсын Засгийн газар Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд иргэдийн бодит орлогыг хамгаалах, хот хөдөөгийн сэргэлтийг дэмжих, хөгжил дагасан бүтээн байгуулалтуудыг хийх замаар эдийн засгийн суурийг тэлэх төсвийн бодлогыг хэрэгжүүлэхэд төсвийн орлогыг зарцуулна.

Дээр дурдсан нөхцөл байдал, үндэслэл, шаардлагын дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд дээр үндэслэн, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн алдагдал болон Засгийн газрын өрийн хэмжээг “Төсвийн тогтвортой байдлын тухай” хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн боловсрууллаа.

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2025-2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 4 дүгээр заалтад хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгад тайлбарыг нэмэлт, өөрчлөлт бол зүйл, эсхүл хэсэг, заалт тус бүрээр багцлан тусгана гэсний дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн агуулгыг зүйлээр тусгалаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь 1 зүйлтэй.

1 дүгээр зүйл – Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн макро үзүүлэлтүүдийн өөрчлөлт.

Дотоодын нийт бүтээгдэхүүн

Монгол Улсын эдийн засаг 2024 онд 7.0 хувиар өсөхөөр байна. Уул уурхайн бүтээгдэхүүнүүд, нүүрсний олборлолт, Оюутолгойн гүний уурхайн олборлолт эрчимжиж, зэсийн баяжмал дахь агууламж нэмэгдсэнээр уул уурхай, түүнээс хамааралтай тээврийн салбарын өсөлт эдийн засгийн өсөлтийн гуравны нэг орчмыг бүрдүүлнэ.

Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортын хоригийг цуцалж, нэвтрүүлэх зөвшөөрөлтэй боомтын тоог нэмэгдүүлж, татаасыг чөлөөлөх замаар хөдөө аж ахуйн салбар дах төрийн оролцоог шат дараатай бууруулна. Мөн хөдөө аж ахуйн зориулалттай тоног төхөөрөмжийн гаалийн албан татварын хөнгөлөлтийг үргэлжлүүлэх, мал, амьтны гоц халдварт өвчнөөс сэргийлэх вакцинаар бүрэн хангах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Ингэснээр хөдөө аж ахуйн салбарын хөрөнгө оруулалт нэмэгдэж, бүтээмжийн өсөлтөөр дамжин салбарын үйлдвэрлэл нэмэгдэнэ. Мөн бэлтгэсэн хадлангийн хэмжээ нэмэгдсэн нь 2023 оны сүүлийн хагас болон 2024 онд мал аж ахуйн салбарын тогтвортой, бүтээмжтэй үйл ажиллагаанд зөргөөр нөлөөлнө.

“УБТЗ” ХНН-ийн дотоодын ачаа тээвэр, зорчигч тээврийн тарифыг 2023 онд нэмэгдүүлсэн. Энэ нь төмөр замын салбарын үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлж, салбарын үйлдвэрлэлийн суурь,

бүтээмжийг зах зээлийн зарчмаар тэлэх нөлөөтэй. Жишээлбэл, тарифын өөрчлөлтийн дараа “УБТЗ” ХНН нь ачааны вагоны тоо хэмжээг нэмэгдүүлэх, хөдлөх бүрэлдэхүүний засварын төвийн өргөтгөлийн ажлуудыг 2024 оноос эхлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Эдгээр арга хэмжээний нөлөөгөөр тээврийн салбарын эдийн засаг дах суурь тэлж, үйлдвэрлэл нэмэгдэнэ.

“Шинэ сэргэлтийн бодлого” болон “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд туссан бодлогын чиглэл, зарчмыг баримталж, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж, үйлдвэржилтийн болон дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлснээр барилга, боловсруулах, худалдаа, үйлчилгээ зэрэг уул уурхайн бус салбаруудын өсөлт эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлнө. Эдгээр үйлдвэржилт, дэд бүтцийн төслүүдийн хэрэгжилт эдийн засаг дахь үндсэн хөрөнгийн хуримтлалыг нэмэгдүүлэх бол өрхийн цалингийн орлого өссөнөөр дотоод эрэлтийн төлөв сайн байх хүлээлттэй байна.

Түүнчлэн Засгийн газрын 2023 оны 233 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд зочид буудал, байр сууц, худалдаа, нийтийн хоолны үйлчилгээний салбарт бизнес эрхлэлтийг дэмжиж, зохицуулалтыг хялбаршуулна. Мөн 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласан бодлогын хүрээнд аялал жуулчлалын үйлчилгээ, дэд бүтцийг сайжруулж, жуулчлалын бүс байгуулах арга хэмжээг хэрэгжүүлснээр худалдаа, үйлчилгээний салбаруудын үйл ажиллагааг дэмжинэ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд тооцсон нүүрсний экспортын биет хэмжээг 10 сая тонноор нэмэгдүүлэн, 60 сая тоннд хүргэх бололцоотой байна. Түүнчлэн, Оюутолгойн гүний уурхайн олборлолт хийгдэж, зэсийн баяжмалын агууламж өссөнөөр уул уурхай, түүнийг дагасан тээвэр логистик, худалдааны салбарын өсөлт нэмэгдэж 2024 онд 6.5 хувь гэж тооцоолж байсан эдийн засгийн өсөлт 7 хувьд хүрэх төлөвтэй байна.

Инфляц

Засгийн газар, төв банкнаас макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсөв, мөнгөний бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Мөн экспортын орлогыг нэмэгдүүлж, валютын бодит мөнгөн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээний үр дүнд гадаад валютын албан нөөц нэмэгдэж байна.

Засгийн газрын 2023 оны 233 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гэрчилгээ авах, хүсэлт гаргах, хянах, олгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, хөдөө аж ахуйн

биржийн үйл ажиллагааг идэвхжүүлэн, хот, суурин газарт нийлүүлэгдэж байгаа махнаас авах төлбөр хураамж, хянан шалгалтын давхардлыг арилгаж, үйл ажиллагааг хөнгөвчлөх замаар хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сувгийг нэмэгдүүлнэ.

Эдгээр арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн үр дүнд инфляцын түвшин 2024 оны эцэст 8.5 хувь орчимд байхаар төсөөлж байна.

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого

2024 онд экспорт 15.4 тэрбум ам.доллар, импорт 10.0 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдаа 5.4 тэрбум ам.долларын ашигтай гарахаар төсөөлж байна.

Засгийн газраас гадаад худалдааг хөнгөвчлөх, экспортын зах зээлийг өргөжүүлэх, хилийн боомтуудын дэд бүтцийг нэмэгдүүлж, ачаа нэвтрүүлэх процессыг хөнгөвчлөх, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тогтолцоог өргөжүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд нүүрс, төмрийн хүдэр, газрын тос, алтны экспортыг нэмэгдүүлэх, тээвэр зохион байгуулалтыг оновчтой хийх, хилийн боомтуудын төмөр замын холболтыг эрчимжүүлэх, бүх боомтод ухаалаг гарцыг ашиглалтад оруулах, хатуу хучилттай авто замаар холбох, уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалсан нүүрсийг тусгай гарцаар нэвтрүүлж, биржээр арилжаалах бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Үүний үр дүнд 2024 онд голлох бүтээгдэхүүний экспортын биет хэмжээг нүүрс 60 сая тонн, зэсийн баяжмал 1,500 мянган тонн, төмрийн хүдэр 8,400 мянган тонн, газрын тос 4,850 мянган баррель, алт 20 тонн байхаар төсөөлж байна.

2024 онд хийгдэх хилийн боомтуудын бүтээн байгуулалт, төмөр зам болон автозамын сүлжээний өргөтгөл, цахилгаан эрчим хүчний станцуудын өргөтгөл болон шинэ бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн нөлөөгөөр тоног төхөөрөмж, барилгын материалын импорт нэмэгдэхээр байна.

Үүний үр дүнд нэгдсэн төсвийн нийт орлогыг 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 4.2 их наяд төгрөг буюу 18.5 хувиар нэмэгдүүлэн 27.2 их наяд төгрөг хүрнэ гэж тооцлоо. Үүнээс 513.7 тэрбум төгрөгийг Төсвийн тогтворжуулалтын санд, 1,353.3 тэрбум төгрөгийг Ирээдүйн өв санд төвлөрүүлэхээр тооцлоо.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагын дагуу тооцсон тэнцвэржүүлсэн нийт орлого 2024 онд 25.3 их наяд төгрөгт хүрэхээр, үүнээс 92.9 хувь буюу 23.4 их наяд төгрөгийг татварын орлого, 7.1

хувь буюу 1.8 их наяд төгрөгийг татварын бус орлогоор тус тус бүрдүүлэхээр тооцлоо.

Төсвийн зарлага

Хэдийгээр эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд эерэг өөрчлөлтүүд гарч эхэлсэн боловч гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр сүүлийн 20 сар дараалан Монгол Улсын инфляц 10 хувиас дээш түвшинд хүрсэн нь иргэдийн бодит орлогод сөргөөр нөлөөлж, ард иргэдийн амьжиргааг дэмжих зайлшгүй шаардлага бий болгосон. Улмаар Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулж, цалингийн суурь итгэлцүүрийг шинэчлэх замаар тэтгэврийн зөрүүний асуудлыг шийдвэрлэж, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлж, төрийн албаны цалингийн тогтолцоог шинэчлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд 2023 оны эцэст бодит орлого нэмэгдэж, төлбөрийн тэнцэл ашигтай гарч, гадаад валютын албан нөөц 4 тэрбум ам.долларыг давж, эдийн засаг 6.0 хувиар өсөх төлөвтэй байна.

Ийнхүү гадаад эрсдэлийн нөлөө намжиж, эдийн засаг цар тахлын өмнөх түвшинд хүрч сэргэсэнээр “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн зорилтод хүрэх “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг үе шаттайгаар хэрэгжүүлэхэд ирэх 2024 оны төсвийн бодлогыг чиглүүлнэ.

Нэг. Монгол Улс 2024 оны төсвийн бодлогоор “Шинэ сэргэлтийн бодлого”-ын тулгуур бүрэлдэхүүн болох “Хот, хөдөөгийн сэргэлт”-ийн зорилтод тусгасан хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, орон нутгийн иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хоёр. Экспортыг нэмэгдүүлэх чиглэлд хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн ил тод арилжааг эрчимжүүлэх, иргэдийн орлогыг хам гаалах чиглэлд цалин, тэтгэвэр тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх, хөгжилд суурилсан хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэхэд чиглэсэн төсвийн бодлогыг хэрэгжүүлнэ.

Гурав. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан иргэд эх орондоо оношлогдон, эмчлүүлэх боломжийг нэмэгдүүлж, орчин үеийн үндэсний оношилгоо, эмчилгээний төвүүдийг байгуулах томоохон зорилтын хүрээнд дэлхийн жишигт нийцсэн шинэ технологи, инновац бүхий эс, эд, эрхтэн шилжүүлэх төвийг Улсын төв нэгдүгээр эмнэлгийн дэргэд байгуулахаар “Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв”-ийн бүтээн байгуулалтын санхүүжилт болох 140.0 тэрбум төгрөг, Улаанбаатар хотын Баянгол дүүрэгт баригдах “Зүрх судасны үндэсний төв”-

ийн гадна шугам сүлжээ, дэд бүтэц, Төв аймгийн Сэргэлэн суманд баригдах “Халдвар үндэсний төв-2”-ийн гадна шугам сүлжээ, дэд бүтэц нийтдээ 15.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 5.1 тэрбум төгрөг тус тус тусгалаа.

Дөрөв. Уул уурхайн орлогын тодорхой хувиас бүрдэж, тухайн орон нутгийн иргэдийн санал санаачилга дээр тулгуурлан, иргэдийн ая тухтай амьдрах орчныг сайжруулахад чиглэсэн Орон нутгийн хөгжлийн сангаас уул уурхайн олборлолт хийгдэж буй аймгуудад нэмэлтээр хуваарилагдаж, үүнээс сумдад олгох санхүүжилтийг 60 хувьд хүртэл нэмэгдүүлнэ. Ингэснээр тогтвортой, хариуцлагатай уул уурхайг дэмжиж, эдийн засгийн эргэлтэд оруулан, байгалийн баялгийн үр өгөөжийг орон нутгийн хөгжилд чиглүүлэх боломж бүрдэнэ.

Төсвийн тэнцэл болон Засгийн газрын өр

Дээрх арга хэмжээнүүдийг 2024 онд хэрэгжүүлснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн алдагдал ДНБ-ий 2.8 хувь, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн Засгийн газрын өрийн үлдэгдэл ДНБ-ий 60.0 хувиас ихгүй байх төсвийн тусгай шаардлага хангагдаж, ирэх 4 жилд нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг 10 мянган ам.долларт хүргэх эдийн засгийн суурийг дэмжиж баталгаажуулах боломжтой болох юм.

Засгийн газрын өрийн хувьд 2023 онд Засгийн газрын өрийн баталгаатай Монгол Улсын Хөгжлийн банк (МУХБ)-ны “Самурай” бонд төлөгдөх хуваарьтай, үүнийг зээлийн эргэн төлөлтөөс Монголбанкинд хуримтлуулж, төлж барагдуулахад бэлэн болж, 2024 онд МУХБ-ны БНХАУ-ын Хөгжлийн банкнаас авах зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх “Чойбалсан ДЦС-ын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөх” төсөл болон “Шинэ сэргэлтийн бодлого”-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслүүдэд Засгийн газрын өрийн баталгаа гаргахаар тооцоолсон. Мөн, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын зүгээс Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах, төвлөрлийг сааруулах, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр дотоодын зах зээлд үнэт цаас гаргаж 2023 онд эхний ээлжид 200.0 тэрбум төгрөгтэй тэнцэх хүлээлттэйгээр тооцоход 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр Засгийн газрын нийт өр 32.2 тэрбум төгрөгтэй тэнцэхээр байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2020 онд Ковид-19 цар тахал, 2022 онд Орос-Украины нөхцөл байдлын дэлхийн эдийн засагт үзүүлсэн сөрөг нөлөөллөөс шалтгаалан өссөн байгаа боловч Засгийн газраас өрийн стратегийн баримт

бичгийн дагуу тодорхой зорилтуудыг хэрэгжүүлэн хугацаа тулаад байсан томоохон төлбөрийн үүргээ амжилттай гүйцэтгэсний үр дүнд Засгийн газрын өрийн баталгаа гаргаагүй тохиолдолд Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн ДНБ-тэй харьцуулсан харьцаа 2023 онд 44.3 хувь, 2024 онд 42.7 хувьтай тэнцэх төсөөлөлтэй буюу Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан 2024 оны өрийн хязгаар болох 60 хувиас хэтрэхгүй байх шаардлагыг хангах төсөөлөлтэй байна.

--- оОо ---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар сарын ... -ны өдөр

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2025-2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:


"1 дүгээр зүйл. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг доор дурдсанаар баталсугай:

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт		Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
		2024 он	2025 он	2026 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	7.0	6.5	5.4
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	8.5	6.0	6.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	25,289.8	27,757.3	29,155.8
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	34.2	33.4	32.4
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	27,360.5	29,417.3	30,955.8
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	37.0	35.4	34.4
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	4,989.2	2,056.7	1,538.5
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	6.7	2.5	1.7
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-2,070.8	-1,660.0	-1,800.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-2.8	-2.0	-2.0
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	6,170.4	6,620.8	6,971.7
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	8.3	8.0	7.7
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	44,400.0	49,800.0	54,000.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	60.0	60.0	60.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	2,389.6	2,437.7	2,461.8
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	3.2	2.9	2.7

Гарын үсэг



2. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ,
ТАНИЛЦУУЛГА



МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтад ““төсөв” гэж төрийн болон орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогц” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтад “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.9 дэх заалтад “Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг жил бүрийн намрын ээлжит чуулганаар хэлэлцэн 11 дүгээр сарын 15-ны дотор батлах” гэж тус тус заасан нь Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

Монгол Улсын Засгийн газар Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулах, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, үнийн өсөлтийг хязгаарлаж иргэдийн бодит орлогыг хамгаалах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бодлого, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Хилийн боомтоор ашигт малтмал тээвэрлэх, экспортлох үйл ажиллагааг эрчимжүүлэх, төрийн өмчит хуулийн этгээдүүдийн засаглалыг сайжруулах зэрэг арга хэмжээний үр дүнд нүүрсний экспорт 2022 онд 31.8 сая тоннд хүрсэн нь урд онуудын түвшнээс даруй хоёр дахин өссөн үзүүлэлт бөгөөд улмаар 2023 оны 9 дүгээр сарын 15-ны байдлаар нүүрсний экспортын биет хэмжээ 46.0 сая тоннд хүрээд байна.

Экспортын орлого нэмэгдсэнээр төлбөрийн тэнцэл сайжирч гадаад валютын албан нөөц 2023 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 3.9 тэрбум ам.долларт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 1.2 тэрбум ам.доллараар нэмэгдсэн үзүүлэлт юм. Экспортын орлого, гадаад валютын урсгалыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг 2024 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлсний үр дүнд гадаад валютын албан нөөц нэмэгдэхээр байна.

Дэлхий дахинд үүсээд байсан хүнс, эрчим хүчний үнийн огцом өсөлтийн гадаад шокоос иргэдийн бодит орлого, амьжиргааг хамгаалах зорилгоор хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг дэмжих, үйлдвэрлэлийн гол орц болох газрын тосны бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд инфляцын хурд харьцангуй удааширч 2023 оны 8 дугаар сард 10 орчим хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.4 хувиар буурсан үзүүлэлт юм. Инфляцын түвшнийг 2024 оны эцэст 8 хувь орчимд байхаар тооцож байна.

Эдгээр макро эдийн засгийн эерэг үзүүлэлтүүдийн үр дүнд эдийн засгийн өсөлт эргэн тогтворжиж, 2023 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 6.4 хувьтай гарч нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн 61 их наяд төгрөг хүрэх төлөвтэй байна. Цаашлаад уул уурхайн бүтээгдэхүүнүүд, нүүрс болон Оюутолгойн гүний уурхайн олборлолт эрчимжиж, зэсийн баяжмал дахь агууламж нэмэгдсэнээр уул уурхай, түүнээс хамааралтай тээврийн салбарын өсөлтийн нөлөөгөөр 2024 онд эдийн засгийн өсөлт 7.0 хувьд хүрч улмаар 2024 онд нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн 74 их наяд төгрөг, төсвийн тэнцвэржүүлсэн орлого 25.3 их наяд төгрөг хүрэх тооцоо гарч байна.

Ийнхүү гадаад эрсдэлийн нөлөө намжиж, эдийн засаг цар тахлын өмнөх түвшинд хүрч сэргэсэнээр “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг бүрэн утгаар нь хэрэгжүүлэх боломж бүрдэж байна. Энэ хүрээнд дараах төсвийн бодлогуудыг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

1/ “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд хэрэгжүүлэх 6 зорилтын нэг болох “Хот, хөдөөгийн сэргэлт”-ийг хэрэгжүүлэхэд онцгой анхаарсан төсвийн бодлого баримтална. Энэхүү бодлогын хүрээнд хөгжил дагасан бүтээн байгуулалтыг хийх, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, эдийн засгаа тэлэхэд чиглэсэн төсвийн арга хэмжээнүүдийг төлөвлөх;

2/ Экспортыг нэмэгдүүлэх чиглэлд хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн ил тод арилжааг дэмжих, иргэдийн орлогыг хамгаалах чиглэлд цалин, тэтгэвэр тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлж, хөгжилд суурилсан хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх төсвийн бодлогыг хэрэгжүүлэх.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөлд 2024 оны төсвийн жилд төвлөрүүлэх нийт орлого, зарцуулах хэмжээ, хөрөнгө ба өрийн удирдлага, улс болон орон нутгийн төсөв хоорондын

татаас, шилжүүлэг болон бусад зохицуулалттай холбогдсон харилцааг тусгасан 4 бүлэг, 23 зүйл, 3 хавсралттай байх бөгөөд доор дурдсан агуулгатай байна. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн нийтлэг үндэслэл, хуулийн зорилт, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль тогтоомжийн тухай;

Хоёрдугаар бүлэгт Монгол Улсын 2024 оны төсвийн орлого, зарлага болон хөрөнгө, өрийн удирдлага, Монгол Улсын төсөвт 2024 оны төсвийн жилд ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээ, төсвийн ерөнхийлөн захирагчдын Монгол Улсын төсөвт 2024 онд эргэн төлөх төлбөр, 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчдын зарцуулах төсөв, эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгох санхүүжилт, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн зардлын хэмжээ, Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 оны төсвийн жилд санхүүжүүлэх "Барих-Шилжүүлэх" концессын төрлөөр бүрэн хэрэгжиж дууссан төсөлд олгох эргэн төлөлтийн дүн, Төсвийн тогтворжуулалтын санд 2024 оны төсвийн жилд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, Ирээдүйн өв санд 2024 оны төсвийн жилд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, 2024 оны төсвийн жилд төсвийн алдагдлыг санхүүжүүлэх Засгийн газрын хийх гадаад, дотоод зээллэгийн дээд хэмжээ, Засгийн газрын авч ашиглах гадаад төслийн зээлийн дээд хэмжээ, 2024 оны төсвийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэй гаргасан зээллэг болон өрийн зохицуулалтын арга хэмжээнээс бусад 2024 оны төсвийн жилд төлөх Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийн хэмжээ, Засгийн газрын гаргах өрийн баталгааны дээд хэмжээ, Засгийн газраас Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, "Засгийн газрын өрийн удирдлагын 2024-2026 оны стратегийн баримт бичиг"-т нийцүүлэн хэрэгжүүлэх өрийн зохицуулалтын үйл ажиллагааны талаар;

Гуравдугаар бүлэгт орон нутгийн төсөвт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх орлого, орон нутгийн хөгжлийн санд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс олгох орлогын шилжүүлгийн талаар;

Дөрөвдүгээр бүлэгт Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүн, хүрэх үр дүнгийн тоон болон чанарын шалгуур үзүүлэлт, улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт, Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх "Барих-Шилжүүлэх" концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн эргэн төлөлтийн жагсаалт болон хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 онд хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийн хуваарилалт ба санхүүжилтийн эрх зүйн орчин бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Тогтоолд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай, Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай, Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай, Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай, Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ТАНИЛЦУУЛГА**

УЛААНБААТАР ХОТ

2023 ОН

Агуулга

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Монгол Улсын макро эдийн засгийн тойм	
I. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ГҮЙЦЭТГЭЛ	1
1.1 Макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал	1
1.2 Макро эдийн засгийн 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэл.....	11
II. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2024 ОНЫ ЧИГ ХАНДЛАГА, ТӨСӨӨЛӨЛ	16
2.1 Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал.....	16
2.2 Макро эдийн засгийн 2024 оны төсөөлөл.....	19
III. ЗАСГИЙН ГАЗРААС 2024 ОНД БАРИМТЛАХ БОДЛОГО, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ	23
ХОЁРДУГААР БҮЛЭГ. Монгол Улсын 2024 оны төсвийн төсөл	28
I. МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	28
1.1 Нэгдсэн төсвийн гүйцэтгэл	28
1.2 Нийт орлого ба тусламжийн дүнгийн гүйцэтгэл	28
1.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл	30
1.4 Гадаадын зээл, тусламжийн гүйцэтгэл	30
II. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЙЛБАР – БҮЛГЭЭР	32
III. ТӨСВИЙН БОДЛОГО	34
3.1 Монгол Улсын 2024 оны төсвийн бодлого	36
IV. ТӨСВИЙН ОРЛОГО, ТАТВАР	43
4.1 Төсвийн орлого, татварын чиглэлээр баримтлах бодлого	43
4.2 Төсвийн орлогын 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэл	49
4.3 Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн нийт орлого	49
4.4 Төсвийн тогтворжуулалтын сангийн орлого	50
4.5 Ирээдүйн өв сангийн орлого	51
4.6 Уул уурхайн салбарын орлого	51
4.7 Татварын орлого	52
4.7.1 Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	52
4.7.2 Хувь хүний орлогын албан татвар.....	53
4.7.3 Дотоодын барааны нэмэгдсэн өртгийн албан татвар.....	53
4.7.4 Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар.....	54
4.7.5 Суудлын автомашинны онцгой албан татвар.....	54

4.7.6 Согтууруулах ундаа, тамхины онцгой албан татвар.....	54
4.7.7 Импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын орлого	55
4.7.8 Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	55
4.7.9 Агаарын бохирдлын төлбөр	55
4.7.10 Хөрөнгийн албан татвар	56
4.7.11 Газрын төлбөрийн орлого	56
4.7.12 Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөр	56
4.8 Татварын бус орлого	56
4.8.1 Газрын тосны орлого	56
4.8.2 Навигацийн орлого	57
4.8.3 Хувьцааны ногдол ашиг	57
4.9 Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт	57
V. ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДАЛ	59
5.1 Урсгал зардлын хуваарилалтад баримтлах бодлого	59
5.2 Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн урсгал зардлын тойм.....	59
5.3 Урсгал зардлын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тойм	59
5.4 Засгийн газрын тусгай сангууд	66
VI. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	70
6.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын судалгаа, статистик	70
6.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2023 оны гүйцэтгэл:	71
6.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын шинэчлэл.....	72
6.4 Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаарх олон улсын үнэлгээ.....	75
6.5 Улсын төсвийн хөрөнгө оруулалт 2024 онд	76
VIII. ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ.....	84
8.1 Гадаад зээл, тусламжийн ашиглалтын мэдээлэл	85
IX. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР	88
9.1 Олон улсын санхүүгийн нөхцөл байдал ба Засгийн газрын өр	88
9.1.1 Засгийн газрын өрийн тусгай шаардлага	88
9.1.2 Монгол Улсын зээлжих зэрэглэл.....	94
9.1.3 Засгийн газрын гадаад зээл	97
9.1.4 Засгийн газрын гадаад үнэт цаас	103
9.1.5 Засгийн газрын дотоод өр.....	107
9.2 Засгийн газрын болзошгүй өр төлбөр	109
9.3 Улсын секторын өр	111
9.4 Улсын нийт гадаад өр	114

9.5 Засгийн газрын 2023-2025 оны өрийн удирдлагын стратегийн баримт бичгийн хэрэгжилт	115
X. 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	124
XI. ТӨСВИЙН БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН ТОЙМ	127
XII. ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ	129

БҮЛЭГ 2. ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 4.1. Нийт орлого ба тусламжийн дүн /их наяд ₮/	50
График 4.2 Уул уурхайн болон бусад салбараас төвлөрүүлэх орлого /нийт орлогод эзлэх хувь/	4
График 4.3. Төсвийн орлого, төрлөөр /тэрбум ₮/.....	4
График 4.4 Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого /уул уурхай, уул уурхайн бус салбараар /тэрбум ₮/	4
График 4.5. Хувь хүний орлогын албан татварын орлого /тэрбум ₮/.....	4
График 4.6. Дотоодын нэмэгдсэн өртгийн албан татварын орлого /тэрбум ₮/.....	4
График 4.8 Импортын гаалийн албан татвар болон НӨАТ /тэрбум ₮/.....	4
График 4.9 Газрын тосны экспортын хэмжээ, үнэ.....	4
График 6.1. Нийт хөрөнгө оруулалтын тоон мэдээлэл /тэрбум ₮/	4
График 6.2. Төсвийн хөрөнгө оруулалтын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь, мэдээлэл /тэрбум ₮/.....	4
График 9.1. Засгийн газрын өрийн хязгаар /2016-2024/	4
График 9.2. Гадаад зээлийн ашиглалтыг зориулалтаар /1991.01.01-2023.06.30/	4
График 9.3. Азийн хөгжлийн банкны санхүүжилтийн ангилал.....	4
График 9.4. Баталгаат овернайт санхүүжилтийн хүүгийн түвшин /2018-2023	4
График 9.5. Засгийн газрын гадаад зээлийн ханшийн багц	4
График 9.6 Гадаад үнэт цаасны олон улсын зах зээл дээрх өгөөж 2022.09.21-2023.09.21	4
График 7.7 Олон улсын ногоон бондын зах зээл, 2017-2022 /тэрбум \$/.....	4
График 7.8 Олон улсын ногоон бондын зах зээл, 2017-2022 /тэрбум \$/.....	4
График 9.9. Ногоон бондын зарцуулалт /2017он, 2022 он/.....	4
График 9.10 Монголын Хөрөнгийн биржээр арилжаалсан үнэт цаасны арилжаа болон ЗГДҮЦ-ны арилжаа.	4
График 10.10. Барих-шилжүүлэх төрлийн концессын үлдэгдэл, гэрээний тоо /2023.06.30/	4
График 12. Улсын нийт гадаад өрийн статистик 2018-2023.11 /тэрбум \$/	4
График. Улсын нийт гадаад өр, зээлдүүлэгчээр, тэрбум ам.доллар, хувнар /2023.06.30/	4
График 10.1. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого /2021-2024 он/, /их наяд ₮/	4
График 10.2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /2022-2025 он/, ДНБ-д эзлэх хувь	4
График 10.3. Засгийн газрын өр /2021-2024 он/	4

БҮЛЭГ 1. ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Эднийн засгийн өсөлт, салбаруудын хувь нэмэр (хувь).....	1
Хүснэгт 2. Ажилгүйдлийн түвшин, насны бүлгээр (хувь).....	5
Хүснэгт 3. Төсвийн үзүүлэлтүүд (тэрбум төгрөг).....	15

БҮЛЭГ 2. ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1 Нэгдсэн төсвийн 2023 оны эхний 8 сарын гүйцэтгэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулсан харьцуулалт / тэрбум ₮/.....	28
Хүснэгт 1.2 Нэгдсэн төсвийн орлогын 2023 оны 8 дугаар сарын гүйцэтгэл /тэрбум ₮/	29
Хүснэгт 1.3 Улсын төсвийн урсгал зарлагын 2023 оны 8 дугаар сарын гүйцэтгэл /тэрбум ₮/	30
Хүснэгт 1.4 Төсвийн хөрөнгө оруулалт 2017-2023 онуудад /тэрбум ₮/	30
Хүснэгт 1.5 Гадаадын зээл, тусламжийн 2023 оны санхүүжилтийн гүйцэтгэл /тэрбум ₮/.....	30
Хүснэгт 4.1. 2024-2029 онд ААНОАТ, ХХОАТ-аас хөнгөлөх орлого, хувь хэмжээ.....	45
Хүснэгт 4.2. 2024 оны нэгдсэн төсвийн нийт орлого /тэрбум ₮/.....	50
Хүснэгт 4.3. Уул уурхайн салбараас орох орлогын төлөвлөгөө /тэрбум ₮/	52
Хүснэгт 4.4. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээ /тэрбум ₮/.....	57
Хүснэгт 5.1. Засгийн газрын тусгай сангийн зардлын төсөл /тэрбум ₮/	66
Хүснэгт 6.3. Төсвийн хөрөнгө оруулалт 2017-2023 онуудад /тэрбум ₮/	71
Хүснэгт 7.1 Гадаадын зээл, тусламжийн 2024 оны төлөвлөгөө, хөгжлийн түншээр (тэрбум. ₮)	86
Хүснэгт 9.1 Засгийн газрын өрийн бүтэц /тэрбум ₮/.....	90
Хүснэгт 9.2. Зээлжих зэрэглэлийн шатлал.....	95
Хүснэгт 9.3 Гадаад үнэт цаас, 2023.06.30 /тэрбум ₮/.....	103
Хүснэгт 9.4. Монгол улсын секторын өрийн статистик 2022 он.....	4
Хүснэгт 10.1 Нэгдсэн төсвийн 2021-2023 оны үзүүлэлтүүд /тэрбум ₮/	4

БҮЛЭГ 2. ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 6.1. Төсвийн хөрөнгө оруулалтын шинэчлэл	72
Зураг 6.2. Төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны үе шат	73
Зураг 6.3. Төсвийн хөрөнгө оруулалтын цахим систем.....	73
Зураг 6.4. Төсвийн хөрөнгө оруулалтын цахимжуулалтын үр дүн	74
Зураг 6.5. Шинэ төслийн санал ирүүлсэн хөрөнгө оруулалтын төрлийн тоо	75
Зураг 6.6. “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын үнэлгээ- PIMA	76
Зураг 6.7. Ажиглагдсан ахиц дэвшил	76
Зураг 6.8. Төслийг үнэлэх болон сонгох үе шат.....	77
Зураг 6.9. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслийн төлөвлөлтийн шалгуур үзүүлэлт	77


I

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ГҮЙЦЭТГЭЛ

1.1 Макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал

Дотоодын нийт бүтээгдэхүүн

График 1. ДНБ-ий өсөлтийн бүтэц, улирлаар



Эх сурвалж 1. Үндэсний статистикийн хороо

Нэрлэсэн ДНБ 2023 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 30.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 30.6 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ 13.6 их наяд төгрөг болж, өмнөх оноос 6.4 хувиар тус тус өслөө¹.

Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйгаас

бусад салбарууд эерэг нөлөө үзүүллээ. Тухайлбал, уул уурхайн салбар 45.2 хувиар, бөөний болон жижиглэн худалдааны салбар 6.6 хувиар, үйлчилгээний салбар 7.4 хувиар, тэр дундаа тээврийн салбар 74.0 хувиар тэлсэн нь эдийн засгийн нийт өсөлтийг дэмжсэн.

Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлт, салбаруудын хувь нэмэр (хувь)

Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023 I-VI
Эдийн засгийн өсөлт	5.6	-4.6	1.6	5.0	6.4
Хөдөө аж ахуй	0.7	0.8	-0.8	1.7	-1.7
Үйлдвэрлэл	0.9	-1.3	-0.6	-1.2	4.2
Уул уурхай	-0.3	-1.4	0.1	-2.1	4.0
Боловсруулах	0.3	0.3	-0.1	0.5	0.1
Цахилгаан	0.1	0.04	0.2	0.1	0.1
Барилга	0.7	-0.1	-0.9	0.2	0.0
Үйлчилгээ	2.9	-3.0	1.8	3.2	3.5
Худалдаа	1.2	-1.4	0.6	1.1	0.7
Тээвэр	0.5	-0.9	-0.3	0.4	1.8
Бусад	1.3	-0.7	1.5	1.7	0.9
Цэвэр татвар	1.0	-1.1	1.3	1.4	0.4

Эх Сурвалж 2. Үндэсний статистикийн хороо

Харин хөдөө аж ахуйн салбар 2023 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.9 хувиар буурсан бөгөөд үүнд, тухайн

¹ УСХ-ноос ДНБ-ий гүйцэтгэлийг улирал бүр олон нийтэд зарладаг. ДНБ-ийг сар бүр тооцож бодлогын шийдвэрт дэмжлэг үзүүлэх зорилгоор УСХ-ноос туршилтын тооцоо хийж байна. Уг туршилтын тооцоогоор эдийн засаг 2023 оны эхний 7 сарын байдалаар өмнөх оны мөн үетэй 6.3 хувиар өссөн байна.

салбарын 92 хувийг бүрдүүлдэг мал аж ахуйн салбар голлон нөлөөллөө. Тодруулбал, улсын нийт мал сүргийн 59 хувийг бүрдүүлдэг Архангай, Баян-өлгий, Говь-алтай, Завхан, Төв, Баянхонгор, Дундговь, Ховд, Өмнөговь, Өвөрхангай, Увс аймагт 2022 онд зуншлага тааруу, гантай байснаас өвөлжилт хүндэрсэн. Үүний улмаас 2023 оны эхний хагас жилд улсын хэмжээнд нийт 3.9 сая толгой мал хорогдсон. Энэ нь 2009 оноос хойших хамгийн өндөр хорогдол болж байна. Харин газар тариалангийн салбарт улсын хэмжээнд нийт 598 мянган га буюу өмнөх оноос 4 хувиар их талбайд тариалалт хийсэн байна.

Уул уурхай, тээврийн салбарууд 2023 оны эхний хагаст эдийн засгийн нийт өсөлтийн дийлэнх хувийг² бүрдүүлэв. Гадаад валютын албан нөөц, экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолын хэрэгжилтийн үр дүнд нүүрсний олборлолт, экспорт нэмэгдсэн. Тухайлбал, нүүрсний олборлолт 2023 оны эхний хагаст 34.3 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 23.8 сая тонноор буюу 3.3 дахин, цар тахлын өмнөх үе буюу 2019 оны мөн үеэс 6.4 сая тонн буюу 23 хувиар нэмэгдсэн нь уул уурхайн салбарын өсөлтөд голлон нөлөөллөө. Мөн зэсийн баяжмалын үйлдвэрлэл эхний хагаст 705 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 27 хувиар өслөө. Үүнд Оюутолгойн гүний уурхайн олборлолт энэ оны 3 дугаар сард эхэлсэн болон дэлхийн зах зээл дээр зэсийн эрэлт өндөр байгаа зэрэг хүчин зүйлс нөлөөлжээ.

Газрын тосны хувьд өмнөх оны эхний хагаст хилийн боомтын үйл ажиллагааны хязгаарлалтаас³ үүдэн экспорт болон олборлолтын үйл ажиллагаа зогссон байсан. Харин хилийн боомтын үйл ажиллагаа эргэж сэргэсэнээр газрын тосны олборлолт 2023 оны эхний хагас жилд 2.5 сая баррельд хүрлээ. Гэсэн хэдий ч цар тахлын өмнөх түвшинд хараахан хүрээгүй байна⁴. Харин алт олборлолт 6.5 тоннд, төмрийн хүдрийн олборлолт 3.1 сая тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс тус тус 15 болон 44 хувиар буурсан бөгөөд 2019 оны түвшинд хүрээгүй хэвээр байна.

Түүнчлэн, нүүрсний экспорт болон уул уурхайн салбарын сэргэлтийн нөлөөгөөр авто зам, төмөр замын ачаа эргэлт сайжирч, тээврийн салбарын өсөлт сэргэв. Мөн уул уурхайн салбарын өсөлтийг даган ачааны тээврийн хэрэгсэл, суудлын автомашин болон жижиглэн худалдааны борлуулалт нэмэгдсэн худалдааны салбарт эергээр нөлөөлөв.

Барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбар 2023 оны эхний хагаст өмнөх оны мөн үеэс тус бүр 1.6 хувиар өслөө. Боловсруулах салбарын өсөлтөд мах боловсруулах үйлдвэрлэл нэмэгдсэн нь голлон

² 2023 оны эхний хагас жилд 6.4 хувийн эдийн засгийн өсөлтийн 5.8 нэгж хувийг уул уурхай болон тээврийн салбар бүрдүүлсэн.

³ Бичигт, Баянхошуу хилийн боомт 2021 оны 12 дугаар сараас 2022 оны 6 дугаар сарын хооронд хаалттай байсан.

⁴ 2019 оны эхний хагас жилд 3.4 сая баррель газрын тос, 5.5 тонн алт, 5.3 сая тонн төмрийн хүдэр олборлосон.

нөлөөлсөн. Тухайлбал, 2023 оны эхний хагас жилд 5.8 мянган тонн адууны мах, 7.7 мянган тонн үхэр, хонь, ямааны мах боловсруулснаар мах боловсруулах, консервлох үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 153 хувиар өссөн байна.

Нийт эрэлт талаас өрхийн хэрэглээ 2.7 хувиар, төрийн байгууллагын хэрэглээ 18.9 хувиар нэмэгдлээ. 2023 онд инфляц буурч, нэрлэсэн цалин өссөнөөр өрхийн бодит орлого 2023 оны 2 дугаар улиралд өнгөрсөн оны мөн үеэс 1.5 хувиар өссөн нь нийт эрэлтэд эерэг нөлөө үзүүлж байна. Мөн хилийн боомт орчмын зохион байгуулалт сайжирснаар гадаад эрэлт сэргэж, экспорт өссөн нь нийт эрэлтийг дэмжлээ. Харин хөдөө аж ахуйн салбарын гарц буурсантай холбоотойгоор мал аж ахуйгаас орох өрхүүдийн бодит орлого 36.1 хувиар буурсан. Энэ нь хөдөөгийн өрхүүдийн хэрэглээг хязгаарлаж байна.

Инфляц

Улсын жилийн инфляц 2023 оны 8 дугаар сард 10.0 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 4.4 нэгж хувиар буурсан бол өмнөх сараас 0.8 нэгж хувиар өсөв. Импортын инфляцын нийт инфляцад үзүүлэх нөлөө 2023 оны эхнээс алгуур буурч байна. Тухайлбал, 2022 онд нийт инфляцын бүрэлдэхүүн дэх импортын барааны инфляцын эзлэх хувь нь 52.0 хувь байсан бол 2023 оны 8 дугаар сард 35.0 хувь болж буурчээ. Импортын барааны инфляц буурахад гадаад валютын албан нөөц өсөж, төгрөгийн ханшийн тогтворжсон нь голлон нөлөөлжээ. Мөн гадаад зах зээлд хүнсний үнэ буурсан, дэлхий нийтээр чингэлэг тээврийн үнэ нь цар тахлын өмнөх түвшинд хүрч буурсан зэрэг нь инфляц буурах чухал нөлөөг үзүүлсэн байна.

Дотоодын хүнсний үнэ 2023 оны 8 дугаар сарын байдлаар 16.4 хувиар өсөж, инфляцын ойролцоогоор 1/2 хэсгийг бүрдүүлж байна. Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2023 оны 4-6 дугаар саруудад эрчимтэй өсөж байсан бол сүүлийн хоёр сард буурч 8 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 13.8 хувь өсжээ. Гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ түүхий эд, үйлдвэрлэлийн зардал өссөнтэй холбоотойгоор өмнөх оны мөн үеэс 49.6 хувийн өсөлттэй байна.

График 2. Жилийн инфляц ба зорилгот түвшин (хувь)



Эх сурвалж 3. Үндэсний статистикийн хороо

Мөн үйлчилгээний үнэ өссөн нь инфляцыг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн. Тухайлбал, 2023 оны 8 дугаар сард боловсролын үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 16.8 хувиар өсжээ.

Мөнгөний нийлүүлэлт


График 3. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт, пассив тал (хувь)



Эх сурвалж 4. Монголбанк

оны мөн үеэс 17.2 хувиар өсөж, нийт өсөлтийн 2/3 хэсгийг бүрдүүлжээ.

График 4. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт, актив тал (хувь)



Эх сурвалж 5. Монголбанк

Тэмдэглэл: ЗГЦЗ- Засгийн газрын цэвэр зээл, ГЦА-Гадаад цэвэр актив


Мөнгөний нийлүүлэлт 2023 оны 7 дугаар сарын байдлаар 32.0 их наяд төгрөгт хүрч, оны эхнээс 7.7 хувиар, өмнөх оны мөн үеэс 18.5 хувиар тус тус өсжээ.

Мөнгөний нийлүүлэлт өсөхөд эх үүсвэр талаас (пассив) төгрөгийн харилцах, хадгаламж нийлбэр дүнгээрээ өмнөх

Харин байршуулалт талаас (актив) экспорт сэргэсэнтэй холбоотойгоор гадаад валютын албан нөөц нэмэгдсэн болон зээл олголт өссөн нь мөнгөний нийлүүлэлт нэмэгдэхэд голлох нөлөөг үзүүлэв.

Ажил эрхлэлт, ажилгүйдэл

График 5. Ажиллах хүч (мян.хүн), ажиллах хүчний оролцооны түвшин (хувь)



Эх сурвалж 6. Үндэсний статистикийн хороо

Эдийн засгийн салбаруудын үйл ажиллагаа сэргэж байгаа хэдий ч хөдөлмөрийн зах зээл цар тахлын өмнөх түвшиндээ хүрээгүй хэвээр байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар ажиллах хүчний оролцооны түвшин 57.9 хувь болж, өмнөх оны мөн үеэс 1.5 нэгж хувиар, цар тахлын

өмнөх үеэс 3.1 нэгж хувиар бага байна. Мөн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 54.5 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.2 нэгж хувиар, цар тахлын өмнөх үеэс 1.9 нэгж хувиар тус тус бага байна.

Ажиллагсдын тоо 2023 оны 2 дугаар улирлын байдлаар 1 сая 160 мянга болж, өмнөх оны мөн үеэс 5 мянган хүнээр буурчээ. Салбараар харвал уул уурхай, хөдөө аж ахуй, цахилгаан, худалдаа, үйлчилгээний салбарын ажилчдын тоо өссөн бол боловсруулах, барилга, тээврийн салбарын ажилчдын тоо буурсан нь сөргөөр нөлөөлсөн байна.

Ажилгүй иргэдийн⁵ тоо цар тахлын өмнөх үеэс 60 мянган хүнээр, өмнөх оны мөн үеэс 28 мянган хүнээр буурч, 71 мянгад хүрлээ. Насны бүлгээр авч үзвэл 25-45 нас буюу хөдөлмөрийн идэвхтэй насны хүн амын ажилгүйдэл бусад насны бүлгүүдтэй харьцуулахад илүү буюу 19 мянган хүнээр буурсан байна.

Хүснэгт 2. Ажилгүйдлийн түвшин, насны бүлгээр (хувь)

Насны бүлэг	2021	2022	2023
	II улирал	II улирал	II улирал
Улсын дүн	8.4	7.8	5.8
Эрэгтэй	8.2	8.5	6.6
Эмэгтэй	8.6	7.0	4.7
15-24 нас	17.1	12.2	14.7
Эрэгтэй	14.5	10.2	15.6
Эмэгтэй	22.1	15.2	12.7
25-54 нас	8.3	7.8	5.2
Эрэгтэй	8.1	8.9	5.7
Эмэгтэй	8.6	6.6	4.6
55+ нас	1.4	4.1	2.9
Эрэгтэй	2.5	4.5	4.0
Эмэгтэй	0.0	3.5	1.7

Эх сурвалж 7. Үндэсний статистикийн хороо

Харин 15-24 насны буюу залуусын ажилгүйдэл 2023 оны 2 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 2.5 нэгж хувиар өсөж 14.7 хувьд хүрсэн нь бусад насны бүлгүүдтэй харьцуулахад хамгийн өндөр байна. Энэ нь залууст хөдөлмөр эрхлэх сонирхол байгаа хэдий ч тохирох ажлын байр хомс, ур чадвар нь ажил олгогчийн шаардлагад нийцэхгүй байгаатай холбоотой байна.

⁵ Ажилгүй хүн гэж сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүн юм. (Үндэсний статистикийн хорооны Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал)

Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцэл ашигтай гарч, гадаад валютын албан нөөц тогтвортой байна. Урсгал данс 2023 оны эхний 7 сард 538 сая ам.долларын, санхүүгийн данс 90 сая ам.долларын, нийт төлбөрийн тэнцэл 452 сая ам.долларын тус тус ашигтай гарлаа. Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолын хэрэгжилтийн үр дүнд экспортын орлого нэмэгдсэнээр 2023 оны эхний хагас жилд урсгал данс 385 сая ам.долларын ашигтай гарсан нь 1998 оноос хойших түүхэн дэх эхний хагас жилийн хамгийн өндөр ашиг байв.

Төлбөрийн тэнцэл сайжирснаар гадаад валютын албан нөөц 2023 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 3.9 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 1.2 тэрбум ам.доллароор нэмэгдлээ. Төгрөгийн ам.доллартой харьцах ханш өнгөрсөн оны 8 дугаар сарын эцэст оны эхнээс 351 төгрөгөөр сулраад байсан бол 2023 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 3,473 болж, оны эхнээс 26 төгрөгөөр суларсан байна.

Гадаад худалдаа

График 6. Төлбөрийн тэнцэл (сая ам.доллар)



Эх сурвалж 8. Үндэсний статистикийн хороо

График 7. ГВАН (сая ам.доллар)



Эх сурвалж 9. Монголбанк, тооцоолол

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2023 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 15.9 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 19.4 хувиар өссөн бол гадаад худалдааны тэнцэл 4.1 тэрбум ам.долларын ашигтай гарлаа. Экспорт 10.0 тэрбум ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 29.2 хувиар өсөв.

График 8. Гадаад худалдааны нийт бараа эргэлт (тэрбум ам.доллар)



Эх сурвалж 10. Газрын ерөнхий газар

Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолын хүрээнд хилийн боомтоор ашигт малтмал тээвэрлэх, экспортлох үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулсан, төрийн өмчит хуулийн этгээдүүдэд онцгой дэглэм тогтоож, компанийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтыг сайжруулсан болон Гашуунсухайт, Шивээхүрэн хилийн боомтуудад AGV (автомат удирдлагатай тээврийн хэрэгсэл) нэвтэрсэн зэрэг хүчин зүйлсийн үр дүнд нүүрсний экспортын биет хэмжээ 2023 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 46.7 сая тоннд хүрлээ.

Түүнчлэн, өнгөрсөн оны мөн үед хилийн боомтын үйл ажиллагаа хаагдсантай холбоотой⁶ тасалдаад байсан газрын тосны экспорт 2023 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 3.2 сая баррельд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 3.4 дахин, гадаад эрэлтээс шалтгаалан удаашраад байсан жоншны экспорт 624 мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 3.1 дахин тус тус нэмэгдээд байна. Мөн Засгийн газраас махны экспортын хоригийг цуцалсан нь нийт экспортын орлогын өсөлтийг дэмжлээ.

Харин зэсийн баяжмал, алтны экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс буурлаа. Оюу толгойн далд уурхай ашиглалтад орсонтой холбоотойгоор зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ 2023 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 1,022 мянган тоннд хүрч өнгөрсөн оны мөн үеэс 5 хувиар өссөн хэдий ч зэсийн баяжмал дахь алтны агууламж багассанаас гадна цэвэр зэсийн үнэ өнгөрсөн оны эцсээс 5 хувиар буурсан нь зэсийн баяжмалын экспортын орлого буурахад нөлөөлөв. Алтны экспортын биет хэмжээ 2023 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 6.8 тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 32 хувиар буурахад олборлолт багассан нь нөлөөлөв.

2023 оны эхний 8 сард импортоор 5.9 тэрбум ам.долларын бараа бүтээгдэхүүн худалдан авсан нь өмнөх оноос 6.2 хувь буюу 1.1 тэрбум ам.доллаароор өссөн байна.



⁶ Бичигт, Баянхошуу хилийн боомт 2021 оны 12 дугаар сараас 2022 оны 6 дугаар сар хүртэл хаалттай байсан



График 9. Импортын өөрчлөлт (сая)

Эх сурвалж 11. Гаалийн ерөнхий газар, тооцоолол

График 10. Импорт, хэрэглээний зориулалтаар, (тэрбум ам.доллар)



Өнгөрсөн онд импортын

өсөлтийн дийлэнх буюу 84.0 хувийг нь импортын барааны үнийн өсөлт бүрдүүлж байсан бол энэ онд импортын өсөлтийн 87.0 хувь нь тоо хэмжээний өсөлт байна. Энэ нь худалдааны түнш орнуудын инфляц буурч, тээврийн зохицуулалт сайжирсан зэрэгтэй холбоотой.

Импортын өсөлтөд хөрөнгө оруулалтын зориулалттай бүтээгдэхүүний импорт өмнөх оны мөн үеэс 16.1 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай тоног

Эх сурвалж 12. Гаалийн ерөнхий газар

төхөөрөмжийг импортын татвараас чөлөөлснөөр хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийн импорт 152.4 сая ам доллар болж 47.7 хувь өслөө. Түүнчлэн нийт тоног төхөөрөмжийн импорт 1.0 тэрбум ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 37.8 хувиар нэмэгдэж, цаашид боловсруулах үйлдвэрлэлийн салбарыг дэмжихээр байна.

Мөн тээврийн зориулалттай ачааны машин болон дизель түлшний импорт нэмэгдэж байна. Эдгээр төрлийн импорт нэмэгдэж байгаа нь уурхай, тээврийн салбарын үйл ажиллагаа сэргэж байгаатай холбоотой.

Харин 2,500-3,500 цилиндрийн багтаамжтай жижиг болон дунд оврын 45.1 мянган автомашин импортолж өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар, хүнсний бүтээгдэхүүний импорт 592.8 сая ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 17.1 хувиар тус тус буурчээ. Эдгээр төрлийн импорт буурсан нь өрхийн бодит орлогын өсөлт хангалттай биш байгаатай холбоотой байж болзошгүй.

Шигтгээ 1. Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоол

Экспортын бодит мөнгөн орлого буурсантай холбоотойгоор 2022 оны 8 дугаар сарын эцэст төлбөрийн тэнцлийн алдагдал 1.5 тэрбум ам.долларт хүрч, төгрөгийн ам.доллартой харьцах ханш оны эхнээс 351 төгрөгөөр сулраад байв. Монгол Улсын Засгийн газраас экспортын орлогыг нэмэгдүүлэх, экспортын ил тод байдлыг сайжруулах хүрээнд “Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 5-ны өдөр баталсан.

Тус тогтоолд гааль, татварын автомат бүрдүүлэлтийн систем бий болгох, ашигт малтмалын борлуулалт, хөрөнгө оруулалт, худалдан авалттай холбоотой ил тод байдлыг хангах, уул уурхайн биржийн тогтолцоог нэвтрүүлэх, ашигт малтмалыг хилийн үнээр худалдан борлуулах, экспорт, тээвэрлэлтийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, байнгын ачаа тээврийн хил нэвтрэх С төрлийн зорчих зөвшөөрлийг олгох эрхийг олборлолтын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжүүдэд шилжүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасан. Тогтоолын хэрэгжилтийн хүрээнд:


- **Гааль, татварын автомат бүрдүүлэлтийн систем ашиглалтад оров.** Бүх төрлийн ашигт малтмалын экспорт уг системээр дамжин хийгдэж байгаа ба 2023 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар уг системд нийт 204 аж ахуйн нэгжийн 2,025 ашигт малтмалын экспортын гэрээ хүчин төгөлдөр үргэлжилж байна. Мөн тус системд тээврийн гэрээ бүртгэх ажлыг 2023 оны 6 дугаар сард эхлүүлээд байна.
- **Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаагаа эхлүүлэв.** Уул уурхайн бүтээгдэхүүний тухай хууль 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр батлагдаж, 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хэрэгжиж эхлэв. Ашигт малтмалыг нээлттэй борлуулах хүрээнд 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн байдлаар нийт 5.0 сая тонн нүүрсийг нээлттэй арилжаалсан бөгөөд үүнээс 3.1 сая тонн нүүрсийг цахим арилжаагаар, 1.9 сая тонн нүүрсийг уул уурхайн бүтээгдэхүүний биржээр тус тус арилжаалаад байна.
- **Нууцад хамаарах гэрээнүүдийг ил болгов.** Ашигт малтмалын борлуулалт, хөрөнгө оруулалт, худалдан авалттай холбоотой ил тод байдлыг хангах хүрээнд Засгийн газрын 2022 оны 449 дүгээр тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-тай холбоотой нууцад хамаарах гэрээний мэдээллийг нууцаас

гаргаж, ил тод болголоо. Мөн борлуулалт, хөрс хуулалт, олборлолтын гэрээний мэдээллийг олон нийтэд нээлттэй болгоод байна.

- “С” төрлийн зөвшөөрлийг олгох эрхийг олборлогч аж ахуйн нэгжүүдэд шилжүүлэв. Тээвэрлэлт, экспортын үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах хүрээнд “Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ-аас байнгын ачаа тээврийн хил нэвтрэх “С” төрлийн зөвшөөрлийг олгох эрхийг Гашуунсухайт, Шивээхүрэн, Ханги, Булган, Бургастай боомтуудад олборлогч аж ахуй нэгжүүдэд шилжүүлээд байна.
- Экспортлогч компаниуд шинээр “уурхайн ам” нөхцөлөөр гэрээ байгуулахыг зогсоож “хилийн үнэ” нөхцөлөөр гэрээ байгуулах шийдвэр гаргав. Энэхүү бодлогын үр дүнд Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн дотоодын тээврийн компаниуд үйлчилгээг гүйцэтгэж, өмнө нь тээврийн үйлчилгээний зардалд төлөгддөг байсан валютын гарах урсгалыг бууруулах нөхцөл бүрдэв.


Улмаар гадаад валютын албан нөөц 2023 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 3.9 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.2 тэрбум ам.доллороор буюу 46 хувиар нэмэгдэж, инфляцын түвшин, төгрөгийн ханш сулрах дарамт буурахад эергээр нөлөөллөө.

График 11. Инфляц (хувь)



Эх сурвалж 13. Үндэсний статистикийн хороо

График 12. Албан хани (төгрөг/ам.доллар)



Эх сурвалж 15. Монголбанк

График 13. ГВАН (сая.ам.доллар)



Эх сурвалж 14. Монголбанк

1.2 Макро эдийн засгийн 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэл

Дотоодын нийт бүтээгдэхүүн


Эдийн засгийн өсөлт 2023 оны жилийн эцэст 6.0 хувьд хүрэхээр төсөөлж байна. Уул уурхайн бүтээгдэхүүний гадаад эрэлт өндөр, экспорт тогтвортой нэмэгдэж, 2023 оны сүүлийн хагаст уул уурхайн салбар (нүүрс олборлолт, зэсийн баяжмалын үйлдвэрлэл) эдийн засгийн өсөлтийг голлон дэмжсэн хэвээр байна. Уул уурхайн салбарын идэвхжилийг дагаад тээвэр болон худалдааны салбарын үйл ажиллагаа сэргэж байна. Мөн Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалт болон Шинэ сэргэлтийн бодлогод туссан төмөр зам, авто зам, боомтын бүтээн байгуулалтууд, Амгалан дулааны станцын өргөтгөл зэрэг нийт 9 төсөл, арга хэмжээ 2023 онд хэрэгжиж дуусахаар байгаа нь барилгын салбарын үйлдвэрлэлд эергээр нөлөөлнө.

Хүнс, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг импортын тарифаас чөлөөлсөн нь оны сүүлийн хагас болон ирэх жилүүдэд боловсруулах салбарын үйлдвэрлэлийг дэмжинэ. Харин оны эхэнд өвөлжилт хүндэрч, том малын зүй бус хорогдол өндөр байсантай холбоотойгоор хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл 2023 онд өмнөх оноос бага хэвээр байна. Ургацын урьдчилсан балансаар өнгөрсөн онтой харьцуулахад улаан буудай 17 хувиар, хүнсний ногоо 18 хувиар, ногоон тэжээл 42 хувиар өсөх төлөвтэй байна.

Шигтгээ 2. Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж


Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж үндсэн хөрөнгийн хуримтлалыг нэмэгдүүлж байна. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 107 дугаар тогтоолоор хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах зориулалттай, тухайн үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх нийт 427 нэр төрлийн машин, тоног төхөөрөмжийг импортын барааны гаалийн албан татвараас чөлөөлөхөөр шийдвэрлэсэн. Үүний үр дүнд 2023 оны эхний хагаст хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийн импорт 116 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 61 хувиар өссөн байна.

График 14. Тоног төхөөрөмжийн импорт
(сая.ам.доллар)



Эх сурвалж 16. Гаалийн ерөнхий газар

График 15. Хүнсний үйлдвэрлэл (тэрбум)



Эх сурвалж 17. Үндэсний статистикийн хороо

Түүнчлэн хүнсний үйлдвэрлэл оны эхний хагаст 954 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 54 хувиар нэмэгдэн, хүн амын хүнсний хангамжийг сайжруулсан эерэг өөрчлөлт гарлаа. Нөгөөтгээгүүр машин тоног, төхөөрөмжийн хуримтлал 11.5 хувиар нэмэгдэн, нийт үндсэн хөрөнгийн хуримтлалыг 8.6 хувиар өсгөсөн нь эдийн засгийн урт хугацааны өсөлтийг дэмжих эерэг нөлөөг үзүүлнэ.

Засгийн газраас 2023-2025 оныг “Монгол зочлох жил” болгож, аялал жуулчлалыг дэмжих арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Улмаар аялал жуулчлалын салбар 2023 онд цар тахлын өмнөх түвшинд хүрч, эдийн засгийн эрэлт, үйлчилгээний салбарын үйл ажиллагааг дэмжинэ.

Төрийн албан хаагчдын цалин, өндөр настны тэтгэвэр 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс нэмэгдсэнээр оны сүүлийн хагаст өрхийн хэрэглээ нэмэгдэж, эдийн засгийн дотоод эрэлтэд эерэг нөлөө үзүүлнэ. Түүнчлэн экспортын түүхий эдүүдийн гадаад эрэлтийн төлөв сайн байснаар төсвийн орлого сайжирч, төсвийн орон зай нэмэгдэх, цаашлаад нийт эрэлтийг дэмжих төлөвтэй байна.

Гадаад худалдаа

2023 онд экспорт 13.1 тэрбум ам.доллар, импорт 9.5 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдаа 3.6 тэрбум ам.долларын ашигтай гарах төлөвтэй байна.

Гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолын хүрээнд Гашуунсухайт, Замын-Үүд, Шивээхүрэн хилийн боомтуудад ухаалаг гарц болон нүүрсний шинжилгээний лаборатори, рентгений тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулж, уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулан, биржээр арилжсан нүүрсийг хил нэвтрүүлэх тусгай гарц, горимыг бий болгож, уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Түүнчлэн, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор оны сүүлийн саруудад тус биржээр арилжаалагдах нүүрсний хэмжээ болон биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдэж экспортын орлогыг дэмжинэ.

ОУВС-гийн 2023 оны 4 дүгээр сард нийтэлсэн “Дэлхийн эдийн засгийн төлөв” тайланд 2023 онд олон улсад бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт саарах төлөвтэй байгаа ч хүнс, шатахууны үнийн өсөлтөөс шалтгаалан оны сүүлийн саруудад манай улсын импортын барааны үнийн өсөлт нэмэгдэх эрсдэлтэй байна. Эдийн засгийн идэвхжил, тэр дундаа боловсруулах, уул уурхай, тээврийн салбарын өсөлтийг дагаж машин, тоног төхөөрөмж, нефтийн бүтээгдэхүүний импорт нэмэгдэхээр байна.

Төлбөрийн тэнцэл

Энэ оны сүүлийн хагаст Монгол Улсын Хөгжлийн банкны бондуудын төлбөр төлөгдөх хуваарьтай байна. Засгийн газраас гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх чиглэлд авч хэрэгжүүлж буй бусад арга хэмжээний үр дүнд 2023 онд төлбөрийн тэнцэл ашигтай гарч, гадаад валютын албан нөөц 4 тэрбум ам.долларыг давахаар хүлээгдэж байна.

Инфляц

Улсын инфляц 2023 оны 8 дугаар сард 10.0 хувьтай гарсан бол 2023 оны эцэст нэг оронтой тоонд хүрэх төлөвтэй байна. Инфляцыг бууруулахад Засгийн газрын зүгээс гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлж, ханшийн зах зээлийг тогтворжуулах, мөн мах, хүнсний ногоо, эм зэрэг голлох бүтээгдэхүүнүүдийн нийлүүлэлтийн сүлжээг сайжруулахад анхаарч ажиллаж байна.

Хүснэгт 3. Төсвийн үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2021		2022		2023	
	Эхний 8 сар	II хагас	Эхний 8 сар	II хагас	I хагас	Эхний 8 сар
Нийт орлого	9,793	7,149	10,956	10,592	11,059	15,248
Нийт зарлага	9,547	8,100	10,928	9,986	9,034	12,791
Нийт тэнцэл	246	-951	29	606	2,026	2,458
Хүүгийн төлбөр	473	408	492	401	514	819
Үндсэн тэнцэл	718	-543	521	1,007	2,539	3,277

Эх сурвалж 18. Сангийн яам


II

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2024 ОНЫ ЧИГ ХАНДЛАГА, ТӨСӨӨЛӨЛ

2.1 Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал

Үнийн өсөлт, томоохон улсуудын авч хэрэгжүүлж буй мөнгөний хатуу бодлого, геополитикийн хямралт байдлын нөлөөгөөр 2023 болон 2024 онд дэлхийн эдийн засгийн өсөлт түүхэн дунджаас бага⁷ буюу 3.0 орчимд хувьд байна гэж Олон Улсын Валютын Сан (ОУВС) тооцоолж байна. Сүүлийн саруудад эрчим хүч, хүнсний үнийн индекс буурч, нийлүүлэлтийн сүлжээний доголдол буурснаар дэлхийн ихэнх улсуудад инфляцын түвшин буурах хандлагатай байна. Гэхдээ инфляцыг онилох мөнгөний бодлоготой нийт улсуудын 89 хувьд нь 2024 оны инфляц зорилтот түвшнээсээ өндөр хэвээр байх төлөвтэй байна. Өөрөөр хэлбэл, цаашид олон улс оронд мөнгөний бодлого нь хатуу хэвээр үргэлжлэхээр байна.

График 16. Дэлхийн эдийн засгийн өсөлтийн тосгоолал (хувь) /2023 оны 9 дүгээр сарын



Эх сурвалж 19. Дэлхийн эдийн засгийн төлөвийн тайлангууд, Блүүмберг терминал

Үнийн өсөлтийг хязгаарлах бодлогын нөлөөгөөр хөгжингүй орнуудын эдийн засгийн идэвхжил саарах ч хөгжиж буй орнуудын өсөлт сэргэж, дэлхийн нийтийн эдийн засгийн өсөлтийг дэмжихээр байна. Үнийн өсөлт удаан хугацаанд үргэлжлэх, БНХАУ-ын эдийн засгийн идэвхжил хүлээлтээс доогуур байх,

санхүүгийн салбарт тогтворгүй байдал үүсэх, геополитикийн зөрчилдөөн гүнзгийрэх зэрэг эрсдэлүүд дэлхийн эдийн засгийн өсөлтийг сааруулж болзошгүй байна.

БНХАУ

Тус улсын эдийн засаг 2023 оны эхний хагаст 5.5 хувиар өссөн ч үл хөдлөх салбарын хямрал үргэлжилж, экспорт, гадаад хөрөнгө оруулалт буурч, дотоод хэрэглээний өсөлт саарах хандлагатай байгаа нь дэлхийн зах зээлд худалдааны эргэлт, түүхий эдийн эрэлт, үнэ буурах эрсдэлийг нэмэгдүүлж байна. Эдийн засгийг идэвхжүүлэх зорилгоор тус улсын төв банкнаас бодлогын хүү болон банкнуудын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үл хөдлөх салбарыг дэмжих зорилгоор орон сууцны зээлийн хүүг бууруулах боломжийг бүрдүүлж, шинэ орон сууцны урьдчилгаа төлбөрийн хувь хэмжээг бууруулаад байна. Мөн аж үйлдвэрийн салбарыг дэмжихэд

⁷ 2010-2019 дундаж өсөлт 3.8 хувь, ОУВС-гийн тооцоолол

чиглэсэн нэмэлт бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар мэдэгдээд байна. Цаашид БНХАУ-ын засгийн газраас бодлогын дэмжлэгийн цар хүрээг хэрхэн тэлэх нь эдийн засгийн өсөлтийг тодорхойлох гол хүчин зүйл болж байна. ОУВС-гаас БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2023 онд засгийн газрын зорилтот түвшин буюу 5 хувийг давж 5.2 хувьд хүрэх бол 2024 онд 4.5 хувьд байна гэж тооцоолсон. Харин Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа ба Хөгжлийн Байгууллага (ЭЗХАХБ) БНХАУ-ын эдийн засгийг 2023 онд 5.4 хувиар, 2024 онд 5.1 тус тус хувиар өсөх төлөвийг зарлаад байна.

ОХУ

Сүүлийн 4 улирал дараалан агшсан ОХУ-ын эдийн засаг өнгөрсөн оны суурийн нөлөөгөөр 2023 оны 2 дугаар улиралд 4.9 хувиар өслөө. Гэсэн хэдий ч хурцадмал байдалтай холбоотой төсвийн зардлын өсөлт, экспортын орлогын бууралт, импортын өсөлтийн нөлөөгөөр рублийн ханш суларч, төв банк бодлогын хүүг 3.5 нэгж хувиар нэмэгдүүлж 12 хувьд хүргээд байна. Цаашид ОХУ-ын эдийн засагт тогтворгүй байдал үргэлжлэх төлөвтэй байна. ОУВС тус улсын эдийн засгийг 2023 онд 1.5 хувиар, 2024 онд 1.3 хувиар тус тус өснө гэж тооцоолж байна.

АНУ

АНУ-ын инфляц зорилтот түвшнээс өндөр хэвээр байна. Төв банк эдийн засгийн халалтыг намжаах зорилгоор мөнгөний хатуу бодлогыг үргэлжлүүлэх талаар зах зээлийн болгоомжлолоос үүдэн Засгийн газрын 10 жилийн хугацаатай үнэт цаасны өгөөж сүүлийн 15 жилийн хамгийн өндөр түвшинд хүрсэн тохиолдол гарлаа. Мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр АНУ-ын эдийн засгийн өсөлт 2023 онд 1.8 хувьд хүрч саарах бол 2024 онд хэрэглээний өсөлтийн эрчим буурснаар өсөлт 1.0 хувьд хүрнэ гэж ОУВС тооцоолж байна.

Евро бүс

Европын төв банк инфляцыг хязгаарлах зорилгоор бодлогын хүүг 10 удаа нэмэгдүүлж, түүхэн дээд түвшинд хүргээд байна. Цар тахлын дараах үйлчилгээний салбарын сэргэлт нь тус бүсийн эдийн засгийн өсөлтийг дэмжиж байгаа ч инфляцаас шалтгаалсан хэрэглээ, хөрөнгө оруулалтын бууралт үргэлжлэх төлөвтэй байна. Үнийн өсөлт, мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр тус бүсийн эдийн засгийн өсөлт 2023 онд 0.9 хувь, 2024 онд 1.5 хувь байх тооцооллыг ОУВС зарлаад байна.

Түүхий эдийн зах зээлийн хандлага

Зэс

Зэсийн үнэ 2023 оны эхний 8 сарын дунджаар 8,387 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 5 хувиар буурсан байна. Чили, Перу дэх уурхайнууд

усны нөөц болон ажил хаялтаас шалтгаалсан нийлүүлэлтийн тасалдал үргэлжилж байгаа ба сэргээгдэх эрчим хүч, цахилгаан автомашины үйлдвэрлэл нэмэгдэж буй шалтгаанаар зэсийн эрэлтийг нэмэгдүүлэх төлөвтэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар 2023 оны дундаж үнэ 8,600 ам.доллар, 2024 онд 9,000 ам долларт хүрэхээр байна.



Эх сурвалж 20. Блүүмберг терминал

Алт

Алтны үнэ 2022 оны эхний 8 сарын дундаар 1,918 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 6.0 хувиар өсөөд байна. Дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал нэмэгдэж, байнгын өндөр инфляцтай байгаа энэ орчинд алтны эрэлт нэмэгдэж байна. Алтны дундаж үнийг 2023 онд 1,935 ам.доллар, 2024 онд 1,950 ам.долларт байхаар тус тус тооцлоо.



Эх сурвалж 21. Блүүмберг терминал

Төмрийн хүдэр

Төмрийн хүдрийн 2023 оны эхний 8 сарын дундаж үнэ 109 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 10 хувиар буурсан байна. Африк, Австрали зэрэг улсууд шинэ уурхайн бүтээн байгуулалтын төслүүдийг эрчимжүүлж, Бразил улс нийлүүлэлтээ жил болгон 6 хувиар нэмэгдүүлэхээ зарлаад байна. Эрэлт талаас БНХАУ-ын аж үйлдвэрлэлийн салбарын сэргэлт удаашралтай байгаагаас шалтгаалан сул байхаар байна. Төмрийн хүдрийн дундаж үнийг 2023 онд 85 ам.доллар, 2024 онд 75 ам.доллар байхаар тооцлоо.




Эх сурвалж 22. Блүүмберг терминал

Коксжих
нүүрс

Австралийн сайн чанарын коксжих нүүрсний үнэ 2023 оны эхний 8 сарын дунджаар 252 ам.долларт хүрч, өмнөх оны эцсээс 31 хувиар буурсан байна. Байгалийн гамшгаас шалтгаалан саатаад байсан Австралийн нүүрсний олборлолт хэвийн болсон. Мөн, БНХАУ бүх төрлийн коксжих нүүрсний татварыг 2022 оны 5 дугаар сараас эхлэн 2023 оны 4 сар хүртэл чөлөөлснөөр нийлүүлэлт нэмэгдэж, коксжих нүүрсний нөөц 4 сар дараалан өсөж, 2018 оноос хойших дээд түвшинд хүрлээ.

График 20. Нүүрсний үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн)



Эх сурвалж 23. Блүмберг терминал

Газрын тос

Брент газрын тосны 2023 оны эхний 8 сарын дундаж үнэ 80 ам.долларт хүрч өмнөх оны эцсээс 19 хувиар буурлаа. ОПЕК-ийн орнууд 6 дугаар сард 2024 онд олборлох газрын тосны хэмжээг бууруулах шийдвэрээ зарласан. Улмаар газрын тосны үнэ 8 дугаар сард 85 ам.доллар болж өмнөх сараас 6 хувиар өсөөд байна. 2024 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн удаашрал, БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын хямралаас үүдэж эрэлт багасах төлөвтэй байна. Газрын тосны дундаж үнийг 2023 онд 78 ам.доллар, 2024 оны дундаж үнэ 83 ам.долларт хүрэхээр байна.

График 21. Газрын тосны үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/баррель)



Эх сурвалж 24. Блүмберг терминал

2.2 Макро эдийн засгийн 2024 оны төсөөлөл

Дотоодын нийт бүтээгдэхүүн

2024 онд эдийн засаг 7.0 хувиар өсөхөөр төсөөлж байна. Уул уурхайн бүтээгдэхүүнүүд, нүүрсний олборлолт, Оюутолгойн гүний уурхайн олборлолт эрчимжиж, зэсийн баяжмал дахь агууламж нэмэгдсэнээр уул уурхай, түүнээс хамааралтай тээврийн салбарын өсөлт эдийн засгийн өсөлтийн гуравны нэг орчмыг бүрдүүлнэ.

Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортын хоригийг цуцалж, нэвтрүүлэх зөвшөөрөлтэй боомтын тоог нэмэгдүүлж, татаасыг чөлөөлөх замаар хөдөө аж ахуйн салбар дах төрийн оролцоог шат дараатай бууруулна. Мөн хөдөө аж ахуйн зориулалттай тоног төхөөрөмжийн

гаалийн албан татварын хөнгөлөлтийг үргэлжлүүлэх, мал, амьтны гоц халдварт өвчнөөс сэргийлэх вакцинаар бүрэн хангах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Ингэснээр хөдөө аж ахуйн салбарын хөрөнгө оруулалт нэмэгдэж, бүтээмжийн өсөлтөөр дамжин салбарын үйлдвэрлэл нэмэгдэнэ. Мөн бэлтгэсэн хадлангийн хэмжээ нэмэгдсэн нь 2023 оны сүүлийн хагас болон 2024 онд мал аж ахуйн салбарын тогтвортой, бүтээмжтэй үйл ажиллагаанд эергээр нөлөөлнө.

“УБТЗ” ХНН-ийн дотоодын ачаа тээвэр, зорчигч тээврийн тарифыг 2023 онд нэмэгдүүлсэн. Энэ нь төмөр замын салбарын үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлж, салбарын үйлдвэрлэлийн суурь, бүтээмжийг зах зээлийн зарчмаар тэлэх нөлөөтэй. Жишээлбэл, тарифын өөрчлөлтийн дараа “УБТЗ” ХНН нь ачааны вагоны тоо хэмжээг нэмэгдүүлэх, хөдлөх бүрэлдэхүүний засварын төвийн өргөтгөлийн ажлуудыг 2024 оноос эхлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Эдгээр арга хэмжээний нөлөөгөөр тээврийн салбарын эдийн засаг дах суурь тэлж, үйлдвэрлэл нэмэгдэнэ.

“Шинэ сэргэлтийн бодлого” болон “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд туссан бодлогын чиглэл, зарчмыг баримталж, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж, үйлдвэржилтийн болон дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлснээр барилга, боловсруулах, худалдаа, үйлчилгээ зэрэг уул уурхайн бус салбарууд эдийн засгийн өсөлтийг дэмжинэ. Эдгээр үйлдвэржилт, дэд бүтцийн төслүүдийн хэрэгжилт эдийн засаг дахь үндсэн хөрөнгийн хуримтлалыг нэмэгдүүлэх бол өрхийн цалингийн орлого өссөнөөр дотоод эрэлтийн төлөв сайн байх хүлээлттэй байна.

Түүнчлэн Засгийн газрын 2023 оны 233 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд зочид буудал, байр сууц, худалдаа, нийтийн хоолны үйлчилгээний салбарт бизнес эрхлэлтийг дэмжиж, зохицуулалтыг хялбаршуулна. Мөн 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласан бодлогын хүрээнд аялал жуулчлалын үйлчилгээ, дэд бүтцийг сайжруулж, жуулчлалын бүс байгуулах арга хэмжээг хэрэгжүүлснээр худалдаа, үйлчилгээний салбаруудын үйл ажиллагааг дэмжинэ.

Шигтгээ 1. “УБТЗ” ХНН-ийн тарифын өөрчлөлт

Төмөр замын тээвэр нь төрийн оролцоо өндөр салбаруудын нэг юм. Өрсөлдөөний тухай хуулийн 6.1-д Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар (ШӨХТГ) нь тус салбарын бүтээгдэхүүнийг борлуулах үнийн өөрчлөлтийг хянан зөвшөөрөл олгохоор заасан. Мөн цар тахал, олон улсын хямралт нөхцөл байдал, “Коронавируст халдвар (Covid-19)-ын цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих нийгмийн хамгааллын зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолоос шалтгаалан тарифыг нэмэгдүүлэлгүй, УБТЗ-ын

даргын 2018 оны А-314 тоот тушаалаар тогтоосон тарифыг мөрдөн үйл ажиллагаа явуулж байсан.

“УБТЗ” ХНН нь Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал, хэрэглэгчдийн эрх ашгийг харгалзан жилд дунджаар ачаа тээврээр 10-45 хувийн алдагдал, зорчигч тээврээр 45-65 хувийн алдагдал хүлээн ажилладаг. Жишээлбэл, 2022 онд орон нутгийн ачаа тээврийн тарифын 19 бүлгээс 13 бүлэгт нь нийт 51.3 тэрбум төгрөгийн, зорчигч тээврээс 63.1 тэрбум төгрөгийн алдагдал тус тус хүлээсэн байна.

Үнэ тарифын зохицуулалтаас үүдэлтэй “УБТЗ” ХНН-ийн үйл ажиллагааны алдагдал нь шаардлагатай хүчин чадлыг нэмэгдүүлж, үйл ажиллагааг сайжруулах боломжийг хязгаарлаж байсан. Тухайлбал, улсын хэмжээнд ашиглагдаж буй нийт зүтгүүрийн вагоны 41 хувь, ачааны вагоны 94 хувь нь 25-аас дээш жилийн насжилттай, ашиглалтын хугацаа нь дуусах дөхсөн вагон байна. Иймд Засгийн газраас үнэ тарифын мөрдлөгт өөрчлөлт оруулж, тарифыг ашигтай түвшинд хүртэл өсгөх чиглэл өгч дотоодын ачаа тээврийн 16, зорчигч тээврийн 2 бүлгийн үнэ, тарифын өөрчлөлтийг ШӨХТГ-аас хянаж, зөвшөөрөл олгосон.

Инфляц

Засгийн газар, төв банкнаас макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсөв, мөнгөний бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Мөн экспортын орлогыг нэмэгдүүлж, валютын бодит мөнгөн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээний үр дүнд гадаад валютын албан нөөц нэмэгдэж байна.

Засгийн газрын 2023 оны 233 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гэрчилгээ авах, хүсэлт гаргах, хянах, олгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааг идэвхжүүлэн, хот, суурин газарт нийлүүлэгдэж байгаа махнаас авах төлбөр хураамж, хянан шалгалтын давхардлыг арилгаж, үйл ажиллагааг хөнгөвчлөх замаар хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сувгийг нэмэгдүүлнэ.

Эдгээр арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн үр дүнд инфляцын түвшин 2024 оны эцэст 8.5 хувь орчимд байхаар төсөөлж байна.

Гадаад худалдаа

2024 онд экспорт 15.4 тэрбум ам.доллар, импорт 10.0 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдаа 5.4 тэрбум ам.долларын ашигтай гарахаар төсөөлж байна.

Засгийн газраас гадаад худалдааг хөнгөвчлөх, экспортын зах зээлийг өргөжүүлэх, хилийн боомтуудын дэд бүтцийг нэмэгдүүлж, ачаа нэвтрүүлэх процессыг хөнгөвчлөх, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн

тогтолцоог өргөжүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд нүүрс, төмрийн хүдэр, газрын тос, алтны экспортыг нэмэгдүүлэх, тээвэр зохион байгуулалтыг оновчтой хийх, хилийн боомтуудын төмөр замын холболтыг эрчимжүүлэх, бүх боомтод ухаалаг гарцыг ашиглалтад оруулах, хатуу хучилттай авто замаар холбох, уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалсан нүүрсийг тусгай гарцаар нэвтрүүлж, биржээр арилжаалах бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Үүний үр дүнд 2024 онд голлох бүтээгдэхүүний экспортын биет хэмжээг нүүрс 60 сая тонн, зэсийн баяжмал 1,500 мянган тонн, төмрийн хүдэр 8,400 мянган тонн, газрын тос 4,850 мянган баррель, алт 20 тонн байхаар төсөөлж байна.

2024 онд хийгдэх хилийн боомтуудын бүтээн байгуулалт, төмөр зам болон автозамын сүлжээний өргөтгөл, цахилгаан эрчим хүчний станцуудын өргөтгөл болон шинэ бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн нөлөөгөөр тоног төхөөрөмж, барилгын материалын импорт нэмэгдэхээр байна. Мөн хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хүнсний хэрэглээг дотоодоос хангах чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээнээс шалтгаалан сүү, гурил, хүнсний ногоо зэрэг зарим хүнсний бүтээгдэхүүний импортын өсөлт бага түвшинд байх төлөвтэй байна.

Макро эдийн засгийн төсөөлөл боловсруулахад ашигласан аргачлал, тооцооны товч танилцуулга

Макро эдийн засгийн төсөөллийг боловсруулахдаа үндсэн үзүүлэлтүүд болох бодит ба нэрлэсэн ДНБ, инфляц, экспорт, импорт, ажилгүйдлийн түвшин зэргийг Олон Улсын Валютын Сангаас боловсруулсан Санхүүгийн програмчлал /Financial Programming/ макро эдийн засгийн загвар болон бусад макро эконометрик загваруудыг суурь болгон ашиглав.

III

ЗАСГИЙН ГАЗРААС 2024 ОНД БАРИМТЛАХ БОДЛОГО, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан бодлого, арга хэмжээнүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд Монгол Улсын нэгдсэн төсвийн хүрээнд дараах 6 бодлогын чиглэлийг баримтлахаар тодорхойллоо.

Нэг. Эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлнэ.

Эдийн засгийг тогтворжуулах хүрээнд 2022-2023 онуудад авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг хадгалж, 2024 онд макро тогтвортой орчныг дэмжсэн төсөв, мөнгөний бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, улсын зээлжих зэрэглэлийг ахиулахыг зорьж байна.

Төсвийн бодлого: Төсвийн бодлогын хүрээнд төсвийн алдагдлыг ДНБ-ий 2.8 хувьд хязгаарлаж, Засгийн газрын өрийн тогтвортой байдлыг хангана. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг хэрэгжүүлж, төсвийн зардлын үр ашгийг сайжруулж, бодлогын орон зайг нэмэгдүүлнэ.

Төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангах: Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах хүрээнд мөнгөний хатуу бодлогыг хэрэгжүүлснээр 2024 онд төсөв, мөнгөний бодлогын уялдаа хангагдана. Мөн Монголбанк гадаад валютын ханшийг зах зээлийн зарчмаар уян хатан тогтох нөхцөлийг бүрдүүлж, зах зээлийн хүлээлтийг эвдэхгүй байх, ил тод нээлттэй үйл ажиллагаа явуулах шаардлагатай байна. Түүнчлэн дотоодын санхүүгийн зах зээлд гадаадын банк, хөрөнгө оруулагчдыг нэвтрүүлэх замаар салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлэх нь зүйтэй.

Хоёр. Экспортыг нэмэгдүүлнэ.

Эдийн засгийн суурийг тэлэх, төрөлжүүлэх хүрээнд уул уурхайн болон уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээг 2024 онд үргэлжлүүлэн авч хэрэгжүүлнэ.

Уул уурхайн экспортыг нэмэгдүүлэхэд уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тогтолцоог бэхжүүлж, өргөжүүлнэ. Нүүрс, төмрийн хүдэр, хайлуур жонш, мөнгө, зэс зэрэг уул уурхайн бүх бүтээгдэхүүнийг үе шаттайгаар биржээр арилжиж, арилжсан бүтээгдэхүүнийг хилийн боомтын тусгай гарцаар нэвтрүүлнэ. Мөн нэг удаагийн арилжааны багцын дүнг нэмэгдүүлж, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын орлогыг нэмэгдүүлнэ.

Хилийн боомтын дэд бүтцийг нэмэгдүүлэх хүрээнд Гашуунсухайт-Ганцмод, Шивээхүрэн-Сэхээ, Ханги-Мандал, Бичигт-Зүүнхатавч хил дамнасан төмөр замын холболтыг эрчимжүүлж, боомтуудыг хатуу хучилттай авто замаар холбоно. Боомтуудад ухаалаг гарцыг бүрэн ашиглалтад оруулж, гаалийн бүрдүүлэлт, хяналтыг эрс хөнгөвчилнө. Мөн

боомтуудыг иж бүрнээр өргөтгөх ажлыг хэрэгжүүлж, Эрэнцав төмөр замын боомтыг олон улсын зэрэглэлтэй болгох, Цагаандэл-Уул боомтын бүтээн байгуулалтыг бүрэн дуусгах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Гадаад худалдааг хөнгөвчлөх хүрээнд "Гадаад худалдааны цахим нэг цонх" мэдээллийн системийг нэвтрүүлж, гадаад худалдааны явцад бүрдүүлэх баримт бичгийн давхардлыг арилгаж, экспортод зарцуулах хугацааг 72 цагт хүргэж бууруулна. Экспортын зах зээлийг өргөжүүлэх хүрээнд БНСУ-тай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг шинээр байгуулах, БНХАУ болон Эмират улстай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулахаар хамтран ажиллах, Тайланд, Вьетнам, Энэтхэг улстай хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах тухай хэлэлцээрийг шинэчлэн байгуулах зэрэг ажлуудыг хэрэгжүүлнэ. Түүнчлэн Евразийн эдийн засгийн холбоотой чөлөөт худалдааны түр хэлэлцээрийг 3 жилийн хугацаатай байгуулахаар тохиролцоод байна. Хэлэлцээрийн үр дүнд Монгол Улсаас ОХУ руу экспортлох ноос, ноолуур, мах, махан бүтээгдэхүүн, арьс ширний 894 нэр төрлийн бүтээгдэхүүнд ногдох ОХУ-ын импортын татварыг чөлөөлнө.

Гурав. Зохицуулалтыг хялбарчилж, бизнесийг дэмжинэ.

Аливаа төрлийн бизнес эрхлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг шийдвэрлэх чиглэлд төрийн зохицуулалтыг хялбарчилж, хувийн секторын чөлөөт өрсөлдөөнийг дэмжих арга хэмжээг 2024 онд авч хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд бизнесийн бүх төрлийн үйл ажиллагаанд байгаль орчны үнэлгээ хийлгэхийг шаардаж буй зохицуулалтыг оновчтой болгож, хялбаршуулна. Бизнесийн үйл ажиллагаанд тавигдах стандартыг тогтоож, байгаль орчны үнэлгээ хийх зайлшгүй шаардлагатай тохиолдолд үнэлгээ хийхтэй холбоотой төрийн байгууллагын үйл ажиллагааг цахимаар шийдвэрлэдэг болно.

Импортын зардлыг бууруулах хүрээнд гаалийн баталгаат агуулахад олон улсын стандартыг нэвтрүүлж, мөрдүүлэх замаар цахим бүртгэлийн системээр бүх төрлийн үйл ажиллагааг автоматжуулж, хүний оролцоо, чирэгдлийг бууруулна.

Төрөөс олгодог тусгай зөвшөөрлийг бүрэн цахим хэлбэрт шилжүүлэх хүрээнд салбар салбарт байгаа тусгай зөвшөөрөл олгоход оролцдог элдэв комисс, зөвлөл, хороог татан буулгаж, Монгол Улс тариалах, үйлдвэрлэх боломжгүй бүтээгдэхүүнд импортын тусгай зөвшөөрөл шаарддагийг хязгаарлана. Мөн магадлан итгэмжлэх тогтолцоог сайжруулах хүрээнд эрүүл мэнд, боловсрол зэрэг салбаруудын стандартыг хялбарчилж, тодорхой, хэрэгжихүйц болгох, хэрэгжилтийг хэрэглэгчдийн үнэлгээгээр тодорхойлох, хяналт шалгалтын тоо, давтамжийг цөөрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Доров. Салбаруудыг татааснаас чөлөөлж, цогц шинэчлэл хийнэ.

Эдийн засгийн салбаруудын өрсөлдөөнийг дэмжих, зах зээл дэх төрийн оролцоог бууруулах чиглэлд 2024 онд хөдөө аж ахуйн салбарт бодлогын цогц шинэчлэл хийх, Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, нийтийн тээврийн тогтолцоог шинэчлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Хөдөө аж ахуйн салбар: Хүнс үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарын бодлогыг цогцоор нь шинэчилж, бие даасан хувийн хэвшлийн оролцогчид бүхий зах зээл болж төлөвших үйл явцыг дэмжинэ. Мөн ХАА-н биржийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, хот суурин газруудын ойролцоо мах, малын зах нээхийг дэмжих замаар хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сувгийг нэмэгдүүлэх, вакцинжуулах үйл ажиллагааг үр ашигтай зохион байгуулах, вакцинжуулалтын тогтолцоог сайжруулна.

Эрчимжсэн мал аж ахуйг дэмжиж, хөдөө аж ахуйн салбарын бизнесийг илүү бүтээмжтэй хэлбэрт шилжүүлэхэд оновчтой бодлого хэрэгжүүлнэ. Тухайлбал, хадлан, тэжээлийн тариалангийн тоног төхөөрөмжийг импортын тарифаас чөлөөлж, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааны зардлыг бууруулна. Хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний гадаад худалдааг нээлттэй болгож, гадаад эрэлтийг нэмэгдүүлэх, угаасан ноолуур, боловсруулаагүй арьс, ширний экспортыг хориглосон техникийн зохицуулалтыг хугацаагүйгээр хүчингүй болгоно. Мөн бүх боомтоор хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн (мах, махан бүтээгдэхүүн, байгалийн хадлан, тэжээл, бордоо) экспортлохыг зөвшөөрөх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Улаанбаатар хотын агаарын бохирдол: Агаарын бохирдлыг бууруулах, дэд бүтцийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд утаа багатай түлшний стандартыг тогтоон мөрдүүлж, зах зээлийг нь либералчилна. Мөн гэр хороолол дахь дэд төвүүдийн суурилагдсан дэд бүтцийн ашиглалтыг нэмэгдүүлж, Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтцийн төслийг үргэлжлүүлнэ.

Авто замын түгжрэл, нийтийн тээвэр: Улаанбаатар хотын зорчих дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах хүрээнд метро барих ажлыг эхлүүлнэ. Мөн Сэлбэ сэргэлт, шинэ тойрог зам, Туулын хурдны зам, нүхэн гарцын төслүүдийг эрчимжүүлж, RFID системийг нэвтрүүлнэ. Нийтийн тээвэрт цогц шинэчлэл хийх хүрээнд нийтийн тээврийн салбар дахь төр, хувийн хэвшлийн түншлэлийг оновчтой хэлбэрт шилжүүлж, нийтийн тээврээр үйлчлүүлэгчийн эрх ашгийг эрхэмлэсэн засаглалын хэлбэрийг бий болгоно. Мөн нийтийн тээврийн зорчих маршрутын зохион байгуулалтыг дэлхийн том хотуудын стандартын түвшинд сайжруулж, либералчлалыг үе шаттай хэрэгжүүлнэ.

Тав. Хөрөнгө оруулалтыг дэмжиж, эдийн засгийг төрөлжүүлнэ.

Эдийн засгийг төрөлжүүлэх, бүтээгдэхүүнүүдийн боловсруулалтын түвшнийг шат шатаар ахиулах хүрээнд хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж, уул уурхайн болон уул уурхайн бус салбарын үйлдвэрлэлийг дэмжинэ.

Уул уурхайн салбарт геологи, хайгуулын ажлыг эрчимжүүлж, хайгуулын лицензийг нэмэгдүүлэх, ордуудын ашиглалтыг нэмэгдүүлнэ. Энэ хүрээнд агаарын геофизикийн судалгааг үргэлжлүүлэн гүйцэтгэж, урьдчилсан илэрц өндөртэй байршлуудыг хувийн хөрөнгө оруулагч нарт дуудлага худалдаагаар борлуулдаг тогтолцоо, зарчимд шилжинэ. Мөн уул уурхайн салбарын бизнесийн тогтвортой үйл ажиллагааг хангахад химийн хортой болон тэсэрч дэлбэрэх аюултай бүтээгдэхүүнийг импортлох асуудлыг БНХАУ-тай харилцан тохиролцоно.

Боловсруулах салбарт зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр, нүүрс баяжуулах үйлдвэр, гангийн үйлдвэр, ураны олборлолт, хүдрийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулахад хөрөнгө оруулалт татах ажлыг хэрэгжүүлнэ. *Барилгын салбарт* ипотекийн санхүүжилтийн тогтолцоог шинэчлэн эх үүсвэрийг шийдвэрлэж, хувийн хэвшил сонирхох бүтээгдэхүүн болгоно. Барилга, худалдаа, үйлчилгээ, тээвэр зэрэг салбарт цалинг цагаар тооцдог системд бүрэн шилжиж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

Аялал жуулчлалын авто замын сүлжээг нэмэгдүүлж, нисэх буудлуудыг олон улсын стандартад нийцүүлж, 200 км тутамд амрах өртөөнүүдийг байгуулна. Түүнчлэн түүх, соёл, байгалийн үзэсгэлэнт газрын нөөц, археологи, байгалийн үзэсгэлэнт газрын нөөц, палеонтологийн нөөцөд үндэслэсэн аялал жуулчлалын чөлөөт бүсийг байгуулна. Гадаад аялагчдад зориулсан татварын буцаан олголтын системийг нэвтрүүлж, автомашинтайгаа аялах боломжийг бүрдүүлнэ. Мөн технологийн олон улсын экспо зэрэг жуулчдыг татах арга хэмжээг нэмэгдүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлд хөрөнгө оруулалт татаж, хөгжүүлнэ.

Зургаа. Амьдралын чанарыг дээшлүүлнэ.

Боловсрол, эрүүл мэндийн салбарт шинэчлэл хийх, иргэдийн нийгмийн баталгааг сайжруулах чиглэлд 2024 онд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн дахин зохион байгуулж, Япон Улсын KOSEN стандартыг нэвтрүүлнэ. Ингэхдээ бүс нутаг бүрийн эдийн засгийн үйл ажиллагаатай уялдуулан төрөлжсөн хэлбэрээр хөгжүүлнэ. Мөн бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр дэх англи хэлний агуулгыг нэмэгдүүлнэ.

Эрүүл мэндийн салбарт гадаад, дотоодын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, тус салбарын өрсөлдөөн, үйлчилгээний чанарыг сайжруулж, хэрэглэгчдэд эрүүл мэндийн үйлчилгээний олон сонголтуудыг бий болгоно. Улсын эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудыг бодит үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд үе шаттай шилжүүлнэ. Мөн зах зээл дэх чанартай эмийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд эмийн хатуу зохицуулалттай орнуудын үйлдвэрлэгч нараас нэгдсэн байдлаар худалдан авалт хийх хэлцэл байгуулж, эмийг импортлоход хувийн хэвшлийн нээлттэй өрсөлдөөнийг дэмжинэ.

Иргэдийн нийгмийн баталгааг сайжруулах хүрээнд төрийн албан хаагчдын цалин, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийг инфляцын түвшинтэй уялдуулан тодорхой дүрмээр нэмэгдүүлдэг тогтолцоонд шилжинэ. Зорилтот бүлгийн нийгмийн баталгааг дээшлүүлэх чиглэлд зорилтот бүлгийг зөв тодорхойлж, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

I МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

1.1 Нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Нэгдсэн төсвийн нийт орлого 2023 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 39.2 хувиар өсөж 15,248.3 тэрбум төгрөгт, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 17.1 хувиар өсөж, 12,790.8 тэрбум төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1.1 Нэгдсэн төсвийн 2023 оны эхний 8 сарын гүйцэтгэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулсан харьцуулалт / тэрбум Т/

Үзүүлэлт	2022.8 Гүйц.	2023.8 Гүйц.	Зөрүү.
Нийт орлого	10,956.4	15,248.3	4,291.9
Төсвийн тэнцвэржүүлсэн орлого	10,028.0	14,609.0	4,581.1
Нийт зарлага	10,927.6	12,790.8	1,863.2
Урсгал зарлага	8,992.5	10,326.2	1,333.7
Хөрөнгийн зарлага	1,847.2	2,383.5	536.3
Эргэж төлөгдөх цэвэр зээл	87.8	81.0	(6.8)

1.2 Нийт орлого ба тусламжийн дүнгийн гүйцэтгэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 2023 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр 15,248.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 39.2 хувиар буюу 4,291.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Ийнхүү орлогын гүйцэтгэл нэмэгдэхэд экспорт сэргэж, эдийн засгийн идэвхжил эрчимжсэн нь голлон нөлөөлөв.

Засгийн газраас экспортыг сэргээх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд:

- Ашигт малтмал тээвэрлэх, экспортлох үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулсан;
- Төрийн өмчит хуулийн этгээдүүдэд онцгой дэглэм тогтоож, компанийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтыг сайжруулсан;
- Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тогтолцоог нэвтрүүлсэн.

Эдгээр арга хэмжээний үр дүнд нүүрсний экспорт 2023 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 46.7 сая тоннд хүрч, нүүрсний экспорт хамгийн дээд хэмжээнд гарч байсан үе буюу 2019 оноос 1.3 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Мөн газрын тосны экспортын хэмжээ өмнөх оны 8 сарын байдлаар 931.9 мянган баррель байсан бол 2023 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр нийт 3.2 сая баррельд хүрч, өмнөх оны мөн үеэс 3.4 дахин нэмэгдээд байна.

Түүнчлэн, гадаад эрэлтээс шалтгаалан удаашраад байсан жоншны экспорт 624 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 3.1 дахин, төмрийн хүдрийн экспорт 3.7 сая тоннд хүрч, өмнөх оны оны мөн үеэс 1.4 дахин тус тус нэмэгдсэн байна. Эдгээр хүчин зүйлийн нөлөөгөөр ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 2,894.4 тэрбум төгрөг, газрын тосны орлого 172.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс тус тус харгалзан 1.7, 4.8 дахин өссөн байна.

Уул уурхайн салбарын сэргэлт болон түүнийг дагасан тээвэр, үйлчилгээний салбарын өсөлтийн нөлөөгөөр эдийн засаг эрчимжиж, эхний хагас жилийн байдлаар эдийн засгийн өсөлт 6.4 хувьд хүрсэн нь аж ахуйн нэгжийн ашигт ажиллагааны түвшинд эерэг нөлөөлөл авчирч, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого 2,878.9 тэрбум төгрөгт хүрэхэд голлон нөлөөллөө.

2023 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлого болох хувь хүний орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар болон байгалийн нөөц ашигласны төлбөр зэрэг орлого өссөн нь нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Хүснэгт 1.1. Нэгдсэн төсвийн орлогын 2023 оны 8 дугаар сарын гүйцэтгэл /тэрбум Т/

Үзүүлэлт	2022.08 Гүйц	2023.08 Гүйц	Зөрүү
Нийт орлого	10,956.4	15,248.3	4,291.9
Тогтворжуулалтын сан	928.5	559.3	(369.2)
Ирээдүйн өв сан	0.0	80.0	80.0
Төсвийн тэнцвэржүүлсэн орлого	10,028.0	14,609.0	4,581.0
Татварын орлого	9,282.8	13,658.5	4,375.7
Татварын бус орлого	745.2	950.5	205.3

1.3 Улсын төсвийн урсгал зарлагын гүйцэтгэл 2023 оны улсын төсвийн урсгал зарлага 12,574.1 төгрөгөөр төлөвлөгдсөн бөгөөд 2023 оны 8 сарын байдлаар 7,270.7 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталсан бөгөөд тус өөрчлөлтөөр өндөр насны болон нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлсэн бөгөөд хүсэлт гаргасан бүх хүүхдэд хүүхдийн мөнгө олгох өөрчлөлт батлагдсан.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд орсон дээрх өөрчлөлтөөр цалин хөлс 994.2 тэрбум төгрөгөөр, өндөр насны болон халамжийн тэтгэвэр тэтгэмж 529.0 тэрбум төгрөгөөр, хүүхдийн мөнгө 167.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь улсын төсвийн 2023 оны 8

дугаар сарын гүйцэтгэл өнгөрсөн оны мөн үеэс 2,028.9 тэрбум төгрөгөөр буюу 38.7 хувиар өсөхөд голчлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 1.3 Улсын төсвийн урсгал зарлагын 2023 оны 8 дугаар сарын гүйцэтгэл /тэрбум Т/

Үзүүлэлт	2022.08 Гүйц	2023.08 Гүйц	Зөрүү
Урсгал зарлага	5,241.8	7,270.8	2,029.0
Бараа, үйлчилгээний зардал	1,554.9	1,990.2	435.3
Хүү	479.9	813.1	333.2
Татаас	781.8	634.3	(147.5)
Урсгал шилжүүлэг	2,425.2	3,833.2	1,408.0

1.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016-2023 онд нийтдээ 10.1 их наяд төгрөгийн санхүүжилт батлагдаж, давхардсан тоогоор 6306 төсөл, арга хэмжээг улсын хэмжээнд хэрэгжүүлж, нийтдээ 7.1 их наяд төгрөгийн санхүүжилт олгосон байна. Түүнчлэн Улсын Их Хурлаас 2010 онд баталсан Концессын тухай хуулийн дагуу концессын “Барих-Шилжүүлэх” төрлөөр гэрээ байгуулсан төслүүдийн эргэн төлөлтийг мөн 2016 оноос эхлэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 1.4 Төсвийн хөрөнгө оруулалт 2017-2023 онуудад /тэрбум Т/

№	Төсвийн жил	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
1	УТХО	977.6	602.1	683.3	1,553.4	1,330.9	1,418.9	1,377.7	2,695.0
2	Концесс	70.7	177.7	82.9	144.7	323.5	266.3	303.6	279.6
	Нийт дүн	1,048.3	779.9	766.2	1,698.1	1,654.4	1,685.2	1,697.4	2,974.6

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд 7.9 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 2.9 их наяд төгрөгийн санхүүжилт бүхий 1143 төсөл, арга хэмжээг байна. Гүйцэтгэлийн хувьд 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар 1.4 их наяд төгрөгийн санхүүжилт хийгдэж, гүйцэтгэл 49.2 хувьтай тэнцүү байна.

1.4 Гадаадын зээл, тусламжийн гүйцэтгэл

Улсын Их Хурлаас 2023 онд гадаад зээл, тусламжийн 140 төслийг санхүүжүүлэхэд нийт 1,795.0 тэрбум төгрөг баталсан бөгөөд 2023 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 876.5 тэрбум төгрөг санхүүжиж, гүйцэтгэл 49.0 хувьтай байна.

Хүснэгт 1.5 Гадаадын зээл, тусламжийн 2023 оны санхүүжилтийн гүйцэтгэл /тэрбум Т/

Эх үүсвэр	2023 онд батлагдсан		Гүйцэтгэл 2023-09-25	Хувь
	Төслийн тоо	Санхүүжилт		
Зээл	108	1,224.5	715.4	58%
Тусламж	32	570.5	161.1	28%

МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛ

Нийт дүн	140	1,795.0	876.5	49%
----------	-----	---------	-------	-----

II

МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЙЛБАР - БҮЛГЭЭР

Хууль тогтоомжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 4 дүгээр заалтад хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгад тайлбарыг шинэчилсэн найруулга бол бүлгээр багцлан тусгана гэсний дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн агуулгыг бүлгээр тусгалаа.

1 дүгээр бүлэг – Нийтлэг үндэслэл

2024 оны төсвийн тухай хуулийн зорилт болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг дурдсан. Хуулийн зорилтын талаар танилцуулгын 3. Төсвийн бодлого хэсэгт дэлгэрэнгүй тусгасан.

2 дугаар бүлэг – Монгол улсын 2024 оны төсвийн орлого, зарлага болон хөрөнгө, өрийн удирдлага

Монгол Улсын төсөвт 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллагын тус бүрээр төсөвт төвлөрүүлэх дүн болон 2024 оны төсвийн жилд төвлөрүүлэх нийт тэнцвэржүүлсэн орлогын дүнг тусгасан. Орлогын дэлгэрэнгүй тайлбарыг 4. Төсвийн орлого хэсэгт оруулсан.

Монгол Улсын төсөвт 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч нарийн эргэн төлөх үндсэн төлбөрийн дүн болон зарцуулах төсвийн дүнг тусгасан бөгөөд урсгал зардлын дэлгэрэнгүй тайлбарыг 5. Урсгал зардал хэсэгт оруулсан.

Улсын төсвийн хөрөнгөөр болон "Барих-Шилжүүлэх" концессын төрлөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төсвийн дүнг тусгасан. Үүний талаар дэлгэрэнгүй тайлбарыг 6. Улсын төсвийн хөрөнгө оруулалт хэсэгт оруулсан.

Төсвийн тогтворжуулалтын санд хуримтлуулах дүн, Ирээдүйн өв санд хуримтлуулах дүн болон 2024 оны төсвийн жилд төсвийн алдагдлын санхүүжүүлэх эх үүсвэрийг тусгасан. Үүний дэлгэрэнгүй тайлбарыг 10. 2024 оны нэгдсэн төсвийн үзүүлэлт хэсэгт оруулсан.

Түүнчлэн, Тухайн төсвийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэй гаргасан зээллэг болон өрийн зохицуулалтын арга хэмжээнээс бусад 2023 оны төсвийн жилд төлөх Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийн хэмжээ, Засгийн газрын гаргах өрийн баталгааны дээд хэмжээг тус тус тусгасан. Дэлгэрэнгүй тайлбарыг 9. Засгийн газрын өр хэсэгт оруулсан.

3 дугаар бүлэг – Орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх орлого, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг

Орон нутагт 2024 оны төсвийн жилд олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ болон 2024 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээг заасан. Дэлгэрэнгүй тайлбарыг 7. Орон нутгийн төсөв хэсэгт оруулсан.

4 дүгээр бүлэг – Бусад зүйл

Хуулийн төслийн хавсралтаар батлах “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт”, “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд эргэн төлөлт хийх концессын "Барих-Шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт", “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд эргэн төлөлт хийх концессын "Барих-Шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг тус тус оруулсан. Түүнчлэн хуулийн дагаж мөрдөх хугацааг тусгасан.

III

ТӨСВИЙН БОДЛОГО, ОНЦЛОГ

Монгол Улсын Засгийн газраас “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хурлаар батлуулсан. Уг бодлогоор ирэх 30 жилд эдийн засгийг арав дахин тэлэх, нийгмийн хөгжил, иргэдийн амьдралын чанараар бүс нутагтаа тэргүүлэгч улс орнуудын нэг болох томоохон зорилтыг тавьсан билээ. Үүний дагуу эхний арван жилд хэрэгжүүлэх “Шинэ сэргэлтийн бодлого”-оор хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлсийн түгжээг тайлах 6 багц сэргэлтийг хэрэгжүүлэхэд төсөв, мөнгөний бодлогыг чиглүүлж байна.

Гэвч эдгээр дунд, урт хугацааны бодлогуудыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ дэлхий нийтийг хамарсан цар тахал, геополитикийн хүндрэлтэй нөхцөл байдал зэрэг гадаад хүчин зүйлээс шууд шалтгаалсан, урьдчилан тааварлах боломжгүй бэрхшээлийг даван туулах хүнд сорилттой тулгарсан билээ.

Сүүлийн жилүүдэд Засгийн газраас дотоод нөөц бололцоондоо тулгуурлан эдгээр хүндрэл бэрхшээлийн эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахад чиглэсэн төсвийн бодлогыг хэрэгжүүлж ирлээ. Тухайлбал, 2020-2021 онуудад Коронавируст халдвар (КОВИД-19) цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, иргэдийн эрүүл мэнд, ажлын байр, орлогыг хамгаалахад зориулан нийт 7.5 их наяд төгрөг бүхий төсвийн багц арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүллээ.

Гэвч коронавируст халдвар (КОВИД-19) цар тахал бүрэн дарагдаагүй байсантай зэрэгцээд ОХУ-Украины хямралт нөхцөл байдал үүсэж эхэлсэн нь 2022 оны төсвийн бодлогод томоохон эрсдэл учруулав. Түүнчлэн улс орнууд өндөр инфляцын эсрэг мөнгөний эрс хатуу бодлого баримталж, БНХАУ-ын Засгийн газраас хэрэгжүүлсэн “Тэг Ковид” бодлогын нөлөөгөөр манай улсын экспорт буурч, төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдэж, гадаад валютын нөөц 2.7 тэрбум ам.долларт хүрч буурсан нь Монгол Улсад давхар цохилтыг өгч, эдийн засагт эрсдэлийг нэмэгдүүлсэн. Энэхүү хүнд сорилтын цаг үед Монгол Улсын Засгийн газраас экспортыг нэмэгдүүлэх, эдийн засагт үүссэн эмзэг байдлыг бууруулах, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх багц арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлсний үр дүнд 2022 оны эцэст нийт экспорт 12.5 тэрбум ам.долларт хүрч, түүхэн дээд түвшинд хүрлээ.

Түүнчлэн, Засгийн газраас “Шинэ сэргэлтийн бодлого”-ын “Боомтын сэргэлт”-ийн зорилтын хүрээнд “Тавантолгой-Гашуунсухайт”, “Зүүнбаян-Ханги” чиглэлийн төмөр замуудыг ашиглалтад оруулж, хилийн боомтод чингэлэг тээврийн болон автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал байгуулсан. Түүнчлэн “Замын-Үүд-Эрээн” боомтын хоёр дахь төмөр замыг барьж, нэвтрүүлэх хүчин чадлыг хоёр дахин

2021 оны төсвийн онцлог: Коронавируст халдвар КОВИД-19 цар тахлын эдийн засгийн нөлөөг бууруулахад чиглэв.

2022 оны төсвийн онцлог: Боомтын сэргэлтийн үр дүнд экспортыг эрчимжүүлж, эдийн засгийг тогтворжуулав.

нэмэгдүүлсэн, “Шивээхүрэн-Сэхээ” боомтын үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлсэн зэрэг арга хэмжээнүүдийн үр дүнд гадаад худалдааны эргэлт 21 тэрбум ам.долларт хүрч түүхэн дээд түвшиндээ хүрснээр төлбөрийн тэнцлийн алдагдал буурч, валютын нөөц 2022 оны эцэст 3.4 тэрбум ам.доллар болж нэмэгдсэн байна.

Харин 2023 оны төсвийн бодлогоор эдийн засгийг тогтворжуулах, төсвийн сахилга батыг бүх шатанд хэрэгжүүлэхэд чиглэн, ашигт малтмал дагасан далд эдийн засгийг ил болгох, төрийн өмчит компаниудын засаглал, үр ашгийг сайжруулах замаар төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Мөн Засгийн газраас нүүрсний олборлолт, тээвэрлэлт, хилээр нэвтрүүлэх үйл ажиллагаанд үүссэн бэрхшээлийг арилгаж, ашигт малтмалын бүтээгдэхүүнийг уул уурхайн биржээр нээлттэй, ил тод арилжиж, олон улсын зах зээлийн үнээр борлуулдаг болсон зэрэг арга хэмжээнүүдийн үр дүнд энэ оны эхний 9 сарын байдлаар нүүрсний экспорт 46.5 сая тонн буюу өмнөх оны мөн үеэс 1.4 дахин нэмэгдсэнээр төсвийн тэнцвэржүүлсэн орлого төлөвлөгөөнөөс давж биелэх боломж бүрдлээ.

Хэдийгээр эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд эерэг өөрчлөлтүүд гарч эхэлсэн боловч гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр сүүлийн 20 сар дараалан Монгол Улсын инфляц 10 хувиас дээш түвшинд хүрсэн нь иргэдийн бодит орлогод сөргөөр нөлөөлж, ард иргэдийн амьжиргааг дэмжих зайлшгүй шаардлага бий болгосон. Улмаар Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулж, цалингийн суурь итгэлцүүрийг шинэчлэх замаар тэтгэврийн зөрүүний асуудлыг шийдвэрлэж, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлж, төрийн албаны цалингийн тогтолцоог шинэчлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд 2023 оны эцэст бодит орлого нэмэгдэж, төлбөрийн тэнцэл ашигтай гарч, гадаад валютын албан нөөц 4 тэрбум ам.долларыг давж, эдийн засаг 6.0 хувиар өсөх төлөвтэй байна.

Ийнхүү гадаад эрсдэлийн нөлөө намжиж, эдийн засаг цар тахлын өмнөх түвшинд хүрч сэргэсэнээр “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн зорилтод хүрэх “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг үе шаттайгаар хэрэгжүүлэхэд ирэх 2024 оны төсвийн бодлогыг чиглүүлнэ.

2023 оны төсвийн
онцлог: Далд эдийн
засгийг бууруулан,
засаглал, ил тод
байдлыг
сайжруулж,
иргэдийн орлогыг
хамгаалав.

2024 оны төсвийн
онцлог: "Хот,
хөдөөгийн
сэргэлт"-ийг
хэрэгжүүлэхэд
онцгой анхаарсан
төсвийн бодлого
баримтална.

3.1 Монгол Улсын 2024 оны төсвийн бодлого

Нэг. Монгол Улс 2024 оны төсвийн бодлогоор "Шинэ сэргэлтийн бодлого"-ын тулгуур бүрэлдэхүүн болох "Хот, хөдөөгийн сэргэлт"-ийн зорилтод тусгасан хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, орон нутгийн иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Үндэсний статистикийн хорооны 2022 оны мэдээгээр Монгол Улсын хүн амын тэн хагас нь нийт газар нутгийн дөнгөж 0.4 хувь болох Улаанбаатар хотод суурьшин амьдарч байна. Нийслэл рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөний үндсэн шалтгаан нь орон нутагт амьдрах нөхцөл, боломж тааруу, орон сууцны хангамж, нийлүүлэлт, дэд бүтэц хангалтгүй байдагтай холбоотой байна.

Олон улсад хэрэгжиж буй орон нутгийн хөгжлийг дэмжих, төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд орон нутагт шилжин суурьших иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, дэд бүтцийн хөгжлийг сайжруулах, орон сууцжуулах, хүний нөөцийн хөгжлийн бодлого хэрэгжүүлэх, хүрээлэн буй орчныг сайжруулах, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх зэрэг арга хэмжээг нийтлэгээр хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, орон нутгийн хөгжлийг дэмжих, шинэ суурьшлын бүсүүдийг байгуулах бодлогыг дараах үндсэн дөрвөн чиглэлээр шат дараатай авч хэрэгжүүлж байна. Тухайлбал:

1. Орон нутгийн дэд бүтцийн хөгжлийн хүрээнд:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг "Шинэ сэргэлтийн бодлого"-ын Хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжих төсвийн бодлогын хүрээнд төвлөрлийг сааруулахад чиглүүлж энэ хүрээнд нийт хөрөнгө оруулалтын 79 хувь буюу 2.6 их наяд төгрөгийн санхүүжилт бүхий 835 төсөл, арга хэмжээ, дэд бүтэц, барилга байгууламжийг төсвийн төсөлд тусгасан бөгөөд дараах онцлох төслүүдийг дурдвал: Үүнд

1. Шинэ сэргэлтийг дэмжих хөгжлийн тойрог авто замын үндэсний сүлжээ бий болгох зорилтын хүрээнд аймгийн төвүүдийг хатуу хучилттай авто замаар холбох, сумдыг улсын чанартай авто замтай холбох **32 томоохон хатуу хучилттай авто зам, гүүрэн байгууламжийг эхлүүлж, үүнд шаардлагатай 978.7 тэрбум төсөвт ортог бүхий 226.7 тэрбум төгрөг** шинээр тусгасан бол он дамжин хэрэгжиж буй боомтын томоохон төслүүдийг үргэлжлүүлэхээр санхүүжилтийг ажлын явц, гүйцэтгэлд үндэслэн тусгав.
2. Хөдөөгийн хөгжлийг эрчимжүүлэх, хотын төвлөрлийг бууруулах зорилтын хүрээнд аймгийн төвүүдийн орон сууцны дэд бүтэц, шинэ суурьшлын дэд бүтэц, инженерийн хангамж, цахилгаан болон дулааны

хангамжийг нэмэгдүүлэх, шинэ эх үүсвэрийг бий болгох чиглэлээр *Хөшгийн хөндийн дэд бүтцэд 50.4 тэрбум тогроз*, БНСУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж байгаа Говьсүмбэр, Дундговь, Завхан, Хэнтий, Сүхбаатар, Төв, Архангай, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай аймгуудын дулааны станцыг шинээр барих төсөлд Монголын талын хариуцах дэд бүтэц, цахилгаан хангамж 2-р хэлхээний санхүүжилтэд нийтдээ *51.8 тэрбум тогрозийн төсөвт өртөг бүхий 22.1 тэрбум тогрозийн санхүүжилт*, барилгын материалын чанар, стандартыг сайжруулах бодлогын хүрээнд Замын-Үүд, Алтанбулаг хилийн боомтуудад барилгын материалын сорилт шинжилгээний лабораториудын тоног төхөөрөмжийн худалдан авахад *23.2 тэрбум тогрозийн төсөвт өртөг бүхий 9.2 тэрбум тогрозийн санхүүжилт тусгасан* бол аймгийн төвүүдийн цахилгаан, дулаан, инженерийн дэд бүтцэд шаардлагатай *нийт 142 төслийн 591 тэрбум тогрозийн санхүүжилтийг* тус тус тусгав.

Түүнчлэн, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр орон нутгийн томоохон дэд бүтэц, авто зам, зарим авто замын засвар, арчлалтын зардлыг шийдвэрлэхээр төсвийн төсөлд тусгалаа.

Тухайлбал, Газрын тос боловсруулах үйлдвэр болон Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, 10 аймгийн дулааны цахилгаан станцын ажлыг эрчимжүүлэх, Азийн хөгжлийн банк (АХБ), Европын хөрөнгө оруулалтын банк (ЕХОБ), Уур амьсгалын ногоон сан (УАНС)-гийн зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилтээр нийт 17 аймгийн 52 суманд хэрэгжих Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх, АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Ховд, Увс, Говь-Алтай, Завхан аймгуудын төвүүдийг холбох 163.3 км болон 198 км авто замын ажлыг эхлүүлэх, Дэлхийн банкны зээлийн санхүүжилтээр шинээр хэрэгжих “Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд:

- Улаанбаатар-Арвайхээр,
- Хархорин-Цэцэрлэг,
- Цэцэрлэг-Тосонцэнгэл,
- Улаанбаатар-Өндөрхаан,
- Булган-Мөрөн,
- Арвайхээр-Баянхонгор,
- Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн автозамуудын ээлжит болон

их засварын ажил, төмөр бетон гүрийн их болон ээлжит засварын ажлыг уг төслийн хүрээнд хийхээр тус тус төлөвлөсөн болно. Мөн Даланзадгад-Мандалговь чиглэлийн авто замын их засварын ажлын санхүүжилтийг гадаадын зээлийн эх үүсвэрээр шийдвэрлэнэ.

2. Орон нутгийг орон сууцжуулах арга хэмжээний хүрээнд:

Олон Улсын Шилжих Хөдөлгөөний байгууллагаас Монгол Улсад 2022 онд хийсэн судалгаагаар орон нутгаас Улаанбаатар хот руу шилжин суурьших болсон хоёр дахь нийтлэг үндсэн шалтгаан нь амьдрах орчин буюу орон сууцны дутагдал байв.

Засгийн газраас төвлөрлийг сааруулах, орон нутаг дахь орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Улаанбаатар хотоос орон нутаг болон Багануур, Багахангай дүүргүүдэд шилжин суурьшиж, анх удаа орон сууц худалдан авахаар хүсэлтээ гаргасан иргэдэд ипотекийн зээлийн хүүгийн 3 нэгж хувийг эхний 3 жилд төсвөөс санхүүжүүлж, орон сууцны зээлийн урьдчилгаа төлбөрийн 60 хүртэл хувьд баталгаа гаргаж байна. Энэ хүрээнд 2023 оны 9 дүгээр сарын байдлаар нийт 241 зээлдэгчдэд 19.4 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгоод байна.

Дээрх бодлогын арга хэмжээг эрчимжүүлэх, орон нутагт амьдрах иргэдийн тав тухтай орчныг бүрдүүлэх, орон сууцны хамрагдалтыг улам нэмэгдүүлэх чиглэлээр 2024 оны төсвийн жилд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- ✓ Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг нийслэл, орон нутагт тэгш хүртээмжтэйгээр үе шаттайгаар нэмэгдүүлнэ. Ипотекийн зээлийн хөтөлбөрийн санхүүжилтийн 18 орчим хувийг орон нутагт олгодог байсныг 2024 оноос 50 хувьд хүргэн нэмэгдүүлэхээр зорьж ажиллаж байна. Ингэснээр орон нутагт өмнө нь 1,900 орчим өрх тус хөнгөлөлттэй зээлд хамрагддаг байсан бол зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлснээр 4,300 гаруй өрх хамрагдах боломжтой болно;
- ✓ Улаанбаатар хотоос орон нутаг болон Багануур, Багахангай дүүргүүдэд шилжин суурьшиж, анх удаа орон сууц худалдан авахаар хүсэлтээ гаргасан иргэдэд ипотекийн зээлийн хүүгийн 3 нэгж хувийг эхний 3 жилд төсвөөс санхүүжүүлж, орон сууцны зээлийн урьдчилгаа төлбөрийн 60 хүртэл хувьд баталгаа гаргах арга хэмжээг үргэлжлүүлнэ. 2024 оны төсвийн төсөлд хүүгийн татаасаар 16.0 тэрбум төгрөгийг төсөвлөсөн болно;
- ✓ Тогтвортой ногоон санхүүжилтийг өргөжүүлэх, агаар, орчны бохирдол, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, амьдрахад таатай орчныг бүрдүүлэх хүрээнд Монгол Улсын Засгийн газар нь Нэгдсэн Үндэсний Байгууллагын Уур амьсгалын ногоон сан болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран үндэсний ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх боломжтой. Энэ хүрээнд 2024 оны төсвийн жилд Засгийн газраас 63.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг эргэж төлөгдөх цэвэр зээл ангилалд тусгаад байгаа бөгөөд олон улсын байгууллага, хувийн хэвшлийн хамтарсан

санхүүжилтээр нийт 253.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй орон сууц барихад зориулж ногоон бизнесийн зээл гаргах боломжтой. Энэхүү эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй орон сууц нь инженерийн дэд бүтцэд холбогдох шаардлагагүй бөгөөд дэд бүтэцгүй, алслагдсан сумдад нэвтрүүлэх боломжтой;

- ✓ Орон нутгийн удирдлагаас иргэдийг орон сууцжуулах чиглэлээр төсөл, арга хэмжээг тухайн орон нутгийн онцлогт нийцүүлэн боловсруулж, шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсвөөр санхүүжүүлэх тохиолдолд улсын төсвөөс тодорхой хэмжээнд дэмжлэг үзүүлнэ;
- ✓ Орон нутагт шинээр барьсан нийтийн зориулалттай орон сууц борлуулсны орлогод ногдох албан татварыг нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг, Дархан-Уул болон Орхон аймгийн төвийн сумын хилийн цэс дотор 2024-2026 онд 50 хувиар, 2027-2029 онд 20 хувиар, эдгээрээс бусад аймаг, сумын хилийн цэсийн дотор 2024-2026 онд 90 хувиар, 2027-2029 онд 50 хувиар тус тус хөнгөлнө;
- ✓ Орон нутаг дахь түрээсийн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг болон аймаг, сумын хилийн цэсийн дотор баригдсан нийтийн зориулалттай орон сууцны барилгад хүн амьдран суух зориулалтаар орон сууц түрээслүүлсний орлогод ногдох албан татварыг 2024-2026 онд 90 хувиар, 2027-2029 онд 50 хувиар тус тус хөнгөлнө.

3. Орон нутагт төрийн албан хаагчдыг тогтвортой ажиллаж, амьдрах боломжоор хангах бодлогын хүрээнд:

- ✓ Хөдөөгийн суманд ажиллаж байгаа 51.8 мянган төрийн албан хаагчид үндсэн цалингийн 40 хувь, харин аймгийн төвийн сум болон нийслэлийн алслагдсан гурван дүүрэгт ажиллаж байгаа 53.4 мянган төрийн албан хаагчид сар бүр үндсэн цалингийн 20 хувиар тус тус тооцож орон нутгийн нэмэгдлийг нийт 105.2 мянган төрийн албан хаагчид олгох бөгөөд тус арга хэмжээнд нийт **306.8 тэрбум төгрөгийг** зарцуулахаар тооцлоо.
- ✓ 21 аймаг болон нийслэл Улаанбаатар хотын Багануур, Багахангай, Налайх дүүргүүдэд тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн захиргааны 3.9 мянган албан хаагчид таван жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгоно. Харин гаалийн байгууллагын алслагдсан хилийн боомтод тогтвор суурьшилтай ажиллаж байгаа 1.2 мянган байцаагчид

таван жил тутамд нэг удаа 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгоно. Тус арга хэмжээнд **59.4 тэрбум төгрөгийг** зарцуулахаар тооцлоо.

4. Орон нутагт бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэх зорилтын хүрээнд:

- ✓ Аймаг, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд оршин суудаг, тухайн орон нутагт бүртгэлтэй Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг аймаг, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 90 хувиар хөнгөлж байна;
- ✓ Багануур, Багахангай, Налайх дүүргээс бусад нийслэл хотын хилийн цэсээс гадна үндсэн үйл ажиллагаа эрхлэн явуулдаг, хуулийн этгээдийн ерөнхий захиргаа нь үйл ажиллагааг явуулж байгаа тухайн орон нутагт бүртгэлтэй, тухайн орон нутгийн татварын албанд бүртгэгдсэн албан татвар төлөгч ажил хайгч иргэнийг хөдөлмөрийн гэрээний дагуу үргэлжилсэн 12 сарын хугацаанд нийт 183 ба түүнээс дээш хоног шинээр ажиллуулсан бол тухайн хугацаанд хамаарах цалингийн зардлыг 20 хувиар нэмэгдүүлж албан татвар ногдох орлогоос нэг удаа хасаж тооцож байна;
- ✓ Нийслэл хотод байрлалтай үйлдвэр, эсхүл агуулахаа Багануур, Багахангай, Налайх дүүргээс бусад нийслэлийн хилийн цэсээс нүүлгэсэн тохиолдолд тухайн нүүлгэн шилжүүлэхтэй холбогдон гарсан зардлыг 50 хувиар нэмэгдүүлж албан татвар ногдох орлогоос хасаж татварын дэмжлэг хэрэгжиж байна;
- ✓ Орон нутагт бизнес эрхлэлтийг дэмжиж төвлөрлийг сааруулж эрчим хүчний тогтвортой эх үүсвэрийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа тул цахилгаан эрчим хүчний 5 мегаваттаас дээш, эсхүл дулааны эрчим хүчний 1.5 мегаваттаас дээш хүчин чадалтай эх үүсвэрийн үндсэн болон туслах тоног төхөөрөмж үйлдвэрлэх үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг 90 хувь хөнгөлж байна;
- ✓ “Хот хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 68 дугаар тогтоолоор Төвлөрлийг сааруулах хүрээнд Улаанбаатар хотоос орон нутагт шилжин үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийг дэмжих 1 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлийг

арилжааны банкнуудын эх үүсвэрт тулгуурлан олгохоор шийдвэрлэсэн болно. Хөнгөлөлттэй зээлд хамрагдах аж ахуй нэгж нь үйл ажиллагаагаа Улаанбаатар хотоос орон нутагт шилжүүлэн тухайн орон нутагт таваас доошгүй ажлын байр бий болгосон байх шаардлагатай ба 500 хүртэл сая төгрөгийн зээлийг 5 жилийн хугацаанд 1 хувийн хүүтэйгээр авах боломжтой. Тус арга хэмжээний хүрээнд 2024 оны төсвийн төсөлд 14.4 тэрбум төгрөгийг төсөвлөсөн болно.

Хоёр. Экспортыг нэмэгдүүлэх чиглэлд хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн ил тод арилжааг эрчимжүүлэх, иргэдийн орлогыг хамгаалах чиглэлд цалин, тэтгэвэр тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх, хөгжилд суурилсан хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэхэд чиглэсэн төсвийн бодлогыг хэрэгжүүлнэ.

Түүнчлэн, хөрөнгийн зах зээлийг дэмжих, хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг сайжруулах, хялбаршуулах, ашигт малтмал баяжуулах, боловсруулах үйлдвэрийг дэмжихэд чиглэсэн татварын бодлогын арга хэмжээ авах болно.

Гурав. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан иргэд эх орондоо оношлогдон, эмчлүүлэх боломжийг нэмэгдүүлж, орчин үеийн үндэсний оношилгоо, эмчилгээний төвүүдийг байгуулах томоохон зорилтын хүрээнд дэлхийн жишигт нийцсэн шинэ технологи, инноваци бүхий эс, эд, эрхтэн шилжүүлэх төвийг Улсын төв нэгдүгээр эмнэлгийн дэргэд байгуулахаар *“Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв”-ийн бүтээн байгуулалтын санхүүжилт болох 140.0 тэрбум тогрог*, Улаанбаатар хотын Баянгол дүүрэгт баригдах *“Зүрх судасны үндэсний төв”-ийн гадна шугам сүлжээ, дэд бүтэц*, Төв аймгийн Сэргэлэн суманд баригдах *“Халдвар үндэсний төв-2”-ийн гадна шугам сүлжээ, дэд бүтэц* нийтдээ *15.6 тэрбум тогрогийн төсөвт ортог бүхий 5.1 тэрбум тогрог* тус тус тусгалаа.

Дөрөв. Уул уурхайн орлогын тодорхой хувиас бүрдэж, тухайн орон нутгийн иргэдийн санал санаачилга дээр тулгуурлан, иргэдийн ая тухтай амьдрах орчныг сайжруулахад чиглэсэн Орон нутгийн хөгжлийн сангаас уул уурхайн олборлолт хийгдэж буй аймгуудад нэмэлтээр хуваарилагдаж, үүнээс сумдад олгох санхүүжилтийг 60 хувьд хүртэл нэмэгдүүлнэ. Ингэснээр тогтвортой, хариуцлагатай уул уурхайг дэмжиж, эдийн засгийн эргэлтэд оруулан, байгалийн баялгийн үр өгөөжийг орон нутгийн хөгжилд чиглүүлэх боломж бүрдэнэ.

Дээрх арга хэмжээнүүдийг 2024 онд хэрэгжүүлснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн алдагдал ДНБ-ий 2.8 хувь, өнөөгийн үнэ цэнээр

илэрхийлэгдсэн Засгийн газрын өрийн үлдэгдэл ДНБ-ий 60.0 хувиас ихгүй байх төсвийн тусгай шаардлага хангагдаж, ирэх 4 жилд нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг 10 мянган ам.долларт хүргэх эдийн засгийн суурийг дэмжиж баталгаажуулах боломжтой болох юм.

IV

ТӨСВИЙН ОРЛОГО, ТАТВАР

1.3 4.1 Төсвийн орлого, татварын чиглэлээр баримтлах бодлого

Ирэх 2024 онд татварын ачааллыг нэмэгдүүлэхгүйгээр хөрөнгө оруулалт, үнэт цаасны зах зээлийг дэмжих, бизнес эрхлэгчдийн татварын орчныг хялбаршуулах, сайжруулах замаар татварын эрсдэлийг бууруулах, төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд орон нутгийг орон сууцжуулах бодлогод дэмжлэг үзүүлэх, малчдын татварын орчныг хялбаршуулан, энгийн ойлгомжтой болгох замаар малын гаралтай түүхий эдийн бүртгэлийг сайжруулах, боловсруулах, баяжуулах үйлдвэрүүдийг дэмжих, гааль, татварын үйл ажиллагаа, бүртгэлийн уялдаа холбоог сайжруулах замаар далд эдийн засгийг бууруулж, татварын тэгш шударга байдлыг хангах, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлнэ.

Нэг. Хөрөнгө оруулалт, хөрөнгийн зах зээлийг дэмжих, бизнесийн орчныг хялбаршуулах татварын бодлогын арга хэмжээ

Цар тахал болон геополитикийн хурцадмал байдлаас үүдэлтэйгээр эдийн засагт тулгарч буй томоохон сорилтуудыг даван туулах зорилгоор бусад улс орнууд эдийн засгийн өсөлтийг дэмжих, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөрөнгийн зах зээлийг дэмжихэд чиглэсэн татварын бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

Монгол Улсын хувьд хөрөнгө оруулалт, үнэт цаасны зах зээл, бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр 2023 оноос эхлүүлсэн татварын бодлогыг өргөжүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөлөө. Үүнд:

1.1. Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хөрөнгийн зах зээлийг дэмжих чиглэлээр:

Улсын Их Хурал, Засгийн газраас хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн өмчит хуулийн этгээдийн тодорхой хувийн хувьцааг хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй арилжаалах, үнэт цаасны анхдагч зах зээлд нээлттэй хувьцаа, үнэт цаас гаргахад татварын дэмжлэг үзүүлэх, ногдол ашиг, хүүгийн орлогын суутган татварын хөнгөлөлт үзүүлэх зэрэг цогц арга хэмжээг авч хэрэгжүүлснээр Хөрөнгийн биржийн зах зээлийн үнэлгээ 3 дахин өсөж, түүхэндээ анх удаа 10 их наяд төгрөгийг даваад байна.

Энэхүү өсөлтийг тогтвортой хадгалах, цаашид нэмэгдүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, хөрөнгийн зах зээлийн эргэлтийг дэмжих зорилгоор дараах татварын бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөлөө. Үүнд:

1. Хөрөнгийн зах зээлийн эргэлтийг дэмжих, бүртгэлийг сайжруулах, хөрөнгө оруулалтын татварын орчныг тодорхой болгох

зорилгоор үнэт цаасны зах зээлд нээлттэй арилжаалсан Засгийн газар, аймаг, нийслэл, Монгол Улсад бүртгэлтэй албан татвар төлөгчийн өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаас борлуулсны орлогод ногдуулах аж ахуйн нэгж, хувь хүний орлогын албан татварыг 2027 он хүртэл 90 хувь, 2029 он хүртэл 50 хувиар үе шаттай хөнгөлөх;

2. Гадаадын хөрөнгө оруулагч Монголын хөрөнгийн зах зээлд шууд хөрөнгө оруулахад дотоодын хөрөнгө оруулагчаас ялгаатай татварын орчин үйлчилж байгаа нь гадаадын хөрөнгө оруулалт татахад сөргөөр нөлөөлж байна. Тодруулбал, Монголын үнэт цаасны зах зээлээс худалдан авсан үнэт цаасаа борлуулахад дотоодын хөрөнгө оруулагч анх худалдаж авсан дүн болон шимтгэлийн зардлаа хасаж, ашгаас татвараа тооцдог бол гадаадын хөрөнгө оруулагч орлогын нийт дүнгээс татвар тооцдог зохицуулалттай. Иймд гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газар, аймаг, нийслэл, Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаас борлуулахад гадаад, дотоодын хөрөнгө оруулагч ижил нөхцөлөөр холбогдох зардлыг хасаж тооцох боломжийг нээх;

3. Засгийн газар, аймаг, нийслэл, Монгол Улсад бүртгэлтэй албан татвар төлөгчийн өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаас борлуулсны орлогыг татвар төлөгч өөрөө тайлагнан төсөвт төлөхөөр татварын хуульд заасан. Монгол Улсын Засгийн газраас хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх цогц бодлогын хүрээнд хөрөнгө оруулагчдын татварын харилцааг хялбаршуулж, тайлан гаргах үүргээс чөлөөлж, хувьцаа, өрийн хэрэгсэл, бусад үнэт цаас борлуулсны орлогод ногдох албан татварыг үнэт цаасны төвлөрсөн хадгаламж болон кастодианы үйл ажиллагаа эрхэлдэг этгээд нэгдсэн журмаар суутган тооцож, төсөвт төлөх зэрэг болно.

1.2. Хувиараа бизнес эрхлэгчдийн татварын орчныг хялбаршуулж, хамрагдалтыг сайжруулах, татварын суурийг өргөжүүлэх чиглэлээр:

Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, татварын орчныг хялбаршуулах зорилгоор 2019 оны татварын хуулийн шинэчлэлээр жилд 50.0 сая төгрөгөөс доош борлуулалтын орлоготой хувиараа бизнес эрхлэгч татварын хялбаршуулсан горимоор үйл ажиллагааны нийт орлогын 1 хувиар албан татвар төлж, тайлагнах боломжийг олгосон.

Татварын хуулийн шинэчлэлийн үр дүнд бизнес эрхлэгч иргэдийн хувь хүний орлогын албан татвар тайлагналын хувь өссөн эерэг үзүүлэлттэй байна. Тухайлбал, 2019 онд хувиараа бизнес эрхлэгчдийн 7 хувь нь татвараа тайлагнадаг байсан бол энэ хэмжээ 2022 онд 28 хувь болж өсжээ. Эдгээр татварын тайлан ирүүлсэн иргэдийн 59 хувь нь хялбаршуулсан горимоор тайлагнасан байна.

Харин жилийн 50 сая төгрөгөөс дээш үйл ажиллагааны орлоготой хувиараа бизнес эрхлэгч борлуулалтын орлого, зардлаа өөрөө тооцож

татвараа тайлагнах одоогийн тогтолцоо нь татвар төлөгчийн хувьд хүндрэлтэй байдгаас төлбөрийн баримт олгохгүй байх, татвараас зайлсхийх сөрөг нөлөөг үүсгэж байна.

Иймд хувиараа бизнес эрхлэгчдийн татвар тайлагнах, төлөх үйл ажиллагааг хялбаршуулан, татварын хамрагдалт, бүртгэлийг сайжруулах зорилгоор орлогын босго хамаарахгүй өөрийн хүсэлтээр татварын хялбаршуулсан горимыг сонгох боломжийг олгохоор төлөвлөлөө.

Хоёр. Орон нутгийг орон сууцжуулах хөтөлбөрийг дэмжих татварын бодлогын арга хэмжээ

“Шинэ сэргэлтийн бодлого”-ын Хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжих бодлогын хүрээнд орон нутагт орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэхэд татварын бодлогоор дэмжлэг үзүүлж, нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг болон аймаг, сумдын нутагт нийтийн зориулалттай орон сууцны барилга барьж борлуулсны орлогод ногдох аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт үзүүлэхээр хуулийн төсөл боловсрууллаа.

Түүнчлэн орон нутагт түрээсийн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нийтийн орон сууцны зориулалттай барилгад хүн амьдран суух зориулалтаар орон сууц түрээслүүлсний орлогод ногдох хувь хүний болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт үзүүлэхээр төлөвлөлөө.

Хүснэгт 4.1. 2024-2029 онд ААНОАТ, ХХОАТ-аас хөнгөлөх орлого, хувь хэмжээ

Татвараас хөнгөлөх орлогын төрөл	Байршил	2024-2026	2027-2029
Борлуулалтын орлого /ААНОАТ/	Багануур, Багахангай, Налайх дүүрэг, Дархан-Уул болон Орхон аймгийн төвийн суманд	50%	20%
	Бусад аймаг, суманд	90%	50%
Түрээсийн орлого /ААНОАТ, ХХОАТ/	Багануур, Багахангай, Налайх дүүрэг болон аймаг, суманд	90%	50%

Гурав. Малчдын татварын орчныг хялбаршуулах, НӨАТ, малын тоо толгойн албан татвар тайлагнах үүргээс чөлөөлөх замаар малын гаралтай түүхий эдийн бүртгэлийг сайжруулах, боловсруулах үйлдвэрүүдэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээ

Татварын хуулиар жилийн 50.0 сая төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой малчин, мал бүхий этгээд нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) суутган төлөгчөөр бүртгүүлж, сар бүр НӨАТ-ын тайлан гаргах үүрэг хүлээдэг. Түүнчлэн, малын тоо толгойн албан татварын тайланг жил бүр малчин өөрөө бэлтгэж тайлагнах үүрэгтэй. Ийнхүү нэмэгдсэн өртгийн, хувь хүний орлогын болон малын тоо толгойн албан татварын тооцоо хийх,

бүртгэл хөтлөх, тайлан гаргах, тушаах зэргээр татварын хууль тогтоомж хэрэгжүүлэх нь малчдын хувьд хүндрэлтэй байна.

Улмаар малчид түүхий эдээ дотоодын боловсруулах үйлдвэр, хоршоонд нийлүүлэхээс илүүтэй дамжуулан борлуулагчдад бүртгэлгүй борлуулах хандлагатай байгаа нь боловсруулах үйлдвэрүүдийн өртөг болон татварын ачааллыг нэмэгдүүлэх, түүхий эдийн хомсдолд оруулах, малын гаралтай түүхий эдийн далд эдийн засгийг үүсгэх эрсдэлийг дагуулж байна. Энэ нь Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг дээшлүүлэх, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд сөрөг нөлөөг үзүүлж байна.

Иймд нэг талаас дотоодын боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих, нөгөө талаас малчдын татварын орчныг хялбаршуулж, таатай болгох зорилгоор дараах татварын арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөлөө. Үүнд:

1. Малчин, мал бүхий этгээдийн борлуулсан таван хошуу мал, анхан шатны боловсруулалтад ороогүй мах, сүү, арьс шир, хонь болон тэмээний ноос, ноолуур, сарлагийн хөөврийг НӨАТ-аас чөлөөлж, суутган төлөгч болж, тайлан гаргах шаардлагагүй болгох;

2. Малчин, мал бүхий этгээдийг малын тоо толгойн албан татварын тайлан гаргах шаардлагагүй болгож, татварын хуулийг хэрэгжүүлэх зардлыг бууруулж, татварын албанаас татварын тооцооллыг шууд тооцон мэдээлж, ногдуулах;

3. Жилийн 50.0 сая төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой малчид татвар ногдох орлого, зардлаа тооцон бүртгэж, төлбөл зохих татвараа өөрөө тодорхойлон хувь хүний орлогын албан татвараа тайлагнах шаардлагатай байдгийг өөрчилж орлогын хэмжээ үл хамаарч татварын хялбаршуулсан горимд хамрагдах боломжийг нээх зэрэг болно.

Хуулийн төсөл батлагдсанаар малчдын татварын тайлагнал, бүртгэлтэй холбоотой үүсдэг хүндрэлийг бууруулах, улмаар дотоодын боловсруулах үйлдвэрүүд НӨАТ-ын хасалтаа бүрэн хийлгэж, малын гаралтай түүхий эдийн нийлүүлэлтийг нэмэгдэх, цаашлаад малын гаралтай түүхий эдийн далд эдийн засгийг бууруулах ач холбогдолтой.

Дөрөв. Ашигт малтмал баяжуулах, боловсруулах үйлдвэрийг дэмжих татварын бодлогын арга хэмжээ

Уул уурхайн салбар нь Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 24 хувь, нэгдсэн төсвийн орлогын 29 хувь, нийт экспортын орлогын 85 орчим хувийг бүрдүүлдэг Монгол Улсын эдийн засгийн гол салбар юм.

Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын бүтцийг харахад нийт ашигт малтмалын экспортын 70 гаруй хувь нь баяжуулж, боловсруулаагүй бүтээгдэхүүн байна. Тухайлбал, 2022 оны нүүрсний нийт экспортын 78 хувь, төмрийн 76 хувь, жоншны 73 хувь нь тус тус баяжуулж, боловсруулаагүй бүтээгдэхүүн эзэлж байна. Энэ нь ашигт малтмалыг баяжуулж, боловсруулах замаар нэмүү өртөг шингээн экспортолноор уул уурхайн салбарын орлого нэмэгдэж, Монгол Улсын эдийн засгийн өсөлт нэмэгдэх нөөц бололцоо байгааг харуулж байна.

Улмаар уул уурхайн салбарын хөгжлийг дараагийн түвшинд хүргэх, тус салбарыг бодит хүчин чадлаар нь ажиллуулж, Монгол Улсын эдийн засагт үзүүлэх нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого” зэрэг Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод уул уурхайн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх тухай тус тус заасан.

Иймд ашигт малтмал баяжуулах, боловсруулах, нэмүү өртөг шингэсэн ашигт малтмалын баяжмал, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр төлөвлөлөө. Үүнд:

1. Засгийн газрын шийдвэрээр техник, эдийн засгийн үзүүлэлт бүхий баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах тоног төхөөрөмжийн нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг 4 жил хүртэл хугацаагаар сунгах, эсхүл уг татварыг 4 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх;

2. Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг сунгасан дээрх тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлөх зэрэг болно.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй баяжуулах, боловсруулах үйлдвэрүүд хүчин чадлаа нэмэгдүүлэх, шаардлагатай үйлдвэрийн шинэчлэлийг хийх, цаашлаад гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчид ашигт малтмал баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийг шинээр барьж байгуулахад томоохон дэмжлэг болно гэж үзэж байна.

Түүнчлэн, геополитикийн хурцадмал байдал, олон улсын эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан Улсын Их Хурлаас импортын автобензин, дизелийн түлшний гаалийн албан татварыг 0-5 хувьд багтаан тогтоохоор Засгийн газарт олгосон эрх 2024 онд дуусгавар болж ирэх оноос 5 хувийн татварт эргэн шилжихээр байна. Иймд олон улсад үүсээд байгаа нөхцөл байдалтай уялдуулан автобензин, дизелийн түлшний гаалийн албан татварыг 0-5 хувьд тогтоохоор Засгийн газарт олгосон эрхийг 2026 он хүртэл сунгахаар төлөвлөлөө.

Тав. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа, хилийн нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Ашигт малтмалыг уул уурхайн биржээр нээлттэй, ил тод олон улсын зах зээлийн үнээр борлуулах, түүнд хяналт тавих, бүртгэх цогц системийг бүрдүүлж, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын орлого, төсвийн орлогыг нэмэгдүүлэх, уул уурхайн экспорттой холбоотой далд эдийн засгийг бууруулах бодлогын арга хэмжээг 2024 онд эрчимжүүлнэ.

Энэ хүрээнд гааль, татварын байгууллагын бүртгэлийн системийг уялдуулан хөгжүүлж, ашигт малтмалын ачих, борлуулах, экспортлох, худалдах, худалдан авах гэрээ бүртгэх, гаалийн лабораторийн дүгнэлт гаргах, гаалийн бүрдүүлэлт хийх, төлбөрийн баримт олгох, татвар ногдуулах, тайлагнах үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, татварыг бүрэн ногдуулдаг болох шинэчлэлийг хэрэгжүүлнэ.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр дамжуулан арилжаанд оролцох аж ахуйн нэгжүүдийг нэмэгдүүлэх, ил тод, нээлттэй арилжааг дэмжих хөшүүрэг бий болгох үүднээс Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 345 дугаар тогтоолоор биржээр дамжуулан борлуулсан ашигт малтмалын бүтээгдэхүүний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээг биржийн үнэд үндэслэн тооцохоор болсон. Ингэснээр биржээр ашигт малтмалаа нээлттэй борлуулах хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн тоо нэмэгдэж, биржийн тогтолцоог өргөжүүлэхэд түлхэц болох юм.

Хилийн нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх хүрээнд хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, боомтуудыг хатуу хучилттай авто замаар холбох, боомтуудад ухаалаг гарцыг суурилуулах, дэд бүтцийг хөгжүүлэх зэрэг арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлнэ.

Зургаа. Татварын ачааллыг нэмэгдүүлэхгүйгээр татварын бүртгэлийг сайжруулан, далд эдийн засгийг бууруулж, татварын суурийг өргөжүүлнэ.

Засгийн газраас татварын ачааллыг нэмэгдүүлэхгүйгээр бүртгэл, татварын хамрагдалтыг сайжруулах, далд эдийн засгийг бууруулан татварын суурийг тэлж төсвийн орлогыг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Засгийн газраас өнгөрсөн жилүүдэд үе шаттай хэрэгжүүлж буй гааль, татвар, санхүүгийн бүртгэл, мэдээллийн уялдаа холбоог сайжруулж, бараа бүртгэлийн нэгдсэн систем, төлбөрийн баримтын бүртгэлийг боловсронгуй болгох ажлыг эрчимжүүлнэ. Тухайлбал, ашигт малтмалын олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын бүхий л үе шатыг худалдан, худалдан авах гэрээ, цахим төлбөрийн баримт, гаалийн лабораторийн

дүгнэлт, гаалийн бүрдүүлэлт, АМНАТ-ийн бүртгэл, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны мэдээлэлтэй уялдуулан цахимаар иж бүрэн бүртгэх, хянах, татварыг бүрэн хураах системийг улам бүр боловсронгуй болгоно.

Үндэстэн дамнасан компаниудын татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэх явдлаас урьдчилан сэргийлэх, татварын ил тод байдлыг хангах чиглэлээр Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэхийн эсрэг (BEPS) байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, үнэ шилжилтийн хяналт шалгалт, татварын мэдээлэл солилцох, татварын суурийг хамгаалах үйл ажиллагааг эрчимжүүлнэ. Түүнчлэн, Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор татварын гэрээтэй холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэх тухай олон талт конвенцод нэгдэн орж, хэрэгжилтийг хангуулснаар татварын суурийг хамгаалах үйл ажиллагааг өргөжүүлэх болно.

4.2 Төсвийн орлогын 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэл

Монгол Улсын Засгийн газраас хилийн боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, байгалийн баялгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлсний үр дүнд уул уурхайн салбарын олборлолт, экспорт нэмэгдэж, зарим бүтээгдэхүүний экспортын хэмжээ цар тахлын өмнөх үе буюу 2019 оны гүйцэтгэлийг давж биелэхээр байна. Мөн уул уурхайн бүтээгдэхүүний гадаад эрэлт өндөр байх төлөвтэй байгаа нь 2023 оны үлдэх хугацаанд манай улсын экспортын тогтвортой өсөлтийг дэмжиж, уул уурхайн болон уул уурхайгаас хамаарсан бусад салбарын орлогын өсөлтөд эерэг нөлөө үзүүлэхээр байна.


Түүнчлэн, тээвэр, худалдааны салбарын өсөлт эрчимжиж байгаа болон иргэдийн орлогыг хамгаалах зорилгоор хэрэгжүүлсэн цалин хөлсийг нэмэгдүүлэх бодлогын нөлөөгөөр дотоод эрэлт нэмэгдэж, эдийн засгийн идэвхжилд эерэг нөлөө үзүүлж байна. Улмаар нэгдсэн төсвийн нийт орлого 22.9 их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн орлого 21.8 их наяд төгрөгт хүрэхээр хүлээгдэж байна.

4.3 Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн нийт орлого

Засгийн газраас ирэх 2024 онд уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг дэмжих, хилийн боомтын дэд бүтцийг хөгжүүлэх, экспортыг эрчимжүүлэх, татварын бүртгэл, хамрагдалтыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлснээр нэгдсэн төсвийн нийт орлогыг 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 4.2 их наяд төгрөг буюу 18.5 хувиар нэмэгдүүлэн 27.2 их наяд төгрөг хүрнэ гэж тооцлоо. Үүнээс 513.7 тэрбум

төгрөгийг Төсвийн тогтворжуулалтын санд, 1,353.3 тэрбум төгрөгийг Ирээдүйн өв санд төвлөрүүлэхээр тооцлоо.

График 4.1. Нийт орлого ба тусламжийн дүн /их наяд Т/



Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагын дагуу тооцсон тэнцвэржүүлсэн нийт орлого 2024 онд 25.3 их наяд төгрөгт хүрэхээр, үүнээс 92.9 хувь буюу 23.4 их наяд төгрөгийг татварын орлого, 7.1 хувь буюу 1.8 их наяд төгрөгийг татварын бус орлогоор тус тус бүрдүүлэхээр тооцлоо.

Хүснэгт 4.2. 2024 оны нэгдсэн төсвийн нийт орлого /тэрбум Т/

Үзүүлэлт	Дүн
Нийт орлого ба тусламж	27,156.8
Тогтворжуулалтын сан	513.7
Ирээдүйн өв сан	1,353.3
Төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламж	25,289.8
1. Татварын орлого	23,436.2
1.1. Орлогын албан татвар	5,663.3
1.2. Нийгмийн даатгалын орлого	4,792.9
1.3. Хөрөнгийн албан татвар	237.5
1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	5,989.2
1.5. Онцгой албан тавар	991.0
1.6. Тусгай зорцуулалтын орлого	28.0
1.7. Гадаад үйл ажиллагааны орлого	1,928.7
1.8. Бусад татвар	3,805.7
2. Татварын бус орлого	1,853.5
2.1. Нийтлэг татварын бус орлого	1,295.2
2.2. Хөрөнгийн орлого	0.3
2.3. Тусламжийн орлого	558.0

4.4 Төсвийн тогтворжуулалтын сангийн орлого

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т заасны дагуу 2024 онд зэс, нүүрснээс төсөвт төвлөрөх орлогын хэмжээ нэгдсэн төсвийн орлогын гурваас дээш хувийг бүрдүүлэхээр тооцож байгаа тул эдгээр бүтээгдэхүүнийг “гол нэр төрлийн эрдэс баялаг” гэж тодорхойлон мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3.а-д заасны дагуу тэнцвэржүүлсэн үнийг тооцсон болно. Ирэх 2024 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнэ тонн тутамд 7,386.6 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнэ тонн тутамд 182.5 ам.доллар байна.

Эдгээр үнийг ашиглан 2024 онд зэсийн баяжмалын орлогоос 441.9 тэрбум төгрөг, нүүрсний орлогоос 71.8 тэрбум төгрөг, нийт 513.7 тэрбум

төгрөгийн орлогыг Төсвийн тогтворжуулалтын санд төвлөрүүлэхээр тооцлоо.

4.5 Ирээдүйн өв сангийн орлого

Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу Төсвийн тогтворжуулалтын санд хуваарилаад үлдэх хэсгийн 20 хувийг 2024 онд Ирээдүйн өв санд төвлөрүүлэхээр хуулийн төсөлд тусгалаа.

Ингэснээр ирэх 2024 онд Ирээдүйн өв санд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс 833.2 тэрбум төгрөгийг төвлөрүүлнэ.


Ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болон төрийн өмчийн үйлдвэрийн газрын төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгаас 520.1 тэрбум төгрөгийг хуваарилж, нийт 1,353.3 тэрбум төгрөгийг тус санд төвлөрүүлэхээр тооцлоо.

4.6 Уул уурхайн салбарын орлого

Засгийн газраас уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тогтолцоог өргөжүүлэх, хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, экспортыг эрчимжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлснээр 2024 онд нүүрсний экспортыг нийт 60.0 сая тоннд хүрэхээр тооцлоо.

Оюу толгой төслийн гүний уурхайн олборлолт эрчимжиж, зэсийн баяжмал дахь зэсийн агууламж нэмэгдэхээр байгаа бөгөөд 2024 онд нийт зэсийн баяжмалын экспортын хэмжээг 1.5 сая тоннд хүрэхээр тооцлоо. Зэсийн зах зээлийн үнийн хувьд олон улсын нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагын төсөөлөлд үндэслэн тонн тутамд 9,000.0 ам.доллар байхаар тооцсон болно.

График 4.2 Уул уурхайн болон бусад салбараас төвлөрүүлэх орлого



Эдгээр хүчин зүйлийг үндэслэн ирэх онд уул уурхайн салбарын орлого 8,001.2 тэрбум төгрөгт хүрч, төсвийн нийт орлогын 29 орчим хувийг бүрдүүлэхээр тооцлоо. Үүнээс ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоор 4,513.5 тэрбум төгрөг, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн төсөвт төвлөрүүлэх аж ахуйн

нэгжийн орлогын албан татварын орлогоор 1,919.4 тэрбум төгрөг, төрийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ногдол ашгийн орлогоор 546.6 тэрбум төгрөгийг төвлөрүүлнэ.

Уул уурхайн салбарын орлогыг бүтээгдэхүүнээр задлан *харуулбал*:


Хүснэгт 4.3. Уул уурхайн салбараас орох орлогын төлөвлөгөө /тэрбум Т/

Үзүүлэлт	Эс	Нүүрс	Алг	Бусад	Нийт
АМНАТ	1,417.7	2,656.7	218.0	221.0	4,513.5
ААНОАТ	480.8	1,296.4	41.4	100.7	1,919.4
Ногдол ашиг	458.0	27.3	-	37.1	546.6
Гаалийн татвар, хураамж	123.1	147.7	-	104.9	375.8
Бусад	276.4	176.1	33.2	184.5	646.0
Нийт	2,756.0	4,304.3	292.6	648.3	8,001.2

4.7 Татварын орлого

Ирэх онд нийт татварын орлого 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 17.3 хувиар нэмэгдэж, 23.4 их наяд төгрөгт хүрэхээр тооцлоо.

График 4.3. Төсвийн орлого, торлоор




Үүнээс 25.6 хувь буюу 5,989.2 тэрбум төгрөгийг нэмэгдсэн өртгийн албан татварын орлого, 20.5 хувь буюу 4,792.9 тэрбум төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлийн орлого, 24.2 хувь буюу 5,663.3 тэрбум төгрөгийг орлогын албан татварын орлого, 8.2 хувь буюу 1,928.7 тэрбум төгрөгийг гадаад үйл ажиллагааны орлого, 4.2 хувь буюу 991.0 тэрбум төгрөгийг онцгой албан татварын орлого, үлдсэн хэсгийг бусад татварын орлого бүрдүүлэхээр байна.

4.7.1 Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар

Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, уул уурхайн гол нэр төрлийн эрдэс бүтээгдэхүүний үнэ, биет хэмжээ, аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагааны түвшин зэрэгт үндэслэн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого ирэх онд энэ оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 22.6 хувиар өсөж 4,205.2 тэрбум төгрөгт хүрэхээр тооцлоо.

Ирэх онд эдийн засгийн идэвхжил үргэлжилж, дотоодын нийт бүтээгдэхүүн 74.0 их наяд төгрөгт, эдийн засгийн бодит өсөлт 7.0 хувь, нийт экспортыг 15,380.0 сая ам.долларт хүрэхээр тооцож байгаа нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогын төсөөлөл өсөхөд голлон нөлөөлөхөөр байна.


График 4.4 Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого /уул уурхай, уул уурхайн бус салбараар /тэрбум Т/



4.7.2 Хувь хүний орлогын албан татвар

Энэ оны 2 дугаар улирлын байдлаар аж ахуйн нэгж, байгууллагын дундаж цалин өмнөх оноос 22.4 хувиар нэмэгдэж, 1,890.0 мянган төгрөгт хүрсэн байна. Үүнд төсөвт байгууллагад ажиллагчдын сарын дундаж цалин өмнөх оны мөн үеэс 18.3 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

График 4.5. Хувь хүний орлогын албан татварын орлого /тэрбум Т/



Засгийн газраас иргэдийн орлогыг хамгаалах зорилгоор цалин хөдөлмөрийн хөлсийг инфляцын түвшинтэй уялдуулан цогцоор нь үе шаттай нэмэгдүүлэх, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэх зэрэг бодлогын арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тооцож, хувь хүний орлогын

албан татварын орлогыг 1,739.3 тэрбум төгрөгт хүрэхээр тооцсон болно.

4.7.3 Дотоодын барааны нэмэгдсэн өртгийн албан татвар

Ирэх онд нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын систем, цахим төлбөрийн баримтын бүртгэлийн системийг үе шаттай хөгжүүлэх, зах худалдааны төвүүдэд үйл ажиллагаа явуулж буй татвар төлөгч цахим худалдаагаар бараа, ажил үйлчилгээ борлуулагч иргэд, аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн баримт олгох ажлыг эрчимжүүлнэ.

График 4.6. Дотоодын нэмэгдсэн өртгийн албан татварын орлого



Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, цахим төлбөрийн баримтын системийн хамрагдалтын түвшин, татварын суурийг тэлэх арга хэмжээ, өмнөх жилүүдийн гүйцэтгэл зэргийг харгалзан 2024 онд дотоодын барааны нэмэгдсэн өртгийн албан татварын орлого энэ оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 26.0 хувиар өсөж, 2,419.0 тэрбум төгрөгт хүрэхээр тооцлоо.

4.7.4 Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар

Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, үнийн огцом хэлбэлзлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд газрын тосны зарим бүтээгдэхүүний гаалийн болон онцгой албан татварыг 2023 оны 244 дүгээр тогтоолоор “0” хүртэл хувиар 2025 он хүртэл тогтоосон.

Иймд ирэх 2024 онд автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын орлогоор нийт 20.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тооцлоо.

4.7.5 Суудлын автомашины онцгой албан татвар

Монгол Улсад импортолж байгаа нийт тээврийн хэрэгслийн 78 орчим хувийг хос тэжээлт, шингэрүүлсэн хийгээр ажилладаг автомашин эзэлж байна.

Суудлын автомашины импорт, импортолсон автомашины насжилт, хөдөлгүүрийн багтаамж зэргийг харгалзан ирэх онд суудлын автомашины онцгой албан татварын орлогоор 330.0 тэрбум төгрөг төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо.


4.7.6 Согтууруулах ундаа, тамхины онцгой албан татвар

Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хууль, түүнийг дагаж батлагдсан Онцгой албан татварын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд үндэслэн 2024 онд согтууруулах ундаа, тамхинд ногдуулах онцгой албан татварын орлогоор 641.0 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо.

4.7.7 Импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын орлого

Нийт импортын өсөлт, өмнөх жилүүдийн орлогын гүйцэтгэл болон импортын барааны хэрэглээний өсөлттэй уялдуулан ирэх онд гаалийн албан татварын орлогоор 1,934.7 тэрбум төгрөг, импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татварын орлогоор 4,060.2 тэрбум төгрөгийг тус тус төсөвт төвлөрүүлэхээр тооцов. Үүнд, шатахууны гаалийн албан татварыг 0-5 хувьд тогтоох Засгийн газарт олгосон эрхийг 2026 он хүртэл сунгахаар тооцсон болно.

График 4.8 Импортын гаалийн албан татвар болон НӨАТ



4.7.8 Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа томоохон аж ахуйн нэгжүүдийн 2024 оны олборлолт, экспортын төлөвлөгөө, олон улсын банк, санхүүгийн байгууллагаас гаргасан эрдэс бүтээгдэхүүний үнийн таамаглал, өмнөх онуудын гүйцэтгэл зэрэгт үндэслэн ирэх онд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоор 4,513.5 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 58.9 хувь буюу 2,656.7 тэрбум төгрөгийг нүүрс, 31.4 хувь буюу 1,417.7 тэрбум төгрөгийг зэсийн баяжмалын экспортоос төвлөрөх орлого эзэлж байна.

Ирэх 2024 онд нүүрсний экспорт 60.0 сая тонн, зэсийн баяжмалын экспорт 1.5 сая тонн, Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд тушаах алтны хэмжээ 20.0 тонн байхаар, харин нүүрсний үнэ тонн тутамд дунджаар 140.0 ам.доллар, зэсийн үнэ тонн тутамд 9,000.0 ам.доллар, алтны үнэ унц тутамд 1,950.0 ам.доллар байхаар төсөөлсөн болно.

4.7.9 Агаарын бохирдлын төлбөр

Агаарын бохирдлын төлбөрийн орлогоор ирэх онд 60.0 тэрбум төгрөг төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо. Үүний 95.0 орчим хувь буюу 57.0 тэрбум төгрөгийг олборлосон түүхий нүүрсэнд ногдуулах агаарын бохирдлын төлбөрөөр, үлдсэн 3.0 тэрбум төгрөгийг авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслээс ялгарах нүүрсхүчлийн хийнд ногдуулах төлбөрөөр тус тус төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо.

4.7.10 Хөрөнгийн албан татвар

Ирэх онд хөрөнгийн албан татварын орлогоор 237.5 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр тооцсон. Хөрөнгийн албан татварын орлогын 78.8 хувийг үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлого, 20.6 хувийг авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлого, 0.6 хувийг бууны албан татварын орлого тус тус эзлэхээр байна.

4.7.11 Газрын төлбөрийн орлого

Газрын суурь үнэлгээ, орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон итгэлцүүр, эзэмшил, ашиглалтад байгаа газрын мэдээлэл зэрэгт үндэслэн 2024 онд газрын төлбөрийн орлогоор 81.0 тэрбум төгрөг төсөвт төвлөрүүлэхээр тооцсон бөгөөд үүнээс газрын төлбөрийн орлогоор 75.0 тэрбум төгрөг, дуудлага худалдааны орлогоор 6.0 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлэхээр тооцов.

4.7.12 Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөр

Монгол Улсын хэмжээнд ашигт малтмалын ашиглалтын 1,888, хайгуулын 498, нийт 2,386 тусгай зөвшөөрөл бүртгэлтэй байна. Ашигт малтмалын тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан хувь хэмжээнд үндэслэн ирэх онд тусгай зөвшөөрлийн төлбөрөөр 29.6 тэрбум төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлэхээр тооцсон болно.

4.8 Татварын бус орлого

Ирэх онд нийт татварын бус орлогыг 1,853.7 тэрбум төгрөг байхаар тооцлоо. Үүнээс 30.1 хувийг тусламжийн орлого, 19.5 хувийг газрын тосны орлого, 16.2 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого тус тус эзлэхээр байна.

4.8.1 Газрын тосны орлого

Монгол Улсын Засгийн газраас нийт 17 талбайд 15 гэрээлэгч аж ахуйн нэгжтэй бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулан, газрын тосны хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс “Петрочайна дачин тамсаг” ХХК нь “Тосон-Уул 19”, “Тамсаг 21” талбайд, “Доншен газрын тос” ХХК нь “Зүүнбаян 97” талбайд олборлолтын үйл ажиллагаа явуулж байна.

График 4.9 Газрын тосны экспортын хэмжээ, үнэ



Нийт газрын тосны 94 гаруй хувийг “Петрочайна дачин тамсаг” ХХК, 6 орчим хувийг “Доншен газрын тос” ХХК экспортолж байна. Ирэх онд газрын тосны нийт экспортын хэмжээг 4.8 сая баррель, баррель тутамд газрын тосны үнийг 83.0 орчим ам.доллар байхаар төсөөлж, нийт 361.9 тэрбум төгрөгийг

газрын тосны орлогыг төсөвт төвлөрүүлэхээр тооцов.

4.8.2 Навигацийн орлого

Манай улсын газар нутаг дээгүүр дамжин өнгөрөх нислэг, олон улсын болон орон нутгийн нислэгийн буулт, хөөрөлтийн тоо, агаарын тээврийн хэрэгсэлд үзүүлэх үйлчилгээний хураамж зэрэгт үндэслэн навигацийн орлогоор ирэх онд улсын төсөвт 150.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлнэ гэж тооцлоо.

4.8.3 Хувьцааны ногдол ашиг

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайлан, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, ашигт ажиллагааны түвшинд үндэслэн ирэх онд 594.8 тэрбум төгрөгийн ногдол ашгийн орлогыг төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо. Үүнээс, 520.1 тэрбум төгрөгийн ногдол ашгийн орлогыг Ирээдүйн өв санд, 74.7 тэрбум төгрөгийн ногдол ашгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлнэ гэж тооцлоо.

4.9 Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бүртгэл, ангилал, тайлагналыг олон улсын жишиг аргачлалд нийцүүлж боловсруулсан журмын дагуу 2024-2025 оны татварын зарлагын төсөөллийг боловсруулан тооцлоо.

Татварын хууль тогтоомжийн дагуу эдлүүлэхээр татварын хөнгөлөлт, чөлөөлөлт 2023 онд 1,398.1 тэрбум төгрөг буюу нийт орлогын 6.1 хувь, 2024 онд 1,579.3 тэрбум төгрөг буюу 5.8 хувь, 2025 онд 1,736.5 буюу 5.6 хувь хүрэхээр байна.

Хүснэгт 4.4. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээ /тэрбум Т/

Үзүүлэлт	2021	2022	2023 ХБГ	2024 ТӨС	2025 ТӨС
Нийт орлогод эзлэх хувь	6.8	6.5	6.1	5.8	5.6
Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт	964.0	1,199.1	1,398.1	1,579.3	1,736.5

МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛ

ААНОАТ	289.0	443.3	535.5	607.4	668.1
НӨАТ	303.8	304.9	350.9	398.0	437.8
Гааль	59.9	63.5	68.5	76.7	83.5
ХХОАТ	181.6	202.2	220.9	250.6	275.6
ОАТ	129.6	185.2	222.3	246.8	271.4

V

ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДАЛ

5.1 Урсгал зардлын хуваарилалтад баримтлах бодлого

“Шинэ сэргэлтийн бодлого”-ын Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд иргэдийн бодит орлогыг хамгаалах, шинээр батлагдсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай төсвийг хуваарилна.

5.2 Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн урсгал зардлын тойм

Төсвийн нийт урсгал зардал 2024 онд 21.3 их наяд төгрөгт хүрэхээр байгаа бөгөөд үүний 60.0 хувийг төрөөс иргэдэд олгодог тэтгэвэр, тэтгэмж, халамж, хүүхдийн мөнгө, болон хуульд заасны дагуу тарифаар гүйцэтгэлд үндэслэн санхүүждэг эрүүл мэнд, боловсролын салбарын цалин хөлс, 16.0 хувийг төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагаатай холбоотой зардал, 15.0 хувийг бусад салбарын цалин хөлс нэмэгдэл, урамшууллын зардал, 6.0 хувийг гадаад, дотоод зээлийн хүүгийн төлбөр, 3.0 хувийг төрөөс иргэн, аж ахуй нэгжид олгох хөнгөлөлт татаас тус тус эзэлж байна.

5.3 Урсгал зардлын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тойм

Иргэдийн бодит орлогыг хамгаалах багц арга хэмжээг хэрэгжүүлнэ

Нэг. Цалин, тэтгэвэр, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлнэ.

Төрийн албаны цалингийн тогтолцоонд шинэчлэл хийх, тэтгэврийн зөрүүг арилгах, нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх зэргээр иргэдийн орлогын баталгааг сайжруулах арга хэмжээг 2023 оны төсвийн бодлогын хүрээнд авч хэрэгжүүлсэн. Тухайлбал,

Адил үнэлэмж бүхий ажил хөдөлмөр эрхэлж байгаа албан хаагчийн цалин хөлс ижил байх зарчим баримталж хэт олон сүлжээ, шатлал бүхий харилцан адилгүй, тэгш бус үнэлэмжтэй төрийн албаны цалингийн сүлжээг шинэчлэн 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлснээр нийт 217.7 мянган албан хаагчдын цалин хөлс дунджаар 40 хувиар нэмэгдээд байна.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “тэтгэврийн зөрүүг ойртуулах” зорилтын хүрээнд тэтгэвэр тогтооход баримталсан цалин хөлсийг 2022 оны дундаж цалингаар суурь болгон индексжүүлсэн. Үүний зэрэгцээ тэтгэврийн зөрүүг арилгасны дараах сууриас тооцож тэтгэврийн хэмжээг үнийн өсөлттэй уялдуулж 10.0 хувь нэмсэн ба энэхүү арга хэмжээнд нийт 496.3 ахмад хамрагдсан.

Мөн 2023 оны 7 дугаар сараас эхлэн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлсэн. Нийгмийн даатгалаас тэтгэвэр авах эрх үүсээгүй хүнд олгох халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгодог тэтгэмж тус бүр 288.0 мянган төгрөг байгааг нэгэн адил 325.0 мянган төгрөгт, нийгмийн халамжийн асаргааны тэтгэмж 84.5 мянган төгрөг байгааг 275.0 мянган төгрөгт, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг, эхэд олгох тэтгэмж 123.1 мянган төгрөг байгааг 275.0 мянган төгрөгт хүргэж тус тус нэмэгдүүлсэн. Энэхүү арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 144.4 мянган хүн хамрагдсан байна.

Ирэх 2024 онд иргэдийн орлогыг хамгаалахад чиглэсэн багц арга хэмжээг үргэлжлүүлэх бодлого баримталж энэ хүрээнд цалин, тэтгэврийг эдийн засгийн өсөлт, инфляц, амьжиргааны түвшинтэй уялдуулан индексжүүлэх, түүнчлэн 2023 онд шинээр батлагдсан нийгмийн даатгал болон боловсролын багц хуулийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөж байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр болон нийгмийн халамжийн тэтгэвэр, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгодог тэтгэмж, нийгмийн халамжийн асаргааны тэтгэмж, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг, эхэд олгох тэтгэмжийн хэмжээг үнийн өсөлттэй уялдуулан 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 10.0 хувиар нэмэгдүүлэхээр тооцлоо. Энэхүү арга хэмжээнд 516.8 мянган тэтгэвэр авагч, давхардсан тоогоор нийт 146.9 мянган нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай хүн хамрагдана.

Ирэх онд төрийн албан хаагчдын цалин хөлсийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх бөгөөд нийтлэг төрийн үйлчилгээ, хот тохижилт үйлчилгээний салбарын ажиллагсдын үндсэн цалинг 20 хувиар, бусад төрийн албан хаагчдын цалинг 10 хувь нэмэгдүүлэхээр тооцож шаардагдах зардлыг төсвийн төсөлд тусгалаа. Тус арга хэмжээнд нийт 217.7 мянган төрийн албан хаагч хамрагдана.

Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд хотын төвлөрлийг сааруулах, төрийн албан хаагчид орон нутагт тогтвор, суурьшилтай ажиллах нөхцөлийг баталгаажуулах зорилгоор орон нутгийн нэмэгдлийг 2023 оноос эхлэн олгож байна. Аймаг, суманд ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид 20 ба түүнээс дээш хувийн нэмэгдэл авч эхлээд байгаа бол орон нутгийн боловсрол, эрүүл мэнд, соёл зэрэг нийгмийн суурь үйлчилгээний салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид 8-20 хувийн нэмэгдэл авч байна.

Ирэх 2024 онд хөдөөгийн суманд ажиллаж байгаа төрийн захиргаа, төрийн үйлчилгээ, улс төрийн албан хаагчдад сар бүр үндсэн цалингийн 40

хувиар, харин аймгийн төвийн сум болон нийслэлийн алслагдсан гурван дүүрэгт ажиллаж байгаа төрийн албан хаагчдад сар бүр үндсэн цалингийн 20 хувиар тус тус тооцож орон нутгийн нэмэгдэл олгохоор төлөвлөж байна. Уг нэмэгдэлд төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчид болон улс төрийн албан хаагчид шинээр хамрагдах бөгөөд энэхүү нэмэгдлийг олгохтой холбогдуулан Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

Улсын Их Хурлаас 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын багц хууль (шинэчилсэн найруулга)-ийн дагуу орлогын эрсдэлд өртөж болзошгүй зарим даатгуулагч иргэдийн төлөх шимтгэлийн ачааллыг хөнгөлөх, залуучуудын ирээдүйд авах тэтгэврийн өгөөжийг нэмэгдүүлэх эрх зүйн орчин бүрдсэн. Тус хуулийн дагуу залуу малчдын нийгмийн даатгалд хамрагдах сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор төрөөс малчдын нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийг, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа иргэний шимтгэлийг 100 хувь хариуцах, нийт даатгуулагчдын тэтгэвэр тогтоолгоход баримтлах дараалсан 7 жилийг 5 жил болгож бууруулах, тэтгэврийн хуримтлалын нөөц санг мөнгөжүүлэх зэрэг арга хэмжээнд шаардагдах зардлыг төсвийн төсөлд тусгалаа.

Мөн Улсын Их Хурлын 2023 оны хаврын чуулганаар батлагдсан Боловсролын багц хууль (шинэчилсэн найруулга)-д багш, ажиллагчдын нийгмийн баталгааг сайжруулахад чиглэсэн зохицуулалтууд тусгагдсан. Тухайлбал, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа багш, ажиллагчдад олгодог тэтгэмжид хамрагдах хүний тоо 2.3 дахин нэмэгдэхээр байгааг харгалзан шаардлагатай нэмэлт зардлыг төсвийн төсөлд тусгалаа.

Түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежид 15-аас доошгүй жил тасралтгүй ажилласан багш, ажилтны нэг хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй, хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцахад нь шаардагдах тэтгэлгийн зардлыг тусгав.

Төрийн албаны тухай хуульд 2022 оны 11 дүгээр сарын 11-ны өдөр орсон өөрчлөлтийн дагуу сум болон нийслэлийн алслагдсан гурван дүүрэгт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгохоор заасны дагуу шаардагдах зардлыг төсөвт тусгалаа.

Монгол Улсын гаалийн албаны хилийн боомтод буюу хөдөө орон нутагт байрлах харьяа гаалийн газар, хороодод 1.2 мянган гаалийн байцаагч ажиллаж байна. “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Боомтын сэргэлтийн арга хэмжээний хүрээнд хилийн зарим боомтыг 24 цагийн

ажиллагаанд шилжүүлэх, гаалийн нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэхийн тулд байцаагч нарын ачааллыг нягтруулах, уртасгасан цагаар ажиллуулах гэх мэт зохион байгуулалтын арга хэмжээг авч байна. Гаалийн байцаагч нарыг тогтвортой ажиллуулах, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, үр дүнг сайжруулахын тулд тэдний нийгмийн асуудлын мөн шийдвэрлэх шаардлагатай гэж үзсэн тул Гаалийн тухай хуульд аймгийн төвийн сумаас бусад суманд тасралтгүй ажиллаж байгаа гаалийн албан хаагчдад таван жил тутамд нэг удаа 12 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох өөрчлөлтийг оруулахаар хуулийн төслийг боловсруулж, тус арга хэмжээг хэрэгжүүлэх зардлыг 2024 оны төсвийн төсөлд тусгалаа.

2022 оны 12 дугаар сарын 23-ний өдөр батлагдсан Шүүх шинжилгээний тухай хууль (шинэчилсэн найруулга)-д аймаг, сумын нутаг дэвсгэр хариуцсан шинжилгээний байгууллагад тасралтгүй ажиллаж байгаа алба хаагчид 5 жил тутамд нэг удаа 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг тухайн байгууллагаас олгоно гэж заасны дагуу нэмж шаардагдах зардлыг тооцож тусгалаа.

Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор газар тариалан, мал аж ахуй, хүнс, хөнгөн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн хүүгийн татаас, урамшууллын зардлыг тооцон тусгав.

Тухайлбал, газар тариалан, мал аж ахуй, хүнсний боловсруулах үйлдвэрлэлийг сайжруулахад зориулж малчид, газар тариалан эрхлэгчид болон хүнсний үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд олгох эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээлийн хүүгийн хөнгөлөлтөд 125.3 тэрбум төгрөг, бусад арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах урсгал зардалд 98.4 тэрбум төгрөг, нийт 223.7 тэрбум төгрөгийг тусгалаа.

Ирэх онд тохиох онцлог арга хэмжээг санхүүжүүлнэ.

Нэг.Улсын Их Хурал болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийг зохион байгуулна.

2024 онд Улсын Их Хурлын болон орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газар болон цагдаагийн байгууллагад шаардагдах зардлыг төсвийн төсөлд бүрэн тусгалаа.

Хоёр. "Парис-2024" зуны Олимп, Паралимпын наадамд оролцоно.

2024 онд Бүгд Найрамдах Франц Улсын Парис хотод зохион байгуулагдах "Парис-2024" зуны Олимп, Паралимпын наадамд Монгол Улсын шигшээ багийн 260 гаруй тамирчныг спортын 27 төрлөөр оролцуулж, Олимпын наадмаас 4-5 медаль, Паралимпын наадмаас 3 медалийг эх орондоо авчрах зорилтыг тавиад байна. Олимпын наадамд

оролцох үндэсний шигшээ багийн үйл ажиллагааны зардал, тамирчдын цалин хөлс, олимпын бэлтгэл, эрх авах болон оноо цуглуулах уралдаан, тэмцээнүүдэд оролцох, ёслолын болон бэлтгэлийн хувцас хэрэглэл, материалын зардлыг 2024 оны төсвийн төсөлд бүрэн тусгалаа.

Гурав.Цэнгэг усны нөөц, гол мөрний бохирдлыг бууруулахад шаардагдах зардлыг төсөвт тусгана.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Цэнгэг усны нөөц, гол, мөрний урсац бүрэлдэх эх зэрэг онцлог экосистемийг тусгай хамгаалалтад авч, унаган байгалийг хамгаалах арга хэмжээний хүрээнд Хөвсгөл нуурыг хамгаалах, бохирдлыг бууруулах зорилгоор тус нуурт 1950-2020 онуудад живсэн машин техникийг илрүүлэх хайгуул судалгаа хийх, татан гаргах үйл ажиллагаанд шаардагдах зардлыг төлөвлөлөө.

Шинэ сэргэлтийн бодлогыг дэмжих арга хэмжээг санхүүжүүлнэ

Нэг.Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын нөлөөлөлд өртөж байгаа иргэдийн нөхөх олговор, эд хөрөнгийн нөхөн төлбөрийг үлдэгдэл санхүүжилтийг бүрэн олгоно.

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын усан сан бүрэлдэх талбайд оршин сууж байгаа Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын 145 өрх, Увс аймгийн Өмнөговь сумын 125 өрх, Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын 3 өрх, Мянгад сумын 5 өрх нийт 278 өрхийн 1280 иргэдийг нүүлгэн шилжүүлж, тэдгээр хүмүүст олгох нэг удаагийн нөхөх олговор болон эд хөрөнгийн нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэн зардлыг 2023 оны төсөвт тусган санхүүжүүлж байна.

Эдгээр үйл ажиллагааны үлдэгдэл санхүүжилтийг 2024 онд бүрэн олгож дуусгахаар төлөвлөн санхүүжилтийг тусгалаа.

Хоёр.Хайгуулын болон ашиглалтын судалгааны зардлыг нэмэгдүүлнэ.

Монгол Улс эрдэс түүхий эдийн зах зээлд нэвтрэх, эрэлтийн өсөлттэй уялдуулан нийт газар нутгийн хэмжээнд ашигт малтмалын хэтийн төлөвөө тодорхойлох зорилгоор агаарын геофизикийн судалгааны ажлыг орчин үеийн техник, технологийн дэвшил, шинэлэг арга, аргачлалыг ашиглан гүйцэтгэхэд шаардагдах геологи, хайгуул судалгааны зардлыг төлөвлөн тусгалаа. Тус судалгааны ажил нь Монгол орны өмнөд хэсгийн 255 мянган кв.км талбайг хамруулан хэрэгжих бөгөөд судалгааны үр дүнг геологи, уул уурхайн салбарт түлхүү ашиглахаас гадна хөдөө аж ахуй(хөрсний доройтол), гамшиг (газар хөдлөлт, хөрсний гулгалт), аялал жуулчлал зэрэг олон салбарт ашиглах боломж бүрдэнэ.

Гурав.Боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

Боомтын сэргэлтийг дэмжих төслүүдийг эрчимжүүлж, хилийн боомтуудын нэвтрэх хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд

агаарын замын хил /Дэглий-цагаан/, авто замын хилийн боомт /Цагаан дэл уул, Бичигт, Боршоо, Бургастай, Алтанбулаг, Замын-Үүд/, төмөр замын хилийн боомт /Шивээхүрэн, Гашуунсухайт/-ын орон тоо, холбогдох төсвийг тооцон тусгалаа.

Дорov.Хууль, тогтоомжид заасны дагуу төрийн байгууллагуудын чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг тусгана.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд Төрийн албаны төв байгууллагын дэргэд төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг зарчим, хэм хэмжээ, ёс зүйн асуудал эрхлэх байгууллагын тогтолцоо, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиг үүрэг бүхий Ёс зүйн хороо бие даасан хараат бус зарчмаар ажиллаж, хорооны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр хуульчилсантай холбогдуулан 2024 оны төсвийн төсөлд тус хороог 24 орон тоотой байхаар төлөвлөж холбогдох зардлыг тусгалаа.

Нийслэл Улаанбаатар хотын газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн менежментийг сайжруулах зорилгоор Засгийн хэрэгжүүлэгч агентлаг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрыг Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд ажиллуулах зохицуулалтыг төсвийн төсөлд тусгалаа.

Төрийн цэрэг болон хууль сахиулах байгууллагуудын албан хаагчдын бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлэх хүрээнд офицер, ахлагч, хугацаат болон гэрээт цэргийн албан хаагчид, сонсогчийн цэргийн дүрэмт хувцас, хэрэглэлээр хангах, хоол, батлагдсан норм стандартын дагуу шатах тослох материал, хээрийн дадлага, сургуулилалт, машин, техник хэрэгслийн урсгал засвар, үйлчилгээ, оюутан-цэрэг эх оронч хүмүүжил төлөвшүүлэх, эх орноо батлан хамгаалах бэлтгэл эзэмшүүлэх хөтөлбөртэй холбогдсон холбогдох төсвийг тооцон тусгалаа.

2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан Шүүх шинжилгээний тухай хууль (шинэчилсэн найруулга)-аар магадлан итгэмжлэгдсэн шинжилгээний лаборатори, шинжилгээний адилтгал, мэдээллийн сан, нутаг дэвсгэр хариуцсан шинжилгээний байгууллагын үйл ажиллагааг зохицуулсантай холбогдуулан шинжээчийн орон тоо, урсгал зардлыг тооцон тусгав.

“Үндэсний энгийн гадаад паспортын загвар, тодорхойлолтыг батлах тухай” Засгийн газрын 2022 оны 155 дугаар тогтоол, мөн “Төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд байгуулж, дүрмийг батлах тухай” Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор “Төрийн үнэт цаас хэвлэл” ХХК-ийг байгуулж, 2023 оны 03 дугаар сарын 01-ны өдрөөс дотоодын үйлдвэрлэгчээс нийлүүлсэн үндэсний энгийн гадаад паспортад бичилт хийж иргэдэд олгож эхэлсэнтэй холбоотойгоор 350.0 мянган ширхэг цахим гадаад паспорт, 50.0 мянган ширхэг энгийн

гадаад паспортын бэлдэц хэвлэх зардал, алсын зайнаас уншигддаг чиптэй 300.0 мянган ширхэг иргэний үнэмлэх хэвлэх зардлыг тооцон тусгалаа.

Хүн амын өсөлт, үнэ тарифын өөрчлөлттэй холбоотой зардлыг төсөвт тусгана.

Нэг.Хүүхдийн мөнгөн тэтгэмж

2023 онд 0-18 хүртэлх насны 1,280.4 мянган хүүхэд хүүхдийн мөнгөн тэтгэмж авч байгаа бол ирэх 2024 оны шинэ төрөлт болон 18 насанд хүрч байгаа хүүхдийн зөрүүгээр тус тэтгэмжид хамрагдах хүүхдийн тоог 22.0 мянгаар нэмэгдүүлэн тооцож, нийт 1,302.4 мянган хүүхдэд сар бүр 100.0 мянган төгрөгийн тэтгэмжийг олгохоор тооцлоо.

Хоёр.Боловсролын үйлчилгээ

2022-2023 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 12 дугаар ангийг 33.2 мянган хүүхэд төгссөн бөгөөд 2023-2024 оны хичээлийн жилд 1 дүгээр ангид 72.9 мянган хүүхэд шинээр элсэн суралцана. Ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа хүүхдийн тоо 30.7 мянгаар нэмэгдэхээр байгаа ба холбогдох гүйцэтгэл, үр дүнгээр олгох санхүүжилтийг нэг суралцагчид ногдох хувьсах зардлаар тооцоолон төлөвлөлөө.

Гурав.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор бүс нутгийн онцлогийг харгалзсан ялгаатай санхүүжилтийг сумын эрүүл мэндийн төвийн эмнэлгүүдэд олгох, нэн шаардлагатай тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн санхүүжилтэд түлхүү анхаарч, төрийн албан хаагчийн цалингийн өсөлттэй уялдуулан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тарифт тохируулга хийхээр тооцож шаардагдах зардлыг тооцож тусгав.

Дөрөв.Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ

Хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт, бага цалин хөлстэй иргэдийн орлогыг хамгаалах хэрэгцээ шаардлагатай уялдаж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ ирэх онд нэмэгдэхээр байна. Үүнтэй уялдан төрөөс эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг нь хариуцдаг зарим иргэдийн шимтгэлийн зардлыг нэмэгдүүлэхээр тооцлоо. Үүнд 0-18 насны хүүхэд, тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн, хүүхдээ асарч байгаа эх, хугацаат цэргийн албаны хаагч, ялтан, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэд хамрагдана.

Тав.Тогтмол зардлын тарифын өөрчлөлтийг төсөвт тусгана.

КОВИД-19 цар тахлын улмаас үүссэн эдийн засгийн хүнд нөхцөл байдалтай холбогдуулан 2020 оноос хойш нэмэгдүүлээгүй байсан байр ашиглалтын тогтмол зардал болох гэрэл цахилгаан, халаалт, цэвэр бохир

усны тарифыг 2022 оны 11 дүгээр сараас эхлэн нэмэгдүүлсэн. Үүнтэй холбоотойгоор төсөвт байгууллагын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг нэмэгдүүлэн тооцож тусгалаа.

5.4 Засгийн газрын тусгай сангууд

2024 онд Засгийн газрын тусгай сангуудаар дамжин нийт 10,135.8 тэрбум төгрөгийн зардал санхүүжүүлэх бол үүний 93.7 хувь буюу 9,505.7 тэрбум төгрөг нь Нийгмийн даатгал, Нийгмийн халамж, Эрүүл мэндийн даатгалын сангуудын зарлага, 6.3 хувь буюу 630.1 тэрбум төгрөг нь бусад тусгай сангийн зардалд хамаарч байна.

Хүснэгт 5.1. Засгийн газрын тусгай сангийн зардлын төсөл /тэрбум Т/

	ЗГ-ын тусгай сан	2023 төсөв	2024 төсөл
1	Боловсролын зээлийн сан	92.0	126.3
2	Нийгмийн даатгалын сан	4,152.7	5,145.5
3	Соёл, урлаг хөгжүүлэх сан	0.8	0.8
4	Засгийн газрын нөөц сан	80.0	80.0
5	Нийгмийн халамжийн сан	2,209.0	2,389.6
6	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	92.4	84.3
7	Эрүүл мэндийг дэмжих сан	2.0	10.0
8	Байгаль орчин, уур амьсгалын сан	0.6	0.7
9	Шинжлэх ухаан, технологийн сан	16.3	13.6
10	Улсын авто замын сан	61.4	61.4
11	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	5.2	5.2
12	Хилийн чанадад байгаа Монгол улсын иргэдэд туслах сан	0.4	0.4
13	Зэвсэгт хүчний хөгжлийн сан	35.0	35.0
14	Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан	79.8	200.6
15	Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан	0.6	0.6
16	Спортыг дэмжих сан	0.0	1.2
17	Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сан	0.0	7.9
18	Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан	0.0	2.0
19	Эрүүл мэндийн даатгалын сан	1,603.5	1,970.6
20	Кино урлагийг дэмжих сан	0.1	0.1
	НИЙТ	8,431.8	10,135.8

Боловсролын зээлийн сан

Боловсролын зээлийн сангийн 2024 оны төсвийн төсөлд 2023 оны батлагдсан түвшнээс зарим зардлыг нэмэгдүүлэн төлөвлөлөө. Үүнд 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгад тусгагдсан сургалтын тэтгэлгийн хөнгөлөлт, чөлөөлөлтөөс гадна Засгийн газрын 2022 оны 346 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын

суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын 2.1.11-т заасан “төрийн өмчийн их, дээд сургуульд багш мэргэжлээр суралцагч”-д олгох тэтгэлэгтэй холбоотой зардал багтаж байна. Түүнчлэн Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлгийн хамрах цар хүрээг нэмэгдүүлж, холбогдох зардлыг тус сангийн 2024 оны төсвийн төсөлд тусгалаа.

Нийгмийн халамжийн сан

Халамжийн сангийн нийт зарлагыг 826.7 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 151.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүллээ. Уг төсөв нь 2023 оны төсвийн тодотголоор нэмэгдүүлсэн нийгмийн халамжийн тэтгэвэр, нийгмийн халамжийн асаргааны тэтгэмж, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж болон тухайн хүүхдийг асарч байгаа эцэг эхэд олгох асаргааны тэтгэмжийг нэмэгдүүлэх тооцоололтой холбоотой төсвийн нөлөөллийг оруулсан.

Мөн инфляцын түвшин, дундаж цалин хөлсний өөрчлөлттэй уялдуулан 2024 оны 4 дүгээр сараас дээрх 4 төрлийн халамжийн тарифыг 10 хувь нэмэгдүүлэхээр тооцлоо.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйлчилгээ, арга хэмжээ, хөтөлбөрүүдийг тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан, үр дүнд суурилсан төсвийн хуваарилалтын зарчимд нийцүүлсэн шинэчлэлийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Эдгээр хөтөлбөр, арга хэмжээнд шаардагдах зардлыг төлөвлөхдөө орон нутгийн онцлог, нөхцөл боломж, хэрэгцээ шаардлагад нийцүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор Халамжаас-Хөдөлмөрт шилжих, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ажиллах хүчин бэлтгэж, хөдөлмөрийн нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлэх, зорилтот бүлэг, зорилтот бүс нутгийн онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой нийцүүлэн боловсрууллаа.

Мэргэжлийн боловсролыг дэмжих сан

Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганаар Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан. Уг хуулийн 29 дүгээр зүйлд мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийн зарцуулах харилцааг зохицуулсны дагуу холбогдох зардлыг 2024 оны тус сангийн төсвийн төсөлд тусгалаа.

Мөн “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив батлах тухай”

Засгийн газрын 2023 оны 200 дугаар тогтоолын дагуу төрийн болон төрийн бус өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төсвийг төлөвлөж, чанар, үр дүнд үндэслэсэн гүйцэтгэлд суурилсан зарчмаар санхүүжүүлэхээр холбогдох зардлыг тус сангийн 2024 оны төсвийн төсөлд тус тус тусгалаа.

Нийгмийн даатгалын сан

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсөвт нийт шимтгэлийн орлогын хэмжээг 4,469.6 тэрбум төгрөг, нийт зарлагын хэмжээг 5,145.5 тэрбум төгрөг байхаар төсөвлөлөө. Улсын төсвөөс тэтгэврийн даатгалын сангийн 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэвэр, цэргийн албан хаагчдын тэтгэвэр, Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай хууль, тэтгэврийн нөөц сангийн мөнгөжүүлэх арга хэмжээнд нийт 1,134.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор тооцлоо.

Тэтгэврийн сангийн нийт алдагдал 998.7 тэрбум төгрөг байгаа нь өмнөх онтой харьцуулахад 246.4 тэрбум төгрөг буюу 32.8 хувиар нэмэгдсэн. Шалтгаан нь нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авагч даатгуулагчдын тооны өсөлт, Улсын Их Хурлын 7 дугаар сарын 7-ны өдрийн чуулганаар батлагдсан Нийгмийн даатгалын багц хуулиудын өөрчлөлт, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлсэн 2023 оны төсвийн тодотголын нөлөөлөл болон 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 10 хувиар нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй холбоотой.

Тэтгэмжийн даатгалын сан, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан, ажилгүйдлийн даатгалын сан зэрэг бусад сангуудын тэнцэл нийт 390.0 тэрбум төгрөгийн ашигтай гарч хуримтлагдахаар байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого: Нийгмийн даатгалын сангийн нийт орлогыг эдийн засгийн идэвхжил нэмэгдэх, Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтийг хангах, нийгмийн даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон төрийн албан хаагчдын цалинг нэмэх зэрэг шалтгаануудыг тооцож 2023 оноос 1,068.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 4,469.6 тэрбум төгрөг байхаар тооцлоо.

Нийгмийн даатгалын сангийн зарлага: Нийгмийн даатгалын сангийн нийт зарлага 5,145.5 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь 2023 онтой харьцуулахад 992.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна. Иргэдийн тэтгэвэр, тэтгэмжид зарцуулах хөрөнгийг нэмэгдүүлэхдээ тэтгэвэр авагчдын тооны өсөлт, 2023 онд хийгдсэн төсвийн тодотголын арга хэмжээг үргэлжлүүлэх, Нийгмийн даатгалын багц хуулиудын хэрэгжилтийг хангах, тэтгэврийн хэмжээг 2024 оны 4 дүгээр сараас 10 хувиар нэмэгдүүлэх зэрэг нөлөөллийг тооцлоо.

Нийгмийн даатгалын сангийн Капитал банкнаас авах 67.2 тэрбум төгрөгийн авлагыг тусгав.

Эрүүл мэндийн даатгалын сан

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн нийт орлогыг 2,002.2 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн. Үүний 1,108.4 тэрбум төгрөгийг төр хариуцах эмнэлгийн тусламж, үйлчилгээ, төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцан төлөх даатгуулагчдын шимтгэлийн орлогоос тус тус бүрдэхээр байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага: Эрүүл мэндийн даатгалын сангийн нийт зарлагыг 1,970.6 тэрбум төгрөг байхаар төлөвлөлөө. Үүнээс эрүүл мэндийн байгууллагад олгох тусламж, үйлчилгээний санхүүжилтийг 1,758.8 тэрбум төгрөг, эрсдэлийн санг 54.6 тэрбум төгрөг, төр хариуцах эмийн зардлын хяналт, хүртээмжийг сайжруулах зорилгоор эмийн үнийн хөнгөлөлтөд олгох санхүүжилтийг 140.0 тэрбум төгрөг, үйл ажиллагааны зардлыг 17.2 тэрбум төгрөг байхаар тус тус тооцлоо.


VI

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

6.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын судалгаа, статистик

Улсын төсвийн хөрөнгө оруулалт нь аливаа улс орны нийгмийн болон эдийн засгийн дэд бүтцийг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн. Монгол Улсын хувьд ч мөн нийгмийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангахад шаардлагатай төсөл, арга хэмжээний дийлэнх хэсгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байна. Монгол Улсын нийт хөрөнгө оруулалтын дунджаар 10 орчим хувийг улсын төсвийн хөрөнгө оруулалт эзэлж байна.

График 6.122. Нийт хөрөнгө оруулалтын тоон мэдээлэл /тэрбум Т/



Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хувьд жилд дунджаар ДНБ-ний 4 хувьтай тэнцэх хэмжээний санхүүжилт батлагдаж, нийгэм, эдийн засгийн олон асуудлыг шийдвэрлэх барилга байгууламж, дэд бүтэц, бүтээн байгуулалтын төслүүдийг хэрэгжүүлсэн.

Нийт хөрөнгө оруулалтын 10 орчим хувийг улсын төсвийн хөрөнгө оруулалт эзэлж байна.

График 6.223. Төсвийн хөрөнгө оруулалтын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь, мэдээлэл /тэрбум Т/



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016-2023 онд нийтдээ 10.1 их наяд төгрөгийн санхүүжилт батлагдаж, давхардсан тоогоор 6306 төсөл, арга хэмжээг улсын хэмжээнд хэрэгжүүлж, 7.1 их наяд төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Түүнчлэн Улсын Их Хурлаас 2010 онд баталсан Концессын тухай хуулийн дагуу концессын “Барих-Шилжүүлэх” төрлөөр гэрээ байгуулсан төслүүдийн эргэн төлөлтийг мөн 2016 оноос эхлэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 6.1. Төсвийн хөрөнгө оруулалт 2017-2023 онуудад /тэрбум Т/

№	Төсвийн жил	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
1	УТХО	977.6	602.1	683.3	1,553.4	1,330.9	1,418.9	1,377.7	2,695.0
2	Концесс	70.7	177.7	82.9	144.7	323.5	266.3	303.6	279.6
Нийт дүн		1,048.3	779.9	766.2	1,698.1	1,654.4	1,685.2	1,697.4	2,974.6

6.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2023 оны гүйцэтгэл:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд 7.9 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 2.9 их наяд төгрөгийн санхүүжилт бүхий 1143 төсөл, арга хэмжээ байна. Гүйцэтгэлийн хувьд 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар 1.4 их наяд төгрөгийн санхүүжилт хийгдэж, гүйцэтгэл 49.2 хувьтай байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хувьд өмнөх онуудад эхлүүлсэн төслүүдийг дуусгах, ашиглалтад оруулах бодлого баримталж,

энэ хүрээнд барилгын материалын үнийн өсөлтөөс үүдсэн нэмэлт санхүүжилтийг 2023 оны төсөвт тусган батлуулсан бөгөөд үнийн өсөлтийн санхүүжилтийг захиалагч, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, хянан баталгаажуулж ирүүлсэн гүйцэтгэл болон үнийн өсөлтийн магадлалын ерөнхий дүгнэлтийн дагуу олгож байна. Үнийн өсөлтийн гүйцэтгэлд 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 199.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, гүйцэтгэл 66.9 хувьтай байна.

6.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын шинэчлэл

Сангийн яамнаас төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, ил тод нээлттэй байдлыг дээшлүүлэх чиглэлээр олон арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал:

Зураг 6.1. Төсвийн хөрөнгө оруулалтын шинэчлэл




Төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг бүрэн цахимд шилжүүлсэн буюу төсвийн төсөлд тусгах төслүүдийн төлөвлөлт, төслүүдийг аргачлалын дагуу үнэлж эрэмбэлэх үе шат, шалгуур үзүүлэлтээр оноо өгөх үйл явц, төлөвлөлтийн үйл ажиллагаанд шаардлагатай зураг төсөв, газрын мэдээллийн системүүдээс мэдээллийн эх сурвалжийг татах зэрэг үйл ажиллагаанаас гадна тухайн жилийн төсвийн тухай хуулиар батлагдсан оруулалтын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хуваарилалт, худалдан авах ажиллагаа, гэрээ байгуулах үйл явц, гэрээ баталгаажуулалт, гүйцэтгэл гаргах, түүнийг хянах, санхүүжүүлэх, гүйлгээ хийх, тэдгээрийн тайлагналт, ашиглалт, өмч бүртгэл гээд бүхий л үйл ажиллагааг цахимжуулж, энэхүү үйл ажиллагаанд оролцогчдыг нэгдсэн платформд нэгтгэж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, үүний үндсэн дээр олон нийтэд ил тод, нээлттэй байдлаар мэдээллийг хүргэж байна.

Зураг 6.2. Төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны үе шат

“www.publicinvestment.gov.mn” вэб сайт болон “Public Investment” гар утасны аппликэйшн бүхний Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын ЦАХИМ СИСТЕМ юм.

ТӨЛӨВЛӨЛТ	ХЭРЭГЖИЛТ	САНХҮҮЖИЛТ	ХЯНАЛТ	ТАЙЛАГНАЛТ
Төсөл, арга хэмжээг анхан шатны байгууллагаас эхлэн санхүүжилтийн бүх эх үүсвэрээр төлөвлөх боломжтой болно. --- Прогд, олон нийт өөрийн орон нутагт хэрэгжүүлэх төслийн саяал өгөх, шийдвэрлэлтийн явцыг хянах боломжтой.	Худалдан авах ажиллагааны цахим системээс тендерийн мэдээлэл болон шааргасан гүйцэтгэлийн мэдээлэл хяруулаг болно. --- Гэрээ бүрэн цахимдаа.	Санхүүжилтийн хүсэлт шийдвэрлэх процесс 100% цахим бөгөөд хууль ёсоор хянаж хямаарах болон төлжих үйл ажиллагааг бууруулсан	Хэрэгжээ буй төслүүдийг эрх бүхий хяналтын байгууллагууд хянахаас гадна төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн мэдээлэл нь прогрд, олон нийтэд ил тод нэвчлэгтэй	Өмнөх онуудад хэрэгжсэн, одоо хэрэгжж буй, төслүүдтэй холбоотой бүхий л төрлийн мэдээллийн нэгдсэн сан бүрдлэн.



Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем одоогийн байдлаар үндсэн 10 системтэй холбогдож, мэдээллийг үндсэн эх сурвалжаас татаж, олон нийтэд хүргэж байна.

Зураг 6.3. Төсвийн хөрөнгө оруулалтын цахим систем



Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хөрөнгө, өмчийн удирдлагыг бүрэн хэрэгжүүлж, ашиглалтад орсон төслүүд, өмчийн үр ашгийг үнэлэх, түүнийг төлөвлөлттэй бүрдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хөрөнгийн чанар, ашиглалтыг сайжруулах үйл ажиллагааг 2023 онд нэвтрүүлэн ажиллаж байна.

Нэг талаар “Шинэ сэргэлтийн бодлого”-ын төрийн бүтээмжсийн сэргэлтийг дэмжих, нөгөө талаар жендерийн мэдрэмжтэй төсвийн хөрөнгө оруулалтыг бий болгох зорилтын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга

хэмжээний хувьд “АНХ УДАА” иргэдийн саналыг авах арга хэмжээг 2023 онд хэрэгжүүллээ.

Дэлхийн банкнаас хэрэгжүүлж буй “Монгол Улсад ил тод байдал, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь” (MASAM II) төслийн хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагад иргэдийн оролцоог хангах зорилгоор “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем” гар утасны аппликэйшнээр дамжуулан төсвийн хөрөнгө оруулалтын талаар мэдлэг мэдээлэлтэй болж, тухайн орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй танилцах, улмаар төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд саналаа өгөх, иргэдийн өгсөн саналыг холбогдох төрийн захиргааны байгууллагууд төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтөд тусгах, иргэдийн өгсөн санал нь төсөвт туссан эсэх талаар эргэж мэдээлэх, хөрөнгө оруулалтын явцад иргэдийн хяналтыг бий болгох боломж бүрдэх юм.

Дээрх ажлын хүрээнд 2023 оны 3-4 дүгээр сарын хооронд MASAM II төслийн хамтран хэрэгжүүлэгчид болох “Глоб Интернешнл төв”, “Дэлхийн Зөн Монгол” олон улсын байгууллага гар утасны аппликэйшнийг иргэдэд танилцуулах уулзалт, ярилцлага зохион байгуулах, аппликэйшнийг ашиглах заавар бүхий брошюр бэлтгэж тараах, улмаар иргэдээс хөрөнгө оруулалтын төсөлд санал авах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулсан.

Төсвийн хөрөнгө оруулалтын аппликэйшнаар 2024 онд хэрэгжүүлэх төслийн саналыг иргэдээс авах үйл ажиллагааг 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 10-ны өдрийн хооронд улсын хэмжээнд зохион байгуулсан үр дүнг нэгтгэн танилцуулбал:

Зураг 6.4. Төсвийн хөрөнгө оруулалтын цахимжуулалтын үр дүн



Иргэдийн саналаар хамгийн өндөр санал авсан төслүүдийг саналын тоогоор эрэмбэлж дараах байдлаар оруулав:

Зураг 6.5. Шинэ төслийн санал ирүүлсэн хөрөнгө оруулалтын төрлийн тоо


**Шинэ төслийн
санал ирүүлсэн
хөрөнгө
оруулалтын
төрлийн тоо**
101/112



Сургууль

Төслийн санал: 257
Давхардсан санал: 805
Үнэлгээ өгсөн тоо: 2530



Цэцэрлэг

Төслийн санал: 129
Давхардсан санал: 407
Үнэлгээ өгсөн тоо: 1892



Явган иргэдийн гам

Төслийн санал: 128
Давхардсан санал: 310
Үнэлгээ өгсөн тоо: 960



Дотуур байр

Төслийн санал: 104
Давхардсан санал: 253
Үнэлгээ өгсөн тоо: 1133



**Өрх & Сум тосгоны
ирүүлэгчдийн тов**

Төслийн санал: 96
Давхардсан санал: 276
Үнэлгээ өгсөн тоо: 646



Соёлын тов

Төслийн санал: 83
Давхардсан санал: 225
Үнэлгээ өгсөн тоо: 1112

Түүнчлэн, Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан Төсвийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэн Төсвийн тухай хуулийн “29¹.2.6. олон нийтээр хэлэлцүүлсэн байх” гэсэн заалтын дагуу Засгийн газраас Ерөнхий сайдаар ахлуулсан ажлын хэсэг, Засгийн газрын гишүүд 2023 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн 21 аймаг, нийслэлийн хэмжээнд 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ тус бүрийг иргэдэд танилцуулж, иргэдийн саналыг авч эрэмблүүлэх ажлыг хэрэгжүүлээ.

Цаашид төсвийн хөрөнгө оруулалтыг илүү ухаалаг, үр ашигтай, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, төсвийн хэмнэлттэй байхад чиглэсэн судалгаа хийж байна. Ингэснээр бид 2025 оноос эхлэн ногоон хөрөнгө оруулалт, эрчим хүчний хэмнэлттэй хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх арга зүй, аргачлалыг нэвтрүүлнэ.

6.4 Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаарх олон улсын үнэлгээ

Дэлхийн банк болон Олон улсын валютын сангаас Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага үйл ажиллагаанд тогтмол үнэлгээ хийж, түүний дагуу тайлан зөвлөмж гаргадаг. “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын үнэлгээ - PIMA” үнэлгээг 2016 онд хийж байсан бол энэ жил буюу 2023 оны 06 дугаар сард дахин хийсэн. Уг үнэлгээгээр Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийн үзүүлэлт 14% болж сайжирсан бөгөөд 2016 онтой харьцуулахад эрс сайжирсан гэсэн дүгнэлтийг өгсөн байна.

Зураг 6.6. “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын үнэлгээ- PIMA”

2016 PIMA			2023 PIMA					
	ҮЕ ШАТ	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	ХЭРЭГЖИЛТ	ҮЕ ШАТ	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	ХЭРЭГЖИЛТ		
А. Төсвийн зарчмын ба шаардлага	1	Төсвийн зарчмын ба шаардлага	Дума	Мүү	1	Төсвийн зарчмын ба шаардлага	Дума	Мүү
	2	Үндэсний болон салбарын төлөвлөлт	Дума	Дума	2	Үндэсний болон салбарын төлөвлөлт	Дума	Дума
	3	Төв, орон нутгийн үндэс	Дума	Дума	3	Байгууллага хоорондын үндэс	Дума	Дума
	4	Төр, хувийн хэвшлийн түншлэл	Мүү	Мүү	4	Төсвийн үнэлгээ	Дума	Дума
	5	Дэд бүтцийн компанийн зохицуулалт	Дума	Дума	5	Дэд бүтцийн бусад санхүүжилт	Сайн	Дума
Б. Урсгал	6	Олон жилийн төсөвлөлт	Дума	Мүү	6	Олон жилийн төсөвлөлт	Дума	Мүү
	7	Төсвийн ил бүрэн байдал	Дума	Мүү	7	Төсвийн ил бүрэн, нэгдмэл байдал	Дума	Мүү
	8	Төсвийн мэдээлэл байдал	Дума	Дума	8	Хөрөнгө оруулалтын төсөвлөлт	Дума	Дума
	9	Төсвийн үнэлгээ	Дума	Мүү	9	Засвар үйлчилгээний санхүүжилт	Дума	Мүү
	10	Төсвийн сонголт	Дума	Мүү	10	Төсвийн сонголт	Сайн	Дума
С. Хэрэгжлэл	11	Хөрөнгө оруулалтын амьдрал	Дума	Дума	11	Хуульчилсан амьдрал	Сайн	Дума
	12	Санхүүжилтийн ололт	Мүү	Мүү	12	Санхүүжилтийн ололт	Сайн	Сайн
	13	Төсвийн гүйцэтгэлийн ил тог байдал	Сайн	Сайн	13	Батлан уриалгаа, хяналт	Дума	Дума
	14	Төсвийн хэрэгжлэлийн үзрэлдэг	Мүү	Мүү	14	Төсвийн хэрэгжлэлийн үзрэлдэг	Сайн	Дума
	15	Төрийн өмчийн хөрөнгийн хяналт-шинэжилгээ	Сайн	Сайн	15	Төрийн өмчийн хөрөнгийн хяналт-шинэжилгээ	Сайн	Сайн

“Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын үнэлгээ- PIMA” үнэлгээ нь зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалт бус төсвийн бүхий л эх үүсвэрийн хөрөнгө оруулалт буюу улсын төсөв, орон нутгийн төсөв, гадаад зээл тусламж болон төрийн өмчит компаниудын хөрөнгө оруулалт зэргийг бүхэлд нь хамруулдаг. Цаашид Монгол Улсын төрийн өмчит компаниудын хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд анхаарал хандуулахыг зөвлөсөн байна.

Зураг 6.7. Ажиглагдсан ахиц дэвшил

ОУВС: Ахиц дэвшил ажиглагдсан

- Улсын төсвөөс санхүүждэг төстүүдийн менежментийг сайжруулав
- Төсвийн үнэлгээ, эрмэлзэх, шинэх журмыг боловсруулав
- Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын системийг (PIMS) боловсруулсан
- Хэрэгжлэх буй төстүүдийн хяналт болгодог болсон
- Санхүүжилтийн хүртээмж боломж сайжирч, сүүлийн жилүүдэд өрийн үлдэгдэл нэрээгүй
- Барих, Шилжүүлэх төслүүд болон Хөгжлийн банкны арилжавны бус загас төсвийн төслүүдийг төсөвт оруулсан.
- Дэд бүтцийн зах зээлд хувийн хэвшлийн оролцох орчим сайжирсан
- ТХХТ-ийн тухай хуулийг баталсан
- Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-д өргөн барьсан
- ТӨҮГ-ын тухай хуулийг УИХ-д өргөн барьсан

6.5 Улсын төсвийн хөрөнгө оруулалт 2024 онд

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2024 оны төлөвлөлтийг Төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай, холбогдох бусад хууль, тогтоомж болон Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх,

санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны журам болон аргачлалууд”-ын хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтын цахим систем /PIMIS/-ээр хэрэгжүүллээ.

Зураг 6.8. Төслийг үнэлэх болон сонгох үе шат



Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг 2 үе шатанд 16 шалгуур үзүүлэлтээр оноо өгч эрэмбэлэн цахим системд хэрэгжүүлж дараагийн шатны байгууллагад илгээх байдлаар төлөвлөдөг.

Зураг 6.9. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслийн төлөвлөлтийн шалгуур үзүүлэлт

Үе шат	Шалгуур үзүүлэлт	Төсвийн ерөнхийлөн захиргагч			Сангийн яам		
		Оноо	Жин	Дүн	Оноо	Жин	Дүн
Төслийн үнэлгээ хийх	1-1 Бодлогын баримт бичигт тусгагдсан байдал	5	1.5	7.5	5	1.5	7.5
	1-2 Бусад төсөл аргаар хэрэгжүүлж эрх зөвшөөрлийг авсан эсэх	5	2.5	12.5	5	2.5	12.5
	1-3 Эдийн засгийн үр ашги, нийгмийн ач холбогдол	5	3	15	5	3	15
	1-4 Төслийн эдийн засгийн шинжилгээ	5	2.5	12.5	5	2.5	12.5
	1-5 Төслийн зарчлыг бүрэн тооцсон эсэх	5	3	15	5	3	15
	1-6 Төслийн боловгүй эрхлэл	5	2	10	5	2	10
	1-7 Төсөл хэрэгжүүлэх дараа үйл ажиллагааг нь үр ашгтай төлөвтэй удирдан гүйцэтгэх, чиглэл байгаа эсэх	5	2	10	5	2	10
		ТМӨ		82.5		82.5	
Төслийг сонгох	2-1 Төслийн гэрэлт үйл ажиллагааны мөнгөбөрт тусгагдсан байдал	5	1	5	5	1	5
	2-2 Тухайн төслийн ерөнхий оруулалтын бодлогын чиглэлд нийцэх буй байдал	5	1	5	5	1	5
	2-3 Тухайн төслийн үндсэн чиглэлтэй нийцэх буй байдал	5	1	5	5	1	5
	2-4 Төслийн зарчлыг бүрэн тооцсон эсэх	5	3	15	5	3	15
	2-5 Санхүүжилтийн эх үүсвэрийн төрөл	5	1.5	7.5	5	1.5	7.5
	2-6 Урсгал зарчлыг төлөвтэй төсвийн болон төсвийн эсх, төсөвт өгч өгөх	5	1	5	5	1	5
	2-7 Төсөл хэрэгжүүлэх нийцэл гэрч боловгүй эрхлэл	5	2.5	12.5	5	2.5	12.5
	2-8 Төслийг хэрэгжүүлэх бусад мөнгө бүрдсэн эсэх	5	1.5	7.5	5	1.5	7.5
	2-9 Төслийн ерөнхийлөн захиргагчийн эрмэлзсэн байдал	5	1	5	5	1	5
		ТМӨ		67.5		67.5	

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглабарын дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдаас 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийт 22.6 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй

2024 онд шаардлагатай санхүүжилт нь 10.4 их наяд төгрөгийн хүсэлт бүхий 2511 төсөл, арга хэмжээний саналыг албан бичгээр болон цахим системээр ирүүлсэн. Төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлсэн саналыг холбогдох хууль, журамд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн дагуу боловсрууллаа.

Төсвийн төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг боловсруулахдаа дараах бодлого, зарчмыг баримталлаа. Үүнд:

- ✓ Хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх төсвийн бодлогыг дэмжихэд төсвийн хөрөнгө оруулалтыг чиглүүлэх;
- ✓ Дэд бүтцийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэхэд чиглэсэн төслүүдийг санхүүжүүлэх;
- ✓ Хөдөөгийн алслагдсан багуудаас мэдээлэл холбооны дэд бүтцэд холбогдоогүй багуудыг харилцаа, холбоожуулах;
- ✓ Иргэдийн оролцоонд суурилсан ил тод, цахим, хэмнэлттэй бөгөөд үр ашигтай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх;
- ✓ Дунд болон урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн төслүүдийг дэмжих;
- ✓ Олон жил үргэлжилсэн дуусаагүй барилга байгууламжийг ашиглалтад оруулах;
- ✓ Төсөвт өртгийн нэмэгдлийг аудитын дүгнэлтэд үндэслэн төсвийн төсөлд тусгах;

Дараа онуудад дамжин хэрэгжих төслүүдийн хувьд ажлын гүйцэтгэлтэй уялдуулан үлдэгдэл санхүүжилтийг тусгах, төсөвт өртгийн нэмэгдлийг магадлалын ерөнхий дүгнэлтэд хийсэн аудитын дүгнэлтийг үндэслэн тусгах, хэрэгжиж байгаа төслүүдэд үнэлгээ өгч, эрэмбэлж, зохицуулалтын тохируулга хийх зарчмыг хөрөнгө оруулалтын бодлогод баримтлав.

Төсвийн Ерөнхийлөн захирагчдаас шилжих буюу он дамжин хэрэгжих төсөл арга хэмжээний 2.8 их наяд төгрөгийн санал ирүүлснээс 946.5 тэрбум төгрөг нь төсөвт өртгийн нэмэгдэл санхүүжилт бөгөөд эдгээрийг УИХ-ын 2022 оны 72 дугаар тогтоолын дагуу аудитын дүгнэлт гаргуулахаар Үндэсний аудитын газарт хүргүүлснээс баталгаажуулж ирүүлсэн 214 төслийн 560.5 тэрбум төгрөгийн төсөвт өртгийн нэмэгдлийг бүрэн тусгалаа.

Шинэ хөрөнгө оруулалтын хувьд Төсвийн Ерөнхийлөн захирагчдаас нийтдээ 11.0 их наяд төгрөгийн төсвийн хөрөнгө оруулалтын санал ирсэн бөгөөд үүнийг холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх,

цахим систем, аргачлалын шалгуур үзүүлэлтийг хангасан эсэх, мөн зураг төсөв, газрын асуудал бүрэн шийдэгдсэн байдал зэрэг шалгуур үзүүлэлтээр эрэмбэллээ.

Түүнчлэн, Шинэ сэргэлтийн бодлогын “Хот, хөдөөгийн сэргэлт”-ийг дэмжих зорилтын хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан ажлын хэсэг нийтдээ 21 аймагт ажилласнаар төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, тухайн орон нутагт нэн тэргүүний болон тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх төсөл, арга хэмжээг 7800 гаруй иргэдэд танилцуулж, иргэдийн саналыг авсны үндсэн дээр төслийн бэлэн байдлаар эрэмбэлэн төсвийн төсөлд тусгалаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжихэд чиглүүлж энэ хүрээнд нийт хөрөнгө оруулалтын 79% буюу 2.6 их наяд төгрөгийн санхүүжилт бүхий 846 төсөл, арга хэмжээ, дэд бүтэц, барилга байгууламжийг төсвийн төсөлд тусгасан бөгөөд дараах онцлох төслүүдийг дурдвал: Үүнд

1. Хөдөөгийн алслагдсан багуудаас мэдээлэл холбооны дэд бүтцэд холбогдоогүй *191 багт харилцаа, холбооны дэд бүтэц бүрдүүлэх зорилгоор 20.0 тэрбум төгрөг;*
2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан томоохон зорилтын нэг болох дэлхийн жишигт нийцсэн шинэ технологи, инноваци бүхий эс, эд, эрхтэн шилжүүлэх төвийг Улсын төв нэгдүгээр эмнэлгийн дэргэд байгуулахаар *“Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв”-ийн бүтээн байгуулалтын санхүүжилт болох 140.0 тэрбум төгрөг;*
3. Түүнчлэн, Улаанбаатар хотын Баянгол дүүрэгт баригдах “Зүрх судасны үндэсний төв”-ийн гадна шугам сүлжээ, дэд бүтэц, Төв аймгийн Сэргэлэн суманд баригдах “Халдвар үндэсний төв-2”-ийн гадна шугам сүлжээ, дэд бүтэц нийтдээ *15.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 5.1 тэрбум төгрөг* тус тус тусгалаа
4. Монгол Улсын урт хугацааны хөгжилийн зорилтод нийцүүлэн хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоог бүрдүүлэх, хот, хөдөөгийн тэнцвэрт хөгжлийг хангах, түүх, соёл, аялал жуулчлалыг дэмжих бодлогын хүрээнд *“Шинэ Хархорум” хотыг байгуулах судалгаа, ТЭЗҮ, зураг төсөв боловсруулахад санхүүжилтэд 30.0 тэрбум төгрөг;*
5. Шинэ сэргэлтийг дэмжих хөгжлийн тойрог авто замын үндэсний сүлжээ бий болгох зорилтын хүрээнд аймгийн төвүүдийг хатуу хучилттай авто замаар холбох, сумдыг улсын чанартай авто замтай холбох *32 томоохон хатуу хучилттай авто зам, гүүрийн байгууламжийг эхлүүлж, үүнд шаардлагатай 978.7 тэрбум төсөвт өртөг бүхий 226.7 тэрбум төгрөг* шинээр тусгасан бол он дамжин

- хэрэгжиж буй боомтын томоохон төслүүдийг үргэлжлүүлэхээр санхүүжилтийг ажлын явц, гүйцэтгэлд үндэслэн тусгав.
6. Хөдөөгийн хөгжлийг эрчимжүүлэх, хотын төвлөрлийг бууруулах зорилтын хүрээнд аймгийн төвүүдийн орон сууцны дэд бүтэц, шинэ суурьшлын дэд бүтэц, инженерийн хангамж, цахилгаан болон дулааны хангамжийг нэмэгдүүлэх, шинэ эх үүсвэрийг бий болгох чиглэлээр *Хөшигийн хондийн дэд бүтцэд 50.4 тэрбум төгрөг*, БНСУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж байгаа Говьсүмбэр, Дундговь, Завхан, Хэнтий, Сүхбаатар, Төв, Архангай, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай аймгуудын дулааны станцыг шинээр барих төсөлд Монголын талын хариуцах дэд бүтэц, цахилгаан хангамж 2-р хэлхээний санхүүжилтэд нийтдээ *51.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 22.1 тэрбум төгрөгийн санхүүжилт*, барилгын материалын чанар, стандартыг сайжруулах бодлогын хүрээнд Замын-Үүд, Алтанбулаг хилийн боомтуудад барилгын материалын сорилт шинжилгээний лабораториудын тоног төхөөрөмжийн худалдан авахад *23.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 9.2 тэрбум төгрөгийн санхүүжилт тусгасан* бол аймгийн төвүүдийн цахилгаан, дулаан, инженерийн дэд бүтцэд шаардлагатай *нийт 142 төслийн 591 тэрбум төгрөгийн санхүүжилтийг* тус тус тусгав.
 7. Төрийн үйлчилгээг иргэдэд тасралтгүй хүргэх, боловсрол, эрүүл мэндийг хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн бүрийг хөгжлөөс хоцроохгүй байх зорилтын хүрээнд улсын хэмжээнд *361.3 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 140 сургууль, 147.8 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 128 цэцэрлэг, 137.5 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 65 эмнэлэг, 43.2 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 36 дотуур байр, 132.8 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 51 соёлын төв, музей, театрын төслүүд, 78.9 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 50 спорт заал, спорт цогцолборын төслүүд*;
 8. Гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж буй томоохон төслүүдийн гэрээний үүргийн хүрээнд Монгол талын хариуцах санхүүжитэд *200.6 тэрбум төгрөг*;
 9. Ногоон хөгжлийн сэргэлтийн хүрээнд Ганга нуур, Өгийнуур, Хэрлэн голыг бохирдлоос хамгаалах, урсацыг нэмэгдүүлэхэд шаардлагатай *9.0 тэрбум төгрөг*;
 10. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ур чадвартай хүний нөөцийг бэлтгэх, мэргэжлийн боловсролыг олгох, ажиллах хүчнийг хэрэгцээг хангах, нөгөө талдаа төвлөрлийг сааруулах, хөдөөгийн ажиллах хүчнийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Хөвсгөл аймагт Политехник коллеж, Дорноговь аймагт Анагаахын салбар сургууль, Завхан аймаг политехник коллеж, хөгжим бүжгийн коллежийн дотуур байрыг шинээр барихаар тусгасан бол урлагийн салбарт өндөр ур чадвар бүхий мэргэжилтэн бэлтгэх хүрээнд Монгол Улсын консерваторийн сургууль, дотуур байр, амфитеатр бүхий цогцолборыг

барихаар 27.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 8.1 тэрбум төгрөг;

11. Төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төслүүдийн бэлтгэл ажил, зураг төсөв, ТЭЗҮ боловсруулахад шаардлагатай санхүүжилт болох 40.0 тэрбум төгрөг;

Төсвийн төсөлд тусгасан нийт хөрөнгө оруулалтын 21.8% нь боловсролын салбарт буюу 709.5 тэрбум төгрөг, 18.3 % нь зам тээврийн салбарт буюу 597.7 тэрбум төгрөг, 7.8% нь эрүүл мэндийн салбарт буюу 254.9 тэрбум төгрөг, 6.8% эрчим хүчний салбарт буюу 220.8 тэрбум төгрөг, 4.7% соёлын салбарт буюу 154.9 тэрбум төгрөг байгаа бол үлдсэн нь бусад салбарт хэрэгжихээр байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд 9.4 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 3.2 их наяд төгрөгийн санхүүжих дүнтэй 1050 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төсвийн төсөлд тусгалаа.

№	ТӨСВИЙН ЖИЛ	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025*	2026**
1	Улсын төсөв	602.1	683.3	1,553.4	1,330.9	1,418.9	1,377.7	2,695.0	3,240.6	2,283.4	1,005.7
2	Концесс	177.7	82.9	144.7	323.5	266.3	303.6	279.6	25.0	93.5	93.5
НИЙТ ДҮН		779.9	766.2	1,698.1	1,654.4	1,685.2	1,697.4	2,974.6	3,265.6	2,376.9	1,099.2

Төсөлд тусгасан төслүүдийг эдийн засгийн ангиллаар нь авч үзвэл дийлэнх нь буюу 82.3% нь барилга байгууламж, дэд бүтэц, бүтээн байгууллалтын төслүүд бол үлдсэн 17.7% их засвар, тоног төхөөрөмж, ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах зориулалт бүхий төсөл, арга хэмжээ байна.

Төсвийн төсөлд тусгасан нийт 1050 төслийн 61% нь 2024 онд, 22% нь 2025 онд ашиглалтад орох бол 16% нь 2026 онд хэрэгжиж дуусахаар байна.



Түүнчлэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд улсын төсвийн хөрөнгө оруулалтыг чиглүүлсэн бөгөөд дараах чиглэлийн томоохон

төслүүд 2024 онд орон нутгийн эх үүсвэрээр хэрэгжихээр байна.
Тухайлбал:

1. Нийслэл Улаанбаатар хотын “Шинэ тойрог зам” төслийн ТЭЗҮ, зураг төсвийг 2023 онд нийслэлийн төсвөөр хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэхүү зам нь нийслэлийн 6 дүүргийн нутаг дэвсгэрийг дамнан, Улаанбаатар хотыг тойрсон дэд төвүүдийг холбосон, олон түвшний огтлол бүхий 88 км үргэлжлэх авто зам байх юм. Нийслэлийн хотын хувьд төслийн хойд болон босоо хэсэг болох 55 км авто замыг хэрэгжүүлэхээр хариуцаж байгаа бол урд хэсэг болох 33 км авто замыг ЗТХЯ хариуцаж байна. Уг төслийн бэлтгэл ажил, зураг төсөв, ТЭЗҮ-г 2023-2024 оны эхний хагаст бэлэн болгож, барилга угсралтын ажлыг нийслэлийн болон ТХХТ-ийн эх үүсвэрээр 2024 онд эхлүүлэхээр төлөвлөсөн байна.
2. Нийслэл Улаанбаатар хотын дугуйн замын сүлжээг бий болгох зорилтын хүрээнд одоогоор 72.3 км дугуйн замыг бий болгосон бөгөөд 2023-2024 онд 139.8 км дугуйн замыг бий болгохоор төлөвлөсөн байна.
3. Нийслэл Улаанбаатар хотод дэд төвүүд бий болгох төслийг 2014 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ хүрээнд Баянхошуу дэд төв, Сэлбэ дэд төв, Дамбадаржаа дэд төв, Дэнжийн мянга дэд төв, Толгойт дэд төв, Шархад дэд төвүүдийг АХБ-ны хөнгөлөлттэй зээл болох 303.3 сая доллар, мөн 36.1 сая зээлжих тусгай эрхийн санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа бөгөөд үе шаттайгаар ашиглалтад орж байна. Ингэснээр агаар хөрсний бохирдол буурах, ажлын байр нэмэгдүүлэх, хэт төвлөрлийг сааруулах, барилгажих төслүүд хэрэгжих нөхцлийг бүрдүүлнэ.
4. Улаанбаатар хотод ногоон байгууламж бүхий хүрээлэн буй орчныг бүрдүүлэх, иргэдийн ая тухтай амьдрах таатай орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд нийслэлийн төсвийн эх үүсвэрээр Чингэлтэй хайрхан “Эрдмийн цэцэрлэгт хүрээлэн”-ийн 80 га, Дамбадаржаа нутаг дэвсгэрийн 40 га, Баянгол цэцэрлэгт хүрээлэнгийн 50 га, Олон улсын цэцэрлэгт хүрээлэнгийн 300 га, Баянгол дүүрэгт “Бичил ой, соёл амралтын бүс” зэргийг хөгжүүлж ногоон байгууламжийг бүрдүүлэх төслийг нийслэлийн төсвөөр хэрэгжүүлж байна.

Түүнчлэн, Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан ажлын хэсэг орон нутагт ажиллаж, иргэдийн санал гаргасан орон нутгийн хөгжилд томоохон ач холбогдох бүхий төслүүдийг бэлэн байдлаас хамааран үе шаттай хэрэгжүүлэх бөгөөд зураг төсөвтэй төслүүдийн хувьд 2024 оны төсөвт тусгагдсан, харин бэлтгэл ажил бүрэн хангагдаагүй төслүүдийн хувьд 2024 онд ТЭЗҮ, зураг төсвийг боловсруулахаар төлөвлөлөө.

Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтыг олон нээлттэй, ил тод байлгах зорилтын хүрээнд 2024 оноос эхлэн төсөл, арга хэмжээ бүрийг төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын “PIMIS” цахим системээс автоматаар коджуулж байгаа бөгөөд төсвийн хөрөнгө оруулалтын цахим системд төсөл бүртгэгдсэнээр тухайн код бий болох юм.



Энэхүү код нь дахин давтагдахгүй бөгөөд тухайн төсөл эхэлснээс хойш ашиглалтад орох, өмчид бүртгэх гэх мэт бүхий л мэдээлэл, тайлагналтын үйл ажиллагаанд солигдохгүй бөгөөд энэхүү кодоор ашиглагдана. Ингэснээр олон нийт, иргэд, төслийн гүйцэтгэгч, захиалагч гээд бүхий л төрлийн оролцогчид тухайн төслийг таньж мэдэх, түүнчлэн төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, тайлагналтын үйл ажиллагаанд энэхүү кодыг бүрэн ашиглана.

Үүнээс гадна улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг гаргахдаа тухайн төслийн анхны төсөвт өртөг буюу төсөвт анх батлагдахдаа хэдэн төгрөгөөр батлагдсаныг оруулдаг боллоо.

VIII

ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ

УИХ-аас 2023 онд гадаад зээл, тусламжийн 140 төслийг санхүүжүүлэхээр нийт 1,795.0 тэрбум төгрөг батлагдсанаас 2023 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 876.0 тэрбум төгрөг санхүүжиж, гүйцэтгэл 49.0 хувьтай байна.

Монгол Улсын Засгийн газар, хөгжлийн түнш улс, олон улсын байгууллагатай хамтран 2023 онд хэрэгжүүлж байгаа болон хэлэлцээрийн шатанд байгаа гадаад зээл, тусламжийн төсөл арга, хэмжээний нийт амлалтын дүн 26.9 их наяд төгрөг байгаа бөгөөд зарцуулаагүй үлдэгдэл 21.4 их наяд төгрөг буюу ашиглалт 20.0 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь цаашид шинэ төсөл эхлүүлэхээс илүүтэй хэрэгжиж байгаа төслүүдээ төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлж дуусгах шаардлагатай байгааг харуулж байна.

Төслүүдийг санхүүжүүлэхэд баримтлах зарчим

Монгол Улсын Засгийн газрын Хөгжлийн түнш улс, олон улсын байгууллагаас 2024 онд авч ашиглах зээл, тусламжийн төслийн төсвийг төлөвлөхдөө эдийн засгийн өсөлтийг дэмжих, Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, хот, хөдөөгийн хөгжлийг дэмжих, тэргүүлэх ач холбогдолтой томоохон төслүүдийг тэргүүн ээлжинд санхүүжүүлэх, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээр хэрэгжүүлж буй төслүүд, хэрэгжиж дуусах төслүүдийн санхүүжилтийг бүрэн тусгах, үргэлжилж буй төслүүдийн хувьд гэрээ хэлэлцээрт тусгагдсан төлөвлөгөөг харгалзан гэрээний хэрэгжилтийг хангах, шинэ төслүүдийн ажлыг эхлүүлэх хэмжээнд ашиглалтыг тусгах зарчим баримталсан болно.

Цаашид олон улсын эдийн засаг, санхүү, төсвийн нөхцөл байдалтай уялдуулан гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийг Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглүүлэн уялдуулж, ач холбогдлоор нь эрэмбэлж, зарим шаардлагагүй төслүүдийн санхүүжилтийг хойшлуулах зайлшгүй шаардлага гарч байна.

Ялангуяа гадаад төслийн зээлийн хувьд бодлогын өөрчлөлт хийж, Улсын Их Хурлаас 2022 онд батлагдсан Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн дагуу гадаадын зээл, тусламжийн төслүүдийг дахин эрэмбэлж, дараах төслүүдийг цаашид хэрэгжүүлэхгүй байх бодлогыг 2024 оны төсвийн жилээс эхлүүлнэ. Үүнд:

1. Эдийн засгийн бодит өсөлт болон экспортын орлогыг нэмэгдүүлэхгүй төслүүд;
2. Гадаад улс орны худалдан авалтыг дэмжих замаар импортыг өсгөдөг төслүүд /зарим 2 талт төслүүд/;
3. Төлбөрийн тэнцэлд дарамт учруулах нөлөө бүхий төслүүд;

4. Олон удаа хугацаа сунгаж, хэрэгжилт, санхүүжилт удаашралтай байгаа төслүүд;
5. Шаардлагагүй томоохон зөвлөх үйлчилгээ бүхий төслүүд зэрэг болно.

Мөн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд төслийн хугацааг олон удаа сунгахгүй байх, бодит салбарыг дэмжсэн төслүүдийг хэрэгжүүлэх, төсөл хэрэгжүүлэх нэгжийн нэгдсэн зохион байгуулалтад оруулах, төслийн бэлтгэл ажлыг бүрэн хангасан үед төслийг эхлүүлэх, хэмнэх боломжтой зардлыг бууруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

8.1 Гадаад зээл, тусламжийн ашиглалтын мэдээлэл

Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголоор гадаад төслийн зээлийн ашиглалт 1,224.5 тэрбум төгрөг, тусламжийн ашиглалт 570.5 тэрбум төгрөгөөр батлагдсан бол 2024 онд 1,225.0 тэрбум төгрөгийн зээл, 558.0 тэрбум төгрөгийн тусламж авч ашиглахаар төсвийн төсөлд тусгалаа.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн гол бодлого болох Хот, хөдөөгийн хөгжлийг дэмжих бодлогын хүрээнд гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр орон нутгийн томоохон дэд бүтэц, авто зам, зарим авто замын засвар, арчлалтын зардлыг шийдвэрлэхээр төсвийн төсөлд тусгасан. Тухайлбал, Газрын тос боловсруулах үйлдвэр болон Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, 10 аймгийн дулааны цахилгаан станцын ажлыг эрчимжүүлэх, Азийн хөгжлийн банк (АХБ), Европын хөрөнгө оруулалтын банк (ЕХОБ), Уур амьсгалын ногоон сан (УАНС)-гийн зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилтээр нийт 17 аймгийн 52 суманд хэрэгжих Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх, АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Ховд, Увс, Говь-Алтай, Завхан аймгуудын төвүүдийг холбох 163.3 км болон 198 км авто замуудын ажлыг эхлүүлэх, Дэлхийн банкны зээлийн санхүүжилтээр шинээр хэрэгжих “Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яамнаас ирүүлсэн саналыг үндэслэн тэргүүн ээлжид:

- Улаанбаатар-Арвайхээр,
- Хархорин-Цэцэрлэг,
- Цэцэрлэг-Тосонцэнгэл,
- Улаанбаатар-Өндөрхаан,
- Булган-Мөрөн,
- Арвайхээр-Баянхонгор,
- Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн автозамуудын ээлжит болон их засварын ажил, төмөр бетон гүүрийн их болон ээлжит засварын ажлыг уг

төслийн хүрээнд хийхээр тус тус төлөвлөсөн болно. Мөн Даланзадгад-Мандалговь чиглэлийн авто замын их засварын ажлын санхүүжилтийг гадаадын зээлийн эх үүсвэрээр шийдвэрлэнэ.

Ирэх 2024 онд авч ашиглах нийт зээл, тусламжийн 40.7 хувийг олон улсын байгууллага, 59.3 хувийг хөгжлийн түнш улс орнуудын эх үүсвэрээс бүрдүүлнэ. Үүнд өмнөх жилүүдийн адил нийт зээл, тусламжийн санхүүжилтэд эзлэх АХБ-ны санхүүжилт өндөр хэвээр 26.3 хувийг эзэлж байгаа бол Дэлхийн банк (ДБ)-ны санхүүжилт 6.1 хувийг, Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ)-ных 6.9 хувийг эзэлж байна. Түүнчлэн, Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)-ын зээл, тусламжийн санхүүжилт 18.3 хувийг эзэлж, Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих, 1008 айлын орон сууцны хороолол барих зэрэг томоохон төслүүдийг санхүүжүүлэх бол Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-ын тусламжаар санхүүжүүлэх Улаанбаатар хотын ундны ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл 18.7 хувийг, Бүгд Найрамдах Энэтхэг Улс (БНЭУ)-ын зээлээр санхүүжүүлэх Газрын тосны үйлдвэр барих төсөл 9.1 хувийг, Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)-ын зээлээр санхүүжүүлэх 10 аймгийн дулааны станц барих зэрэг төслийн санхүүжилт нийт зээл, тусламжийн санхүүжилтийн 5.8 хувийг эзлэхээр байна.

Хүснэгт 7.1 Гадаадын зээл, тусламжийн 2024 оны төлөвлөгөө, хөгжлийн түншээр (тэрбум. Т)

Хөгжлийн түншүүд	Зээл ашиглалт	Тусламж ашиглалт	Нийт дүн
Азийн хөгжлийн банк	377.2	91.3	468.4
Америкийн Нэгдсэн Улс	-	334.1	334.1
Бүгд Найрамдах Хятад Ард Улс	240.1	86.6	326.6
Бүгд Найрамдах Энэтхэг Улс	162.0	-	162.0
Европын сэргээн босголт, хөгжлийн банк	114.8	22.9	122.7
Дэлхийн банк	106.5	1.9	108.4
Бүгд Найрамдах Солонгос Улс	102.8	-	102.8
Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	25.0	23.5	48.5
Австри	26.3	-	26.3
Польш	24.4	-	24.4
Европын хөрөнгө оруулалтын банк	16.0	-	16.0
Бүгд Найрамдах Франц Улс	15.0	-	15.0
Япон	15.0	-	15.0
Боловсролын Дэлхийн Түншлэл	-	9.5	9.5
Люксембург	-	2.7	2.7
Кувейт	-	0.5	0.5
Хөдөө аж ахуйн хөгжлийн олон улсын сан	0.1	-	0.1

Нийт дүн	1,225.0	558.0	1,783.0
----------	---------	-------	---------

Засгийн газрын 2024 оны гадаад зээл, тусламжийн ашиглалтыг бүтцийн хувьд авч үзвэл 1,326.0 тэрбум төгрөг буюу 74.4 хувийг хөрөнгө оруулалтын зардалд, 270.0 тэрбум төгрөг буюу 15.1 хувийг дамжуулан зээлдүүлэх зардалд, 187.0 тэрбум төгрөг буюу 10.5 хувийг урсгал зардлын санхүүжилтээр тус тус ашиглахаар төлөвлөсөн.

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР

9.1 Олон улсын санхүүгийн нөхцөл байдал ба Засгийн газрын өр

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын дараах эдийн засгийн хүндрэлийн үед үнийн хөөргөдөл, ханшийн тогтворгүй байдал, зах зээлийн тодорхойгүй байдлаас шалтгаалж дэлхийн улс орнуудад төсвийн зарлагаа өсгөж, гамшгаас сэргийлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлснээр өрийн таазыг нэмэгдүүлэх шаардлага үүсч, нэмж өр үүсгэх хэмжээг тэлэх бодлогыг баримталж байна. Тухайлбал, Их Британи улсын хувьд төсвийн зарлага тэр дундаа татаасыг нэмэгдүүлснээр цэвэр өрийн ДНБ-д эзлэх хувь 1961 оноос хойш анх удаа 100 хувьд хүрч, Засгийн газрын шинээр үүсгэх өрийн хэмжээ 2023 оны 05 дугаар сард 18.3 тэрбум фунт хүрсэн байна. Мөн АНУ-ын хувьд Засгийн газрын өрийн тааз буюу нэмж өр үүсгэх дээд хэмжээ 31.3 их наяд ам.доллартой тэнцэж өрийн дефолтын эрсдэл үүссэн тул 2025 он хүртэл 2 дахин нэмэх тухай хуулийг баталсан байна.

Монгол Улстай ижил зээлжих зэрэглэлтэй Кени улсын хувьд ханшийн сулрал болон гадаад зээлийн ашиглалт ихэссэнээс шалтгаалж Засгийн газрын нийт өрийн хэмжээ 10.8 тэрбум ам.доллаар өсч нийт 70.8 тэрбум ам.долларт хүрсэн тул өрийн хязгаар болох 70.0 тэрбум ам.доллаар давсан байна. Цаашилбал, Албани улсын Засгийн газрын өрийн ДНБ-д харьцах харьцаа 80.1 хувьд хүрсэн нь сүүлийн 30 жилд байгаагүй өндөр түвшиндээ хүрээд байна.

Харин Монгол Улсын Засгийн газрын өрийн үлдэгдэл 2022 оны жилийн эцсийн байдлаар, нэрлэсэн дүнгээр 31.9 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр ДНБ-ний 52.4 хувийг эзэлж байсан бол 2023 оны эхний хагас жилийн байдлаар 31.1 их наяд төгрөг, энэ нь өнөөгийн үнэ цэнээр ДНБ-ний 43.3⁸ хувьтай тэнцэж байгаа нь өрийн хязгаар буюу Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тусгай шаардлагыг бүрэн хангаж, цаашлаад энэ оны хязгаар болох 65.0 хувиас 21.7 хувиар бага үзүүлэлттэй байна.

Засгийн газрын өрийн хувьд 2023 онд Засгийн газрын өрийн баталгаатай Монгол Улсын Хөгжлийн банк (МУХБ)-ны “Самурай” бонд төлөгдөх хуваарьтай, үүнийг зээлийн эргэн төлөлтөөс Монголбанкинд хуримтлуулж, төлж барагдуулахад бэлэн болж, 2024 онд МУХБ-ны БНХАУ-ын Хөгжлийн банкнаас авах зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх “Чойбалсан ДЦС-ын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөх” төсөл болон “Шинэ сэргэлтийн бодлого”-ын үйл ажиллагааны

⁸ ДНБ-ны хэмжээг 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр тооцов.


хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслүүдэд Засгийн газрын өрийн баталгаа гаргахаар тооцоолсон. Мөн, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын зүгээс Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах, төвлөрлийг сааруулах, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр дотоодын зах зээлд үнэт цаас гаргаж 2023 онд эхний ээлжид 200.0 тэрбум төгрөгтэй тэнцэх хүлээлттэйгээр тооцоход 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр Засгийн газрын нийт өр 32.2 тэрбум төгрөгтэй тэнцэхээр байна. Доорх хүснэгтэд Засгийн газрын өрийн үлдэгдэл болон Төсвийн тусгай шаардлагыг дэлгэрэнгүй байдлаар харуулав.

Хүснэгт 9.1 Засгийн газрын өрийн бүтэц /тэрбум Т/

ӨРИЙН ХЭРЭГСЭЛ	2022	2023.06.30	2023*	2024**
Засгийн газрын дотоод өр	1,035.5	651.6	1,064.1	3,089.6
Дотоод үнэт цаас	1,035.5	651.6	1,064.1	3,089.6
Засгийн газрын гадаад өр	29,372.1	29,372.1	30,601.4	31,569.0
Гадаад үнэт цаас	9,359.8	9,070.6	9,248.8	9,360.0
Гадаад зээл	20,281.8	20,301.4	21,352.7	22,209.0
Засгийн газрын бусад өр	1,275.3	1,086.9	506.8	562.8
Засгийн газрын өрийн баталгаа	811.8	744.1	30.7	29.8
Барих-шилжүүлэх концесс	463.5	342.8	276.0	33.0
Орон нутгийн өр	0.0	0.0	200.0	500.0
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР	31,964.8	31,110.6	32,172.3	35,221.4
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)	27,690.6	27,033.6	27,672.6	30,099.3
Хуулнар тогтоосон өрийн хязгаар	70.0%	65.0%	65.0%	60.0%
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ	52.4%	43.3%	44.3%	42.7%

9.1.1. Засгийн газрын өрийн тусгай шаардлага

График 9.24. Засгийн газрын өрийн хязгаар



Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2020 онд Ковид-19 цар тахал, 2022 онд Орос-Украины нөхцөл байдлын дэлхийн эдийн засагт үзүүлсэн сөрөг нөлөөллөөс шалтгаалан өссөн байгаа боловч Засгийн газраас өрийн стратегийн баримт бичгийн

дагуу тодорхой зорилтуудыг хэрэгжүүлэн хугацаа тулаад байсан томоохон төлбөрийн үүргээ амжилттай гүйцэтгэсний үр дүнд Засгийн газрын өрийн баталгаа гаргаагүй тохиолдолд Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн ДНБ-тэй харьцуулсан харьцаа 2023 онд 44.3

хувь, 2024 онд 42.7 хувьтай тэнцэх төсөөлөлтэй буюу Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан 2024 оны өрийн хязгаар болох 60 хувиас хэтрэхгүй байх шаардлагыг хангах төсөөлөлтэй байна.

Шигтгээ 4. Засгийн газрын гадаад төлбөрийн эдийн засаг, төсөвт үзүүлэх нөлөөлөл



Дээрх графикт Засгийн газрын гадаад төлбөрийн эдийн засаг, төсөвт үзүүлэх нөлөөллийг өрийн зохицуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй тохиолдолд болон хэрэгжүүлснээр хэрхэн өөрчлөгдөж байгааг харууллаа.

Засгийн газрын гадаад төлбөрийн дарамт 2017, 2021, 2022, 2023 онуудад бусад үетэй харьцуулахад илүү өндөр байсан. Тухайлбал, 2017 онд Чингис бондын 500 сая ам.доллартой тэнцэх төлбөр, Дим сам бондын 161 сая ам.доллартой тэнцэх төлбөр болон МУХБ-ны евробондын төлбөр хүлээгдэж байсан. Мөн 2021 онд Мазаалай бондын 500 сая ам.доллар, 2022 онд Чингис бондын 1,000.0 сая ам.доллар, 2023 онд Гэрэгэ бондын 800 сая ам.доллар, МУХБ-ны Самурай бонд, евробондын нийт 740 сая ам.долларын өр төлбөр төлөгдөх хуваарьтай байсан. Үүнийг графикт үзүүлснээр гадаад төлбөр болон төсвийн орлогын харьцаа 2017 онд 43.0%, 2021 онд 21.6%, 2022 онд 26.3%, 2023 онд 36.6% болон экспортод эзлэх хувь 2017 онд 22.8%, 2021 онд 11.2%, 2022 онд 11.3%, 2023 онд 16.5%-д тус тус хүрээд байснаас харж болно.

Харин энэхүү хугацаа тулсан өр төлбөрийг Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичигт тусгасны дагуу өрийн зохицуулалтын арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж, боломжит хэмжээгээр төсвөөс төлж барагдуулж байгаатай холбоотойгоор тус үзүүлэлтүүдийг жил бүр жигд бууруулж ирсэн. Ингэснээр гадаад төлбөр болон төсвийн орлогын харьцаа 2017 онд 9.0 хувь, 2021 онд 14.1 хувь, 2022 онд 10.6 хувь, 2023 онд 11.8 хувь болон экспортод эзлэх хувь 2017 онд 5.3 хувь, 2021 онд 7.3 хувь, 2022 онд 4.5 хувь, 2023 онд 5.2 хувь-д тус тус хүргэж гадаад төлбөрийн эдийн засаг, төсөвт үзүүлэх нөлөөг бууруулсан.

Тус бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж 2024 онд гадаад төлбөр болон төсвийн орлогын харьцаа 18.3 хувь болон экспортод эзлэх хувь 8.8 хувь-д хүрээд байсан бол 2023 оны 01 дүгээр сард Сенчири-2 өрийн зохицуулалтын үйл ажиллагааны үр дүнд тус харьцаа үзүүлэлт тус тус 15.4 хувь, 7.3 хувь болж буураад байна.

9.1.2. Монгол Улсын зээлжих зэрэглэл

Улсын зээлжих зэрэглэл гэдэг нь тухайн улсын хөрөнгө оруулалтын эрсдэлийг үнэлэх гол шалгуур үзүүлэлт бөгөөд гадаад, дотоод хөрөнгө оруулагчдаас тухайн улсад олгосон хөрөнгө оруулалт, санхүүжилт, зээлийн төлбөрийг эргэн төлөх чадвар, зээлдэгчийн ерөнхий эрсдэлийг илтгэдэг үзүүлэлт юм.

Монгол Улсын Засгийн газрын хувьд Фитч агентлагтай 2007 онд, Эс энд Пи агентлагтай 2009 онд, Мүүдис агентлагтай 2012 онд тус тус хамтран ажиллах гэрээ байгуулсны үндсэн дээр Монгол Улсын зээлжих зэрэглэлийг жил бүр тогтоолгож ирсэн.

Засгийн газрын зүгээс сүүлийн жилүүдэд зээлжих зэрэглэл тогтоогч агентлагууд болон Засгийн газрын гадаад үнэт цаасны хөрөнгө оруулагчдад Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал, цаашдын төлөв байдлын талаарх мэдээг тухай бүр хүргэн, олон улсын хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ тухай бүр хариуцлагатайгаар хүлээж Засгийн газрын гадаад үнэт цаасны эргэн төлбөрүүдийг цаг хугацаанд нь эргэн төлж ажилласнаар олон улсын санхүүгийн зах зээл дээрх нэр хүнд, хөрөнгө оруулагчдын итгэлийг алдалгүй ажиллаж байна.

Монгол Улсын зээлжих зэрэглэлийн түвшин цар тахлын нөхцөл байдал, Орос-Украины хурцадмал байдал, дэлхий даяарх үнийн өсөлт, Төв банкнуудын мөнгөний хатуу бодлого зэрэг санхүүгийн салбарын тодорхойгүй нөхцөл байдлын үед ижил зээлжих зэрэглэлтэй бусад улсуудтай харьцуулахад зээлжих зэрэглэлээ амжилттай тогтвортойгоор хадгалан Монгол Улсын зээлжих зэрэглэлийг хамгийн сүүлийн байдлаар Фитч агентлаг 2022.05.18-ны өдөр В тогтвортой түвшинд, Эс энд Пи агентлаг 2022.07.29-ний өдөр В тогтвортой түвшинд, Мүүдис агентлаг 2023.02.14-ний өдөр В3 тогтвортой түвшинд тус тус үнэлсэн.

Хүснэгт 9.2. Зээлжих зэрэглэлийн шатлал

№	ЭС ЭНД ПИ	ФИТЧ	МҮҮДИС	ТАЙЛБАР
1	AAA	AAA	Aaa	Хамгийн бага эрсдэлтэй
2	AA+	AA+	Aa1	Маш бага эрсдэлтэй
3	AA	AA	Aa2	
4	AA-	AA-	Aa3	
5	A+	A+	A1	
6	A	A	A2	Бага эрсдэлтэй
7	A-	A-	A3	
8	BBB+	BBB+	Baa1	
9	BBB	BBB	Baa2	Дунд зэргийн эрсдэлтэй
10	BBB-	BBB-	Baa3	
11	BB+	BB+	Ba1	
12	BB	BB	Ba2	Тодорхой хэмжээний эрсдэлтэй
13	BB-	BB-	Ba3	
14	B+	B+	B1	
15	В/Тогтвортой /Монгол Улс/	В/Тогтвортой /Монгол Улс/	B2	Харьцангуй өндөр эрсдэлтэй /Турк, Бахрейн, Габон, Египет, Кени/
16	B-	B-	В3/Тогтвортой /Монгол Улс/	
17	CCC+	CCC+	Саа1	Маш өндөр эрсдэлтэй
18	CCC	CCC	Саа2	
19	CCC-	CCC-	Саа3	
20	CC	CC	Ca	Дефолт болох эрсдэлтэй
21	R	C	C	Дефолт
22	SD	RD		
23	D	D		

Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Мүүдис, Эс энд Пи, Фитч агентлагуудын улсын зээлжих зэрэглэл тогтоох аргачлалын судлан үзэхэд нийтлэг байдлаар тус агентлаг аливаа улсын институт, засаглалын байдал, макро эдийн засгийн нөхцөл байдал, улсын төсөв, гадаад эрсдэл болон эрсдэлд мэдрэмтгий байдлыг онцгойлон анхаарч үздэг байна.

Иймд төрийн бодлого тодорхойлогч, зохицуулагч байгууллагууд хамтран дор дурдсан зээлжих зэрэглэл тогтоох шалгуур үзүүлэлтүүдийг сайжруулах чиглэлээр цаашид бодлогын баримт бичгүүд, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусган ажилласнаар бид Монгол Улсын зээлжих зэрэглэлийг тогтвортойгоор сайжруулан ажиллах, бууруулахаас сэргийлж ажиллах бүрэн боломжтой байна.

Шигтгээ 5. Зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагуудаас тавьдаг шалгуурууд

Зээлжих зэрэглэл сайжруулахад:

1. Гадаад валютын албан нөөцийг тогтвортой нэмэгдүүлэх;
2. Засгийн газрын өрийн тогтвортой байдлыг хангах, өрийн удирдлагын стратегийн хэрэгжилтийг хангаснаар дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулах, гадаад өр төлбөрийг тогтворжуулах;
3. Эдийн засгийн өсөлт, экспортын орлогыг тогтворжуулах, нэмэгдүүлэх;
4. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, дэмжих бизнесийн таатай орчныг бүрдүүлэх
5. Засгийн газрын өрийн ДНБ-тэй харьцах харьцааг бууруулахтай зэрэгцэн төсвийн алдагдлыг бууруулах
6. Засгийн газрын гадаад өрийг зохистойгоор удирдах, бууруулах
7. Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээг бууруулж, төсвийн удирдлагыг сайжруулах
8. Эдийн засгийн өсөлт уул уурхайн салбараас хэт хамааралтай байгааг бууруулж, эдийн засгийг улам төрөлжүүлэх
9. Төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх зэргийг анхаарч ажиллах шаардлагатай болно.

Зээлжих зэрэглэлийг бууруулахаас сэргийлэхэд:

1. Гадаад санхүүжилтийн эх үүсвэр татах чадвар буурах, Гадаад валютын албан нөөц нь БНХАУ-ын хилийн боомтын асуудлаас үүдэн буурах үзэгдэл ажиглагдсан зэргээс үүдэн гадаад нөхцөл байдлын эрсдэл нэмэгдэхээс сэргийлэх
2. Төсвийн алдагдлыг бууруулж чадахгүй байх, Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх харьцааг тогтворжуулж чадахгүй байхаас сэргийлэх
3. Улс төрийн тогтворгүй байдал нь Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг бууруулах, стратегийн ач холбогдол бүхий уул уурхайн төслүүдийг зогсоох эрсдэлтэйг анхаарах
4. Засгийн газрын санхүүжилт, зээлийн хэрэгцээ шаардлагын өсөлтийг хязгаарлах
5. Засгийн газрын өрийн хөрвөх чадварын эрсдэлээс сэргийлэх
6. Макро эдийн засгийн тогтвортой байдалд нөлөөлөхүйц гадаад санхүүжилтийн дутагдлыг нөхөх зэрэг болно.

9.1.3. Засгийн газрын гадаад зээл

Засгийн газрын зүгээс 1991 оноос 2023 оны эхний хагас жилийн хооронд нийт 8,178.7 сая ам.доллартой тэнцэх хэмжээний зээлийн хөрөнгийг 22 зээлдүүлэгчийн 329 төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд ашигласан байна. Үүнээс 2023 оны эхний хагас жилийн байдлаар 1,800.2 сая ам.долларыг эргэн төлж 5,937.3 сая ам.доллартой тэнцэх үлдэгдэлтэй байна.

Энэхүү гадаад зээлийн хөрөнгийг төслийн зээлийн хүрээнд 5,723.0 сая ам.доллар, хөтөлбөрийн зээлийн хүрээнд 2,455.7 сая ам.доллартой тэнцэх хэмжээний хөрөнгийг авч ашигласан бөгөөд гадаад төслийн зээлийн ашиглалтын 39.5 хувийг барилгын ажил, 26.2 хувийг тоног төхөөрөмж, 14.4 хувийг үйл ажиллагааны зардал, 12.7 хувийг зөвлөх үйлчилгээний зардалд, 5.1 хувийг магадалшгүй зардалд, үлдсэн 2.1 хувийг санхүүгийн шимтгэлд зарцуулсан байна.

Засгийн газрын гадаад төслийн зээлийн хувьд 2,332.6 сая ам.доллартой тэнцэх эх үүсвэрийг дэд бүтцийн буюу зам, тээвэр, эрчим хүч, орон сууц, нийтийн аж ахуйн салбаруудад, 1,461.8 сая ам.доллартой тэнцэх эх үүсвэрийг эргэлтийн хөрөнгө буюу жижиг дунд үйлдвэрлэлийн зээл, барааны зээл, банк санхүүгийн салбаруудад зарцуулсан бол үлдсэн 1,207.6 сая ам.доллартой тэнцэх хэмжээний хэсгийг нийгмийн шинж чанартай төсөл, арга хэмжээнүүд болох эрүүл мэнд, боловсрол, онцгой байдал зэрэг салбаруудад ашигласан байна.

Засгийн газрын гадаад төслийн зээлийн ашиглалтын 46.6 хувийг дэд бүтцэд, 29.2 хувийг эргэлтийн хөрөнгөд, үлдсэн 24.1 хувийг нийгмийн чанартай төсөл хөтөлбөрүүдэд зарцуулжээ. Дэд бүтцийн салбарын 86.8 хувийг зам, тээврийн салбар, үлдсэн 13.2 хувийг уул уурхай, эрчим хүчний салбарууд тус тус эзэлж байна.

Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл бодитоор жил бүр өсөж байгаа бөгөөд 2023 оны байдлаар ашиглаагүй үлдэгдэл 3.0 тэрбум ам.доллар буюу 10.4 их наяд төгрөгтэй тэнцэж байна. Үүнээс жил бүр Улсын төсөвт төсөвлөхдөө нийт гадаад зээлийн ашиглалтын хэмжээг 1.3 их наяд төгрөгөөс ихгүй байхаар хязгаарладаг тул үлдэж буй ашиглаагүй зээлийн хэмжээнд тодорхой хувиар шимтгэл төлөх нөхцөлтэй зээлд төлж байгаа зээлийн хэмжээ жилд дунджаар 10.0 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

Түүнчлэн, гадаад зээлийн нийт авч ашигласан хөрөнгийг задалж харвал, 39.5 хувийг барилгын ажил, 26.2 хувийг тоног төхөөрөмж, 14.4 хувийг үйл ажиллагааны зардал, 12.7 хувийг зөвлөх үйлчилгээний зардалд, 5.1 хувийг магадалшгүй зардалд, үлдсэн 2.1 хувийг санхүүгийн шимтгэлд зарцуулсан байна.

График 9.25. Гадаад зээлийн ашиглалтыг зориулалтаар /1991.01.01-2023.06.30/




Монгол Улсын хувьд 1991 оноос 2010 оны хооронд нэг хүнд ногдох Үндэсний нийт орлого 1,005 ам.доллараас бага тул бага-орлоготой орны ангилалд багтааж, олон улсын санхүүгийн байгууллагуудаас нэн хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл олгодог байсан. Харин 2011 онд тус үзүүлэлт 1,890 ам.долларт хүрч, дундаж орлоготой орны шалгуурыг хангаж эхэлсэн тул олон улсын санхүүгийн байгууллагуудаас авах зээлийн нөхцөл хосолмол буюу арилжааны болон хөнгөлөлттэй зээлийг хослуулан авч эхэлсэн.

Тухайлбал, Монгол Улсын хамгийн томоохон зээлдэгч болох Азийн хөгжлийн банк болон Дэлхийн банк 2011 онд манай улсын эдийн засаг, дотоодын нийт бүтээгдэхүүн, хөрөнгө оруулалтын өсөлтөөс хамааран Монгол Улсад олгодог байсан нэн хөнгөлөлттэй эх үүсвэрийн хөнгөлөлтийг бууруулж, хөнгөлөлттэй эх үүсвэр болон энгийн эх үүсвэрийг холимог байдлаар олгож эхэлсэн.

Азийн Хөгжлийн Банкны хувьд 2011 онд Монгол Улсын ангиллыг А буюу ДНБ бага, зээлжих зэрэглэл доогуур улсуудын жагсаалтаас дээшлүүлж, Б ангилал буюу ДНБ-ын орлого дундаж, зээлжих зэрэглэл тогтвортой орны жагсаалт руу оруулсан. Ингэснээр Монгол Улс хувьсах хүүтэй энгийн эх үүсвэр болон тогтмол хүүтэй хөнгөлөлттэй эх үүсвэрийг ашиглаж эхлэх болсон. Цаашлаад АХБ-ны зүгээс жил бүр Монгол Улсын ашиглаж болох нэн хөнгөлөлттэй эх үүсвэрийн хэмжээг бууруулж, тогтмол хүү 1 хувь байсныг 2011 оноос шат дараатайгаар нэмсээр 2 хувь болгоод байна. Хувьсах хүүтэй энгийн эх үүсвэрийн хувьд зах зээлийн нөхцөл байдлаас хамааран ихээхэн өөрчлөгддөг бөгөөд КОВИД-19 цар

тахал болон Орос-Украины нөхцөл байдлаас хамааран 2021 онд 0.16 хувьтай байсан хүү 2023 оны 8 дугаар сарын байдлаар 5.3 хувь болтлоо өссөн.

График 9.26. Азийн хөгжлийн банкны санхүүжилтийн ангилал



*-АХС: Азийн хөгжлийн сан

Эх сурвалж 25. Азийн хөгжлийн банк

Дэлхийн банкны хувьд мөн адил 2011 оноос эхлэн шат дараатайгаар Монгол Улсын Олон улсын хөгжлийн ассоциацийн зээлдэгчээс шилжиж, 2020 оны 7-р сарын 1-ний өдрөөс эхлэн зөвхөн Олон улсын сэргээн босголт хөгжлийн банкны зээлдэгч болсон. Олон улсын сэргээн босголт хөгжлийн банкнаас олгож буй зээллэгийн ерөнхий нөхцөл нь Баталгаат овернайт санхүүжилтийн хувьсах хүү дээр 1.3 хувийн нэмэгдэлтэй, 5 жилийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх, 25 жилийн хугацаанд эргэн төлөлт хийх нөхцөлтэй бөгөөд хөрөнгө баталгаажуулсны төлбөр жилийн 0.25 хувьтай тэнцэж байна.

Энэ хүрээнд Засгийн газрын Өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт тусгасны дагуу эдийн засгийн бодит өсөлт болон экспортын орлогыг нэмэгдүүлэхгүй, гадаад улс орны худалдан авалтыг дэмжих замаар импортыг өсгөж, төлбөрийн тэнцэлд дарамт учруулах нөлөө бүхий Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэрийг авч ашиглахаас татгалзаж, бодит эдийн засгийн салбарт чиглэсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх гадаад зээлийг түлхүү авч ашиглах төлөвлөгөөтэй байна.

Засгийн газрын нийт гадаад зээлийн хэмжээ 2023 оны хагас жилийн байдлаар 20.3 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй байгаагийн 3.4 их наяд төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлтэй олгожээ.

Дамжуулан зээлийн эргэн төлөлт 2019 он хүртэл 30-50 тэрбум төгрөг жилд эргэн төлөгддөг байсан бол сүүлийн жилүүдэд төсвийн сахилга бат, зээлийн эргэн төлөлтийг сайжруулах ажлыг үе шаттай авч хэрэгжүүлснээр

2020 онд 182.0 тэрбум, 2021 онд 97.0 тэрбум төгрөг төвлөрсөн бөгөөд 2022 оноос Орон нутгийн Засаг даргын Тамгын газруудаар дамжуулан олгосон эргэн төлөлт огт хийгддэггүй байсан зээлийн хугацаа хэтэрсэн төлбөрийг орон нутгийн төсвөөс суутгах ажлыг зохион байгуулснаар дамжуулан зээлийн эргэн төлөлтөд тус онд 197.1 тэрбум, 2023 оны эхний хагас жилийн байдлаар 56.0 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлж зээлийн эргэн төлөлт мэдэгдэхүйц сайжирсан. Орон нутгийн Засаг даргын Тамгын газруудын дамжуулан зээлийн эргэн төлөлт 2024 оны төсвийн жилээс хэвийн болж, төлбөрийн ачаалал буурна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 94 дүгээр тогтоолоор Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн дүрмийн сангийн Монголын талын хувь хэмжээг 83,673.5 сая төгрөгөөр, Оросын талын хувь хэмжээг ижил хэмжээгээр нэмэгдүүлэх асуудлаар Оросын талтай хэлэлцээ хийхийг Засгийн газарт даалгасан.

Түүнчлэн, Оросын талтай тохиролцсон тохиолдолд тус нийгэмлэгийн дүрмийн санг нэмэгдүүлэхтэй холбоотой Монголын талаас шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тус нийгэмлэгт олгосон “МОН-П1”, “МОН-П2” хөнгөлөлттэй зээлийн үндсэн төлбөрийн авлагаас шилжүүлэн тооцох замаар бүрдүүлэхийг даалгасан болно.

Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн “Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 380 дугаар тогтоолын хүрээнд Оросын талтай дүрмийн санг нэмэгдүүлэхтэй холбоотой харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулж, 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдөр Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийг үүсгэн байгуулах тухай 1949 оны хэлэлцээрийн протоколыг байгуулсан болно.

Үүнтэй холбоотойгоор Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 315 дугаар тогтоолоор “Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийг үүсгэн байгуулах тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн газар хоорондын 1949 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн хэлэлцээрийн протокол”-ыг баталж, Монголын талын дүрмийн санг нэмэгдүүлэхтэй холбоотой хөрөнгийг Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд тусгаж шийдвэрлэхээр даалгасан байх тул Төсвийн тухай хуулийн 24.2-т заасны дагуу Монголын талаас тус нийгэмлэгийн дүрмийн санг нэмэгдүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг 2024 оны төсвийн төсөлд тусгасан болно.

Засгийн газрын гадаад зээлийн хүүгийн зардлын хувьд 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт 472.6 тэрбум төгрөгтэй тэнцэхээр байна.

Нэг. Ашиглагдаагүй зээлийн хэмжээнд төлж буй шимтгэл:

Засгийн газрын хувьд 1991 оноос хойш нийт 38 зээлдүүлэгчийн 12.9 тэрбум ам.доллартой тэнцэх хэмжээний 346 зээлийн гэрээг байгуулж 2023 оны хагас жилийн байдлаар нийт 8.2 тэрбум ам.доллартой тэнцэх хэмжээний зээлийг авч ашигласан бол авч ашиглаагүй үлдэгдэл 3.0 тэрбум ам.доллартой тэнцэж байна.

Энэхүү гадаад зээлийн авч ашиглаагүй үлдэгдлээс зээлдүүлэгч байгууллагууд болон улс орнууд мөнгөн хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны шимтгэл нэртэйгээр тухайн зээлийн авч ашиглаагүй хэмжээнээс 0.1 хувиас 0.5 хувьтай тэнцэх төлбөрийг Засгийн газраас нэхэмжилдэг. Тухайлбал, БНЭУ-аас авч ашиглаж буй “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн зээлийн хэмжээ 1.2 тэрбум ам.доллартой тэнцэж байгаа боловч 2023 оны 08 дугаар сарын байдлаар 150 сая ам.доллартой тэнцэх хэмжээний ашиглалт гарсан байгаа тул Засгийн газрын зүгээс тус төслийн ашиглаагүй байгаа 1.0 тэрбум ам.доллартой тэнцэх зээлийн үлдэгдэлд 0.5 хувийн шимтгэлийг төлөхөөр байна.


Засгийн газрын гадаад зээлийн ашиглаагүй үлдэгдэл их байгаа ч улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардалд тусч, төсвийн алдагдал нөлөөлөх тул гадаад зээлийн ашиглалтын зардлыг төлөвлөгөөт дүнгээр гаргах боломж хязгаарлагдмал байдаг байна. Тухайлбал, 2023 онд гадаад зээлийн ашиглалтын хязгаар 1,224.5 тэрбум төгрөгтэй тэнцэж байсан бол 2024 онд 1,225.0 тэрбум төгрөгтэй тэнцэхээр төсвийн төсөлд тусгаад байна. Ийнхүү гадаад зээлийн ашиглалтын хэмжээ өсөхгүй байгаа нь дээрх мөнгөн хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны шимтгэлийн хэмжээг бууруулахгүй байх эрсдэлтэй байна.

Хоёр. Хөвөгч хүү:

Дэлхий даяар 2022 онд эдийн засаг, нийгмийн хүндрэлийн дараах мөчлөгт шилжиж, инфляц хурдтай өссөнөөр эдийн засагт томоохон нөлөө үзүүлэгч орнууд мөнгөний бодлогоо хатууруулсан байдаг. Тухайлбал, АНУ-ын инфляц 2022 оны 06 дугаар сард 9.4 хувьд хүрч 1981 оноос хойш хамгийн өндөр түвшиндээ хүрсэн тул төв банкны бодлогын хүүгээ тогтвортой өсгөж 2023 оны 07 дугаар сард гэхэд 5.5 хувьд хүргэж өсгөсөн. Мөн Австрали улсын инфляц 2022 оны 07 дугаар сарын байдлаар 6.1 хувьд хүрч 2001 оноос хойш хамгийн өндөр түвшиндээ хүрсэн тул төв банкны бодлогын хүү 2022 онд 0.1 хувь байсан бол 2023 оны 05 дугаар сард 4.1 хувьд хүргэж өсгөөд байна.

Ийнхүү олон улсад мөнгөний хатуу бодлого үргэлжилснээр АНУ-ын богино хугацаат үнэт цаасны зах зээл дээрх гурван төрлийн овернайт зээлийн жигнэсэн дундаж хүүгээр тодорхойлогддог баталгаат овернайт санхүүжилтийн хүүгийн түвшин /SOFR/-ийн хэмжээ 2022 оны 02 дугаар сард 0.05 хувь байсан бол 2023 оны 07 дугаар сар гэхэд 5.3 хувь болж өсөөд байна.

График 9.27. Баталгаат овернайт санхүүжилтийн хүүгийн түвшин /2018-2023/



Засгийн газрын гадаад зээлийн 25.4 хувийг хөвөгч хүүтэй зээл эзэлдэг бөгөөд хөвөгч хүүгийн түвшин 1.0 хувиар өсөхөд нийт зээлийн багцын дундаж хүүгийн түвшин 0.25 хувиар өсөхөөр байна. Харин сүүлийн 1 жилийн хугацаанд баталгаат овернайт санхүүжилтийн хүүгийн түвшин 5.3 хувиар өссөн байгаа нь нийт өрийн багцын дундаж хүүгийн түвшнийг 1.3 хувиар өсгөөд байна.

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт “Дэлхий нийтэд тулгараад байгаа нь инфляцын өсөлтөөс шалтгаалан гадаад зах зээлд бий болоод байгаа хүүгийн өсөлтөөс хамааран урт, дунд хугацаанд Засгийн газрын гадаад зээлийн хөвөгч хүү өсөх тохиолдолд тогтмол хүүтэй зээл авах нөхцөлийг зээлдүүлэгч талд тавьж ажиллах” гэж тусгасан. Энэ нь хөвөгч хүүгийн өсөлт үргэлжлэх тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын зүгээс олон улсын санхүүгийн байгууллагуудад тогтмол хүүтэй зээл авах саналыг тавьж ажиллахаар төлөвлөж байна.

Цаашилбал, баталгаат овернайт санхүүжилтийн хүүгийн түвшин нь АНУ-ын бодлогын хүүтэй шууд уялдах бөгөөд олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын тооцооллоор гутранги нөхцөлд 2024 оны сүүлийн хагас жилээр АНУ-ын бодлогын хүү 4.75 хувьд хүрч 2025 оноос буурах төлөвтэй гэж үзэж байгаа бол өөдрөг нөхцөлд 2024 онд сүүлийн хагас жил гэхэд 3 хувиас буурах төлөвтэй байгаа гэж дүгнэсэн байна.


Иймд 2024 оноос эхлэн энэхүү хүүгийн түвшин буурч Засгийн газраас төлөх хүүгийн зардал дагаад буурах төлөвтэй байгаа бөгөөд хөвөгч хүү нь 0 хүртэл буурах тохиолдол байдаг болно. Энэ тохиолдолд тогтмол хүүтэй зээлээс хөвөгч хүүтэй зээл нь зардал багатай болно.

Гурав. Төгрөгийн бусад валюттай харьцах ханш:

Засгийн газрын нийт өрийн 97 хувийг гадаад валютаар илэрхийлэгдсэн өрийн хэмжээ эзэлдэг бөгөөд үүний 67 хувийг гадаад зээл бүрдүүлдэг байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар 48.7 хувийг ам.доллар, 25.2 хувийг зээлжих тусгай эрх, 18.3 хувийг иен, 5.9 хувийг евро эзэлж байна.

График 9.28. Засгийн газрын гадаад зээлийн ханшийн багц

Нийт: 20,301.4 тэрбум төгрөг (2023.06.30)



Ийнхүү нийт Засгийн газрын өрийн 97.0 хувийг эзэлж буй гадаад зээллэгийн хувьд гадаад валютын ханш өсөхөд дагаад хүүгийн төлбөр тэр хэмжээгээр ихэснэ.

9.1.4. Засгийн газрын гадаад үнэт цаас

Засгийн газраас олон улсын зах зээлд арилжаалсан гадаад үнэт цаасны үлдэгдэл 2023 оны эхний хагас жилийн байдлаар 9,070.6 тэрбум төгрөг буюу 2,642.6 сая ам.доллартой тэнцэж байна

Хүснэгт 9.2 Гадаад үнэт цаас, 2023.06.30 /тэрбум Т/

№	Гадаад үнэт цаас	Хүү	Хугацаа	Үлдэгдэл тб ₮
1	Хуралдай	8.750%	7 жил	1,347.3
2	Номад	5.125%	5.5 жил	2,059.5
3	Сенчирн-2027	3.500%	6 жил	1,716.3
4	Сенчирн-2028	8.650%	5 жил	2,231.2
5	Сенчирн-2031	4.450%	10 жил	1,716.3

НИЙТ

9,070.6

Засгийн газар нь 2023 онд өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт заасны дагуу гадаад үнэт цаасны өрийн зохицуулалтын арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бөгөөд олон улсын зах зээлийн нөхцөл байдал, хөрөнгө оруулагчдын байр сууриас шалтгаалан шинээр хийх өрийн зохицуулалтын арга хэмжээний хугацаа, зардлын түвшин тодорхойлогдоно.

Олон улсын зах зээл гаргасан Монгол улсын гадаад үнэт цаасны хоёрдогч зах зээл дээрх өгөөжийг доорх графикт харуулав.

График 9.6 Гадаад үнэт цаасны олон улсын зах зээл дээрх өгөөж 2022.09.21-



Эх үүсвэр: Блүүмберг терминал

Дэлхий даяар инфляц түүхэн дээд хэмжээнд хүрч, АНУ-ын Төвбанкны бодлогын хүү өсөж 4.25 - 4.5 хувьд хүрсэн, БНХАУ-ын “Тэг Ковид”-ын бодлого болон Орос Украины хурцадмал нөхцөл байдал үүссэн энэ хүнд цаг үед манай улстай ижил зээлжих зэрэглэлтэй буюу “В” зэрэглэлтэй орнуудын хувьд олон улсын хөрөнгийн зах зээлээс эх үүсвэр татах боломж огцом хумигдаж байсан. Үүнтэй зэрэгцэн 2022 оны 09 дүгээр сард Блүүмберг платформд Монгол Улсын тухайн үеийн эдийн засгийн нөхцөл байдал, валютын нөөцийн огцом бууралт, төлбөрийн тэнцлийн алдагдлын талаар мэдээлэл нийтлэгдсэнээр Монгол Улсын Засгийн газрын бондын өгөөж 5-8 дахин нэмэгдэж 40 хувьд хүрч, 2022 оны 12 сард өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдалтай тулгарч байсан.

Гэсэн хэдий ч Засгийн газрын зүгээс олон улсын санхүүгийн зах зээлийн нөхцөл байдлыг анхааралтай ажиглаж, олон улсын хөрөнгө оруулагчидтай тогтмол мэдээлэл солилцож, эдийн засгийн үзүүлэлтүүд 2022 оны гүйцэтгэлээр сайжирч, зах зээлийн цонх үеийг ашиглан 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр “Сенчири 2” төслийн хүрээнд Монгол Улсын Засгийн газар 5 жилийн хугацаатай, 8.65 хувийн хүүтэй, нийт 650 сая ам.долларын өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж хугацаа тулаад байсан “Гэрэгэ” бондоос 149.3 сая ам.доллар, “Хуралдай” бондоос 495.3 сая ам.доллартой тэнцэх хэсгийг дахин санхүүжүүлээд байна.

Монгол Улс 2017 онд АНУ-ын бодлогын хүү 1 хувьтай байхад анхны өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор “Хуралдай” бондыг 8.75 хувийн хүүтэйгээр 2017 оны 03 дугаар сард, “Гэрэгэ” бондыг 5.625 хувийн хүүтэйгээр 2017 оны 11 дүгээр сард олон улсын санхүүгийн зах зээл дээр гаргаж байсан бол АНУ-ын бодлогын хүү 4.5 хувь болж өссөн энэ үед дээрх бондуудтай ижил түвшинд дахин санхүүжилт хийсэн.

Дээрх өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлснээр “Гэрэгэ” бондын үлдэгдэл 82.0 сая ам.доллартой тэнцсэн бөгөөд Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт тусгасны дагуу улсын төсвөөс боломжит хэмжээгээр төлж барагдуулсан. Ингэснээр Засгийн газрын гадаад бондын үлдэгдэл нийт 82.0 сая ам.доллароор буурсан.

Түүнчлэн, “Хуралдай” бондын үлдэгдэл өрийн зохицуулалтын арга хэмжээний үр дүнд 392.5 сая ам.доллартой тэнцэж байгаа бөгөөд 2024 онд төлөгдөх нөхцөлтэй. Тус бондын төлбөрийг зардал-ашгийн тооцооллыг хийж, хамгийн ашигтай хувилбарыг сонгосны үндсэн дээр өрийн зохицуулалтын үйл ажиллагааг зохион байгуулж, төлж барагдуулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.


Ногоон санхүүжилт

Дэлхий дахинд хурдацтай өрнөж буй хөгжил дэвшлээс үүдсэн нийгэм, эдийн засаг, байгаль орчны асуудлыг шийдэх, дэлхийн хүн амын тав тухтай, тогтвортой амьдралын хэв маягийг бий болгох зорилгын хүрээнд улс орнууд байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжилд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг эрчимтэй санхүүжүүлэх болсон.

Сүүлийн жилүүдэд байгаль орчинд ээлтэй төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилтийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд олон улсын санхүүгийн зах зээлд ногоон бонд гаргах сонирхол, эрэлт хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна. Энэ хүрээнд Дэлхийн улс орнууд 2016 оноос хойш олон улсын санхүүгийн зах зээлд ногоон бонд босгох замаар байгаль орчинд ээлтэй төсөл хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлж, улмаар ногоон эдийн засаг


руу шилжих шилжилтийг хийж эхлээд байна. Тухайлбал, 2021 онд нийт 16 улсын Засгийн газар 92 тэрбум ам.долларын санхүүжилт, 2022 онд нийт 17 улсын Засгийн газар 81 тэрбум ам.долларын санхүүжилтийг олон улсын санхүүгийн зах зээлээс татан төвлөрүүлээд байна.

График 7.7 Олон улсын ногоон бондын зах зээл, 2017-2022 /тэрбум \$/



Ногоон бондын зах зээлд Европ, Хойд Америкийн улс орнууд, нэн ялангуяа хөгжингүй улс орнууд голлон оролцдог ба 2022 оны байдлаар хөгжингүй орнууд ногоон бондын зах зээлийн 67.6 хувийг эзэлж байна.


График 7.8 Олон улсын ногоон бондын зах зээл, 2017-2022 /тэрбум \$/



Засгийн газар болон компанийн бондоос ялгаатай нь ногоон бонд гаргагч нь зах зээлээс босгосон санхүүжилтээ зөвхөн ногоон хөгжлийн шаардлага хангасан төслүүдэд хуваарилах ёстой байдгаараа онцлогтой. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал нь дэлхий нийтийн өмнө тулгамдаж буй томоохон асуудлын нэг бөгөөд энэ хүрээнд олон улсад жил бүр шинээр

гаргаж буй ногоон бондуудын 30-35 хувь нь эрчим хүчний төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор гаргаж байна.

График 9.9. Ногоон бондын зарцуулалт /2017 он, 2022 он/



9.1.5. Засгийн газрын дотоод өр


Засгийн газрын дотоод үнэт цаас

Засгийн газрын дотоод үнэт цаас (ЗГДҮЦ)-ны хүү тогтох зарчим нь 2012-2017 оны хооронд өрсөлдөөнт арилжаанд оролцогчдоос ирүүлсэн хүүгийн саналаар буюу бодлогын хүүгийн түвшнээс 3-5 хувиар өндөр тодорхойлогддог байсан нь өрсөлдөөнт бус арилжааны хүү болж иргэд, хуулийн этгээдүүдэд худалдаалагддаг байсан. Ийнхүү ЗГДҮЦ өндөр хүүтэйгээр арилжаалагдах нь ЗГДҮЦ-ны хүүгийн зардлыг өсгөх, улмаар төсөвт дарамт үзүүлж эхэлсэн. Түүнчлэн, ЗГДҮЦ-ны арилжааны хөрөнгө оруулагчдын 86 хувь нь арилжааны банкнууд байсан нь Засгийн газрын үнэт цаасны хөрөнгө оруулагчдын өрсөлдөөнийг хязгаарлаж байсан тул Засгийн газрын дотоод үнэт цаас гаргалтыг 2017 оны 10 дугаар сараас эхлэн зогсоосон.

Засгийн газрын өрийн оновчтой багцын бүтцийг бий болгох, Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээг бага зардлаар, боломжит эрсдэлийн түвшинд хангах зорилгоор Сангийн сайдын 2022 оны 7 дугаар сарын сарын 6-ны өдрийн 145 дугаар тушаалын дагуу 300.0 тэрбум төгрөгтэй тэнцэх Засгийн газрын дотоод үнэт цаасыг “Хадгаламжийн даатгалын корпораци сан”-д, Сангийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын сарын 29-ний өдрийн 183 дугаар тушаалын дагуу 383.9 тэрбум төгрөгтэй тэнцэх Засгийн газрын дотоод үнэт цаасыг “Монгол Улсын Хөгжлийн банк”-д хаалттай хүрээнд арилжаалсан байна.

ЗГДҮЦ-ны үлдэгдэл 2023 оны эхний хагас жилийн байдлаар 651.6 тэрбум төгрөг байгаа бөгөөд үүнээс 555.0 тэрбум төгрөг төсвийн алдагдал санхүүжүүлэх, 96.0 тэрбум төгрөг нь “Сайн хувьцаа” хөтөлбөрийг санхүүжүүлэх зориулалтаар арилжаалсан үнэт цаас байна.

График 9.10 Монголын Хөрөнгийн биржээр арилжаалсан үнэт цаасны арилжаа болон ЗГДҮЦ-ны арилжаа.



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Санхүүгийн зохицуулах хорооноос гаргадаг судалгаагаар 2023 оны хагас жилийн байдлаар үнэт цаасны зах зээлд нийт 608 зохицуулалттай этгээд, хувьцаат компани үйл ажиллагаа явуулж байгаа нь 2017 оны мөн үеэс 2 дахин нэмэгдсэн, 533.9 тэрбум төгрөгийн үнэт цаас зах зээлд арилжаалагдсан нь 2018 оны мөн үеэс 6.8 дахин өссөн үзүүлэлттэй байна. Мөн үнэт цаасны данстай 2.5 сая хүн байгаа нь нийт хүн амын 75 хувь буюу 2017 оны мөн үеэс 2.7 дахин өссөн байна. Үнэт цаасны зах зээлийн арилжаанд оролцогчдын 98 хувь нь дотоодын иргэн, ААН байгаа нь ЗГДҮЦ-ны арилжаа зогссон 2017 онтой харьцуулахад үнэт цаасны зах зээл харьцангуй өсөлттэй хөрөнгө оруулагчдын тоо нэмэгдсэн эерэг үзүүлэлттэй байгаа нь ЗГДҮЦ гаргахад таатай нөхцөл байдлыг үүсгээд байна.

Түүнчлэн, Олон улсын валютын сан 2021 онд Монгол Улсын дотоод үнэт цаасны зах зээлийн талаар судалгаа хийж, зөвлөмж гаргаад байна. Уг зөвлөмж нь ЗГДҮЦ-ны арилжааг бага хэмжээний богино хугацаат үнэт цаасаар эхлүүлэх аажмаар хэмжээг нэмэгдүүлж урт хугацаат үнэт цаас болгон шилжүүлэх, цөөн тооны худалдан авагчид зах зээлд давамгайлахаас сэргийлж арилжааны банкнуудын анхдагч зах зээлийн арилжаанд дээд хязгаар тогтоох, мэргэжлийн хөрөнгө оруулагчийг төрөлжүүлэн тэдгээрийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай талаар дурдсан байна.

ЗГДҮЦ-ны зах зээлийг хөгжүүлэх, хөрөнгийн зах зээл дэх жишиг хүүгийн түвшин /бенчмарк/-г тогтоох зорилгоор жил бүр шинээр гаргах Засгийн газрын дотоод үнэт цаасны 10-20 хүртэлх хувийг урьдчилан зарласан хугацаа, нөхцөл бүхий хуваарийн дагуу олон нийтэд нээлттэй зарлаж, хуваарийн дагуу үнэт цаасны арилжааг зохион байгуулах замаар арилжааг тогтмолжуулах. Бенчмаркийг тогтоосноор зах зээлийг илүү тогтвортой болгоход чухал нөлөө үзүүлдэг бөгөөд тухайн үнэт цаас нь эрэлт их, купон нь зах зээлтэй уялдаж тогтсон үед бенчмарк гэж тооцох боломжтой байдаг.

Олон улсын туршлагаас харахад Норвеги улс нь дотоод зах зээлдээ 11 жилийн хугацаатай бондыг гаргаж 2 жил бүр дахин арилжаалах захиалга өгдөг. Ингэснээр зах зээлд 1, 3, 5, 7, 9, 11 жилийн хугацаатай бондуудын өгөөжийн бенчмаркийг тогтоох боломжтой болдог бөгөөд 2 жилийн дараа дахин 11 жилийн хугацаатай үнэт цаас арилжаалж тухайн өгөгдөл тогтмол шинэчлэгдэх давуу талтай байдаг.

Харин Сингапур улс нь өөр өөр давтамжтайгаар өгөгдөл шаардлагатай болох үед 2, 5, 10, 15, 20, 30 жилийн хугацаатай бондуудыг олон улсын зах зээлд арилжаалж мэдээллийг шинэчилдэг бөгөөд өрийн багцад шаардагдах хэрэгслийг тухай бүр арилжаалах боломжтой болдог давуу талтай. Монгол Улсын хөрөнгийн зах зээлд Норвеги улсын туршлага илүү тохиромжтой байна. Учир нь Монгол Улсын хөрөнгийн зах зээл бусад улстай харьцуулахад жижиг тул Засгийн газарт шаардлагатай үнэт цаасыг авах эрэлтийн дутагдал үүсэх эрсдэлтэй байна. Харин ижил давтамжтайгаар зөвхөн нэг үнэт цаасыг дахин арилжаалж эхлэхэд хөрөнгө оруулагчид урьдчилан бэлтгэх боломжийг олгоно.

9.2 Засгийн газрын болзошгүй өр төлбөр

Төсвийн тухай хуулийн дагуу Засгийн газрын болзошгүй өр төлбөрт Засгийн газрын тусгай сангийн үүсгэсэн өр төлбөр, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн өр, төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасны дагуу гаргасан баталгаа, Засгийн газрын өрийн баталгаа гаргасан зээллэгийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний мэдээллийг оруулж тооцдог. Засгийн газрын өрд эдгээр болзошгүй өр төлбөрөөс зөвхөн Засгийн газрын өрийн баталгаа гаргасан зээллэгийн хэмжээ тусгагддаг болно.

9.1.6. Засгийн газрын өрийн баталгаа

“Засгийн газрын өрийн баталгаа” нь баталгаа гаргуулагч зээллэгийн төлбөрийн үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон тохиолдолд төлбөрийг баталгаа гаргуулагчийн өмнөөс төлж барагдуулахаар Засгийн газрын хүлээсэн үүрэг бөгөөд улсын төсөвт учирч болзошгүй өр төлбөрт хамаарна. Засгийн газрын өрийн баталгаатай зээллэгийн төлбөрийг Монгол Улсын

Хөгжлийн банк, “Эрдэнэс Монгол” ХХК зэрэг зээл авсан байгууллагууд эргэн төлөлтийн хуваарийн дагуу хэвийн гүйцэтгэж байна.

9.1.7. “Самурай” үнэт цаасанд гаргасан Засгийн газрын өрийн баталгааг 2023 онд эргэн төлнө - МУХБ 2014 оны 01 сарын 06-ны өдөр Японы зах зээл дээр 30.0 тэрбум иений “Самурай” үнэт цаасыг 10 жилийн хугацаатай, жилийн 1.52 хувийн хүүтэй арилжаалсан бөгөөд Засгийн газрын 2013 оны 417 дугаар тогтоолоор Засгийн газар баталгаа гаргасан. МУХБ гэрээний дагуу “Самурай” үнэт цаасны үндсэн төлбөрийг 2023 оны 12 дугаар сард 714.5 тэрбум төгрөгтэй тэнцэх иений төлбөрийг төлөх хуваарьтай байна.

Түүнчлэн, Самурай бондыг төлөх валютыг тус банкны олгосон зээлийн эргэн төлөлтийн хуримтлагдсан эх үүсвэрээс бүрдүүлж, Монголбанкинд Японы иений валютаар бүрэн байршуулаад байна. Ингэснээр хөрөнгө оруулагчдын өмнө Монгол Улсын Засгийн газар болон Хөгжлийн банк нь нэгэн цогц санхүүгийн систем болж тооцогддог тул Хөгжлийн банкны дахин санхүүжилтийн эрсдэлээс сэргийлж, эх үүсвэрийг бүрэн нөөцөлж чадсан энэхүү арга хэмжээ нь хөрөнгө оруулагчдын өмнө Монгол Улсад итгэх итгэлийг сэргээхэд чухал ач холбогдолтой болж байна.

9.1.8. “Эрдэнэс монгол” ХХК-д гаргасан Засгийн газрын баталгаа 2031 онд бүрэн төлөгдөх хуваарьтай байна. Азийн хөгжлийн банкнаас авч буй хөнгөлөлттэй техник туслалцааны зээл “Эрдэнэс Монгол” ХХК 2016 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр 35.0 сая ам.долларын ЛИБОР (6 сар) +0.6 хувийн хүүтэй, 15 жилийн хугацаатай зээлийг Азийн хөгжлийн банкнаас авсан бөгөөд Засгийн газрын 2016 оны 138 дугаар тогтоолоор Засгийн газрын баталгаа гаргасан. Зээлийн үлдэгдэл 2023 оны хагас жилийн байдлаар 29.6 тэрбум төгрөгтэй тэнцэж байгаа бөгөөд 2031 онд зээл төлөгдөж дуусна.

9.1.9. Барих-шилжүүлэх төрлийн концесс

Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 10 концессын гэрээний үлдэгдэл 2022 онд 463.5 тэрбум төгрөгтэй тэнцэж байгаа бол орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 3 концессын гэрээний хүрээнд 0.4 тэрбум төгрөгтэй тэнцэж байсан бол 2023 оны эхний хагас жилийн байдлаар 342.8 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

График 10.29. Барих-шилжүүлэх төрлийн концессын үлдэгдэл, гэрээний тоо



Түүнчлэн, Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоолд “Улсын төсөв болон Хөгжлийн банкнаас эргэн төлөгдөх нөхцөлтэй хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжүүлж чадаагүй үлдэгдэл, “Барих-шилжүүлэх” концессын гэрээний эргэн төлөлт, шүүхийн шийдвэрээр олгох санхүүжилтийг 2017 оноос эхлэн векселиэр баталгаажуулахгүй байх;” гэж, Засгийн газрын 2016 оны 37 дугаар тогтоолд “Концессын гэрээ байгуулах замаар улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөх үүрэг шинээр үүсгэхгүй байх” гэж тус тус заасны дагуу 2017 оноос эхлэн барих-шилжүүлэх төрлийн концессын гэрээ болон векселийн гэрээг байгуулагдаагүй байна.

9.3 Улсын секторын өр

Улсын секторын өр нь Засгийн газрын өрөөс гадна Төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдүүдийн өр төлбөрийг нэгтгэж тооцсон ойлголт бөгөөд Олон улсын валютын сан, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагаас дэлхийн улс орнуудын улсын өрийн статистикийг тогтсон стандартын дагуу нэгтгэн улирал бүр тайлан гаргадаг байна. Тус статистикийг гаргаснаар Засгийн газар ирээдүйд гарч болзошгүй өр төлбөрийн эрсдэлээс сэргийлэх, оновчтой удирдах хөшүүргийг бие болгох онцлог ач холбогдолтойгоос гадна мэдээллийн ил тод байдлыг сайжруулж байдаг байна.

Хүснэгт 9.4 Монгол улсын секторын өрийн статистик 2022 он

	2022.06.30	2022.12.31
I. Засгийн газрын өр	28,508.8	31,964.8
Төв Засгийн газрын өр	27,076.7	30,677.1
Орон нутгийн өр	21.0	12.3
Засгийн газрын баталгаа	940.7	811.8
Барих-Шилжүүлэх үлдэгдэл	470.5	463.5
концессын		

II.Төрийн өмч, төрийн өмч давамгайлсан санхүүгийн бус салбарын байгууллагуудын өр	6,803.5	7,959.8
Үүнээс:		
Гадаад	5,049.9	4,415.5
Богино хугацаат өр	2,779.9	3,684.5
Урт хугацаат өр	2,270.0	731.0
Дотоод	1,753.5	3,544.3
Богино хугацаат өр	601.5	1,566.5
Урт хугацаат өр	1,152.0	1,977.8
Улсын секторын өр (I+II)	35,312.3	39,924.6

Дээрх хүснэгтэд улсын секторын өрийн статистикийг нэгтгэн харуулсан ба Төрийн өмч, төрийн өмч давамгайлсан санхүүгийн бус салбарын байгууллагуудын хамгийн том буюу нийт өрийн 90 -ээс дээш хувийг эзэлж буй 15 байгууллагыг багтаасан болно.

Түүнчлэн Засгийн газраас зөвхөн өрийн удирдлагыг сайжруулахаас гадна хөрөнгө, өр төлбөрийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэхэд онцгой анхаарч ажиллаж байна.

Улсын хөрөнгө, өр төлбөрийн нэгдсэн удирдлага нь төрийн салбарт тулгарч болох санхүүгийн эрсдэлүүдийг тодорхойлж, урьдчилан сэргийлснээр санхүүгийн тогтвортой байдлыг хадгалж, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд оршино. Засгийн газрын тайлан тэнцэл нь хөрөнгө, өр төлбөрөөс бүрдэх бөгөөд улс улсын онцлогоос хамаарч Төв засгийн газар, орон нутгийн захиргаа, тэтгэврийн сан, төрийн өмчит компани, Төв банкныг хамруулдаг. Улсын хөрөнгө, өр төлбөрийн нэгдсэн удирдлагыг оновчтой хэрэгжүүлснээр ханш, хүү, инфляц, түүхий эдийн ханш зэрэг хүчин зүйлийн эрсдэлээс сэргийлээд зогсохгүй нийгмийн халамж гэх мэт эх үүсвэр нь тодорхойгүй, ирээдүйд гарах төсвийн зардал зэрэг урт хугацааны төсвийн асуудлуудыг ч шийдэх боломж бүрддэг.

Гэвч ихэнх улс орны жишээнээс харахад хөрөнгө, өр төлбөрийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэхэд хэд хэдэн нийтлэг бэрхшээл тулгардаг. Нэгт, улс орнуудын нэгтгэсэн тайлан тэнцэлд тухайн улсын нийт хөрөнгө бүртгэгдсэн байх нь ховор бөгөөд энэ нь бүх хөрөнгө болон өр төлбөрийн мэдээллийг шууд авахад хүндрэл учруулдаг. Засгийн газрын түгээмэл тайлан тэнцлийн хөрөнгө талд зам, дэд бүтэц зэрэг үл хөдлөх хөрөнгө, төрийн өмчит компаниудын хөрөнгө зэрэг хөдлөх хөрөнгө байдаг. Хэдийгээр төв банк хараат бус үйл ажиллагаатай ч ихэнх улсад Засгийн газрын ашиг алдагдлыг зохицуулах зорилгоор арилжаа гүйлгээ хийдэг тул Засгийн газрын тайлан тэнцэлд багтдаг. Засгийн газрын хөрөнгө дотор томоохон хувийг ирээдүйн төсвийн орлого эзэлдэг бол өр төлбөр талд ч мөн ихээхэн хувийг ирээдүйн төсвийн зардал эзэлдэг.

ХӨРӨНГӨ	ӨР ТӨЛБӨР
Ул хөдлөх хөрөнгө (газар, дэд бүтэц)	Засгийн газрын өр
Төрийн сангууд	Төслийн гүйцэтгэгчдэд шилжүүлэх төлбөрүүд
Төрийн өмчит компаниудын хөрөнгө	Гэрээгээр шилжүүлэх бусад шилжүүлэг
Төв банкин дахь гадаад валютын нөөц	Ирээдүйн төсвийн зардлын өнөөгийн үнэ цэнэ
Бусад санхүүгийн хөрөнгө	
Ирээдүйн төсвийн орлогын өнөөгийн үнэ цэнэ	

9.1.10. Орон нутгийн өр

Өрийн удирдлагын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.2 дахь заалтад тусгасны дагуу аймаг, нийслэлийн өрийг Засгийн газрын өрд бүртгэж, тайлагнадаг. Энэ хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын зүгээс 2021 онд Монгол Улсын Хөгжлийн банкнаас нийтийн тээврийн авто баазыг нэмэгдүүлэх зорилгоор авч ашигласан 21.0 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний зээлийг Засгийн газрын өрд бүртгэсэн бөгөөд 2023 онд дууссан байна.

Түүнчлэн, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын зүгээс Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулж, түгжрэлийг бууруулах, авто зам, замын байгууламжийн сүлжээг өргөтгөх, агаарын бохирдлыг бууруулах төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зорилгоор 500 тэрбум төгрөг хүртэлх хэмжээний үнэт цаасыг дотоодын зах зээлд арилжаалах төлөвлөгөөтэй байгаа бөгөөд эхний ээлжид 2023 онд багтаан Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах, инженерийн дэд бүтцийн хүртээмж, авто зам, замын байгууламжийн сүлжээг нэмэгдүүлэх, сургууль цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Цаашлаад 2024 онд Сэлбэ, дунд голын дагуу үерийн гамшгаас сэргийлж, далан байгуулах, Улаанбаатар хотын авто замын сүлжээний нэвтрүүлэх чадварыг сайжруулж, түгжрэлийг бууруулах зорилгоор хэрэгжүүлж буй “Сэлбэ сэргэлт” төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд үе шаттайгаар бондыг арилжаалахаар байна.


Түүнчлэн, орон нутгийн Засаг даргын Тамгын газруудыг дотоодын зах зээлд үнэт цаас гаргах асуудал нь одоогийн байдлаар эрх зүйн орчин дутмаг, бусад арилжаанд оролцогч байгууллагуудтай харилцах харилцааны асуудал тодорхой бус байна. Энэ асуудлыг шийдвэрлэхээр Засгийн газрын зүгээс ажиллаж байгаа бөгөөд тодорхой төсөл, арга хэмжээг улсын төсөв, гадаад зээлээс санхүүжүүлэхээс гадна орон нутгийн төсөвт үнэт цаас гаргах замаар хэрэгжүүлэх нь ихээхэн боломжийг нээж өгөхөөр байна.

9.4 Улсын нийт гадаад өр

Монгол Улсын нийт гадаад өрийн хэмжээ 2023 оны хагас жилийн байдлаар 33.8 тэрбум ам.доллартой тэнцэж байгаагаас 21.8 тэрбум ам.долларыг аж ахуй нэгжүүдийн гадаад өр, 8.0 тэрбум ам.долларыг Засгийн газрын гадаад өр, 2.0 тэрбум ам.долларыг Төв банкны өр, үлдсэн 1.7 тэрбум ам.долларыг арилжааны банкнуудын өр тус тус эзэлж байна.


Монгол Улсын нийт гадаад өрийн ДНБ-д харьцуулах харьцаа үзүүлэлт 2021 он хүртэл 200 хувиас өндөр байсан бол 2022 оноос эхлэн буурч 2023 оны хагас жилийн байдлаар 189 хувьтай тэнцэж байна. Мөн энэхүү үзүүлэлтэд Оюутолгойн өр төлбөр орж тооцогдох бөгөөд үүнийг хасахад ДНБ-д эзлэх улсын нийт гадаад өрийн хэмжээ 117 хувьтай тэнцэж байна.

График 30. Улсын нийт гадаад өрийн статистик 2018-2023.И /тэрбум \$/



Улсын нийт гадаад өрийг зээлдүүлэгч тус бүрээр харуулбал Олон зээлдүүлэгч оролцсон зээллэгийн үлдэгдэл 12.9 тэрбум ам.доллар, Нидерланд улсын 11.3 тэрбум ам.доллар, БНХАУ-ын 3.7 тэрбум ам.доллар, Япон улсын 1.2 тэрбум ам.доллар, Сингапур улсын 1.0 тэрбум ам.доллар, бусад улсын 3.6 тэрбум ам.доллартой тэнцэж байна.

График. Улсын нийт гадаад ор, зээлдүүлэгчээр, тэрбум ам.доллар, хувиар /2023.06.30/



9.5 Засгийн газрын 2023-2025 оны өрийн удирдлагын стратегийн баримт бичгийн хэрэгжилт

Засгийн газрын зүгээс “Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичиг”-ийг боловсруулж үндсэн 6 зорилтыг дэвшүүлсэн.

Зорилт 1

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, гадаад зээлийн өрийн үйлчилгээний төсөвт үзүүлэх төлбөрийн дарамтыг бууруулна.

1.1 Эдийн засгийн бодит осолт болон экспортын орлогыг нэмэгдүүлэхгүй, гадаад улс орны худалдан авалтыг дэмжих замаар импортыг осгож, төлбөрийн тэнцэлд дарамт учруулах нөлөө бүхий Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэрийг авч ашиглахаас татгалзах;

Засгийн газар хөгжлийн түншүүдтэй хөгжлийн хамтын ажиллагааны дунд хугацааны стратегийг тохиролцон Засгийн газрын шугамаар гадаад улс, олон улсын банк, санхүүгийн байгууллагаас зээл авахдаа зээлийн ерөнхий хэлэлцээр байгуулагдсан, тусгайлсан зээлийн хэлэлцээрээр эх үүсвэр баталгаажсан, эдийн засгийн үр ашигтай төсөл, арга хэмжээ байх шаардлагыг тавьж, үргэлжилж буй төслүүдийн хувьд тухайн жилд дуусгавар болох төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бүрэн тусгах, тэргүүлэх ач холбогдолтой, амжилттай хэрэгжиж буй төсөл, арга хэмжээг дэмжих зарчмыг баримтлан ажиллаж байна.

Энэ хүрээнд Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын “Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр УИХ-аар соёрхон батлуулсан. Уг хөтөлбөрийн хүрээнд хүнс, хөдөө

аж ахуйн үйлдвэрлэл болон хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, инженерийн дэд бүтэц, агро-парк байгуулах, үйлдвэрлэлийг дэмжих санхүүжилтийн механизмыг боловсруулж, санхүүжилтийн хэрэгцээг хангаснаар импортыг бууруулж, экспортыг нэмэгдүүлэх зорилготой болно.

Хөтөлбөрийг Азийн хөгжлийн банк, Уур амьсгалын ногоон сан болон Европын хөрөнгө оруулалтын банкны хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж болон Монгол Улсын Засгийн газрын оролцоотойгоор нийт 735.0 сая ам.долларын санхүүжилтээр 17 аймаг, 52 байршилд хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Түүнчлэн, Азийн хөгжлийн банкнаас ирэх жилүүдэд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор Монгол Улсад 655.0 сая ам.долларын санхүүжилтийн эх үүсвэрийг хуваарилж, Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн хэлэлцээрийг амжилттай байгуулсан бөгөөд Улсын Их Хурлаар 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдөр соёрхон батлуулсан. Тус Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн хүрээнд эдийн засгийн бодит өсөлтийг нэмэгдүүлэх, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд нийт 191.7 сая ам.долларын санхүүжилтээр дараах 3 төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Үүнд:

1. Хилийн үр бүтээмжийг сайжруулж тогтвортой худалдааг дэмжих төсөл;
2. Сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх төсөл (дамжуулах шугам) буюу (Эрдэнэбүрэн-Мянгад эрчим хүчний дамжуулах шугам);
3. Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил /II үе шат/ төсөл зэрэг төслүүд болно;

Зорилт 2 ●

Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж, дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулна.

2.1, 2.2. Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрийг монгол хөрөнгийн хуримтлалаас боломжит хэмжээгээр төлөх, өрийн зохицуулалтын арга хэмжээ, хугацаанаас нь өмнө худалдан авах, дахин санхүүжүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

Дахин санхүүжилтийн арга хэмжээний хүрээнд 2023 оны 01-р сард Сенчири- 2 өрийн зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлж нийтдээ 650 сая ам.доллартой тэнцэх гадаад үнэт цаасыг дахин санхүүжүүлсэн бөгөөд “Гэрэгэ” бондын 435.3 сая ам.долларыг, “Хуралдай” бондын 207.5 сая ам.долларын төлбөрийг тус тус шийдвэрлэсэн.

Гадаад үнэт цаасны төлбөрийг мөнгөн хөрөнгийн хуримтлалаас боломжит хэмжээгээр төлөх арга хэмжээний хүрээнд 2022 оны 12 дугаар сарын 5-ны өдөр эргэн төлөгдөх хуваарьтай Чингис бондын үлдэгдэл 136.8 сая ам.долларыг 2022 оны 12 дугаар сарын 5-ны өдөр , Гэрэгэ бондын

үлдэгдэл төлбөр болох 82.0 сая ам.долларыг 2023 оны 04 дүгээр сарын 28 -ны өдөр гадаад валютын албан нөөцөд дарамт учруулахгүйгээр тус тус улсын төсвөөс төлж дуусгах үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүллээ.

2.3. Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулах үүднээс зэрэглэл тогтоогч байгууллага, хөрөнгө оруулагчдыг мэдээллээр тогтмол ханган хамтарч ажиллах;

Засгийн газрын зүгээс 2023 оны 06 дугаар сард олон улсын хөрөнгө оруулагчидтай роудшоу уулзалт (non deal roadshow) зохион байгуулсан. Энэхүү уулзалтын гол зорилго нь Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал, Монгол Улсын Хөгжлийн банкны үнэт цаасны эргэн төлөлт болон Хуралдай бондын эргэн төлөлтийн талаар мэдээллийг хүргэсэн бөгөөд хөрөнгө оруулагчдын саналыг сонсох байсан.

Түүнчлэн, 2023 оны 05 дугаар сард олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Фитч агентлагийн төлөөлөлтэй, 07 дугаар сард Эс энд Пи агентлагийн төлөөлөлтэй тус тус уулзалтыг зохион байгуулж, зээлжих зэрэглэл тогтоолгосон бөгөөд Монгол Улсын 2023 оны зээлжих зэрэглэлийг В тогтвортой түвшинд хэвээр хадгалаад байна. Мөн цаашид зээлжих зэрэглэлээ нэмэгдүүлэхэд дараах нөхцөлийг тавьсан болохыг мэдэгдсэн. Үүнд:

- ГВАН-ийг их хэмжээгээр нэмэгдүүлж, Засгийн газрын гадаад өрийн удирдлагын стратегийг хэрэгжүүлж, гадаад санхүүжилтийн хэрэгцээг бууруулж тогтвортой байдлыг хадгалах;
- Макро эдийн засгийн зөв, зохистой бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, түүхий эдийн үнийн болон олон улсын эдийн засгийн савлагаанд хэт мэдрэг байдлыг бууруулж, гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирэхэд таатай бизнесийн орчныг бүрдүүлэх;
- Засгийн газрын өрийн ДНБ-тэй харьцах харьцааг тогтмол бууруулах;
- Монгол Улсын эдийн засаг таамаглаж байгаагаас илүү буюу ижил орлоготой улс орнуудтай харьцуулахад сайжрах;
- Эдийн засгийн өсөлт хүлээлтээс давж өссөн тохиолдолд энэ нь төсөв, өр, гадаад зах зээлийн үзүүлэлтийг хурдан сайжруулах;
- Монгол Улсын тогтолцооны шинэчлэл, сайжруулалт хийх, ялангуяа бодлого боловсруулахдаа бодит ахиц дэвшил гаргах зэрэг болно.

Зорилт 3

Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж, орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх, Засгийн газрын өрийн багц дахь зах зээлийн эрсдэлээ сэргийлэх зорилгоор үүсмэл арга хэрэгслийг өрийн зохицуулалтын үйл ажиллагаанд нэвтрүүлнэ.

3.1 Дэлхий нийтэд тулгараад байгаа нь инфляцын осолтоос шалтгаалан гадаад зах зээлд бий болоод байгаа хүүгийн осолтоос хамааран урт, дунд хугацаанд Засгийн газрын гадаад зээлийн ховогч хүү осох тохиолдолд тогтмол хүүтэй зээл авах нөхцөлийг зээлдүүлэгч талд тавьж ажиллах

Засгийн газрын гадаад зээлийг авахдаа зээлийн хөнгөлөлтийн түвшнийг харгалзан үзэж Засгийн газраас гадаад зээл шинээр авах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ зээлдэгч байгууллагатай зээлийн хэлэлцээрт 2023 оны байдлаар 5 хувьтай тэнцэж байгаа хөвөгч хүүг багасгах бодлогыг баримталж ажиллаж байна. Тухайлбал, 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлаар батлагдсан “Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн 560.0 сая ам.доллартой тэнцэх хэмжээний зээлийн хөрөнгийн 420.0 сая ам.доллартой тэнцэх хэмжээний зээлийг тогтмол хүүтэй, үлдсэн 140 сая ам.долларыг хөвөгч хүүтэй нөхцөлтэйгөөр авч ашиглах болгож зээлийн нөхцөлийг сайжруулаад байна.

3.2 Орон нутгийн засаг захиргааны өрийн удирдлагын чадавхыг бэхжүүлж, болзошгүй ор толборийн эрсдэлээс сэргийлэх, Засгийн газрын өрийн мэдээллийн нэгдсэн санг хөтлөх талаар хамтран ажиллах

Өрийн удирдлагын тухай хуулийн 28¹ дүгээр зүйлийн 28^{1.7} дахь хэсэгт “аймаг, нийслэлийн Засаг даргын үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээлэхтэй холбогдсон журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулан, Засгийн газарт баталж мөрдүүлнэ” гэж заасны дагуу Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 199 дүгээр “Журам батлах тухай” тогтоолын хавсралтаар “Нийслэлийн үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээлэх журам”-ыг баталж Нийслэлийн Засаг даргын Тамгын газар дотоодын зах зээлд үнэт цаас гаргах эрх зүйн орчныг бүрдүүлж өгсөн болно.

Зорилт 4

Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих, үнэт цаасны арилжааг тогтмолжуулна.

4.1 Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжаанд орчин үеийн дэвшилтэт технологийг ашигласан арилжааны систем нэвтрүүлэх;

ЗГДҮЦ-ыг Монголын хөрөнгийн биржээр арилжаалах арга хэмжээг төлөвлөн ЗГДҮЦ-ны арилжааны шинэ системийн загварыг хөгжүүлэн туршилтын шатандаа явж байна. Энэхүү арилжааны систем нь хөрөнгө оруулагч нарт ашиглахад хялбар, ойлгомжтой байхаас гадна системийн аюулгүй байдлыг бүрэн хангасан дотоод систем байна.

4.2 Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч зах зээл дэх арилжаанд оролцогчдын эрэлтийг нэмэгдүүлэх, хоёрдогч зах зээл дэх үнэт цаасны хорвох чадварыг сайжруулах зорилгоор Засгийн газрын дотоод үнэт цаасыг хугацаанаас нь олно буцаан худалдан авах, зорилтот зах зээлд

чиглэсэн Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг зохион байгуулах дэд бүтэц болон хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх

Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 77 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааны журам”-ын 15 дугаар хэсэгт ЗГДҮЦ-ыг буцаан худалдан авах, хугацаа сунгах, нөхцөл тогтоох тухай заасан байдаг. Түүнчлэн, зорилтот зах зээлд чиглэсэн тендерийн зориулалттай Засгийн газрын дотоод үнэт цаасны талаар судалгааг хийж, ЗГДҮЦ-ыг тендерийн барьцаанд ашиглах тухай дээрх журамд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулаад байна.

Зорилт 5

Улсын стратегийн томоохон төслүүдэд Засгийн газрын өрийн баталгаа гаргах, хувийн хэвшлийн компаниудад дэмжлэг үзүүлэх байдлаар Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны зорилтыг хангаж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг хязгаарлана.

5.1 Эдийн засаг болон нийгмийн үр өгөөж ондортэй төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангагдсан, "Шинэ сэргэлтийн бодлого"-д нийцсэн төслүүдийн санхүүжилтийн эх үүсвэрт Засгийн газрын өрийн баталгаа гаргах замаар дэмжлэг үзүүлэх;

Засгийн газрын зүгээс бэлтгэл ажлаа бүрэн хангасан, зардал-ашгийн тооцоогоор ашигтай гарсан, эргэн төлөгдөх боломжтой “Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг Засгийн газрын өрийн баталгаа гаргаж дэмжлэг үзүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд 2023 оны 08 дугаар сарын байдлаар Засгийн газрын өрийн баталгаа гаргуулах хүсэлт албан ёсоор ирээгүй байна.

5.2 Засгийн газрын өрийн баталгаа гаргасан төслүүдийн эргэн тололт, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны хяналтыг сайжруулж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг бууруулах.

Засгийн газрын өрийн баталгаа гаргасан байгууллагууд болох “Эрдэнэс Монгол” болон Монгол Улсын Хөгжлийн банкны 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтэд эрсдэлийн үнэлгээг хийсэн бөгөөд Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн Төрийн аудитын үйл ажиллагаагаар хянуулж ажилласан.

5.3 Тосвоос иүүд тологдох нөхцөлтэй Барих-Шилжүүлэх төрлийн концессын гэрээ байгуулахгүй, өрийн бичиг /вексель/ шинээр гаргахгүй байх

Засгийн газраас шинээр Барих-Шилжүүлэх нөхцөлтэй концессын төрлийн гэрээ болон өрийн бичиг нэмж байгуулаагүй бөгөөд цаашид стратегийн баримт бичигт заасан арга хэмжээг баримталж ажиллана.

Зорилт 6

Засгийн газрын өрийн удирдлагын ил тод байдлыг сайжруулна.

6.1 Улирал бүр Засгийн газрын өрийн товхимлыг олон нийтэд ил тод мэдээлэх

Засгийн газрын өрийн статистикийн товхимлыг улирал бүр бэлтгэн Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын цахим хуудсанд олон нийтэд ил тод байдлаар байршуулж байна.

6.2 Улсын секторын өрийн мэдээллийг олон улсын байгууллагаас тогтоосон нэгдсэн стандартын дагуу бэлтгэж, мэдээлэх

Улсын секторын өрийн мэдээллийг Төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан 98 хуулийн этгээдүүдээс цуглуулж нэгтгэн хагас жил бүр Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Сангийн яамны цахим хуудсанд олон улсын байгууллагаас тогтоосон стандартын дагуу нийтэд ил тод байдлаар тайлагнаж байна. Түүнчлэн мэдээллийг нэгтгэсэн санг сайжруулах ажлыг зохион байгуулж E-balance санхүүгийн тайлангийн системд тогтсон загварыг үүсгэн байгууллагуудаас мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг боловсронгуй болгосон.

Шигтгээ 6. Засгийн газрын өрд нөлөөлөгч хүчин зүйлс

Өрийн тогтвортой байдлын шинжилгээнд аливаа улсын Засгийн газрын өр, ДНБ-ний харьцаа 50 хувиас давсан тохиолдолд тухайн улсыг “Сайтар шинжлэх” шаардлагатай орны ангилалд багтаан илүү нарийвчилсан шинжилгээг хийдэг. Олон Улсын Валютын сангийн 2021 оны Өрийн динамикийн шинжилгээг боловсруулсан байдаг. Энэхүү шинжилгээнд Засгийн газрын өрийг дараах байдлаар томъёолсон байна.

$$D_t = e_t^{eop} D_{t-1}^f + D_{t-1}^d + e_t^{avg} i_t^f D_{t-1}^f + i_t^d D_{t-1}^f - PB_t + OF_t + SF_t^{ier}$$

Энд:

D_t -t үеийн Засгийн газрын өрийн хэмжээ

e_t^{eop} - гадаад валютын жилийн эцсийн ханш

e_t^{avg} -гадаад валютын жилийн дундаж ханш

i_t^f -гадаад валютаар илэрхийлэгдсэн өрийн жигнэсэн дундаж хүү

PB_t -Төсвийн тэнцэл болон хүүгийн зардал

OF_t -бусад өр үүсгэгч хүчин зүйлс

SF_t^{ier} -ханшийн олз/гарз

Харин энэхүү статик томъёоллоос өрийн жилийн өөрчлөлийг гаргаж авахад (жижиг үсгээр ДНБ-д эзлэх хувийг харуулав):

$$d_t - d_{t-1} = \frac{i_t - (1+g_t)\pi_t}{(1+g_t)(1+\pi_t)} d_{t-1} + \frac{\varepsilon_t^{eop} + i_t^f [(1+\varepsilon_t^{eop})\varepsilon_t^{eop}/\varepsilon_t^{eop} - 1]}{(1+g_t)(1+\pi_t)} \alpha_{t-1} d_{t-1} - \frac{g_t}{(1+g_t)(1+\pi_t)} d_{t-1} - pb_t + of_t + sf_t^{ier}$$

Энд:

π_t -t үеийн дефлятоор гаргасан инфляц


α_t -нийт өрд эзлэх гадаад валютаар илэрхийлэгдсэн өрийн хэмжээ

ε_t -гадаад валютын ханшийн жилийн өөрчлөлт

g_t -Эдийн засгийн өсөлт


Энэхүү шинжилгээнд Монгол Улсын эдийн засгийн өгөгдлийг орлуулж үзэхэд Засгийн газрын өр, ДНБ-ний харьцаа 2017-2019 онуудад буурсан нь ДНБ-ний өсөлт болон бодит хүүгийн түвшнээс хамаарсан байна. Цаашид ч бодит ДНБ-ний өсөлтийг дэмжиж, төсвийн үндсэн тэнцлийг бууруулах нь өрийн тогтвортой байдлыг хангах суурь үндэс болохоор байна. 2020 оны хувьд цар тахлаас шалтгаалж төсвийн тэнцэл алдагдалтай, ханш суларсан бодит эдийн засгийн өсөлт сөрөг гарсан тул өрийн хэмжээ нэмэгдсэн байна. 2022 онд валютын ханш огцом суларсан ч эдийн засгийн бодит өсөлт, инфляцын түвшин өндөр байгаагаас шалтгаалж ДНБ-ний хэмжээ өссөн нь ДНБ-д эзлэх өрийн хэмжээг буурахад нөлөө үзүүлсэн байна. Засгийн газрын

өр болон ДНБ-ний харьцаа эдийн засгийн өсөлтөөс шалтгаалж буурах төлөвтэй байна.



Шигтгээ 7. Өрийн эмзэг байдлын шинжилгээ

Монгол Улсын өрийн эмзэг байдлыг одоогийн тоон мэдээлэлд үндэслэн үнэлбэл бондын өгөөжийн зөрүү, гадаад санхүүжилтийн хэрэгцээ, Засгийн газрын богино хугацаат өрийн жилийн өөрчлөлт, Засгийн газрын гадаад өр болон Засгийн газрын гадаад валютаарх өр зэрэг 5 үзүүлэлтийн 2 нь анхааруулах дээд түвшнээсээ давсан байна.



- 1. Бондын өгөөжийн зөрүү:** МУЗГ-ын олон улсын зах зээлд гаргасан бондын 3 сарын дундаж өгөөж АНУ-ын ижил хугацаатай ЗГ-ын бондтой харьцуулахад 3.32%-иар өндөр буюу үүнтэй дүйцэхүйц эрсдэлийн нэмэгдэлтэй хэмээн зах зээлд үнэлэгдэж байна. Энэ нь нь дээд анхааруулах түвшин 6%-иас бага үзүүлэлт юм.
- 2. Гадаад санхүүжилтийн хэрэгцээ:** 2023 оны урсгал тэнцэл, улсын болон хувийн секторын гадаад өрийн үйлчилгээний төлбөрийн нийлбэрээр тодорхойлогдох ДНБ-д эзлэх уг үзүүлэлт 12% байгаа нь дээд анхааруулах түвшин 15%-аас бага буюу гадаад санхүүжилтийн хэрэгцээний хувьд дундаж эрсдэлтэй гэсэн үр дүнг үзүүлж байна.
- 3. Засгийн газрын богино хугацаат өрийн жилийн өөрчлөлт:** 2023 оны гүйцэтгэлээр нийт өрд эзлэх ЗГ-ын богино хугацаат өрийн үлдэгдэл 0.6 хувиар буурсан байгаа нь бага эрсдэлтэй гэсэн үр дүнг харуулж байна.
- 4. Засгийн газрын гадаад өр:** Уг үзүүлэлтийн анхааруулах дээд түвшин 45% бөгөөд манай улсын хувьд 97% байгаа нь гадаад өрийн дарамт өндөр, гадаад санхүүжилтээс хэт их хамааралтайг харуулж байна.
- 5. Засгийн газрын гадаад валютаарх өр:** Уг үзүүлэлтийн анхааруулах дээд түвшин 60% бөгөөд манай улсын хувьд 97% байгаа нь гадаад өрийн дарамт өндөр, гадаад валютын ханшийн эрсдэлд эмзэг байгааг илтгэнэ.

Х

2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

10.1 Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд

Төсвийн төсөлд Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 25.3 их наяд төгрөг буюу ДНБ-ий 34.2 хувь, нийт зарлагын хэмжээг 27.4 их наяд төгрөг буюу 37.0 хувь, төсвийн алдагдлыг 2.1 их наяд төгрөг буюу ДНБ-ий 2.8 хувьтай тэнцүү байхаар төлөвлөлөө.

Хүснэгт 10.1 Нэгдсэн төсвийн 2021-2024 оны үзүүлэлтүүд /тэрбум Т/

Үзүүлэлтүүд	2021 Гүйц.	2022 Гүйц.	2023 Тод Бат.	2024 Төс.
НИЙТ ОРЛОГО	14,306.4	18,521.6	21,823.5	27,156.8
Тогтворжуулалтын сан	627.9	1,394.6	501.6	513.7
Ирээдүйн өв сан	967.0	-	540.0	1,353.3
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО	12,711.4	17,126.9	20,781.9	25,289.8
Татварын орлого	11,299.9	15,459.0	18,915.4	23,436.1
Татварын бус орлого	1,411.5	1,668.0	1,866.5	1,853.7
НИЙТ ЗАРЛАГА	15,630.4	18,159.7	22,371.4	27,360.5
Урсгал зардал	12,804.0	14,229.3	16,914.1	21,324.8
Хөрөнгийн зардал	2,982.2	3,803.4	5,616.2	6,170.4
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-155.8	127.0	-159.0	-134.7
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ	-2,919.0	-1,032.7	-1,589.5	-2,070.8
ДНБ-д эзлэх хувь	-6.8%	-2.0%	-2.6%	-2.8%

10.2 Төсвийн тогтворжуулалтын сан болон Ирээдүйн өв сангийн үлдэгдэл

Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд Төсвийн тогтворжуулалтын санд хуримтлагдах хэмжээг 513.7 тэрбум төгрөг байхаар, Ирээдүйн өв санд хуримтлагдах хэмжээг 1,353.3 тэрбум байхаар тус тус тусгасан. Харин сангуудын үлдэгдэл 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар Төсвийн тогтворжуулалтын сангийн үлдэгдэл 1,231.4 тэрбум төгрөг, Ирээдүйн өв сангийн үлдэгдэл 2,788.3 тэрбум төгрөг тус тус байна.

10.3 Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь -2,070.8 тэрбум төгрөг байгаагаас гадаад зээлийн ашиглалтын 1,225.0 тэрбум төгрөг нь эх үүсвэртэй алдагдал юм. Түүнчлэн, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу төсвийн дэмжлэг 355.0 тэрбум төгрөг болон

Засгийн газрын дотоод үнэт цаас гаргах замаар тус тус төсвийн алдагдлыг санхүүжүүлэхээр тусгасан.

10.4 Төсвийн тусгай шаардлагад нийцсэн төсвийн төлөвлөлт


Улсын Их Хурлаас 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдөр баталсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд заасны дагуу 2024 онд төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг ДНБ-ий 2.8 хувиас, Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл ДНБ-ий 60.0 хувиас ихгүй байх төсвийн тусгай шаардлагад Монгол Улсын 2024 оны төсвийн үндсэн үзүүлэлтүүдийг бүрэн нийцүүлж хуулийн төслийг боловсрууллаа.

Монгол Улсын
2024 оны төсвийн
төслийг төсвийн
тусгай
шаардлагад бүрэн
нийцүүлэн
боловсрууллаа.

Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон байх:

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3.а-д заасан шаардлагын дагуу зэс, нүүрсний үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон бөгөөд 2024 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 7,386.6 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 182.5 ам.доллар байхаар тооцлоо.


График 10.31. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого /2021-2024



Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 2024 онд тухайн жилийн ДНБ-ий 2.8 хувиас илүүгүй байх:

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл -2,070.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ий -2.8 хувьтай тэнцэхээр төлөвлөлөө.


График 10.32. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /2022-2025 он/,



Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь ДНБ-ий 60.0 хувиас хэтрэхгүй байх:

Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа нь 42.7 хувьд хүрэх төлөвтэй байгаа нь Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг хангаж байна.

График 10.33. Засгийн газрын өр /2021-



Тухайн жилийн нэгдсэн

төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх:

Тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлт 22.5 хувьтай, 2012-2023 оны эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дундаж 12.9 хувьтай тус тус тэнцэж байна. 2024 оны төсвийн төсөлд нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлт 22.3 хувь буюу тусгай шаардлагыг хангаж байна.

XI

ТӨСВИЙН БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН ТОЙМ

Нэг. Орос-Украины нөхцөл байдал: Дайны нөхцөл байдал хүндэрсэн тохиолдолд манай улсын ОХУ, Европоос импортолдог стратегийн бүтээгдэхүүний нийлүүлэлт тасалдах, улмаар импортын бараа, бүтээгдэхүүний үнэ өсөх, үйлдвэрлэлийн зардал нэмэгдэж, аж ахуйн нэгжийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэл байна.

Хоёр. БНХАУ-ын эдийн засгийн сэргэлтийн удаашрал: Манай улсын худалдааны гол түнш БНХАУ-ын эдийн засгийн сэргэлт огцом удааширч, аж үйлдвэр болон үл хөдлөх, барилгын салбарын эрэлт буурвал манай улсын уул уурхайн голлох бүтээгдэхүүнүүдийн эрэлт, үнэ буурч, экспортын орлого төсөөллөөс бага байх, улмаар төсвийн орлогыг бүрдүүлэгч гол салбар болох уул уурхайн орлогыг бууруулах эрсдэл байна. Тус улсын Засгийн газраас эдийн засгийг эрчимжүүлэх бодлогын дэмжлэгийг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлт зорилтот түвшин буюу 5 хувьд хүрэх хүлээлттэй байна.

Гурав. Дэлхий нийтэд хүнсний үнэ өсөх: Дэлхийн инфляцын түвшний оргил үе өнгөрсөн хэдий ч хүнсний инфляц өндөр хэвээр байна. Ялангуяа, хөгжиж буй орнуудад хүнсний инфляц илүү өндөр хэвээр байна. Тухайлбал, дэлхийн цагаан будааны экспортын 40 орчим хувийг үйлдвэрлэдэг Энэтхэг улс цаг агаарын таагүй байдлаас шалтгаалан 40 хувиар бага ургац хураасан бөгөөд дотоодын хэрэгцээгээ хангах зорилгоор цагаан будааны экспортод хориг тавиад байна. Энэ нь дэлхийн цагаан будааны экспортыг 10 орчим хувиар бууруулах нөлөөтэй байна. Мөн дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт хүнсний ургацад сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Дөрөв. Санхүүгийн салбарын эмзэг байдал: Манай улсын санхүүгийн салбарын нийт активын 90 гаруй хувийг банкны салбар дангаараа бүрдүүлж байна⁹. Санхүүгийн салбарын тогтвортой байдал системийн нөлөө бүхий банкнуудын үйл ажиллагаанаас бүрэн хамаарч байгаа нь аливаа гадаад, дотоод эрсдэл үүссэн тохиолдолд банкны салбараар дамжин санхүүгийн салбарын тогтвортой байдал алдагдах эрсдэлийг нэмэгдүүлж байна. Иймд санхүүгийн салбарыг бэхжүүлэх, эрсдэлийг даван туулах чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Тав. Мал, амьтны өвчин, цаг агаар, ган, зуд: Мал, амьтны халдварт өвчин, цаг агаарын таагүй нөхцөл, ган зудын эрсдэлт хүчин зүйлсээс шалтгаалан хөдөө аж ахуйн болон аялал жуулчлалын салбарын үйлдвэрлэл, бүтээмж төсөөлөл буурч болзошгүй.

⁹ Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо

Зургаа. Зээлжих зэрэглэл буурах болон аливаа төрлийн хориг: Хөрш орнуудыг хамарсан геополитикийн хүндрэлтэй асуудлууд өрнөж буй энэ үед манай улс аливаа төрлийн хоригт өртөхгүй байх, зээлжих зэрэглэлийг сайжруулах хүрээнд олон улсад баримталж буй дүрэм журмуудыг сайтар мөрдөж, зээлжих зэрэглэл тогтоодог болон хориг арга хэмжээ авах эрх бүхий олон улсын байгууллагуудад хүргүүлэх холбогдох үнэлгээний тайлангуудыг сайтар бэлтгэх нь зүйтэй байна. Зээлжих зэрэглэл буурч, аливаа хоригт орсон тохиолдолд гадаадын хөрөнгө оруулалт, гадаад зээлийн урсгал буурах, төлбөр тооцоо саатах зэрэг эрсдэлүүд үүсэж болзошгүй.

XII

**ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН
ТӨСӨЛ**

Төрийн бүтээмж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр 6 хуулийн төсөл:

1. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
2. Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай
3. Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
4. Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
5. Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай
6. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Татварын бодлогын хүрээнд 6 хуулийн төсөл:

7. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай
8. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
9. Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
10. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
11. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
12. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаатай хамаарал бүхий 3 хуулийн төсөл:

13. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт оруулах тухай
14. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай
15. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай

Геодезн зураг зүйн газрын чиг үүргийг Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлэхтэй холбоотой 6 хуулийн төсөл:

16. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
17. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
18. Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
19. Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
20. Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
21. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

● **Улсын Их Хурлын 7 тогтоолын төсөл:**

1. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай
2. Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай
3. Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай
4. Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
5. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай
6. Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай
7. Засгийн газарт чиглэл өгөх тухай

● **Нийт 21 хуулийн төсөл, 7 Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан хүргүүлж байна.**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын төсөвт 2024 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, орлого төвлөрүүлэх байгууллага, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого, төсвийн ерөнхийлөн захирагчид төсөв зарцуулах эрх олгох, Төсвийн тогтворжуулалтын санд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, Ирээдүйн өв санд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, мөнгөн гүйлгээтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Монгол Улсын 2024 оны төсвийн хууль тогтоомж

2.1. Монгол Улсын 2024 оны төсвийн хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА БОЛОН
ХӨРӨНГӨ, ӨРИЙН УДИРДЛАГА

3 дугаар зүйл.Монгол Улсын төсөвт 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллага доор дурдсан орлого төвлөрүүлнэ:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Монгол Улсын Их Хурлын дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	100.0 100.0
2	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	185.0 185.0
3	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	510.0 510.0
4	Санхүүгийн зохицуулах хорооны дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	2,737.7 2,737.7
5	Монгол Улсын Ерөнхий сайд	600,431.7

	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар үүнээс: Ирээдүйн өв санд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	596,002.5 520,083.2 4,429.2
6	Монгол Улсын Шадар сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	15,941.5 15,941.5
7	Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	132.6 132.6
8	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	175.0 175.0
9	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	1,485.5 1,485.5
10	Гадаад харилцааны сайд Дипломат төлөөлөгчийн газрууд	6,000.0 6,000.0
11	Сангийн сайд Татварын ерөнхий газар үүнээс: Төсвийн тогтворжуулалтын санд үүнээс: Ирээдүйн өв санд Гаалийн ерөнхий газар Сангийн яам Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	17,895,074.2 10,388,746.9 513,710.9 833,224.2 6,727,915.6 211,194.0 558,000.0 9,217.6
12	Хууль зүй, дотоод хэргийн сайд Улсын бүртгэлийн ерөнхий газар Цагдаагийн ерөнхий газар Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	83,749.0 45,000.0 2,700.0 1,552.9 34,496.1
13	Батлан хамгаалахын сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	38,185.4 38,185.4
14	Боловсрол, шинжлэх ухааны сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	5,857.9 5,857.9
15	Зам, тээврийн хөгжлийн сайд Иргэний нисэхийн ерөнхий газар Зам, тээврийн хөгжлийн яам Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	175,300.0 150,000.0 300.0 25,000.0
16	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ашигт малтмал, газрын тосны газар Үндэсний геологийн алба Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	426,173.4 421,903.3 110.0 4,160.2
17	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	54,588.5 54,588.5
18	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	38,454.4 850.0 2,535.1

	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	35,069.3
19	Эрүүл мэндийн сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	5,555.4 5,555.4
20	Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	8,665.5 8,665.5

4 дүгээр зүйл.Монгол Улсын төсөвт 2024 оны төсвийн жилд төвлөрүүлэх төсвийн тэнцвэржүүлсэн орлого 18,023,227.3 сая төгрөг байна.

5 дугаар зүйл.Монгол Улсын төсөвт 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй эргэн төлөх үндсэн төлбөр төлнө:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Сангийн сайд Үүнээс: УБТЗ-ХНН-ийн дүрмийн санд	437,311.2 83,673.5
2	Хууль зүй, дотоод хэргийн сайд	20,600.7
3	Боловсрол, шинжлэх ухааны сайд	30,000.0
4	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	22,758.8
5	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	10,286.9

6 дугаар зүйл.Монгол Улсын төсвөөс 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан төсөв зарцуулна:

6.1.Монгол Улсын төсвөөс 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн зарцуулах зардал доор дурдсан хэмжээтэй байна:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Урсгал зардал	29,711.3 29,711.3
2	Монгол Улсын Их Хурлын дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	131,912.7 109,823.1 22,089.6
3	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга Урсгал зардал	4,068.6 4,068.6
4	Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Урсгал зардал Хөрөнгийн зардал	28,675.2 17,146.4 11,528.8
5	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	142,327.2 127,502.2 14,825.0

6	Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Урсгал зардал	5,216.3 5,216.3
7	Улсын ерөнхий прокурор Урсгал зардал Хөрөнгийн зардал	88,426.8 79,578.5 8,848.3
8	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Урсгал зардал	19,071.5 19,071.5
9	Монгол Улсын Ерөнхий аудитор Урсгал зардал Хөрөнгийн зардал	41,435.6 40,554.5 881.1
10	Авлигатай тэмцэх газрын дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	45,847.7 43,189.6 2,658.2
11	Санхүүгийн зохицуулах хорооны дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	14,995.6 14,103.1 892.5
12	Төрийн албаны зөвлөлийн дарга Урсгал зардал	6,226.4 6,226.4
13	Үндэсний статистикийн хорооны дарга Урсгал зардал	21,628.6 21,628.6
14	Сонгуулийн ерөнхий хорооны дарга Урсгал зардал	65,215.9 65,215.9
15	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга Урсгал зардал	8,475.6 8,475.6
16	Монгол Улсын Ерөнхий сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	330,180.2 279,571.1 50,609.0
17	Монгол Улсын Шадар сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	280,812.1 246,844.7 33,967.4
18	Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	87,648.9 18,648.9 69,000.0
19	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	102,249.4 60,663.6 41,585.8
20	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	226,599.3 197,118.4 29,480.9
21	Гадаад харилцааны сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	194,190.4 180,790.4 13,400.0
22	Сангийн сайд	4,557,661.9

	Урсгал зардал	2,505,385.7
	үүнээс: Зээлийн хүүгийн төлбөрт	1,173,620.2
	Хөрөнгийн зардал	269,276.2
	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	1,783,000.0
23	Хууль зүй, дотоод хэргийн сайд	1,388,359.1
	Урсгал зардал	1,269,805.2
	Хөрөнгийн зардал	118,553.8
24	Зам, тээврийн хөгжлийн сайд	682,238.2
	Урсгал зардал	24,056.4
	Хөрөнгийн зардал	658,181.8
25	Батлан хамгаалахын сайд	564,548.3
	Урсгал зардал	551,083.0
	Хөрөнгийн зардал	13,465.3
26	Боловсрол, шинжлэх ухааны сайд	4,258,954.1
	Урсгал зардал	3,549,488.2
	Хөрөнгийн зардал	709,466.0
27	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	60,235.3
	Урсгал зардал	20,235.3
	Хөрөнгийн зардал	40,000.0
28	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	528,522.5
	Урсгал зардал	433,713.6
	Хөрөнгийн зардал	94,808.9
29	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	3,942,221.9
	Урсгал зардал	3,898,140.8
	Хөрөнгийн зардал	44,081.1
30	Эрүүл мэндийн сайд	1,651,185.1
	Урсгал зардал	1,396,234.8
	Хөрөнгийн зардал	254,950.3
31	Эрчим хүчний сайд	359,758.8
	Урсгал зардал	138,959.5
	Хөрөнгийн зардал	220,799.2
32	Барилга, хот байгуулалтын сайд	413,628.2
	Урсгал зардал	10,613.5
	Хөрөнгийн зардал	403,014.7
33	Соёлын сайд	402,361.3
	Урсгал зардал	247,472.1
	Хөрөнгийн зардал	154,889.1
34	Цахим хөгжил, харилцаа холбооны сайд	85,658.9
	Урсгал зардал	71,125.9
	Хөрөнгийн зардал	14,533.0
35	Шүүхийн сахилгын хорооны дарга	4,037.0
	Урсгал зардал	4,037.0
36	Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга	146,521.2
	Урсгал зардал	73,637.5
	Хөрөнгийн зардал	72,883.7

37	Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	11,287.0 5,823.9 5,463.1
38	Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Хөрөнгийн зардал	56,229.2 56,229.2

6.2. Монгол Улсын төсвөөс 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр доор дурдсан хэмжээтэй санхүүжилт олгоно:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Сангийн сайд	182,210.5
	Үүнээс: Хөдөөгийн сэргэлт- Амьдралын чанар	98,537.0
2	Барилга, хот байгуулалтын сайд	5,000.0
3	Боловсрол, шинжлэх ухааны сайд	31,036.3
4	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	50,285.5

7 дугаар зүйл. Монгол Улсын төсвөөс 2024 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээ 20,735,898.0 сая төгрөг байна.

8 дугаар зүйл. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 оны төсвийн жилд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг 3,240,600.0 сая төгрөгөөр санхүүжүүлнэ.

9 дүгээр зүйл. "Барих-Шилжүүлэх" концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 оны төсвийн жилд 25,000.0 сая төгрөгийн эргэн төлөлт хийнэ.

10 дугаар зүйл. 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар Төсвийн тогтворжуулалтын сангийн үлдэгдэл 1,231,447.7 сая төгрөг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Төсвийн тогтворжуулалтын санд 2024 оны төсвийн жилд 513,710.9 сая төгрөг хуримтлуулна.

11 дүгээр зүйл. 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар Ирээдүйн өв сангийн үлдэгдэл 2,788,332.7 сая төгрөг, Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу Ирээдүйн өв санд 2024 оны төсвийн жилд 1,353,307.4 сая төгрөг хуримтлуулна.

12 дугаар зүйл. 2024 оны төсвийн жилд төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг доор дурдсанаар баталсугай:

12.1.Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.1, 12.1.3, 12.1.6 болон 28¹.1-д заасан зориулалтаар хийх гадаад, дотоод зээллэгийн дээд хэмжээг 3,414,050.7 сая төгрөг хүртэл;

12.2.Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.5-д заасан зориулалтаар Засгийн газрын авч ашиглах гадаад төслийн зээлийн дээд хэмжээг 1,225,000.0 сая төгрөг хүртэл.

13 дугаар зүйл.Тухайн төсвийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэй гаргасан зээллэг болон өрийн зохицуулалтын арга хэмжээнээс бусад 2024 оны төсвийн жилд төлөх Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийн хэмжээ 3,286,546.7 сая төгрөг байна.

14 дүгээр зүйл.Засгийн газрын гаргах өрийн баталгааны дээд хэмжээ 2024 оны төсвийн жилд 3,550,000.0 сая төгрөг байна.

15 дугаар зүйл.Засгийн газар Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.2 болон 12.1.4-т заасан зориулалтаар Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт нийцүүлэн өрийн зохицуулалтын үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ОЛГОХ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ, ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САН БОЛОН УЛСЫН ТӨСВӨӨС ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНД ОЛГОХ ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ

16 дугаар зүйл.2024 оны төсвийн жилд орон нутгийн төсөвт доор дурдсан хэмжээтэй санхүүгийн дэмжлэг олгоно:

Д/д	Аймаг	Олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай	36,330.5
2	Баян-Өлгий	25,354.0
3	Баянхонгор	38,528.9
4	Булган	11,275.0
5	Говь-Алтай	32,936.4
6	Дундговь	27,020.2
7	Завхан	38,096.6
8	Өвөрхангай	33,457.9
9	Сүхбаатар	11,939.2
10	Төв	20,069.8
11	Увс	34,085.9
12	Ховд	14,730.9

13	Хөвсгөл	43,404.5
14	Хэнтий	39,582.6
15	Говьсүмбэр	5,424.2
Нийт дүн		412,236.5

17 дугаар зүйл.2024 оны төсвийн жилд орон нутгийн төсвөөс улсын төсөвт доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлнэ:

Д/д	Аймаг	Төвлөрүүлэх орлогын хэмжээ /сая төгрөгөөр/
1	Дорноговь	9,090.9
2	Дорнод	2,761.9
3	Өмнөговь	717,507.2
4	Сэлэнгэ	1,058.6
5	Дархан-Уул	406.7
6	Улаанбаатар	232,695.5
7	Орхон	178,422.2
Нийт дүн		1,141,943.0

18 дугаар зүйл.2024 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг доор дурдсан хэмжээтэй байна:

Д/д	Аймаг	Шилжүүлгийн хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай	12,118.9
2	Баян-Өлгий	11,406.6
3	Баянхонгор	20,660.6
4	Булган	13,601.6
5	Говь-Алтай	16,592.9
6	Дорноговь	41,298.3
7	Дорнод	24,783.3
8	Дундговь	15,244.6
9	Завхан	14,040.3
10	Өвөрхангай	13,854.9
11	Өмнөговь	45,585.0
12	Сүхбаатар	17,474.9
13	Сэлэнгэ	26,529.0
14	Төв	27,155.9
15	Увс	12,477.3
16	Ховд	28,053.0
17	Хөвсгөл	15,990.5
18	Хэнтий	17,789.1
19	Дархан-Уул	19,834.2
20	Улаанбаатар	47,781.3
21	Орхон	33,099.6

22	Говьсүмбэр	6,704.8
Нийт дүн		482,076.7

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

19 дүгээр зүйл."Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлт"-ийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

20 дугаар зүйл."Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-ыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

21 дүгээр зүйл."Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд эргэн төлөлт хийх концессын "Барих-Шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-ыг 3 дугаар хавсралтаар баталсугай.

22 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг



МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ХАВСРАЛТ

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН,
ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ТАЛААРХ ТООН БОЛОН ЧАНАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	ТЕЗ	Хөтөлбөр	Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн	№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	2024 оны зорилтот түвшин				
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА													
70101 Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагаа													
1	1.1	1.1.1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан үндэсний хөтөлбөр, чуулган, форум, уулзалт, хөтөлбөрт арга хэмжээ болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн төрийн айлчлал бусад арга хэмжээг хэрэгжүүлнэ.	1.1.1.1	Хэрэгжилтийн биелэлт	хувь	2022	89.0	91.0				
				70424 Дотоод, гадаад шуурхай мэдээллийн үйл ажиллагаа									
				1.2	1.2.1	Монгол Улсын иргэд, олон нийт, байгууллага хэвлэл мэдээллийн хэрэгслийг дотоод болон гадаад улс орны хэмжээнд болж байгаа үйл явдлын мэдээллээр тогтмол, шуурхай хангана.	1.2.1.1	Эж хэл дээр бэлтгэн гаргах мэдээ мэдээлэл	100	2023	12,000	12,360	
1.2.2	Монгол Улсын гадаад, дотоод бодлого, түүх, өв соёл, уламжлал, хөгжил дэвшлийг гадаад улс оронд тогтмол мэдээлж сурталчлан таниулна.	Гадаад хэл дээр бэлтгэн гаргах мэдээ мэдээлэл	100				2023	11,208	11,544				
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА													
70102 Хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих													
2	2.1	2.1.1	Хууль тогтоомжийн төслийг Байнгын хорооны болон Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулана.	2.1.1.1	Хууль тогтоомжийн төсөл	100	2022	557 хууль, 84 тогтоолын төсөл	Суурь түвшинээс доошгүй				
				2.1.2.1	Хяналтад авах хууль тогтоомж	100	2022	Хууль 154, Тогтоол 107, Байнгын хорооны хорооны тогтоол 109	Суурь түвшинээс доошгүй				
МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА													
70404 Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих													
3	3.1	3.1.1	Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавина.	3.1.1.1	Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хуульд нийцүүлэн хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байдал	хувь	2021	100	90<				
				3.1.1.2	Бага судалын хуралдаанаар гомдлыг хуульд нийцүүлэн хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байдал	хувь	2021	100	90<				
				3.1.1.3	Дунд, их судалын хуралдаанаар маргааныг хуульд нийцүүлэн хуулийн хугацаанд хянан шийдвэрлэсэн байдал	хувь	2021	100	90<				

Монгол Улсын гаалийн албанд одоогоор 1346 гаалийн улсын байцаагч, үүнээс хилийн боомтод буюу хөдөө орон нутагт байрлах харьяа гаалийн газар, хороодод 1175 байцаагч ажиллаж байна. Гаалийн шинэчлэлийн хүрээнд хилийн зарим боомт 24 цагийн хуваарьт шилжиж байгаа, мөн дийлэнх боомтуудын ажлын ачаалал нэмэгдэж байгаатай холбогдуулан батлагдсан орон тоонд багтаан хилийн боомтод буюу хөдөө орон нутагт байрлах харьяа гаалийн газар, хороодод ажиллах гаалийн улсын байцаагчдын нийгмийн баталгааг сайжруулах шаардлагатай байна. Хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжих төсвийн бодлогын хүрээнд гаалийн шинэчлэлийг эрчимжүүлэх, хөдөө орон нутагт ажиллах төрийн албан хаагчийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах зорилгоор аймгийн төвийн сумаас бусад суманд тасралтгүй ажиллаж байгаа гаалийн албан хаагчдад таван жил тутамд нэг удаа 12 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгохоор тооцож шаардагдах зардлыг 2024 оны төсвийн төсөлд тусгасантай холбогдуулан Гаалийн тухай хуулийн 280 дугаар зүйлд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулав.

Зөвшөөрлийн тухай хуулиар “Татваргүй барааны дэлгүүр ажиллуулах” тусгай зөвшөөрлийг дуудлага худалдааны журмаар олгохоор зохицуулсан. Харин Гаалийн тухай хуулиар дээрх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр олгохоор тусгасан нь хууль хоорондын зөрчлийг бий болгож байна. Тусгай зөвшөөрөл олгох харилцааг нарийвчлан зохицуулсан хууль нь Зөвшөөрлийн тухай хууль тул Гаалийн тухай хуулийг уг хуульд нийцүүлэх зорилгоор Гаалийн тухай хуулийн 138 дугаар зүйлийн 138.3 дахь хэсгийг өөрчлөх хуулийн төсөл боловсруулав.

Татварын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсэгт заасан журамд бараа, бүтээгдэхүүнийг экспортлох, импортлох этгээд нь гаалийн байгууллагад мэдүүлэхдээ олон улсын стандартыг хангасан зураасан кодыг оруулахаар заасан. Иймд гаалийн байгууллагын гадаад худалдааны статистик мэдээлэл, бүртгэлийн уялдааг хангах зорилгоор бараа, бүтээгдэхүүнийг бүртгэхэд БТКУС-ийн ангиллаас гадна олон улсын стандартыг хангасан зураасан кодыг ашиглах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Тус хуулийн төсөл батлагдсанаар бараа, бүтээгдэхүүний гарал үүслийн бүртгэл, хяналтын тогтолцоо сайжрах, улмаар хүнс болон эмийн чанар, аюулгүй байдлыг хангах, гаалийн үйл ажиллагааг автоматжуулах, “Гадаад худалдааны цахим нэг цонх” мэдээллийн системийн үйлчилгээ, бизнесийн үйл ажиллагаанд эрх бүхий этгээд зөвшөөрөлтэй олгохтой холбоотой үйл ажиллагааг хялбаршуулах боломж бүрдэх зэрэг ач холбогдолтой.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Гаалийн тухай хуулийн 280 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 280.7 дахь хэсэг нэмсүгэй:

“280.7.Улаанбаатар хотоос бусад орон нутагт тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчид таван жил тутамд арван хоёр сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг тухайн байгууллагаас олгоно.”

2 дугаар зүйл.Гаалийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “ангиллын” гэснийг “ангилал болон Татварын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсэгт заасан журмын дагуу олгосон зураасан” гэж, 138 дугаар зүйлийн 138.3 дахь хэсгийн “сонгон шалгаруулалтын” гэснийг “дуудлага худалдааны” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийн 2 дугаар зүйлээр өөрчилж буй Гаалийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн өөрчлөлтийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс, бусад нэмэлт, өөрчлөлтийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Татварын хуульд заасны дагуу жилийн 50.0 сая төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой малчин, мал бүхий этгээд нэмэгдсэн өртгийн албан татвар /цаашид “НӨАТ” гэх/ суутган төлөгчөөр бүртгүүлж сар бүр НӨАТ-ын тайлан гаргах үүрэг хүлээдэг. Үүний дагуу Монгол Улсад 250 мянга орчим малчин, мал бүхий этгээд татвар төлөгчөөр бүртгэгдсэнээс 2022 оны жилийн эцсийн байдлаар 470 малчин НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлжээ. Түүнчлэн нийт малчдын 23 хувь нь 369.3 тэрбум төгрөгийн малын гаралтай түүхий эдийн борлуулалтын орлогоо тайлагнаж, тодорхой хэмжээнд төлбөрийн баримт олгож байна.

Малчид, мал бүхий этгээдүүд НӨАТ-ын тооцоо хийх, бүртгэл хөтлөх, тайлан гаргахад хүндрэлтэй байдаг тул татварын албанаас малчдын малын гаралтай түүхий эдийн борлуулалтыг төлбөрийн баримтаар бүртгэх үйл ажиллагааг хялбаршуулан цахимжуулж, малчдад хүндрэлгүй байдлаар аж ахуйн нэгжүүд цахимаар бүртгэх технологийн боломжийг олгосон билээ.

Гэвч татварын тайлан, бүртгэлийн шаардлагаас шалтгаалан малчид түүхий эдээ дотоодын үйлдвэр, хоршоонд нийлүүлэхээс илүү дамжуулан борлуулагчдад бүртгэлгүй борлуулах хандлагатай байгаа нь малчдын татварын эрсдэлийг нэмэгдүүлэх, боловсруулах үйлдвэрүүдийн өртөг, татварын ачааллыг нэмэгдүүлэх, түүхий эдийн хомсдолд орох зэрэг сөрөг нөлөөг үүсгэж байна. Энэ нь Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг дээшлүүлэх, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.

Иймд малчдын татварын орчныг энгийн, ойлгомжтой болгох, хялбаршуулах, татварын эрсдэлийг бууруулах, дотоодын боловсруулах үйлдвэрүүдэд тулгараад буй хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх зорилгоор малчин, мал бүхий этгээдийн борлуулсан таван хошуу мал, анхан шатны боловсруулалтад ороогүй мах, сүү, арьс шир, хонь болон тэмээний ноос, ноолуур, сарлагийн хөөврийг НӨАТ-аас чөлөөлөхөөр хуулийн төсөл боловсрууллаа.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.1.4-т зааснаар малчид суутган төлөгчөөр бүртгэгдсэн эсэхээс үл хамааран дотоодын үйлдвэрлэгчдийн худалдан авсан малын гаралтай бүтээгдэхүүний үнийн дүнд 10 хувийн албан татвар шингэсэн гэж үзэж албан татварыг хасаж тооцдог тул энэ хуулийн төслөөр боловсруулах үйлдвэрүүд болон малчдын татварын ачаалал нэмэгдэхгүй, төсвийн орлогод сөрөг нөлөө үзүүлэхгүй юм.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 13.1.29 дэх заалт нэмсүгэй:

"13.1.29. малчин, мал бүхий этгээдийн борлуулсан таван хошуу мал, анхан шатны боловсруулалтад ороогүй мах, сүү, арьс шир, ноолуур, хонь болон тэмээний ноос, сарлагийн хөөвөр."

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

*Хувь хүний орлогын албан татварын тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Улсын Их Хурал, Засгийн газраас хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхээр авч хэрэгжүүлж буй бодлогын үр дүнд Монгол Улсын Хөрөнгийн биржийн зах зээлийн үнэлгээ 2023 оны 06 дугаар сард түүхэндээ анх удаа 10 их наяд төгрөгийг давсан. Энэ нь 2021 оны жилийн эцэстэй харьцуулахад 4.1 их наяд төгрөг буюу 69 хувь, 2022 оны жилийн эцэстэй харьцуулахад 3.2 их наяд төгрөг буюу 46 хувиар тус тус нэмэгдсэн үзүүлэлт юм. Цаашид хөрөнгийн зах зээлийн өсөлтийг дэмжих, тогтвортой хадгалахад үнэт цаасны борлуулсны орлогод ногдуулах татварын одоогийн тогтолцоог боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай байна.

Тухайлбал, Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгч дотоодын үнэт цаасны зах зээлд шууд хөрөнгө оруулан худалдан авсан хувьцаа, өрийн хэрэгслээ борлуулахад татвар ногдуулах орлогыг нийт дүнгээс тооцдог ялгаатай дэглэм үйлчилж байгаа нь цаашид гадаадын стратегийн хөрөнгө оруулагч татахад сөргөөр нөлөөлж байна. Иймд гадаадын хөрөнгө оруулагчийн дотоодын хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн адилаар тухайн хувьцаа, үнэт цаасыг худалдан авахад гарсан холбогдох зардлыг хасаж тооцохоор хуулийн төсөлд тусгалаа.

Мөн өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогыг татвар төлөгч өөрөө тайлагнан төсөвт төлөхөөр татварын хуульд заасан боловч энэ төрлийн татварын тайлангийн ирц хангалтгүй байгаагаас татварын орчин ойлгомжгүй, хөрөнгө оруулагчдад хүндрэлтэй нөхцөл үүсэж байна. Иймд Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч, Засгийн газар, аймаг, нийслэлийн дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа борлуулсны орлогод ногдох орлогын албан татварыг 2024-2026 онд 90 хувиар, 2027-2029 онд 50 хувиар тус тус хөнгөлөхөөр төлөвлөлөө. Ингэхдээ хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогод ногдох албан татварыг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн болон кастодианы үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж нь ногдуулж, суутган төсөвт төлж, тайлагнахаар тусгасан.

Шинэ сэргэлтийн бодлогын Хот, хөдөөгийн сэргэлтэд аймгийн төвүүдийг бие даасан хот болгон хөгжүүлэх, шинэ суурьшлын бүсийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэд, аж ахуйн нэгжийг цогц бодлогоор дэмжих замаар төвлөрлийг сааруулахаар заасан. Орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэх, орон сууцжуулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж байгаа боловч нийт манай улсын нийт 330 сумын 117 суманд орон сууц баригдаагүй байгаа нь төвлөрлийг сааруулах бодлогыг эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Иймд орон нутгийг орон сууцжуулах бодлогыг хэрэгжүүлэхэд татварын бодлогын дэмжлэг үзүүлж орон нутаг дахь түрээсийн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх түр хугацааны татварын хөнгөлөлтийг түрээслүүлэгчид олгох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа.

Монгол Улсад жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, татварын орчныг хялбаршуулах зорилгоор 2019 оны татварын шинэчлэлээр хувиараа бизнес эрхлэгчийн тайлангаар баталгаажсан албан татвар ногдох орлого нь 50 сая төгрөгөөс хэтрээгүй тохиолдолд татварын хялбаршуулсан горимоор үйл ажиллагааны нийт орлогын 1 хувиар албан татвар төлж, жилд нэг удаа тайлан гаргах боломжтой болсон.

Татварын хуулийн шинэчлэлийн үр дүнд нийт хувиараа бизнес эрхлэгчдийн хувь хүний орлогын албан татварын тайлагналт 2019 онд 7 хувь байсан нь 2022 онд 28 хувь болж өссөн ба тэдгээрийн 59 хувь нь хялбаршуулсан горимоор тайлагнасан байна. Үүнээс харахад хувь хүний орлогын албан татварын тайланг хялбаршуулсан горимоор тайлагнах сонголтыг хувиараа бизнес эрхлэгчдэд олгосон шийдвэр нь татварын тайлагнал, хамрагдалт, бүртгэлд эерэг нөлөө үзүүлсэн нь харагдаж байна.

Харин 50.0 сая төгрөгөөс дээш үйл ажиллагааны орлоготой хувиараа бизнес эрхлэгч хувь хүмүүс борлуулалтын орлого, зардлаа өөрөө тооцож татвараа тайлагнах одоогийн тогтолцоо нь татвар төлөгчийн хувьд хүндрэлтэй байдгаас төлбөрийн баримт олгохгүй байх, татвараас зайлсхийх сөрөг нөлөөг үүсгэж байна. Улмаар хувиараа бизнес эрхлэгчдийн 72 хувь нь татвараа тайлагнахгүй хэвээр байгаа нь тодорхой хэмжээний далд эдийн засгийг бүрдүүлж байна.

Иймд хувиараа бизнес эрхлэгчдийн татвар тайлагнах, төлөх үйл ажиллагааг хялбаршуулан болгож далд эдийн засгийг бууруулах зорилгоор орлогын босго хамаарахгүй бүх хувиараа бизнес эрхлэгч, татвар төлөгч хувь хүн өөрийн хүсэлтээр хялбаршуулсан горимыг сонгож үйл ажиллагааны орлогоо тайлагнах боломжийг олгох хуулийн төслийг боловсрууллаа.

Дээрх хуулийн төсөл батлагдсанаар хөрөнгийн зах зээлийн таатай орчныг бүрдүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, үнэт цаасны зах зээлийг идэвхжүүлэх, түүнчлэн хөдөө, орон нутаг дахь орон сууцны тоог нэмэгдүүлэх, хувиараа бизнес эрхлэгчдийн татварын зардлыг бууруулан татварын суурийг өргөжүүлэх зэрэг эерэг нөлөөтэй гэж үзэж байна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оныдугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/20 дугаар зүйлийн 20.4, 20.5 дахь хэсэг:

“20.4.Засгийн газар, аймаг, нийслэл, Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаасыг Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгч борлуулсны орлогод албан татвар ногдуулах орлогыг энэ хуулийн 17.1.3-т заасны дагуу тодорхойлно.

20.5.Дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан Засгийн газар, аймаг, нийслэл, Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаас борлуулсны орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох, суутган тооцох, төсөвт төлөхөд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.14-т заасан журмыг баримтална.”

2/23 дугаар зүйлийн 23.16, 23.17 дахь хэсэг:

“23.16.Нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг болон аймаг, сумын хилийн цэсийн дотор баригдсан нийтийн зориулалттай орон сууцны барилгад хүн амьдран суух зориулалтаар орон сууц түрээслүүлсний орлогод ногдох албан татварыг 2024-2026 онд 90 хувиар, 2027-2029 онд 50 хувиар тус тус хөнгөлнө.

23.17.Засгийн газар, аймаг, нийслэл, Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаас борлуулсны орлогод ногдох албан татварыг 2024-2026 онд 90 хувиар, 2027-2029 онд 50 хувиар тус тус хөнгөлнө.”

3/25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсэг:

“25.8.Дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаас борлуулсны орлогод ногдуулах албан татварыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.9, 24.1.10-т заасан зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч этгээд ногдуулж, суутгана.”

2 дугаар зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.5 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1.6 дахь заалт, 27.1 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “20.1-д” гэснийг “20.1, 20.4-т” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийн “Тайлангаар баталгаажсан өмнөх жилийн албан татвар ногдох орлогын хэмжээ 50.0 сая төгрөгөөс хэтрээгүй нөхцөлд тухайн” гэснийг, мөн зүйлийн 15.7 дахь хэсгийн “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангаж нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлсэн,” гэснийг, мөн хэсгийн “эрхтэй” гэснийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 2 дугаар зүйлийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс, 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 3 дугаар зүйлийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2030 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл тус тус дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Улсын Их Хурлаас 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр баталсан Малын тоо толгойн албан татварын тухай хуулиар орон нутаг бие даан малын тоо толгойн албан татвар тогтоон төсвөө бүрдүүлж малын тоо толгойг бэлчээрийн даацтай уялдуулах, бэлчээрийн доройтлыг бууруулах, байгаль орчны сөрөг үзэгдлээс сэргийлэх бодлого хэрэгжүүлэх санхүүгийн боломжийг олгосон билээ

Малын тоо толгойн албан татварын тухай хууль хэрэгжиж эхэлснээр 2021 онд 110 мянган малчин нийт 15.3 тэрбум төгрөг, 2022 онд 120 мянган малчин нийт 19.9 тэрбум төгрөгийн малын тоо толгойн албан татварыг тус тус төлсөн ба тайлангийн ирц 82 хувьтай байна.

Малын тоо толгойн албан татварын тухай хуульд заасны дагуу татварын албанаас жил бүрийн мал тооллогын дүнд үндэслэн малчдад малын тоо толгойн албан татварыг тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон хэмжээгээр ногдуулж байна. Улмаар ногдуулсан татварыг малчид цахимаар хянан, баталгаажуулан албан татвараа тайлагнаж байна.

Татварын албаны статистик мэдээгээр 2022 онд нийт тайлан ирүүлсэн малчдын 99.5 хувь нь дээрх аргачлалын дагуу ногдуулсан татварын дүнг аливаа өөрчлөлтгүйгээр баталгаажуулсан байна. Үүнээс үзэхэд малчин, мал бүхий этгээд малын тоо толгойн албан татварын тайлан гаргуулахгүйгээр төр өөрт байгаа мэдээлэлд үндэслэн албан татварыг бүрэн ногдуулах боломжтой байна.

Иймд малчин, мал бүхий этгээдийн татварын орчныг хялбаршуулах, энгийн ойлгомжтой болгох зорилгоор малчин, мал бүхий этгээд малын тоо толгойн албан татварын тайлан гаргах шаардлагагүй болгож, татварын хуулийг хэрэгжүүлэх зардлыг бууруулж, татварын албанаас татварын тооцооллыг шууд тооцон мэдээлж, татвар ногдуулахаар хуулийн төслийг боловсрууллаа.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “үндэслэн” гэсний дараа “татварын алба тооцож, төлбөл зохих албан татварыг” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“7.3.Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу албан татвар төлөгчийн тухайн жилд төлбөл зохих албан татварыг татварын алба татвар төлөгчид цахим, эсхүл хуульд заасан бусад хэлбэрээр дараагийн татварын жилийн эхний улиралд багтаан мэдэгдэнэ.

7.4.Энэ хуулийн дагуу албан татвар ногдуулах, төлөх, татвар төлөгчтэй харилцах журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.”

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

*Гаалийн тариф, гаалийн татварын тухай
хуульд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
хуулийн төсөл*

Уул уурхайн салбар нь Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 24 хувь, нэгдсэн төсвийн орлогын 29 хувь, нийт экспортын орлогын 85 орчим хувийг бүрдүүлдэг эдийн засгийн чухал ач холбогдол бүхий салбар юм.

Улсын Их Хурлаас баталсан “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого” зэрэг Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд уул уурхайн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх тухай тус тус заасан.

Гэвч уул уурхайн бүтээгдэхүүний экспортын бүтцээс үзэхэд нийт ашигт малтмалын экспортын 70 гаруй хувь нь баяжуулж, боловсруулаагүй бүтээгдэхүүн байна. Тухайлбал, 2022 оны нүүрсний нийт экспортын 78 хувь, төмрийн 76 хувь, жоншны 73 хувь нь тус тус баяжуулж, боловсруулаагүй бүтээгдэхүүн байна.

Иймд ашигт малтмал баяжуулах, боловсруулах нэмүү өртөг шингэсэн ашигт малтмалын баяжмал, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор Засгийн газрын шийдвэрээр техник, эдийн засгийн үндэслэл бүхий үйлдвэрүүдийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах тоног төхөөрөмжийн нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг 4 жил хүртэлх хугацаагаар сунгах, эсхүл уг татварыг 4 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх, гаалийн албан татвараас чөлөөлөн дэмжлэг үзүүлэх хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй баяжуулах, боловсруулах үйлдвэрүүд хүчин чадлаа нэмэгдүүлэх, шаардлагатай үйлдвэрийн шинэчлэлийг хийх, цаашлаад гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид ашигт малтмал баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийг шинээр барьж байгуулахад дэмжлэг болно гэж үзэж байна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/38 дугаар зүйлийн 38.1.22 дахь заалт:

“38.1.22.энэ хуулийн 40.6-д заасны дагуу тогтоосон төслийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах тоног төхөөрөмж.”

2/40 дүгээр зүйлийн 40.6 дахь хэсэг:

“40.6.Ашигт малтмал баяжуулах, боловсруулах замаар нэмүү өртөг шингэсэн ашигт малтмалын баяжмал, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх техник, эдийн засгийн үндэслэл бүхий үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах тоног төхөөрөмжийн нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг 4 жил хүртэл хугацаагаар сунгах, эсхүл уг татварыг 4 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх шийдвэрийг Засгийн газар гаргаж болно.”

2 дугаар зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.6 дахь хэсгийн дугаарыг “40.7” гэж, мөн хэсгийн “40.4, 40.5-д заасныг хэрэгжүүлэх журмыг” гэснийг “38.1.22, 40.2, 40.4, 40.5, 40.6-д заасныг хэрэгжүүлэх журам, тавигдах шаардлагыг” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2027 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Цар тахал, геополитикийн хурцадмал байдлаас үүдэлтэй худалдааны хориг арга хэмжээнүүд нь дэлхийн улс орнуудын инфляцын түвшнийг нэмэгдүүлж, улмаар улс орнууд бодлогын хүүгээ өсгөн эдийн засгаа хумих бодлого хэрэгжүүлсэн. Энэ нь дэлхийн хөрөнгийн зах зээлийн тогтворгүй байдлыг бий болгосон билээ. Үүнтэй холбоотойгоор улс орнууд хөрөнгө оруулалтын орчноо сайжруулах зорилгын хүрээнд татварын бодлогоор дэмжих арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, өнгөрсөн 2 жилийн хугацаанд ХБНГУ, Бельгийн Хаант Улс, Шведийн Хаант Улс, БНХАУ, Бүгд Найрамдах Индонез Улс, Тайландын Хаант Улс зэрэг улсууд хөрөнгийн зах зээлээ дэмжих, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх чиглэлээр татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогыг хэрэгжүүлсэн.

Монгол Улсын хувьд өнгөрсөн жилүүдэд хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас авч хэрэгжүүлсэн төрийн өмчит хуулийн этгээдийн тодорхой хувийн хувьцааг хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй арилжаалах, үнэт цаасны анхдагч зах зээлд үнэт цаасаа гаргахад татварын дэмжлэг үзүүлэх, нээлттэй арилжаалах үнэт цаасны ногдол ашиг, хүүгийн суутган татварын хөнгөлөлт үзүүлэх зэрэг арга хэмжээнүүдийн үр дүнд 2022-2023 онуудад тус зах зээлийн үнэлгээ 3 дахин өсөж хөрөнгийн зах зээлийн үнэлгээ түүхэндээ анх удаа 10 их наяд төгрөгийг давсан байна. Энэхүү өсөлтийг тогтвортой хадгалах, цаашид нэмэгдүүлэх зорилгоор олон улсын түгээмэл туршлагад үндэслэн дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдад чиглэсэн татварын бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр дараах хуулийн төслийг боловсрууллаа.

Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгч дотоодын үнэт цаасны зах зээлд шууд хөрөнгө оруулан худалдан авсан хувьцаа, өрийн хэрэгслээ борлуулахад татвар ногдуулах орлогыг нийт дүнгээс тооцдог ялгаатай дэглэм үйлчилж байгаа нь цаашид гадаадын стратегийн хөрөнгө оруулагч татахад сөргөөр нөлөөлж байна. Иймд гадаадын хөрөнгө оруулагчийн дотоодын хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн адилаар тухайн хувьцаа, үнэт цаасыг худалдан авахад гарсан холбогдох зардлыг хасаж тооцохоор хуулийн төсөлд тусгалаа.

Мөн хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогыг татвар төлөгч өөрөө тайлагнан төсөвт төлөхөөр татварын хуульд заасан боловч энэ төрлийн татварын тайлангийн ирц хангалтгүй байгаагаас татварын орчин ойлгомжгүй, хөрөнгө оруулагчдад хүндрэлтэй нөхцөл үүсэж байна. Иймд Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч, Засгийн газар, аймаг, нийслэлийн дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа борлуулсны орлогод ногдох орлогын албан татварыг 2024-2026 онд 90 хувиар, 2027-2029 онд 50 хувиар тус тус хөнгөлөхөөр төлөвлөлөө. Ингэхдээ хувьцаа, үнэт

цаас борлуулсны орлогод ногдох албан татварыг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн болон кастодианы үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж нь ногдуулж, суутган төсөвт төлж, тайлагнахаар тусгасан.

Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжих төсвийн бодлогын хүрээнд Улаанбаатар хотоос орон нутаг руу шилжин суурьшигчдын амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, орон нутагт шилжин суурьшсан иргэд, аж ахуйн нэгжүүдийг цогц бодлогоор дэмжин төвлөрлийг сааруулах арга хэмжээнүүдийг Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын хүн амын Улаанбаатар хот руу шилжих хөдөлгөөн тогтмол нэмэгдэж, 2022 оны байдлаар Улаанбаатар хотын хүн ам 1.7 саяд хүрсэн нь нийт хүн амын 48 хувийг эзэлж байна. Төвлөрөл нэмэгдэж байгаа гол шалтгаануудын нэг нь орон нутагт орон сууцны хангамж хангалтгүй байгаагаас иргэд хотоос орон нутагт шилжин суурьших сонирхол бага байх шалтгааны нэг болж байна. Түүнчлэн, орон нутагт орон сууц барих эдийн засгийн хөшүүрэг хангалтгүй байгаагаас барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн 18 хувь нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

Засгийн газраас хэрэгжүүлж буй орон нутгийг орон сууцжуулах бодлогын хэрэгжилтийг татварын бодлогоор дэмжиж орон нутагт шинээр орон сууц барьж борлуулсан, түрээслүүлсэн аж ахуйн нэгжүүдэд татварын хөнгөлөлт үзүүлэхээр Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа. Хуулийн төсөлд Багануур, Багахангай, Налайх дүүрэг, Дархан-Уул болон Орхон аймгийн төвийн суманд нийтийн зориулалттай орон сууц барьж, борлуулсны орлогод ногдох албан татварыг 2024-2026 онд 50 хувиар, 2027-2029 онд 20 хувиар, бусад сумын төвд 2024-2026 онд 90 хувиар, 2027-2029 онд 50 хувиар тус тус хөнгөлөхөөр төлөвлөсөн.

Мөн нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг болон аймаг, суманд баригдсан нийтийн зориулалттай орон сууцны барилгад хүн амьдран суух зориулалтаар орон сууц түрээслүүлсний орлогод ногдох албан татварыг 2024-2026 онд 90 хувиар, 2027-2029 онд 50 хувиар тус тус хөнгөлөхөөр тооцлоо.

Дээрх хуулийн төсөл батлагдсанаар хөрөнгийн зах зээлийн таатай орчныг бүрдүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, үнэт цаасны зах зээлийг идэвхжүүлэх, түүнчлэн хөдөө, орон нутаг дахь орон сууцжуулалтыг нэмэгдүүлэх зэрэг зорилгыг нөлөөтэй гэж үзэж байна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оныдугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/18 дугаар зүйлийн 18.13, 18.14 дэх хэсэг:

“18.13. Засгийн газар, аймаг, нийслэл, Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаасыг Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгч борлуулсны орлогод албан татвар ногдуулах орлогыг энэ хуулийн 18.3-т заасны дагуу тодорхойлно.

18.14. Дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан Засгийн газар, аймаг, нийслэл, Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаасыг борлуулсны орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох, суутган тооцох, төсөвт төлөх, тайлагнах журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга хамтран батална.”

2/22 дугаар зүйлийн 22.5.15, 22.5.16, 22.5.17 дахь заалт:

“22.5.15. Орон нутагт шинээр барьсан нийтийн зориулалттай орон сууц борлуулсны орлогод ногдох албан татварыг нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг, Дархан-Уул болон Орхон аймгийн төвийн сумын хилийн цэс дотор 2024-2026 онд 50 хувиар, 2027-2029 онд 20 хувиар, эдгээрээс бусад аймаг, сумын хилийн цэсийн дотор 2024-2026 онд 90 хувиар, 2027-2029 онд 50 хувиар тус тус хөнгөлнө.

22.5.16. Нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг болон аймаг, сумын хилийн цэсийн дотор баригдсан нийтийн зориулалттай орон сууцны барилгад хүн амьдран суух зориулалтаар орон сууц түрээслүүлсний орлогод ногдох албан татварыг 2024-2026 онд 90 хувиар, 2027-2029 онд 50 хувиар тус тус хөнгөлнө.

22.5.17. Засгийн газар, аймаг, нийслэл, Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн дотоодын үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаас борлуулсны орлогод ногдох албан татварыг 2024-2026 онд 90 хувиар, 2027-2029 онд 50 хувиар тус тус хөнгөлнө.”

3/24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэг:

“24.5.Дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан Засгийн газар, аймаг, нийслэл, Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаас борлуулсны орлогод ногдуулах албан татварыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.9, 24.1.10-д заасан зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч этгээд суутган, төсөвт төлж тайлагнана.”

2 дугаар зүйл.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалтын “18.6.8-д” гэснийг “18.6.8, 18.13-т” гэж, 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийн дугаарлалтыг “24.6” гэж, 26 дугаар зүйлийн 26.15 дахь хэсгийн “22.5.11-д” гэснийг “22.5.11, 22.5.14, 22.5.15, 22.5.16-д” гэж, мөн хэсгийн “төсөлд” гэснийг “төсөл, үйл ажиллагаанд” гэж, мөн хэсгийн “төслийн” гэснийг “төсөл, үйл ажиллагааны” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2030 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл, 1 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 2 дугаар зүйлийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс тус тус дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай

Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас авч хэрэгжүүлсэн төрийн өмчит хуулийн этгээдийн тодорхой хувийн хувьцааг хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй арилжаалах, үнэт цаасны анхдагч зах зээлд үнэт цаасаа гаргахад татварын дэмжлэг үзүүлэх, нээлттэй арилжаалах үнэт цаасны ногдол ашиг, хүүгийн суутган татварын хөнгөлөлт үзүүлэх зэрэг арга хэмжээнүүдийн үр дүнд 2022-2023 онуудад тус зах зээлийн үнэлгээ 3 дахин өсөж хөрөнгийн зах зээлийн үнэлгээ түүхэндээ анх удаа 10 их наяд төгрөгийг давсан байна. Энэхүү өсөлтийг тогтвортой хадгалах, цаашид нэмэгдүүлэх зорилгоор олон улсын түгээмэл туршлагад үндэслэн дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдад чиглэсэн татварын бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр хуулийн төслийг боловсрууллаа.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч, Засгийн газар, аймаг, нийслэлийн дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа борлуулсны орлогод татварын хөнгөлөлт үзүүлэхээр, гадаадын хөрөнгө оруулагчийн хувьд үнэт цаасыг худалдаж авсан үнэ болон худалдан авахад төлсөн баримтаар нотлогдож байгаа шимтгэлийн дүнг хасаж, албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохоор эдгээр хуулийн төслүүдийг боловсруулсан.

Эдгээр заалтыг улсын хэмжээнд нэг мөр хэрэгжүүлэх зорилгоор албан татвар хувьцаа, үнэт цаас борлуулсан орлогоо өөрөө тайлагнах одоогийн тогтолцоог өөрчилж үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн болон кастодианы үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж нь ногдуулж, суутган төсөвт төлж, тайлагнахаар тусгаж байна. Үүнтэй холбогдуулан үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн болон кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд бусдын өмнө буюу татварын албаны өмнө хүлээсэн татвар суутган үүргээ хэрэгжүүлэхийг хориглох утгатай хэсэгт нэмэлт оруулж татварын хуультай нийцүүлэхээр Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.8, 46 дугаар зүйлийн 46.6 дахь хэсгийн “өмнө хүлээсэн” гэсний дараа “татварын хуульд зааснаас бусад” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

*Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай
хуульд нэмэлт оруулах тухай*

Монгол Улсын Их Хурал 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр “1955 оны “Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр” болон “Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” 68 дугаар тогтоолыг баталсан.

Тус тогтоолд “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд боомтын сэргэлтийн хэрэгжилтийг хангах зорилгоор 1955 оны “Хилийн төмөр замын хэлэлцээр”-т өөрчлөлт оруулах асуудлыг судлах, “Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай” хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, Төмөр замын хилийн боомтын холболтын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийн болон барилга байгууламжийг цогцоор нь барих ажлыг эрчимжүүлэх, нүүрсний ордыг иж бүрэн ашиглаж, эдийн засгийн үр өгөөж, тээвэрлэлт, экспортыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Тус тогтоолын хэрэгжилтийг хангахын тулд “Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын холболтын бүтээн байгуулалт, нүүрсний худалдах, худалдан авах урт хугацааны гэрээ, Тавантолгойн нүүрсний ордыг иж бүрэн ашиглах, олборлолт, тээвэрлэлт, экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээг цогцоор нь авч хэрэгжүүлэх шаардлага үүссэн боловч хууль, эрх зүйн хүрээнд хэд хэдэн хүндрэл үүсээд байна. Тухайлбал, дээрх тогтоолын 4 дэх заалтын хүрээнд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хил доторх “Ганцмод” боомт хүртэлх төмөр замын суурь бүтэц эзэмшигч төрийн өмчит компани болон “Эрдэнэс Тавантолгой” ХК хооронд үе шаттайгаар жил бүр 20 сая тонноос доошгүй хэмжээний нүүрсийг харилцан ашигтай, тогтвортой, зах зээлийн зарчимд нийцүүлэн урт хугацаагаар худалдах, худалдан авах гэрээ байгуулах хэлэлцээрийн явцад Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг буюу төрийн өмчит хуулийн этгээдийн борлуулах уул уурхайн бүтээгдэхүүнийг заавал биржээр арилжих зохицуулалт хөндөгдөж байгаа юм. Өөрөөр хэлбэл, дээрх Монгол Улсын Их Хурлын 68 дугаар тогтоолд тусгайлан дурдсан худалдан авагчтай урт хугацаанд нүүрс худалдах, худалдан авах харилцааг Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн хуулиар зохицуулах боломжгүй нөхцөл байдал үүсэж байгаа юм. Иймд Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах, стратегийн ач холбогдолтой төсөл хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Их Хурлын шийдвэр, эсхүл Монгол Улсын олон улсын гэрээний дагуу урт хугацаагаар уул уурхайн бүтээгдэхүүн худалдах, худалдан авах харилцаанд Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн хууль үйлчлэхгүй байх өөрчлөлтийг оруулахаар тусгалаа.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.3 дахь хэсэг нэмсүгэй:

“10.3. Стратегийн орд эзэмшигч төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь Монгол Улсын олон улсын гэрээ, эсхүл Монгол Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу уурхайн үйл ажиллагааны тасралтгүй, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор зах зээлийн зарчимд нийцүүлэн урт хугацаагаар уул уурхайн бүтээгдэхүүн худалдахад энэ хуулийн 10.2 дахь хэсэг хамаарахгүй.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурал 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр “1955 оны “Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр” болон “Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” 68 дугаар тогтоолыг баталсан.

Тус тогтоолд “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд боомтын сэргэлтийн хэрэгжилтийг хангах зорилгоор 1955 оны “Хилийн төмөр замын хэлэлцээр”-т өөрчлөлт оруулах асуудлыг судлах, “Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай” хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, Төмөр замын хилийн боомтын холболтын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийн болон барилга байгууламжийг цогцоор нь барих ажлыг эрчимжүүлэх, нүүрсний ордыг иж бүрэн ашиглаж, эдийн засгийн үр өгөөж, тээвэрлэлт, экспортыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Монгол Улсын Их Хурлын 68 дугаар тогтоолын 6 дахь заалт буюу Тавантолгойн нүүрсний ордыг иж бүрэн ашиглах, олборлолт, тээвэрлэлт, экспортыг нэмэгдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангах хүрээнд Тавантолгойн нүүрсний ордын олборлолт, уурхайн хүчин чадлыг урт хугацаанд үе шаттай нэмэгдүүлэх чиглэлд бусад этгээдтэй хамтран ажиллахад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн гэрээний хугацааны дээд хязгаар төслийг урт хугацаанд хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж байгаа тул Монгол Улсын олон улсын гэрээ, эсхүл Монгол Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу урт хугацааны стратегийн ач холбогдолтой төсөл хэрэгжүүлэх хүрээнд ажил, үйлчилгээг 10 хүртэл жилийн хугацаатай гэрээ байгуулан худалдан авахаар тендер шалгаруулалт зарлаж болох хуулийн нэмэлтийн төслийг боловсрууллаа.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.15 дахь хэсэг нэмсүгэй:

“8.15.Стратегийн орд эзэмшигч төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь Монгол Улсын олон улсын гэрээ, эсхүл Монгол Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу уурхайн үйл ажиллагааны тасралтгүй, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор хайгуул, олборлолтын ажлыг гүйцэтгэх этгээдтэй арав хүртэл жилийн хугацаатай гэрээ байгуулах тендер шалгаруулалт зарлаж болно.”

2 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.5 заалтын “7.6” гэсний дараа “, 8.15” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурал 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр “1955 оны “Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр” болон “Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” 68 дугаар тогтоолыг баталсан.

Тус тогтоолд “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд боомтын сэргэлтийн хэрэгжилтийг хангах зорилгоор 1955 оны “Хилийн төмөр замын хэлэлцээр”-т өөрчлөлт оруулах асуудлыг судлах, “Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай” хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, Төмөр замын хилийн боомтын холболтын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийн болон барилга байгууламжийг цогцоор нь барих ажлыг эрчимжүүлэх, нүүрсний ордыг иж бүрэн ашиглаж, эдийн засгийн үр өгөөж, тээвэрлэлт, экспортыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Монгол Улсын Их Хурлын 68 дугаар тогтоолын 6 дахь заалт буюу Тавантолгойн нүүрсний ордыг иж бүрэн ашиглах, олборлолт, тээвэрлэлт, экспортыг нэмэгдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангах хүрээнд Тавантолгойн нүүрсний ордын олборлолт, уурхайн хүчин чадлыг урт хугацаанд үе шаттай нэмэгдүүлэх чиглэлд бусад этгээдтэй хамтран ажиллахад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн гэрээний хугацааны дээд хязгаар төслийг урт хугацаанд хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж байна.

Иймд Монгол Улсын олон улсын гэрээ, эсхүл Монгол Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу урт хугацааны стратегийн ач холбогдолтой төсөл хэрэгжүүлэх хүрээнд ажил, үйлчилгээг 10 хүртэл жилийн хугацаатай гэрээ байгуулан худалдан авахаар тендер шалгаруулалт зарлаж болохоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг боловсруулсан. Үүнтэй холбогдуулан нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу гүйцэтгэгч сонгох ажиллагаанд зарцуулах боломжит дээд хугацааг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжиж эхлэх хугацааг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацаагаар хойшлуулах хуулийн өөрчлөлтийн төслийг боловсрууллаа.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ,
ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-Д
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсгийн "2023 оны 12 дугаар сарын 01-ний" гэснийг "2024 оны 01 дүгээр сарын 01-ний" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

*Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Монгол Улсад газрын бүртгэлийг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар /иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийн бүртгэл/, Улсын бүртгэлийн ерөнхий газар /өмчлөх эрхийн бүртгэл/, Ашигт малтмал, газрын тосны газар /уул уурхайн газар/, Байгаль орчин, аялал жуулчлалын яам /тусгай хамгаалалттай газар/, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам /тариалан, бэлчээр/ зэрэг байгууллагууд зэрэгцэн эрхэлж байгаа нь чиг үүргийн давхардал болон зохиомол шат дамжлагыг бий болгохын зэрэгцээ “Монгол Улсын газар нутаг салшгүй бүрэн бүтэн, газрын сан нэгдмэл байх” гэсэн Газрын тухай хуульд заасан зарчмыг алдагдуулж байна.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрыг Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлж, газар олгох, бүртгэх, төлөвлөх эрх бүхий яам, агентлагууд, Засаг дарга нартай харилцан уялдаатай, хяналт тавьж ажиллах боломж нөхцөлөөр хангаж, газрын асуудлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтад оруулж цэгцлэх хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Үүнтэй холбогдуулан “Нийслэл Улаанбаатар хотод гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гамшгийн хор уршгийг арилгах, нийслэлийн хот төлөвлөлт, газар зохион байгуулалттай холбогдуулах авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 294 дүгээр тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрыг Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд ажиллуулахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосонтой холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа. Хуулийн төсөл батлагдсанаар газрын харилцаа, геодези, зураг зүйн асуудал Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарч хот, хөдөөгийн сэргэлт, газар зохион байгуулалтын асуудлыг хамтад нь шийдвэрлэх боломж бүрдэнэ.

Хуулийн төсөлтэй уялдуулан Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг тус тус боловсруулсан болно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “-зөвшөөрлийн нэгдсэн бодлого” гэсний дараа “-газрын харилцаа, геодези, зураг зүйн асуудал” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 10 дахь заалтын “газар зохион байгуулалт болон” гэснийг, мөн хэсгийн 12 дахь заалтын “-газрын харилцаа, геодези, зураг зүйн асуудал;” гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрыг Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд ажиллуулах болсонтой холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй уялдуулж Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар газрын харилцааны асуудал Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарч хот, хөдөөгийн сэргэлт, газар зохион байгуулалтын асуудлыг хамтад нь шийдвэрлэх боломж бүрдэнэ.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тухай хуулийн 18 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 18.1.8-18.1.10 дахь заалт нэмсүгэй:

"18.1.8.газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн үйл ажиллагааны журмыг батлах;

18.1.9.газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмыг батлах;

18.1.10.энэ хуулийн 18.1.7-д заасан ерөнхий төлөвлөгөө, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нийцсэн эсэх талаар гаргасан газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүгнэлтэд үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх олгох шийдвэр гаргах."

2 дугаар зүйл. Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"23.2.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах эрх хэмжээтэй байна:

23.2.1.газрын талаарх хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

23.2.2.улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулах;

23.2.3.аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд дүгнэлт өгөх, хэрэгжилтэд хяналт тавих;

23.2.4.улсын хэмжээнд газар зохион байгуулалтын үйл ажиллагааг эрхлэх, эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтыг боловсруулж, Засгийн газарт оруулан шийдвэрлүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

23.2.5.газрын нэгдмэл сангийн болон газрын тайланг жил бүр нэгтгэн Засгийн газарт танилцуулах;

23.2.6.энэ хуулийн 16.1.2-16.1.9, 16.1.12, 16.1.16-т заасан газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ заагийг тогтоох саналаа Засгийн газарт оруулах;

23.2.7.улсын хэмжээнд газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үйл ажиллагаанд хяналт тавих;

23.2.8.улсын хэмжээнд газрын кадастрын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх, улсын газрын мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх;

23.2.9.газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалд хамаарах газрыг тогтоох болон нэг ангиллаас нөгөөд шилжүүлэх асуудлыг Засгийн газарт оруулан шийдвэрлүүлэх;

23.2.10.газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, мэргэжлийн байгууллагад эрх олгох, эрхийг цуцлах, тэдгээрийн ажиллах журам, зааврыг батлан мөрдүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих, дүгнэлт өгөх;

23.2.11.Засгийн газраас тогтоосон хязгаарт багтаан аймаг, нийслэл, дүүргийн газрын албаны бүтэц, орон тоог батлах;

23.2.12.газрын биржийн үйл ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулах;

23.2.13.газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлох аргачлалыг батлах;

23.2.14.газрыг хамгаалах, нөхөн сэргээх, газар зохион байгуулалтын үйл ажиллагаанд хяналт тавих;

23.2.15.газрын талаарх хууль тогтоомж зөрчсөн байгууллага, албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгуулах саналыг Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх;

23.2.17.газар зохион байгуулалт, газрын кадастрын судалгаа, шинжилгээний ажил эрхлэх;

23.2.18.энэ хуулийн 20.2.9-д заасны дагуу холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран шалгалт хийж, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах.

23.2.19.газрын төлөв байдал, чанарыг тодорхойлох, үнэлгээ өгөх, чанарын өөрчлөлтийг улсын хэмжээнд хянан дүгнэх үүрэг бүхий хяналт шинжилгээ /мониторинг/-ний сүлжээ ажиллуулах;

23.2.20.газрын тухай хууль тогтоомж, газар зохион байгуулалт, газрын кадастр, төлөв байдал, чанарын хянан баталгааны үйл ажиллагаанд төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх;

23.2.21.газрын төлөв байдал, нөөц, чанарын өөрчлөлтийг тодорхойлох, газар эзэмшигч, ашиглагчийн бүртгэлийг эрхлэх зорилго бүхий газрын нэгдмэл сангийн мэдээллийн сан, сүлжээг орчин үеийн техник, технологид тулгуурлан бий болгох.

23.2.22.нэгж талбарын хувийн хэрэг хөтлөх журмыг батлах."

3 дугаар зүйл.Газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 8.4 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.2.1 дэх заалт, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг, 42 дугаар зүйлийн 42.1, 42.2 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 55 дугаар зүйлийн 55.4 дэх хэсэг, 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэг, 58 дугаар зүйлийн 58.3, 58.6 дахь хэсгийн "төв" гэснийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл.Газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн "18.1.10" дахь заалтыг 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн, бусад зүйлийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрыг Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд ажиллуулах болсонтой холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй уялдуулж Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар газрын кадастрын асуудал Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарч хот, хөдөөгийн сэргэлт, газар зохион байгуулалтын асуудлыг хамтад нь шийдвэрлэх боломж бүрдэнэ.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**КАДАСТРЫН ЗУРАГЛАЛ БА ГАЗРЫН КАДАСТРЫН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Кадастрын зураглал болон газрын кадастрын тухай хуулийн 9¹ дүгээр зүйлийн гарчиг, мөн зүйлийн 9^{1.1} хэсгийн “төв” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрыг Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд ажиллуулах болсонтой холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй уялдуулж Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар газрын төлбөрийн асуудал Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарч хот, хөдөөгийн сэргэлт, газар зохион байгуулалтын асуудлыг хамтад нь шийдвэрлэх боломж бүрдэнэ.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн “төлбөрийн болон татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дарга” гэснийг “асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

*Геодези, зураг зүйн тухай хуульд
Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрыг Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд ажиллуулах болсонтой холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй уялдуулж Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар газрын харилцаа, геодези, зураг зүйн асуудал Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарч хот, хөдөөгийн сэргэлт, газар зохион байгуулалтын асуудлыг хамтад нь шийдвэрлэх боломж бүрдэнэ.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5.5.10-5.5.14 дэх заалт нэмсүгэй:

“5.5.10.геодези, зураг зүйн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

5.5.11.Монгол Улсын нутаг дэвсгэрийг зурагжуулах төрийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх;

5.5.12.геодези, зураг зүйн заавар, дүрэм батлах, стандартыг боловсруулж мөрдүүлэх;

5.5.13.олон улсын гэрээгээр геодези, зураг зүйн асуудлаар Монгол Улсын хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

5.5.14.иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох.”

2 дугаар зүйл.Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7.2, 5.7.3 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “төв” гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл.Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 3.7 дахь заалтад нэмэлт оруулснаар зөвшөөрлийн нэгдсэн сангаас олгогдох зөвшөөрөл нь цахим гарын үсэг бүхий QR кодтой зөвшөөрлийн гэрчилгээг олгох, мөн зүйлийн 5 дахь хэсэгт эрх бүхий этгээдээс олгодог энгийн болон тусгай зөвшөөрлийг шинээр эсвэл сунгуулахад материал хүлээн авахдаа илүү хариуцлагатайгаар бүрдлийг шалгах, бүрэн бол богино хугацаанд зөвшөөрлийг шийдвэрлэх, олгохгүй уддаг байдал арилах боломжтой байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг өөрчлөлт оруулснаар зөвшөөрлийн цахим хэлбэрээр олгох боломжийг бүрдүүлж өгч байгаа, 5.5 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт зөвшөөрлийн нөхөн бүрдүүлэлтийн хугацааг ажлын хоног гэж өөрчилснөөр урт үргэлжилсэн амралтын өдрүүдийн өмнө сунгуулах хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд хүндрэл үүсэхээс сэргийлж энгийн үед хоёр долоо хонгийн хугацаанд материал бүрдүүлэх боломж бүрдэнэ.

Түүнчлэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрыг Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд ажиллуулах болсонтой холбогдуулан Зөвшөөрлийн тухай хуульд зохих зохицуулалтыг тусгасан болно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 3.7 дахь заалтын “тамга /тэмдэг/” гэсний дараа “эсхүл тоон гарын үсэг бүхий QR код (лавлагаа авах холбоос)” гэж, мөн зүйлийн 5 дахь хэсгийн “энгийн” гэсний дараа “болон тусгай” гэж, 5.5 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “хугацаа” гэсний дараа “ажлын” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “бичиг” гэснийг “бичгийг цаасан эсхүл цахим хэлбэрээр” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 3.4, 3.6, 3.7 дахь заалтын “төв” гэснийг-тус тус хассугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

*Авлигын эсрэг хуульд
өөрчлөлт оруулах тухай*

Гүйцэтгэх ажил болон мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий төрийн тусгай байгууллагын албан хаагчдын эрх зүйн баталгааг Тагнуулын байгууллагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-д “Гадаадын тусгай алба, байгууллага, гэмт бүлэглэлд нэвтрэн тусгай үүрэг гүйцэтгэсэн, ажиглалтын албанд болон техникийн албаны тусгай нэгжид ажилласан нэг жилийг 1 жил 4 сартай дүйцүүлэн тооцно.”, Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2-т “Цагдаагийн алба хаагчийн ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар, цагдаагийн байгууллагын нууцалбал зохих албанд гүйцэтгэх ажилтнаар ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар тус тус тооцно” гэж тус тус заасан. Түүнчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 286 дугаар зүйлийн 286.7-д “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн баривчлах байр, цагдан хорих төв, цагдан хорих байр, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, хаалттай хорих ангид 1 жил ажилласан хугацааг 1 жил 3 сар, нээлттэй хорих анги, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага болон харьяа бусад байгууллагад 1 жил ажилласан хугацааг 1 жил 2 сар ажилласанд тооцно”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-д “Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн алба хаасан хугацааг тооцохдоо алба хаасан зургаан сар тутмыг найман сард дүйцүүлэн тооцно.” гэж заасан байна.

Гэвч Авлигын эсрэг хуулийн 30 дугаар зүйлийн 30.9-д “Авлигатай тэмцэх газарт гүйцэтгэх ажилтан, мөрдөгчөөр ажилласан хугацааг цэргийн алба хаасан хугацаанд тооцно.” гэж зааснаас өөрөөр ямар нэгэн эрх зүйн зохицуулалтгүй явж ирсэн байна. Энэ нь ижил төстэй чиг үүрэг бүхий төрийн бусад тусгай байгууллагаас гүйцэтгэх ажилтан, мөрдөгчийн албан тушаалд албан хаагчийг шилжүүлэн, сэлгэн ажиллуулах тохиолдолд эрх зүйн байдал нь дордох үр дагавартай болж байна.

Иймд хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, хуулийг нэг мөр хэрэглэх, Авлигатай тэмцэх газрын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хүрээнд гүйцэтгэх ажилтан болон мөрдөгчийн үйл ажиллагааны онцлог, ажлын ачаалал зэргийг харгалзан энэхүү албан тушаалд ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар нэмэгдүүлэн тооцож нийгэм, эрх зүйн эрх зүйн баталгааг хангах шаардлагатай байна.

Хуулийн төсөл батлагдсанаар албан хаагчийг сэлгэн ажиллуулах тохиолдолд эрх зүйн байдал нь дордохгүй байх нөхцөл бүрдэж авилагтай тэмцэх газрын гүйцэтгэх ажилтан, мөрдөгчөөр болон нууцалбал зохих албанд ажиллаж байгаа албан хаагчдын нийгмийн баталгаа сайжирна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Авлигын эсрэг хуулийн 30 дугаар зүйлийн 30.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"30.9.Авлигатай тэмцэх газарт гүйцэтгэх ажилтан, мөрдөгч, нууцалбал зохих албаны ажилтнаар ажилласан хугацааг цэргийн алба хаасан хугацаанд тооцох ба эдгээр албан тушаалд ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар дүйцүүлэн тооцно."

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Түншлэлийн төвийг Засгийн газрын шийдвэрээр түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд байгуулна.”, 12.3-т “Түншлэлийн төв нь аж ахуйн тооцоот төрийн өмчит үйлдвэрийн газар байх бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу Засгийн газар байгуулж, дүрмийг батална” гэж заасан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх хэсэгт зааснаар Засгийн газар нь хэмнэлтийн талаар “чиг үүргийн давхардалтай, эсхүл чиг үүрэг ойролцоо, харилцан уялдаа бүхий үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа төсвийн байгууллага, төрийн болон олон нутгийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, татан буулгах, бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх зэргээр удирдлагын зардлыг хэмнэх” арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр заасан.

Түүнчлэн, “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн шинэчлэлийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 345 дугаар тогтоолын 1.4-д “Засгийн газрын шийдвэр гарснаас бусад тохиолдолд охин болон хараат төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг шинээр байгуулахгүй” гэж заасан.

Иймд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Түншлэлийн төвийг Засгийн газраас байгуулах хүртэл түүний чиг үүргийг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэхээр тусгалаа.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ
ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд дор дурдсан агуулгатай 8¹ дүгээр зүйл нэмсүгэй:

“8¹ дүгээр зүйл.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан Түншлэлийн төв байгуулагдах хүртэл тус төвийн чиг үүргийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.”

2 дугаар зүйл.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн “хууль батлагдсанаас хойш 6 сарын хугацаанд” гэснийг “хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Дэлхийн геополитикийн хурцадмал байдалтай уялдуулан Оросын Холбооны Улс (ОХУ)-д тавьсан эдийн засаг, худалдааны хориг арга хэмжээ нь улс орнуудын эдийн засагт сөргөөр нөлөөлж эхэлсэн. Тухайлбал, ОХУ-ын экспортын голлох бүтээгдэхүүн болох байгалийн хий, газрын тосны үнэ дэлхийн зах зээл дээр огцом өссөнөөр нийлүүлэлтийн тасалдал үүсэх эрсдэлийг дагуулж, улмаар импортлогч орнуудын газрын тосны бүтээгдэхүүний үнэд нөлөөлсөн.

Монгол Улсын Их Хурлаас дээрх нөхцөл байдалтай холбогдуулан автобензин, дизелийн түлшний үнийг тогтвортой байлгахад дэмжлэг үзүүлэх зорилгоор "Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын 2023 оны 10 дугаар тогтоолыг баталж, импортын автобензин, дизелийн түлшний гаалийн албан татварыг 0-5 хувьд багтаан тогтоох эрхийг Засгийн газарт олгосон. Тус тогтоолд заасны дагуу Засгийн газарт олгосон эрх нь 2024 онд дуусгавар болж ирэх оноос импортын автобензин, дизелийн түлшний гаалийн албан татвар 5 хувьд эргэн шилжихээр байна.

Монгол Улсын хувьд автобензин, дизелийн түлш зэрэг эдийн засагт чухал нөлөө үзүүлдэг газрын тосны бүтээгдэхүүнийхээ хэрэглээний 95 хувийг ОХУ-аас импортолдог. Түүнчлэн автобензин, дизелийн түлш зэрэг шатахууны бүлгийн бараа нь хэрэглээний үнийн индексийг тооцоход ашигладаг бараа, үйлчилгээнээс бүрдсэн хэрэглээний сагсны нийт жингийн 5.3 хувийг эзэлдэг ба үүнээс А-92 автобензин 2.7 хувь, дизель түлш 1.2 хувийг тус тус бүрдүүлдэг байна. Дотоодод шатахууны үнэ нэмэгдсэнээр бусад өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өсөж, улмаар инфляцыг хөөрөгдөхөд нөлөөлөх эрсдэлтэй тул тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулан гаалийн албан татварын хувь хэмжээг 0-5 хувьд тогтоох нь зүйтэй байна.

Иймд геополитикийн хурцадмал байдал үргэлжилж байгаатай холбогдуулан Засгийн газарт автобензин, дизелийн түлшний гаалийн албан татварт зохицуулалт хийх боломжийг олгосон эрхийн хугацааг 2026 он хүртэл сунгахаар "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар...

Улаанбаатар
хот

ТОГТООЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 10 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн “2024 оны” гэснийг “2026 оны” гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн зорилтуудыг үндэслэн "Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Улсын Их хурлын 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 26 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт тусгасан зорилт 2-т "Засгийн газрын гадаад үнэт цаас төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж, дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулна" гэж заасан байдаг. Энэхүү зорилтын хүрээнд 2024 оны 03 дугаар сард эргэн төлөх хуваарьтай "Хуралдай" бондын төлбөр болох 392.5 сая ам.доллартой тэнцэх хэмжээний хөрөнгийг төсөвт дарамт учруулахгүйгээр өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Түүнчлэн, дээрх стратегийн баримт бичгийн зорилт 4-т "Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийн дэмжих, үнэт цаасны арилжааг тогтмолжуулна." гэж заасны дагуу Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч зах зээл дэх арилжаанд оролцогчдын эрэлтийг нэмэгдүүлэх, хоёрдогч зах зээл дэх үнэт цаасны хөрвөх чадварыг сайжруулах зорилгоор Засгийн газрын дотоод үнэт цаасыг хугацаанаас нь өмнө буцаан худалдан авах, зорилтот зах зээлд чиглэсэн Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг зохион байгуулах, дэвшилтэт технологи ашигласан систем нэвтрүүлж зах зээлийг хөгжүүлэхээр Засгийн газрын дотоод үнэт цаасыг арилжаалж эхлэхээр төлөвлөөд байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хүрээнд 2023 оны төсвийн алдагдлыг санхүүжүүлэх, цаашлаад Засгийн газрын өрийн оновчтой багцын бүтцийг бий болгох, Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээг бага зардлаар, боломжит эрсдэлийн түвшинд байлгах зорилгоор Засгийн газрын үнэт цаасыг олон улсын болон дотоодын зах зээлд арилжаална.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар...

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС ГАРГАХ ЭРХ ОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Өрийн удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2024 онд гадаад, дотоод үнэт цаас гаргах асуудлыг Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль болон Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт нийцүүлэн шийдвэрлэх эрхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т олгосугай.

2. Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

*Засгийн газрын өрийн баталгаа
гаргах зөвшөөрөл олгох тухай*

1. “Чойбалсангийн ДЦС-ыг 50 МВт-аар өргөтгөх, шинэчлэх” төслийн талаар

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь “Чойбалсан ДЦС-ын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт-аар нэмэгдүүлж, өргөтгөх төсөл”-ийг хэрэгжүүлж байна. Уг төсөл хэрэгжсэнээр Дорнод, Сүхбаатар аймгийн 36 сум, багийн 25,139 айл өрх, 3,133 аж ахуйн нэгж, албан байгууллага, уул уурхайн 13 ордын олборлох үйлдвэрүүдийг тасралтгүй, найдвартай эрчим хүчээр хангагдах юм. Түүнчлэн зүүн бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа Петрочайна дачин тамсаг ХХК, Цайрт минерал ХХК, ХХЕМ ХХК, Эм Эл Цахиурт овоо ХХК-ийн хэрэгжүүлж байгаа төслүүдийн өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний хэрэгцээг хангахын зэрэгцээ цаашид төлөвлөсөн бүтээн байгуулалтын төслүүдийн эрчим хүчний хэрэгцээг байгаль орчинд ээлтэй технологи бүхий дотоодын эх үүсвэрээс бүрэн хангах ач холбогдолтой юм.

Энэхүү төслийн санхүүжилтийн 75 хувь буюу 420.0 сая юанийг Монгол Улсын Хөгжлийн банк (Хөгжлийн банк) нь Хятадын Хөгжлийн банкнаас татан төвлөрүүлэх зээлийн гэрээг 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан ба үлдэх 25 хувийг улсын төсвөөс 2023 онд бүрэн санхүүжүүлээд байна.

Төслийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл одоогоор 65 хувьтай байгаа бөгөөд 2023 оны 4 дүгээр улиралд багтаан бүрэн ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-аас 2023 оны 4 дүгээр сараас хойш нийт 166.7 сая юанийн санхүүжилтийн хүсэлт хүргүүлсэн боловч БНХАУ-ын Хөгжлийн банк одоогоор шийдвэрлээгүй байна.

Санхүүжилт саатсан шалтгаан нь Хөгжлийн банкны 2022 оны санхүүгийн аудитлагдсан тайлангаар банкны “тогтвортой санхүүжилтийн харьцаа” 37.8% байсан нь Монголбанкнаас тогтоосон шаардлагыг хангаагүйтэй холбоотой. Энэ нь Хөгжлийн банкны олон улсын зах зээлд гаргасан 500.0 сая ам.долларын Евробонд болон Япон улсын зах зээлд Засгийн газрын баталгаатай гаргасан 30.0 тэрбум иений бондын хугацаа энэ оны 4 дүгээр улиралд дуусах хуваарийн дагуу урт хугацаат санхүүжилтийн дүн буурсантай холбоотой юм. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй байх нь Зээлийн гэрээний хүрээнд үүргийн зөрчил үүсэж, улмаар Хятадын Хөгжлийн банк зээлийг хугацаанаас өмнө дуудах эрсдэл үүссэн бөгөөд нэмэлт санхүүжилтийг ашиглах боломжгүй болсон.

Дээрх үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлэхээр Монгол Улсын Хөгжлийн банкны зүгээс БНХАУ-ын Хөгжлийн банкт удаа дараа хэлцэл хийсэн бөгөөд БНХАУ-ын Хөгжлийн банкнаас дараах шаардлагуудыг тавьсан. Үүнд:

1. Хөгжлийн банкны Хятадын Хөгжлийн банкнаас авах зээлд Монгол Улсын Засгийн газраас баталгаа гаргах;

2. Засгийн газрын баталгааны хугацаанд 2023-2024 онуудад төлөгдөх зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг эскроу дансанд байршуулах;
3. Хөрөнгө барьцаалах зэрэг болно.

Иймд үүссэн нөхцөл байдлыг харгалзан Монгол Улсын Хөгжлийн банкны зүгээс ирүүлсэн хүсэлт, өндөр ач холбогдол бүхий стратегийн төслийг төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулах эдийн засгийн зайлшгүй хэрэгцээ шаардлагын үүднээс Монгол Улсын Хөгжлийн банканд Засгийн газрын өрийн баталгаа гаргах шийдвэрийн төсөл боловсруулав.

2. Газрын тосны бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс сэргийлэх талаар

Бүтээгдэхүүний хил үнийн өсөлтөөс үүдэн өргөн хэрэглээний АИ-92 автобензинийн жижиглэнгийн үнэ 2022 оны 04 дүгээр сард өнөөдрийн зарагдаж байсан 2390 төгрөг дээр 900 орчим төгрөгөөр нэмэгдэх нөхцөл байдал үүссэн. Улмаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас ОХУ-ын Роснефть нээлттэй хувьцаат нийгэмлэгтэй хэлэлцээр хийж АИ-92 автобензинийн хил үнэ 1110 тонн/ам.долларыг 840 ам.доллар болгон бууруулсан бөгөөд энэхүү хэлэлцээрийн гол нөхцөл нь 2022 оны 4, 5, 6 дугаар саруудын нийт хэрэглээ болох 120.0 мянган тонн бүтээгдэхүүний захиалгын төлбөр 100,800,000 ам.доллартой тэнцэх хэмжээний эх үүсвэрийн 85 хувьд Засгийн газрын өрийн баталгаа гаргасан. Засгийн газрын өрийн баталгаа гаргуулсан аж ахуйн нэгжүүд зээлийн төлбөрийг хоцроосон тохиолдол гараагүй бөгөөд газрын тосны бүтээгдэхүүний борлуулалтыг амжилттай хийсэн. Түүнчлэн АИ-92 автобензиний гаалийн албан татвар, дизель түлшний онцгой албан татварыг тэглэснээр 2022 оны сүүлийн улиралд автобензиний жижиглэнгийн борлуулалтын үнэ литр тутамд 781-1,103 төгрөгөөр буурсан. Засгийн газрын өрийн баталгаа гаргуулсан аж ахуйн нэгжүүд зээлийн төлбөрийг хоцроосон тохиолдол гараагүй бөгөөд газрын тосны бүтээгдэхүүний борлуулалтыг амжилттай хийж чадсан болно.

Цаашид газрын тосны бүтээгдэхүүний хил үнийн өсөлт, шатахууны экспортлогч улсын шийдвэрээс шалтгаалан газрын тосны бүтээгдэхүүн хомсдох нөхцөл байдал үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Засгийн газар болон шатахуун импортлогч байгууллагуудад дутагдаж болзошгүй санхүүжилтийн нөөцийг бүрдүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Иймд санхүүжилтийг түргэн, шуурхай шийдвэрлэх, төлбөрийг цаг алдалгүй гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэхэд Засгийн газрын өрийн баталгаа гаргах замаар дэмжлэг үзүүлэх зорилгоор УИХ-ын тогтоолын төслийг боловсруулав.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар...

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАТАЛГАА ГАРГАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Өрийн удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т зөвшөөрсүгэй:

1/Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хөгжлийн банкны 420 сая юанийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Чойбалсан Дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөх” төслийн зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрт зориулж Монгол Улсын Хөгжлийн банканд 2024 оны төсвийн жилд Засгийн газрын өрийн баталгаа гаргах;

2/Газрын тосны бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, нөөц бүрдүүлэх нөхцөл үүссэн тохиолдолд эх үүсвэрийг татан төвлөрүүлэх зорилгоор 2024 онд багтаан эргэн төлөх нөхцөлтэй хийгдэх зээллэгт Засгийн газрын өрийн баталгаа гаргах.

2.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

*Тогтоолын хавсралтад нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай*

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрыг Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд ажиллуулах болсонтой холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй уялдуулж Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай шийдвэрийн төслийг боловсрууллаа.

Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсанаар газрын харилцаа, геодези, зураг зүйн асуудал Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарч хот, хөдөөгийн сэргэлт, газар зохион байгуулалтын асуудлыг хамтад нь шийдвэрлэх боломж бүрдэнэ.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар...

Улаанбаатар
хот

ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч"-ийн Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний "Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг" гэсэн хэсэгт "2.Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар" гэж нэмсүгэй.

2."Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч"-ийн "Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг" хэсгийн "2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17" гэсэн дугаарыг "3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11,12, 13, 14, 15, 16, 17, 18" гэж өөрчилсүгэй.

3."Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч"-ийн Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний "Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг" хэсгийн "18. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар" гэснийг хассугай.

4.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

*"Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль
батлагдсантай холбогдуулан авах
зарим арга хэмжээний тухай*

Монгол Улсын эдийн засаг 2024 онд 7.0 хувиар өсөж, нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн 74 их наяд төгрөгт, нэгдсэн төсвийн нийт орлого 27.2 их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн орлого 25.3 их наяд төгрөгт хүрэхээр байна.

Монгол Улсын Засгийн газраас 2024 онд баримтлах төсөв, санхүүгийн бодлого нь Шинэ сэргэлтийн бодлогын хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжихэд чиглэгдэж байна. Энэ хүрээнд иргэд, аж ахуй эрхлэгчдэд татварын хөнгөлөлт үзүүлэх, хөдөө орон нутагт орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төрийн албан хаагчдын цалин, нийгмийн баталгааг сайжруулах зэрэг багц арга хэмжээг хэрэгжүүлэхээр тооцсон болно.

Иймд хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжих төсвийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Засгийн газар, орон нутгийн засаг захиргаа, Монголбанкны зүгээс анхаарч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээг тусгасан Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Тогтоолын төсөл батлагдсанаар Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан Хөдөөгийн сэргэлтийг дэмжих зорилт төсвийн бодлогын хүрээнд хангагдах ач холбогдолтой.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар...

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлж, төвлөрлийг сааруулах зорилгоор 2024 оныг “Хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжих” жил болгон зарласугай.

2.Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/орон нутагт иргэд шилжин, тогтвортой суурьших орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор иргэдийг орон сууцжуулахад чиглэсэн төсөл, арга хэмжээг тухайн орон нутгийн онцлог, дэд бүтцийн бэлэн байдал, иргэд, зорилтот бүлгийн шаардлагатай уялдуулан зохион байгуулах;

2/хөдөөд орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээнд шаардагдах санхүүжилтийг төр, хувийн хэвшлийн түншлэл, улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээл, тусламжийн эх үүсвэрээс бүрдүүлэх замаар олон талын оролцоог хамарсан хамтын санхүүжилтээр шийдвэрлэх;

3/байгаль орчинд ээлтэй, эрчим хүчинд хэмнэлттэй орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн урт хугацааны ногоон санхүүжилтийн арга хэрэгслийг нэвтрүүлэх;

4/иргэдийг орон сууцжуулах арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж байгаа орон нутгийг санхүүгийн дэмжлэгээр урамшуулах механизм бүрдүүлж, сайн туршлагыг сурталчлах ажлыг зохион байгуулах;

5/төрийн захиргаа, төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдад олгох орон нутгийн нэмэгдлийг аймгийн төвийн сум болон нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэгт 20 хувиар, аймгийн төвөөс бусад суманд 40 хувиар тус тус тооцож хуваарилах;

6/орон нутгийн тохижилт үйлчилгээний ажилчдын үндсэн цалинг 20 хувиар нэмэгдүүлэх;

7/анхан шатлалын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг бүс нутгийн онцлогийг харгалзан ялгаатай хуваарилах, иргэдийг тусламж үйлчилгээний шатлал хооронд хүнд суртал, чирэгдэлгүйгээр шуурхай шилжүүлдэг байх зэрэг зохицуулалтын оновчтой арга хэрэгслийг 2023 онд багтаан шийдвэрлэж, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэх;

8/өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог үргэлжлүүлэн эрчимжүүлж үүнд хөдөөгийн хүн хамрагдалтыг нэмэгдүүлэх аян зохион байгуулах;

9/Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гэрээний үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжийг тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэж улирал бүр мэдээлэх, хэрэгжилтийг хангуулах;

10/төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, ашиглалтад хүлээн авах, өмчид хүлээн авах үйл ажиллагаанд ногоон байгууламжийн стандарт болон тусгай хэрэгцээт иргэдийн хэрэгцээнд нийцсэн байдлын стандартыг чанд мөрдөж хэрэгжүүлэх, зохион байгуулах;

11/Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн "18.1.10" дэх заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд Газрын багц хуулийн төсөл, Ашигт малтмалын тухай Чөлөөт бүсийн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулан 2023 оны 12 дугаар сарын 31-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

3.Дараах арга хэмжээ авч ажиллахыг аймаг, сумын Засаг дарга нарт даалгасугай.

1/орон сууц барихад шаардлагатай газрын зөвшөөрөл бусад холбогдох зохицуулалт, шаардлагатай санхүүжилтийг өөрт хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд болон Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлэх;

2/чадварлаг боловсон хүчнийг орон нутагт шилжин тогтвор суурьшилтай амьдрах таатай нөхцөл бүхий хөтөлбөр, арга хэмжээг санаачилж орон нутгийн онцлогтоо тохируулан хэрэгжүүлэх;

3/аймаг, сумын орон нутгийн хөгжлийн санд хуваарилсан хөрөнгийг "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжих чиглэлээр Засгийн газраас тодорхойлсон хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулах. Хөтөлбөр арга хэмжээний ач холбогдлыг орон нутгийн иргэдэд таниулан сурталчлах ажлыг зохион байгуулах;

4/нийслэл Улаанбаатар хотод бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаагаа орон нутагт шилжүүлэх, салбараа нээх зэрэг тохиолдолд ажлын байр болон ажилчдын орон сууцны барилга барих газрын зөвшөөрлийг холбогдох хууль, журамд заасны дагуу саадгүй, шуурхай олгох.

4.Орон сууцны ипотекийн зээлийн эрэлт, төвлөрлийг сааруулах төрийн бодлоготой уялдуулж ипотекийн хөтөлбөрийн эх үүсвэрийг нийслэл болон орон нутагт тэгш хүртээмжтэй, үе шаттай нэмэгдүүлэхийг Монголбанкны Ерөнхийлөгч /Б.Лхагвасүрэн/-д даалгасугай.

5.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төсвийн байнгын хороо /Г.Тэмүүлэн/-д даалгасугай.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

*Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн
албан тушаалын цалингийн хэмжээг
шинэчлэн тогтоох тухай*

Авлигын эсрэг хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д "Авлигатай тэмцэх газрын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана", 29.2-т "Авлигатай тэмцэх газрын төсвийг улсын төсөвт тусгайлан тусгах бөгөөд энэхүү төсөв нь үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна", УИХ-ын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2023-2030"-д авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын хараат бус, бие даасан байдлыг хангаж, аливаа нөлөөллийн эрсдэлийг бууруулна" гэж заасан.

Авлигатай тэмцэх газрын албан хаагчдын цалингийн хэмжээг адил төстэй чиг үүрэг гүйцэтгэдэг төрийн бусад хууль сахиулах байгууллагын албан хаагчийн цалингаас 50-60 хувь өндөр байх жишгийг баримталсан байдаг.

Өнөөдрийн байдлаар цалин, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогыг үйл ажиллагааны уялдаа бүхий шүүх, прокурорын байгууллагатай харьцуулахад 10-20 хувиар доогуур байна. Байцаан шийтгэх ажиллагааны хувьд тус газрын процессын дагуу хийгдсэн ажил дээр үндэслэн прокурор, шүүхийн байгууллагын ажиллагаа явагддаг бөгөөд анхан шатны үндсэн ажлыг гүйцэтгэдэг байгууллагын албан хаагчийн цалин нь дээрх шүүх эрх мэдэл, хууль хяналтын байгууллагын албан хаагчийн албан тушаалын цалингаас бага байх нь хараат бус байдлаар ажиллах эдийн засгийн баталгаа нөхцөлийг хангах хуулийн шаардлага хангагдахгүй байна.

Иймд адил төстэй чиг үүрэг гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишигтэй дүйцүүлэн Авлигын эсрэг хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсэгт заасныг баримтлан хуулиар тусгайлан эрх олгосон чиг үүргийг хараат бусаар, бие даан хэрэгжүүлэх, мэргэшсэн, чадварлаг, дадал туршлага бүхий мэргэжлийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор "Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулав.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар...

Улаанбаатар
хот

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН АЛБАН ХААГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН
ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ**

Авлигын эсрэг хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоол баталсантай холбогдуулан "Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Монгол Улсын Их Хурлын 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 85 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тогтоолыг 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН АЛБАН ХААГЧИЙН
АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

Д/д	Албан тушаал	Албан тушаалын сарын цалингийн хэмжээ /төгрөгөөр/
1	Авлигатай тэмцэх газрын дарга	4 338 298
2	Авлигатай тэмцэх газрын дэд дарга	4 041 128
3	Хэлтсийн дарга	3 984 234
4	Албаны дарга	3 670 140
5	Ахлах ажилтан	3 493 365
6	Ажилтан	3 293 035
7	Туслах ажилтан	1 880 970

ТАНИЛЦУУЛГА

Засгийн газарт чиглэл өгөх тухай

Хөгжлийн сэргэлтийг дэмжих бодлогын баримт бичигт тусгагдсан болон тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, ачаа тээврийн урсгалыг сайжруулах, хилийн боомтуудыг хатуу хучилттай авто замаар холбох, хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, дулааны цахилгаан станцуудын хүчин чадлыг өргөтгөх, байгаль орчинд ээлтэй, шинжлэх ухаан, дэвшилтэт технологид суурилсан эрчим хүчний шинэ эх үүсвэр барих, Нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, төвлөрлийг сааруулах, шинэ суурьшлын бүс, хот байгуулах дэд бүтэц шинээр бий болгох болон төрийн үйлчилгээний салбарын томоохон төсөл, хөтөлбөрийг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, төсвийн хөрөнгө оруулалт хүрэлцээгүй тул хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих замаар төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Иймд дээрх салбаруудад хэрэгжих тэргүүлэх ач холбогдолтой төсөл, хөтөлбөрүүдийг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хүрээнд түншлэлийн зарчмаар хэрэгжүүлэх талаар судлан, холбогдох арга хэмжээ авах талаар Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар...

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗАРТ ЧИГЛЭЛ ӨГӨХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан болон тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, ачаа тээврийн урсгалыг сайжруулах, төмөр зам, нисэх буудал, авто зам, замын байгууламжийн сүлжээг өргөтгөн шинэчлэх, боомтын хүчин чадлыг сайжруулах, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийг нэмэгдүүлэх, Нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, төвлөрлийг сааруулах, шинэ суурьшлын бүс, хот байгуулах дэд бүтэц бий болгох болон төрийн үйлчилгээний салбарын төсөл хөтөлбөрийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэн тэргүүнд дэмжих зарчимд тулгуурлан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хүрээнд хэрэгжүүлэх талаар судлан, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ц.Цэрэнпунцаг/-нд даалгасугай.

Гарын үсэг

Ажлын хэсгийн нэрс

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон дагалдах хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэхтэй холбоотой Сангийн яамнаас оролцох ажлын хэсгийн нэрс:

№	Нэр	Албан тушаал	Утас
1	Б.Жавхлан	Сангийн сайд	99113555
2	С.Мөнгөнчимэг	Сангийн дэд сайд	99075752
3	Ж.Ганбат	Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	99104599
4	М.Санжаадорж	Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга	99190219
5	Б.Тэлмүүн	Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга	99087638
6	Г.Золбоо	Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга	99196439
7	Б.Сүх-Очир	Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга	99011664
8	Б.Цогбадрах	Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга	99098442
9	З.Энхболд	Сангийн яамны Хууль эрх зүйн газрын дарга	96652191
10	Э.Батмөнх	Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга	89992039
11	П.Бат-Эрдэнэ	Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга	99017530
12	Л.Ичинноров	Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга	99266680
13	С.Тулга	Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга	98110000
14	Ж.Дэлгэржаргал	Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	99100568
15	Б.Ганзориг	Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга	88005775

МОНГОЛ УЛСЫН

ЗАСГИЙН ГАЗАР